

Хувь хүний санхүү

Сурах бичиг

Хянан тохиолдуулсан:

Док. Ц.Болормаа

Улаанбаатар хот

2016 он

Зохиогчид:

I, II, III бүлэг: Н. Батжаргал

IV бүлэг: Н. Батжаргал, Д.Лхагвадорж

V бүлэг: Док. Л.Оюун

VI бүлэг: Док. Д.Оюунцэцэг

VII бүлэг: Док. З.Оюунцацрал

VIII, IX бүлэг: Л.Оюун

X бүлэг: Док. З. Оюунцацрал

XI бүлэг: Док. Д.Оюунцэцэг, Д.Лхагвадорж

XII бүлэг: Док. Д.Оюунцэцэг

XIII, XIV, XV бүлэг: Г.Балж

XVI бүлэг: Док. Д.Оюунцэцэг

© Монголбанк

Бүх эрх хуулиар хамгаалагдсан болно. Зохиогчийн эрхийг эзэмшигчийн бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр энэхүү сурах бичгийн аль ч хэсгийг хувилах, бичлэг хийх зэрэг аливаа хэлбэрээр эсвэл арга хэрэгслээр хуулбарлах буюу дамжуулахыг хориглоно.

ӨМНӨХ ҮГ.....	5
ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ.....	6
БҮЛЭГ I. ХУВИЙН САНХҮҮГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ.....	7
СЭДЭВ 1. САНХҮҮГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ХУВЬ ХҮНИЙ САНХҮҮ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ.....	7
1.1 Хувь хүний санхүүгийн мөн чанар.....	7
1.2 Хувь хүний санхүүгийн шийдвэр гаргалт.....	10
1.3 Санхүүгийн шийдвэрт нөлөөлөх нийгэм, эдийн засгийн хүчин зүйл.....	13
СЭДЭВ 2. ХУВИЙН САНХҮҮГИЙН ТӨЛӨВЛӨЛТ, АЧ ХОЛБОГДОЛ, ҮЕ ШАТ.....	15
2.1 Санхүүгийн төлөвлөлтийн үйл явц.....	15
2.2 Хувь хүний санхүүгийн зорилго.....	19
2.3 Алдагдсан боломжийн өртөг.....	21
2.4 Санхүүгийн зорилгод хүрэхүй.....	22
СЭДЭВ 3. АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ.....	27
3.1 Ажил мэргэжлийн сонголт, түүнд нөлөөлөх хүчин зүйл.....	27
3.2 Ажил мэргэжлийн төлөвлөлт хийх.....	29
БҮЛЭГ II. МӨНГӨ, МӨНГӨНИЙ ҮНЭ ЦЭНЭ.....	34
СЭДЭВ 4. МӨНГӨНИЙ ЦАГ ХУГАЦААНЫ ҮНЭ ЦЭНЭ.....	34
4.1 Мөнгөний мөн чанар, үүрэг.....	34
4.2 Мөнгөний ханш уналт, түүний үр нөлөө.....	36
4.3 Хүү, түүний тооцоолол.....	38
4.4 Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ.....	40
СЭДЭВ 5. МӨНГӨН ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА, ӨРХИЙН ТӨСӨВ.....	45
5.1 Хувь хүний төсөв, түүний бүтэц.....	45
5.2 Өрхийн төсвийн удирдлагын аргууд.....	48
5.3 Хувийн (өрхийн) төсөв зохиох аргачлал.....	54
5.4 Хувь хүн, өрх, аж ахуйн нэгж ба улсын төсвийн уялдаа холбоо.....	55
СЭДЭВ 6. ХУВЬ ХҮНИЙ ТАТВАРЫН УДИРДЛАГА.....	59
6.1 Татварын мөн чанар, түүний төрлүүд.....	59
6.2 Татварын тооцоолол хийх арга зүй.....	63
6.3 Татварыг тайлагнах, төсөвт төлөх.....	67
6.4 Татварын төлөвлөлт хийхэд анхаарах зүйлс.....	68
БҮЛЭГ III. ХУВИЙН САНХҮҮГИЙН ШИЙДВЭР ГАРГАЛТ.....	71
СЭДЭВ 7. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ХУВЬ ХҮНИЙ ОРОЛЦОО.....	71
7.1 Санхүүгийн зах зээлийн тухай ойлголт, түүний төрлүүд.....	71
7.2 Санхүүгийн байгууллагуудын онцлог, үзүүлэх үйлчилгээ.....	79
7.3 Санхүүгийн зах зээл дэх хувь хүний оролцоо.....	82
СЭДЭВ 8. ЗЭЭЛИЙН ТӨРӨЛ, АНГИЛАЛ.....	90
8.1 Зээлийн тухай ойлголт.....	90
8.2 Арилжааны банкны зээлийн ангилал, төрөл.....	92
8.3 Зээлийн нийгэм эдийн засгийн ач холбогдол.....	96

СЭДЭВ 9.ЗЭЭЛИЙН УДИРДЛАГА.....	103
9.1 Зээлийн эрсдэл, түүнд нөлөөлөх хүчин зүйлс.....	103
9.2 Зээлийн нөхцөл, зарчим.....	106
9.3 Зээлийн шинжилгээ.....	111
БҮЛЭГ IV. ХУВИЙН САНХҮҮГИЙН ШИЙДВЭР ГАРГАЛТ.....	116
СЭДЭВ 10.ХАДГАЛАМЖИЙН ШИЙДВЭР ГАРГАЛТ.....	116
10.1 Хуримтлалын тухай ойлголт, мөн чанар.....	116
10.2 Хадгаламжийн тухай ойлголт, мөн чанар.....	121
10.3 Хадгаламжийн орлогын тооцоолол.....	129
СЭДЭВ 11.ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨРЛҮҮД.....	138
11.1 Хөрөнгө оруулалт, түүний мөн чанар, ач холбогдол.....	138
11.2 Хувьцааны хөрөнгө оруулалт.....	141
11.3 Бондын хөрөнгө оруулалт.....	145
11.4 Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт.....	147
СЭДЭВ 12.ХУДАЛДАН АВАЛТЫН ШИЙДВЭР ГАРГАЛТ.....	150
12.1 Худалдан авалтын шийдвэр гаргалт.....	150
12.2 Худалдан авалт хийх аргууд.....	152
12.3 Хэрэглэгчийн эрх ашгийн хамгаалалт.....	158
12.4 Орон сууц, тээврийн хэрэгсэл худалдан авахад анхаарах зүйлс.....	164
СЭДЭВ 13.ХУВЬ ХҮНИЙ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА.....	164
13.1 Эрсдэлийн тухай ойлголт.....	167
13.2 Эрсдэлийн төрлүүд.....	169
13.3 Хувь хүний эрсдэлийн удирдлага.....	171
СЭДЭВ 14.ДААТГАЛ, ТҮҮНИЙ ТӨРЛҮҮД.....	171
14.1 Даатгалын хэлбэрүүд.....	179
14.2 Даатгалын гэрээ байгуулахад анхаарах зүйлүүд.....	182
БҮЛЭГ V.ТЭТГЭВРИЙН БА ӨВ ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ.....	182
СЭДЭВ 15. ТЭТГЭВРИЙН ТӨЛӨВЛӨЛТ.....	182
15.1 Тэтгэврийн төлөвлөлт, түүний ач холбогдол.....	182
15.2 Тэтгэврийнхээ орлогоор амьдрах нь.....	185
15.3 Өндөр насны тэтгэврийн тухай ойлголт.....	188
15.3 Тэтгэврийн даатгалын нэрийн дансны тухай.....	193
15.4 Цэргийн албан хаагчдын тэтгэврийн тухай ойлголт.....	194
СЭДЭВ 16.ӨВ ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ.....	197
16.1 Өв хөрөнгийн төлөвлөлт.....	197
16.2 Итгэмжлэл.....	200
16.3 Гэрээслэл, түүний төрлүүд.....	202
НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР.....	207
НОМ ЗҮЙ.....	215
ХАВСРАЛТ.....	217

“Иргэн баян бол улс баян” хэмээх үг буй. Үүний цаана иргэн бүр эрх үүргээ ухамсарлан, өөрийн амьдрал ахуйдаа эзэн болж чадвал улс орны хөгжил сайн сайхан байхыг өгүүлж буй хэрэг билээ. Нөгөө талаас, аливаа улсын хөгжлийн эрхэм зорилго бол ард иргэдийнхээ сайн сайхан аж байдлыг дээшлүүлэх явдал байдаг. Энэ зорилгод хүрэхэд улс орон эдийн засгийн хувьд чадамжтай, хувь хүмүүс санхүүгийн хувьд чадамжтай байх нь илүү чухаг. Төр засаг дангаараа ажиллаад энэ зорилгыг биелүүлэх боломжгүй, гагцхүү үүнд иргэн бүрийн үүрэг, хувь нэмэр, идэвх санаачлага, оролцоо хэрэгтэй юм.

Эдийн засаг, санхүүгийн боловсролыг их, дээд сургуулиудад олон төрлийн хичээлээр олгодог ч тэр бүр хувь хүн, өрх, гэр бүлийн түвшинд уялдаа холбоотойгоор авч үздэг тусгайлсан хичээл, сургалтын хөтөлбөр одоохондоо нийтлэг биш байна. Тиймээс энэхүү орон зайг нөхөх үүднээс Монголбанкнаас санаачлан Сангийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Санхүүгийн зохицуулах хороо, Монголын банкны холбоо, Монголын даатгагчдын холбоо, Хадгаламжийн даатгалын корпораци, санхүүгийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг төрийн бус байгууллага, холбоод, их, дээд сургуулиудтай хамтран “Олон нийтийн санхүүгийн суурь мэдлэгийг дээшлүүлэх” үндэсний хөтөлбөрийг боловсруулж, 2015 онд баталсан. Энэ хөтөлбөрийн хүрээнд МУИС-ийн Бизнесийн сургууль, СЭЗИС, ХААИС-ийн Эдийн засаг, бизнесийн сургуулийн багш нар “Хувь хүний санхүү” хичээлийн үндэсний сурах бичгийг боловсруулан та бүхэнд толилуулж байна.

Энэ сурах бичгээр хувь хүн та өөрийн санхүүгээ зөв удирдан жолоодох, тухайлбал, хувь хүний санхүүгийн талаарх үндсэн ойлголт, тодорхойлолтууд, орлого, зарлагаа тооцоолох, хянах, хуримтлал, хадгаламжтай болох, хөрөнгө мөнгөө зарцуулахтай холбогдон гарч болох аливаа эрсдэлт байдлаас сэргийлэх, хамгаалах, эдийн засаг, санхүүгтэй холбоотой зөв, оновчтой шийдвэр гаргах зэрэг өөрийн өдөр тутмын болоод ирээдүйн эдийн засгийн амьдралд нэн шаардлагатай, мэдвэл зохих хувь хүний санхүүгийн мэдлэг, ур чадварыг эзэмших юм.

Бид хязгаарлагдмал нөөцөөр хязгааргүй хэрэгцээгээ хангахыг тэмүүлдэг. Тэгвэл хэрэгцээгээ бүрэн хангахын тулд хязгаарлагдмал нөөц, хөрөнгө мөнгийг зөв зарцуулахтай холбоотой хувь хүний санхүүгийн төлөвлөлт танд маш чухал. Хувь хүн өөрийн санхүүгээ зөв төлөвлөж, амьдралынхаа баталгаагаа хангаж чадвал улс орны эдийн засаг ч дагаад тогтвортой байх нөхцөл бүрдэнэ. Тэгэхээр санхүүгийн, тэр дундаа, хувь хүний санхүүгийн мэдлэг боловсрол, түүнийгээ зөв хэрэглэж сурах нь чухал гэдгийг энэхүү сурах бичиг ойлгуулах болно.

Хувь хүн та өөрийн бүхий л талын нөөц бололцоог ашиглах, нийгэм, эдийн засаг, санхүүгийн үйлчилгээний талаарх өөрт хэрэгтэй мэдээлэл олж авах, мэдээлэлдээ тулгуурлан шийдвэр гаргах, сонголт хийхдээ хэрэглэх зөв мэдлэг, хандлага, ур чадвар, зан үйл, дадал зуршлыг энэ сурах бичгээс олж авна гэдэгт бид найдаж байна.

Док.Ц.Болормаа, МУИС-ийн Бизнесийн сургуулийн захирал

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Аж ахуйн нэгж байгууллага
ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
ББСБ	Банк бус санхүүгийн байгууллага
БДК	Брокер, дилерийн компани
БСБ	Банк санхүүгийн байгууллага
ВЗЗ	Валютын зах зээл
ЖДҮ	Жижиг дунд үйлдвэр
ЗБДС	Зээлийн батлан даалтын сан
ЗГ	Засгийн газар
ЗГҮЦ	Засгийн газрын үнэт цаас
МЗЗ	Мөнгөний зах зээл
МУ	Монгол Улс
МХБ	Монголын хөрөнгийн бирж
МЭД	Малын эрсдэлийн даатгал
НД	Нийгмийн даатгал
НДШ	Нийгмийн даатгалын шимтгэл
ННФ	Нээлттэй нийгэм форум
НӨАТ	Нэмэгдсэн өртгийн албан татвар
НҮБ	Нэгдсэн үндэсний байгууллага
СЗХ	Санхүүгийн зохицуулах хороо
ТЕГ	Татварын ерөнхий газар
УИХ	Улсын их хурал
ҮЦГТТХТ	Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв
ХДК	Хадгаламжийн даатгалын корпораци
ХЗЗ	Хөрөнгийн зах зээл
ХЗХ	Хадгаламж зээлийн хоршоо
ХҮИ	Хэрэглээний үнийн индекс
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар

БҮЛЭГ I. ХУВИЙН САНХҮҮГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ

СЭДЭВ 1. САНХҮҮГИЙН ТУХАЙ ОЙЛГОЛТ, ХУВЬ ХҮНИЙ САНХҮҮ, ТҮҮНИЙ ОНЦЛОГ

Сэдвийг судлахын ач холбогдол, үр дүн

Энэ сэдвийг судалснаар хувь хүний санхүүгийн мөн чанар, зорилго, үүрэг, зарчим, ач холбогдол болон санхүүгийн төлөвлөгөө, шийдвэрт нөлөөлөх хүчин зүйлсийг ойлгож, оновчтой шийдвэр гаргах чадварыг эзэмшинэ.

Тулгуур ойлголт

- Амьдралын мөчлөг
- Санхүүгийн тогтолцоо
- Санхүүгийн тогтолцооны үндсэн үүрэг
- Санхүүгийн төлөвлөгөө
- Санхүүгийн тулгуурлах зарчим
- Хувь хүний санхүүгийн мөн чанар
- Хувь хүний санхүүгийн төлөвлөлт
- Хувь хүний санхүүгийн удирдлага
- Хувь хүний санхүүгийн үндсэн үүрэг
- Хувь хүний санхүүгийн үүрэг

1.1. Хувь хүний санхүүгийн мөн чанар

*“Иргэн баян бол улс баян
Улс баян бол иргэн баян”*

Хувь хүний санхүү нь тодорхой хугацаанд хүмүүс хязгаарлагдмал мөнгөн орлого, зарлагаа хэрхэн оновчтой удирдаж байгааг судалдаг санхүүгийн шинжлэх ухааны нэг салбар юм. Хувь хүний санхүүгийн үндсэн мөн чанар бол хувь хүний орлого, зарлага ямагт хувьсах шинж чанартай, тодорхой цаг хугацааны явцад тархсан байдалтай байдаг. Санхүүгийн үүднээс орлого, зарлагын бодит хэмжээг өөр хэн нэгэн этгээд, шийдвэр гаргагчид яв цав тодорхойлох боломжгүй.

Хувь хүний санхүүгийн мөн чанар:
Орлого, зарлага ямагт хувьсах цаг хугацааны явцад тархсан байдалтай байдаг.

Ямар ч хүн өнөөдрийн олсон орлогоо өдөрт нь бүгдийг зарцуулахгүй маргааш, эсвэл бүр алс хэтэд чиглэсэн хөрөнгө оруулалт хийх зорилгоор хадгалж, хуримтлуулах нь зохистой.

Иймд амьдралын тодорхой зорилготой, түүндээ хүрэх санхүүгийн зорилготой байх нь зайлшгүй чухал юм. Энэ нь өнөөдрийн орлогоо магадгүй тэтгэвэрт суухдаа хэрэглэх эх үүсвэр болгох зорилгоор хуваарилна гэсэн үг. Хувь хүн, өрх гэр, компани, улс орон аль аль нь ялгаагүй ямагт үр ашиг муутай хөрөнгө оруулалтаас үр ашигтай хөрөнгө оруулалтад тэмүүлэх нь зайлшгүй болохоор улс орон, салбар хооронд хөрөнгө хуваарилагдах шаардлага аяндаа бий болдог. Өнөөдөр манай улсын мянга мянган залуус гадаад улс оронд сурч, хөдөлмөрлөж олсон орлогоосоо эцэг эх, гэр орон, эх орон луугаа явуулж байгаа нь санхүүгийн урсгал цаг хугацаа,

салбар, улс орны хооронд хуваарилагдаж байдгийг харуулж байгаа юм. Иймээс хувь хүн санхүүгээ оновчтой удирдан зохион байгуулж, хамгийн үр ашигтай хөрөнгө оруулалтыг тодорхой цаг хугацаанд улс орон, салбарын хүрээнд хийх боломжтой болдог.

Хувь хүний санхүүгийн зорилго, үүрэг. Хувь хүний санхүү бол санхүүгийн тогтолцооны үндсэн гол хэсэг төдийгүй оршин тогтнох үндэс суурь нь юм. Учир нь хувь хүн, өрх гэрийн орлогын дахин хуваарилалт байхгүй бол компани үйлдвэрлэл, үйлчилгээ явуулах ямар ч утга учир, ач холбогдол байхгүй, аж ахуйн нэгж компани байхгүй бол улс орны үндсэн гол татвар төлөгч байхгүй, энэхүү төр засгийн орлогын эх үүсвэр байхгүй бол улс орон оршин тогтноход хэцүү билээ.

Хувь хүний санхүүгийн үндсэн үүрэг:
Хязгаарлагдмал санхүүгийн нөөцийг үр ашигтай хуваарилах явдал.

Хувь хүн, өрх гэр, компани, төр засгийн түвшинд зохих хэмжээний ялгаатай санхүүгийн шийдвэрүүд гарч байдаг.

Энэхүү их бага, том жижиг санхүүгийн шийдвэрүүд санхүүгийн тогтолцоо, санхүүгийн зах зээл, санхүүгийн байгууллагуудын тусламжтайгаар хэрэгжиж, амьдралд биеллээ олно.

Санхүүгийн тогтолцоо: *Санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн зах зээлийн нэгдэл.*

Тиймээс хувь хүн санхүүгийн хувьд ямар үүрэгтэй, ямар зарчмыг баримталж, санхүүгээ удирдах нь оновчтой талаар авч үзэх хэрэгтэй.

Хувь хүний санхүү нь аж ахуйн нэгж, төр засгийн газартай адил үндсэн 3 үүргийг гүйцэтгэх ёстой. Үүнд:

1. Хуваарилах: Хувь хүн өнөөдөр олсон орлогоосоо хэдийг нь, юунд, хэзээ хуваарилах талаар ямагт шийдвэр гаргаж байдаг
2. Хянах: Хувь хүн өөрсдийн олж байгаа орлого, гарч байгаа зардлуудыг байнга хянаж, бүртгэж тооцдог байх ёстой
3. Зайлшгүй санхүүгийн нөөц бүрдүүлэх

Хувь хүний санхүүгийн үүрэг:
Хуваарилах, хянах, санхүүгийн нөөц бүрдүүлэх

Хувь хүн үндсэн хэрэгцээгээ хангах, хоол хүнс, хувцас хунар, ахисан түвшний сургалтанд хамрагдахад мөнгө буюу санхүүгийн нөөц зайлшгүй хэрэгтэй болдог.

Санхүүгийн нөөц гэдэгт ерөнхийдөө мөнгө, мөнгөтэй адилтгах санхүүгийн хэрэгслүүд болох хугацаатай болон хугацаагүй хадгаламж, хувьцаа ба өрийн бичгийг хамруулж ойлгож болно.

Санхүүгийн тогтолцооны үндсэн үүрэг: *Хязгаарлагдмал санхүүгийн нөөцийг үр ашигтай удирдах явдал.*

Хувь хүний хувьд ч гэсэн санхүүгийн энэ үүрэг хамгийн чухал юм.

Хүн бүр өөрийн олсон мөнгөн орлогоо оновчтой, үр ашигтай зарцуулах талаар тооцоо, төлөвлөгөөтэй байх ёстой. Аль ч улс орны санхүүгийн тогтолцоо дараах үүргүүдийг хангаж, хувь хүн болоод бүхий л шатны санхүүгийн шийдвэр гаргагчдыг дэмждэг байх шаардлагатай. Үүнд:

1. Санхүүгийн нөөцийг цаг хугацаа, улс орон, эдийн засгийн салбар хооронд шилжүүлэх боломжоор хангах
2. Эрсдэлийг удирдах бололцоог бий болгох
3. Төлбөр тооцоо гүйцэтгэх
4. Санхүүгийн нөөцийг нэгтгэх, төвлөрүүлэх
5. Мэдээллээр хангах

Эдгээр үүргийг хангахад банк, санхүү, даатгалын байгууллагын үйл ажиллагаа, үүрэг, оролцоо ихээхэн чухал юм. Түүнээс гадна банкны тогтолцооны төлбөр тооцооны тогтолцоо чухал ач холбогдолтой байдаг.

Хувь хүний санхүүгийн зарчим, ач холбогдол

Санхүүгийн шинжлэх ухааны үүднээс авч үзвэл, санхүүгийн тулгуур үндсэн 2 зарчим байдаг гэж хэлж болно.

Санхүүгийн тулгуур зарчим:

1. Өнөөдрийн 1 төгрөг маргаашийн 1 төгрөгнөөс ямагт үнэтэй;
2. Эрсдэлгүй 1 төгрөг эрсдэлтэй 1 төгрөгнөөс ямагт үнэ цэнэтэй.

Иймээс өнөөдрийн гаргах санхүүгийн шийдвэрийг зөв тооцож, тодорхойлж гаргахгүй бол үр ашиггүй, ач холбогдолгүй, буруу шийдвэр гаргаж болзошгүй.

Өөрөөр хэлбэл, үр өгөөж хүртэхгүй, үрэлгэн зардал гаргаснаар ирээдүйд олж болох ашгаасаа татгалзаж байна гэсэн үг. Хэрвээ та баталгаатай ажлын байртай, байнгын тогтмол орлоготой бол таны эрсдэл хар зах дээр наймаа, арилжаа хийж орлого олдог хүнээс хамаагүй бага гэсэн үг. Мөн тодорхой мөнгө төлж, хонжворт сугалаанд оролцон, аз туршиж олох мөнгөнөөс банкны хадгаламжид мөнгөө хийх нь эрсдэл багатай.

Үүний зэрэгцээ хувь хүн санхүүгийн шийдвэр гаргахдаа дараах зарчмыг зайлшгүй баримтлах шаардлагатай. Үүнд:

- Тооцоотой байх: Олсон орлогоосоо үндсэн зардлаа хангаад, тодорхой хэмжээний ахиу орлоготой буюу ашигтай үлдэх
- Төлөвлөгөөтэй байх: Чиглэсэн зорилго, төлөвлөгөөтэй байх нь орлого, зарлагаа оновчтой удирдах удирдамж, чиглэл болно
- Санхүүгийн нөөцийг тасралтгүй, оновчтой бүрдүүлэх: Өөрийн үндсэн хэрэгцээг хангах хэмжээний орлоготой байх, түүнийг оновчтой бүрдүүлэх

ТАНЫ МЭДЛЭГТ

1990 онд Сүхбаатар дүүргийн 11-р хорооллын 3 өрөө орон сууц (анхны хоршооллын орон сууц) 10'000 төгрөг байсан бол өнөөдөр ямар үнэтэй байгааг та бүхэн мэдэх билээ.

Хувь хүн санхүүгийн дээрх зарчмуудыг мөрдөж, санхүүгээ оновчтой удирдахад санхүүгийн зорилго, төлөвлөгөө хамгийн чухал бөгөөд түүнд тулгуурлан санхүүгийн шийдвэр гаргах ёстой.

ШИГТГЭЭ

“Хаана хүрэхээ мэдэхгүй хүн яаж хүрэхээ мэдэхгүй. Хаа нэгэн газар очлоо ч өөрийн очих ёстой байсан газар гэдгээ мэдэхгүй”

Ж. Мейгер

1.2. Хувь хүний санхүүгийн шийдвэр гаргалт

Хувь хүний санхүүгийн удирдлагын үндсэн асуудал бол санхүүгийн хувьд сэтгэл хангалуун байхуйцаар мөнгөн хөрөнгийг оновчтой удирдах явдал. Хувь хүний санхүүгийн шийдвэр гаргалт тухайн хүний нас, хүйс, мэргэжил, мэдлэг, итгэл үнэмшил, шашин шүтлэг, өрхийн бүтэц, улс орны нийгэм эдийн засгийн байдлаас ихээхэн шалтгаалдаг.

Ямар ч хүн олсон орлогоосоо хэдийг нь хэрэглэж, хэдийг нь хуримтлуулах вэ? гэсэн шийдвэр гаргаж байдаг. Энэхүү үүсгэж байгаа хуримтлал бол мөнгөөр хийж байгаа хөрөнгө оруулалт юм.

Хувь хүний санхүүгийн удирдлага:

Хувь хүн санхүүгийн хувьд сэтгэл ханамжтай байхуйцаар мөнгөн хөрөнгийг оновчтой удирдах арга механизм.

20 эсвэл 50 настай хүний гаргах санхүүгийн шийдвэр, мөнгөний зарцуулалт мэдээж ялгаатай, өөр өөр хэдий ч хувь хүний санхүүгийн удирдлагыг ерөнхийд нь:

- Хөрөнгө оруулалтын удирдлага
- Санхүүжилтийн удирдлага
- Эрсдэлийн удирдлага гэж ангилж болно.

Ер нь хөрөнгө оруулалтыг хийж байгаа хэлбэрийнх нь хувьд санхүүгийн болон бодит хөрөнгө оруулалт гэж ангилж болно. Санхүүгийн хөрөнгө оруулалтыг мөнгө болон мөнгөтэй адилтгах үнэт цаасаар хийдэг бол бодит хөрөнгө оруулалт нь материаллаг хэлбэртэй хөрөнгөөр хийж байгаа хөрөнгө оруулалт юм. Хувь хүн нэгэнт тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийхээр шийдсэн бол түүнийг санхүүжүүлэх эх үүсвэрийг оновчтой, зөв бүрдүүлэхэд удирдлага хэрэгтэй. Мөн хөрөнгийг ямагт эрсдэл дагаж хуваарилагддаг учраас түүнийг удирдаж, эрсдэлийг бууруулах шийдвэр гаргах шаардлагатай.

Хувь хүний санхүүгийн шийдвэр гаргалт, түүнд үзүүлэх нөлөө



Мөнгө бол манай нийгмийн чухал асуудлын нэг¹. Ямар ч хүн хүссэн цагтаа хүссэн зүйлээ авах хэмжээний мөнгөтэй байхыг хүсдэг. Харамсалтай нь санхүүгийн зөв удирдлагыг хэрэгжүүлж чадаагүйгээс энэ хүсэл бодол ихэнх тохиолдолд мөрөөдөл төдий зүйл болж хувирдаг.

Хүн бүр өдөр тутам ямар нэг байдлаар санхүүгийн шийдвэр гаргаж байдаг бөгөөд тэдгээрийг дараах байдлаар ангилна. Үүнд:

1. Хэрэглэх эсвэл хуримтлуулахтай холбоотой шийдвэр
2. Хөрөнгө оруулалтын шийдвэр
3. Санхүүжилтийн шийдвэр
4. Эрсдэлийг удирдах, бууруулахтай холбоотой шийдвэр

Өнөөгийн олж байгаа орлогоосоо хичнээнийг өнөөдөр хэрэглэж, хэдийг ирээдүйдээ зориулан хадгалах нь зохистой талаар гаргах шийдвэр бол хамгийн чухал шийдвэр бөгөөд хүн хүсэлдээ хөтлөгдөж бус хэрэгцээ шаардлагадаа нийцүүлэн хэрэглэж, тодорхой хэмжээний хуримтлалыг үүсгэж байх нь зайлшгүй чухал шийдвэр юм. Хувь хүн өөрийн бий болгосон хуримтлалаасаа тодорхой хэмжээний ашиг олох зорилгоор оюуны болон бодит хөрөнгө оруулалт хийх шийдвэр гаргадаг. Оюуны хөрөнгө оруулалтыг ахисан шатны сургалтад хамрагдах, хэлний мэдлэгээ дээшлүүлэх, төсөл хөтөлбөр боловсруулахад зөвлөгөө, мэдээлэл авах зорилгоор хийдэг. Харин бодит хөрөнгө оруулалтыг машин механизм, тоног төхөөрөмж, орон байр, эд хөрөнгө худалдан авах замаар хийдэг.

Нэгэнт тодорхой хэмжээний хөрөнгө оруулалт хийхээр шийдсэн нөхцөлд санхүүжилт хэрэгтэй болдог. Энэ үед өөрийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн бусдын мөнгийг хэзээ, хичнээнийг ашиглах талаар оновчтой шийдвэр гаргах ёстой. Хөрөнгө оруулалтыг даган хуваарилагдах эрсдэл болон учирч болох эдийн засгийн тодорхой бус байдлыг ямар хугацаанд хэрхэн бууруулах, эсвэл тооцоолсон эрсдэлийг хүлээн авах эсэх талаар шийдвэр гаргах нь мөн зайлшгүй чухал асуудал.

Амьдралын нөхцөл байдал ба санхүүгийн төлөвлөлт

Хувь хүний санхүүгийн төлөвлөлт бол хувь хүний мөнгөө удирдах үйл явц бөгөөд санхүүгийн шийдвэр гаргалтад хяналт тавих гол хэрэгсэл болдог.

Хувь хүний санхүүгийн төлөвлөлт:
Хувь хүн ирээдүйн санхүүгийн найдвартай хамгаалалтыг бүрдүүлэх зорилгоор мөнгөн орлого, зарлагаа төлөвлөх үйл явц.

Хувь хүн, өрх гэр бүлийн гаргаж байгаа санхүүгийн шийдвэр бүр тодорхой хэрэгцээ, зорилгыг хангахуйц төлөвлөгдсөн байх ёстой.

¹ Jack R. Kapoor, Les R. Dlabay, Robert J. Hughes “Focus on Personal Finance”, 2004. p 2

Санхүүгийн төлөвлөгөө нь хувь хүний ирээдүйн хэрэгцээ, нөөц эх үүсвэрийн талаарх тодорхой бус байдлыг бууруулж, хувь хүний сэтгэл ханамжийг нэмэгдүүлэх хэрэгсэл болдог. Санхүүгийн төлөвлөгөө бол хувь хүний санхүүгийн өнөөгийн нөхцөл байдал, хэрэгцээг шинжилж дүгнэсэн, ирээдүйн санхүүгийн үйл ажиллагаанд зөвлөмж болох албан ёсны удирдамж гэж хэлж болох юм.²

Санхүүгийн төлөвлөгөө: *Хувь хүний өнөөгийн санхүүгийн нөхцөл байдал, санхүүгийн хэрэгцээг шинжилж, дүгнэсэн ирээдүйн санхүүгийн үйл ажиллагаанд зөвлөмж болох албан ёсны удирдамж.*

Хувь хүний өдөр тутмын санхүүгийн шийдвэрт тухайн хүний наснаас эхлээд өрх гэрийн бүтэц, хүүний түвшин, инфляци зэрэг олон хүчин зүйл нөлөөлж байдаг.

Хувь хүний санхүүгийн төлөвлөлт, шийдвэр гаргалтад нөлөөлдөг үндсэн 3 элемент бол амьдралын нөхцөл байдал, хувь хүний үнэлэмж буюу ертөнцийг үзэх үзэл болон эдийн засгийн хүчин зүйл юм.³ Хувь хүний нас, орлого, өрхийн бүтэц, итгэл үнэмшил зэрэг хувь хүний хүчин зүйлүүд хувь хүний зарлага болон хуримтлалд шууд нөлөө үзүүлдэг гэж хэлж болно.

Амьдралын мөчлөг: *Насанд хүрэгсдийн санхүүгийн хэрэгцээ болон гэр бүлийн нөхцөл байдлыг харуулдаг үе шат*

Нийгэм хувьсан өөрчлөгдөхийн хэрээр санхүүгийн хэрэгцээ, шаардлага ч өөрчлөгдөж байна.

Өнөөдөр хожуу гэрлэлт нэмэгдэж байгаагаас гадна эцэг эсвэл эх дангаараа өрх толгойлдог айл өрх олон болсон, мөн харьцангуй урт насалж байгаа нь санхүүгийн шийдвэрт ихээхэн нөлөөлж байна. Хувь хүний санхүүгийн шийдвэр гаргалтад гэрлэлтийн байдал, өрхийн хэмжээ, бүтэц, ажил эрхлэлт зэргээс гадна амьдралын дараах үйл явдлууд ч бас нөлөөлдөг. Үүнд:

- Төгсөлт (боловсролын янз бүрийн түвшин);
- Сүй тавих, гэрлэх
- Хүүхэд төрүүлэх, үрчилж авах
- Ажил мэргэжлээ өөрчлөх
- Оршин суух газраа өөрчлөх
- Өрх тусгаар үр хүүхдээ харах
- Эрүүл мэндийн байдал муудах
- Гэр бүл салах
- Тэтгэвэрт суух
- Гэр бүлийн гишүүн, эхнэр, нөхөр нас барах зэрэг нь одоо зарцуулах эсвэл ирээдүйдээ зориулан хадгалах эсэх шийдвэрт шууд хүчтэй нөлөө үзүүлдэг.

² Jack R. Kapoor, Les R.Dlabay, Robert J. Hughes “Focus on Personal Finance”, 2004. p 2

³ Jack R. Kapoor, Les R.Dlabay, Robert J. Hughes “Personal Finance”, 2008. p 11

1.3. Санхүүгийн шийдвэрт нөлөөлөх нийгэм, эдийн засгийн хүчин зүйл

Санхүүгийн шийдвэр гаргалтад нөлөөлөх өөр нэг чухал хүчин зүйл бол нийгэм эдийн засгийн нөхцөл байдал болохыг өмнө дурдсан билээ. Нийгэм эдийн засгийн хүчин зүйлс болон тэдгээрийн санхүүгийн шийдвэрт үзүүлэх нөлөөг Хүснэгт 1-1-ээр харууллаа.

Хувь хүний санхүүгийн шийдвэрт нөлөөлдөг хүчин зүйлсээс хэрэглээний үнэ, хэрэглээний зардал болон хүүний хувь хэмжээ хамгийн хүчтэй нөлөөлдөг. Энэ талаар 4-р бүлэг сэдвийн хүрээнд дэлгэрэнгүй авч үзэх болно.

Хүснэгт 1-1. Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлийн нөлөө ба санхүүгийн шийдвэр⁴

Нийгэм эдийн засгийн хүчин зүйл	Хэмжих үзүүлэлт	Санхүүгийн шийдвэрт үзүүлэх нөлөө
Хэрэглээний үнэ	Төгрөгийн худалдан авах чадвар; Инфляцийн өөрчлөлт	Хэрэв хэрэглээний үнэ орлогоос тань хурдан өсвөл худалдан авах бараа, үйлчилгээний хэмжээ буурна.
Хэрэглээний зардал	Хувь хүн болон өрхийн бараа, үйлчилгээний эрэлт	Хэрэглээний зардал нэмэгдэх нь өндөр цалинтай болон нэмэлт ажил хайхад хүргэнэ.
Хүүний хувь хэмжээ	Мөнгөний үнэ өртөг; Зээлийн өртөг; хадгалсан эсвэл хөрөнгө оруулсан мөнгөний өгөөж.	Хүүний хувь хэмжээ өсөхөд авч байгаа зээлийн өртөг нэмэгдэнэ. Хүүний өндөр түвшин нь хадгаламж, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлж, зээлийн эрэлтийг бууруулна.
Мөнгөний нийлүүлэлт	Эдийн засагт эргэж байгаа мөнгөний хэмжээ	Хадгаламж, хөрөнгө оруулалт нэмэгдэхэд хүүний түвшин буурна. Мөн хадгаламж нэмэгдэхэд (зардал буурах) ажил эрхлэлт буурч болно.
Ажилгүйдэл	Ажил эрхлэх боломжтой ч ажил эрхлээгүй байгаа хүний тоо	Ажилгүй хүмүүс өрийн хэмжээгээ бууруулах болон амьжиргааг хангах нөөц сантай байх ёстой. Ажилгүйдэл нэмэгдэхэд хэрэглээний зардал буурна.
Орон байрны шав	Шинээр баригдаж байгаа орон байрны тоо	Ажил эрхлэлт, цалин, хэрэглээний зардал нэмэгдэх болон эдийн засаг сайжрахад шинээр баригдах орон байрны тоо нэмэгдэнэ.
Дотоодын нийт бүтээгдэхүүн (ДНБ)	Тухайн улсын хилийн дотор гадаадын болон дотоодод үйлдвэрлэсэн нийт бараа, үйлчилгээ	ДНБ-ий хэмжээ өсөхөд хувь хүний санхүүгийн чадавхи дээшилж, ажил эрхлэлт нэмэгдэнэ.
Худалдааны тэнцэл	Улсын экспорт болон импортын зөрүү	Хэрэв улс орны импорт экспортоосоо их байвал төлбөрийн тэнцлийн алдагдал үүсч, валютын ханшаар дамжин үнэ өөрчлөгдөхөд хүргэнэ.
Үнэт цаасны зах зээлийн индекс /Тор-20/	Хувьцааны үнэ цэнийг илэрхийлдэг индекс	Энэ индекс хувьцааны үнийн ерөнхий өөрчлөлтийг харуулдаг.

⁴ Jack R. Kapoor, Les R. Dlabay, Robert J. Hughes "Personal Finance", 2008. p 13

Сэдвийн дүгнэлт

Хувь хүний санхүүгийн үндсэн үүрэг бол хязгаарлагдмал санхүүгийн нөөцийг үр ашигтай хуваарилах бөгөөд энэ үүргийг биелүүлэхэд санхүүгийн төлөвлөгөөтэй, тооцоотой, санхүүгийн нөөцийг оновчтой бүрдүүлэх зарчим мөрдөх шаардлагатай. Хувь хүний санхүүгийн гол ач холбогдол нь санхүүгийн эрх чөлөөнд хүрэх явдал юм.

Хувь хүний санхүүгийн зорилго, санхүүгийн төлөвлөлтийн шийдвэрт хувь хүний амьдралын нөхцөл байдал (орлого, нас, өрхийн бүтэц хэмжээ, эрүүл мэнд болон хувь хүний үнэлэмж, ертөнцийг үзэх үзэл) хүчтэй нөлөө үзүүлж байдаг.

Хувь хүний санхүүгийн зорилго, санхүүгийн төлөвлөлтийн шийдвэр мөн эдийн засгийн хүчин зүйл (үнэ, хүүний түвшин болон ажил эрхлэлтийн боломж)-ээс шууд хамаарч байдаг.

Бататгах асуултууд:

1. Хувь хүний санхүүгийн үндсэн үүрэг, зарчим, ач холбогдол юу вэ?
2. Хувь хүний нас, гэрлэлтийн байдал, өрхийн бүтэц, хэмжээ, ажил эрхлэлтийн байдал зэрэг хувийн хүчин зүйлс нь санхүүгийн шийдвэрт хэрхэн нөлөөлдөг вэ?
3. Нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсийн хувь хүний санхүүгийн шийдвэр гаргалтад үзүүлэх нөлөөг тайлбарлана уу.

Сэдвийг судлахын ач холбогдол, үр дүн

Энэ сэдвийг судалснаар хувь хүний санхүүгийн шийдвэр гаргах үйл явцад шинжилгээ хийх, хувь хүний санхүүгийн шийдвэртэй холбоотой алдагдсан боломжийн өртгийг тодорхойлох, амьдралын янз бүрийн нөхцөл байдалд хувь хүний санхүүгийн зорилгыг хангах стратегийг тодорхойлох чадварыг эзэмшинэ.

Тулгуур ойлголт

- Алдагдсан боломжийн өртөг
- Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ
- Дампуурал

2.1. Санхүүгийн төлөвлөлтийн үйл явц

Хүн бүр сэтгэл хангалуун, санаа зовох зүйлгүй амьдрахыг хүсдэг. Гэвч үнэндээ хүн бүр идэр залуу насандаа, тэтгэвэрт гарсан хойноо ч тэр хүссэн бүхнээ авч, дэлхий тойрон аялж чаддаг бил үү? Хүн амьдрах хугацаандаа хоол хүнс, машин, орон байр, тавилга эд хогшил худалдаж авах, ахисан түвшний сургалтад хамрагдах, буяны байгууллагад хандив өргөх, аялах зугаалах гээд маш олон төрлийн санхүүгийн зорилго тавьж амьдардаг. Эдгээр болон өөр бусад зорилгодоо хүрэхийн тулд аль нь хамгийн чухал, нэн тэргүүнийх вэ? гэдгийг зөв тодорхойлох хэрэгтэй.

Санхүүгийн хувьд сэтгэл хангалуун байх асуудал бол зохион байгуулалт сайтай хүний оновчтой мөнгөний удирдлага болон санхүүгийн зөв төлөвлөлтийн үр дүн байдаг. Хувь хүний санхүүгийн төлөвлөлт хэд хэдэн давуу талтай. Үүнд:

- Амьдралынхаа турш санхүүгийн нөөцийг оновчтой бүрдүүлэх, хуваарилах, хадгалж хамгаалах бололцоог нэмэгдүүлнэ
- Санхүүдээ хяналт тавьснаар хэрээс хэтэрсэн өр төлбөр, дампуурал, бусдын хараат болохоос хамгаална
- Зөв сайн төлөвлөлт, үр дүнтэй уялдаа холбоо бүхий санхүүгийн шийдвэрийн үр дүнд хувь хүний нийгмийн харилцаа холбоо өргөжин тэлнэ
- Хувь хүн ирээдүйн зардлаа урьдчилан тооцож, санхүүгийн зорилгодоо хүрэх ба санхүүгийн сэтгэл зовоосон асуудлуудаас ангижирч, санхүүгийн эрх чөлөөг мэдэрнэ

Зураг 2-1-д харуулж буй өөр хоорондоо уялдаа холбоо бүхий санхүүгийн төлөвлөлтийн үйл явц амьдралын ямар ч нөхцөл байдалд нийцнэ.

Зураг 2-1. Санхүүгийн төлөвлөлтийн үйл явц⁵

1. Санхүүгийн өнөөгийн нөхцөл байдлаа тодорхойлох. Эхний энэ үе шатанд орлого, хадгаламж, амьжиргааны зардал болон өр төлбөрийн талаар санхүүгийн өнөөгийн нөхцөл байдлаа тодорхойлно. Санхүүгийн төлөвлөлтийн үйл ажиллагаанд зориулж өөрийн мөнгө, бусдаас авах авлага, бусдад өгөх өр төлбөр болон өөрийн мөнгөний зарцуулалтын талаар бүртгэл тооцоо хөтлөх ёстой.

2. Санхүүгийн чухал. Санхүүгийн олон зорилгоос алийг түрүүлж хэрэгжүүлэхийг шийдэх ёстой. Таны санхүүгийн зорилго өнөөгийн бүх орлогоо зарцуулахаас зорилгоо тодорхойлох. Ямар ч хүн санхүүгийн зорилгодоо шинжилгээ хийх нь зүйтэй. Санхүүгийн тодорхой зорилго санхүүгийн төлөвлөлтөд үнэхээр эхлээд хуримтлалаа нэмэгдүүлэх, ирээдүйн санхүүгийн аюулгүй байдлаа хангах хөрөнгө оруулалтын хөтөлбөрийг хэрэгжүүлэх зэрэг өргөн цар хүрээг хамарна.

3. Арга замаа сонгох. Арга замаа оновчтой сонгох нь санхүүгийн шийдвэр гаргалтад чухал нөлөөтэй.

- **Үйл ажиллагааны тогтмол хэвшилд суралцах:** Жишээ нь, сар бүр хадгалах боломжтой мөнгөний хэмжээг тодорхойлох
- **Өнөөгийн нөхцөл байдлаа сайжруулах:** Сар бүр хадгалах мөнгөө өсгөх
- **Одоогийн нөхцөл байдлаа өөрчлөх:** Хадгаламжийн дансны оронд мөнгөний захын данс ашиглах гэх мэт. Мөнгөний захын данс гэдэг нь нэг хүртэлх жилийн хугацаатай хувьцаа, бонд эзэмших боломжтой дансыг хэлдэг
- **Үйл ажиллагааны шинэ арга сонгох:** Сарын хадгаламжийн хүүний орлогоос зээлийн картын өрөө төлөх зэргээр арга замаа сонгох хэрэгтэй.

⁵ Jack R. Kapoor, Les R. Dlabay, Robert J. Hughes "Personal Finance", 2008. p 3

Санхүүгийн шийдвэр гаргахын тулд дээрх арга замуудаас хамгийн зөв сонголтыг хийх нь чухал. Боломжит сонголтуудаас хамгийн оновчтойг сонгох нь үр ашигтай, сэтгэл хангалуун шийдвэр гаргахад тусалдаг. Ер нь ямар нэг арга замыг сонгохгүй, юу ч бодохгүй шийдвэр гаргах нь хамгийн аюултай сонголт байж болох юм шүү.

4. Арга замаа үнэлэх: Амьдралын нөхцөл байдал, хувь хүний амьдралыг үзэх үзэл, эдийн засгийн нөхцөл байдалтай уялдуулан боломжит арга замуудыг үнэлэх хэрэгтэй.

- **Сонголтын үр дүн, ач холбогдлыг үнэлэх:** Ямарваа шийдвэр нөгөө боломжит хувилбарыг ямагт үгүйсгэж байдаг. Жишээ нь, та амралтынхаа мөнгөөр хувьцаанд хөрөнгө орууллаа гэхэд та амралтад амарч чадахгүй байх жишээтэй. Алдагдсан боломжийн өртөг бол хийх гэсэн сонголтоо алдах явдал юм. Энэ нь ерөнхийдөө ямарваа нэг шийдвэр гарахгүйг илтгэх бөгөөд дандаа мөнгөөр илэрхийлэгдэхгүй байж болно.

Алдагдсан боломжийн өртөг:
Сонголт хийх явцад алдсан өөр нэг боломжоос олж болох байсан орлого, ашиг.

Жишээ нь, их сургуульд орсон ч амжилттай төгсөж чадахгүй бол мөнгө, цаг хугацаагаа аль алиныг нь алдахын зэрэгцээ тухайн цаг хугацаанд хийх боломжтой байсан бусад боломжоо ч алдана.

Тиймээс ямарваа шийдвэр гаргахын өмнө алдагдах боломжуудыг заавал тооцох хэрэгтэй. Хувь хүний амьдралын нөхцөл байдал, үнэт зүйлс хүн бүрт ялгаатай болохоор алдагдсан боломжийн өртөг ч мөн өөр өөр байна.

- **Эрсдэлийг үнэлэх:** Хувь хүний санхүүгийн шийдвэр гаргалтын нэг хэсэг нь тодорхой бус байдаг. Их сургуулиудиа аль нэгийг нь сонгох болон мэргэжил сонгоход ч эрсдэлтэй. Тухайлбал, хэрвээ та энэ мэргэжлээр ажиллах дургүй юм уу, ажил олж чадахгүй бол яах вэ? Даатгагдсан хадгаламжийн дансанд мөнгө байршуулах эсвэл бага үнэтэй эд зүйл худалдаж авах зэрэг зарим нэг шийдвэрийн эрсдэл бага байдаг. Мэдээж өндөр үнэтэй эд зүйл алдахаас бага үнэтэй эд зүйл алдах нь эрсдэл багатай.

Ихэнх санхүүгийн шийдвэрүүдэд эрсдэлийг үнэлж, тодорхойлох хэцүү (Хүснэгт 2-1-ийг харна уу) байдаг. Эрсдэлийг тодорхойлох хамгийн сайн арга бол санхүүгийн төлөвлөлтийн мэдээллийн эх сурвалжийг ашиглах, бусдын туршлага болон өөрийнхөө туршлага дээр тулгуурлан мэдээлэл цуглуулах явдал юм.

Хүснэгт 2-1. Эрсдэлийн төрлүүд⁶

Инфляцийн эрсдэл	Үнийн өсөлт эсвэл бууралт нь (дефляци) худалдан авах чадвар өөрчлөгдөх шалтгаан болдог. Аливаа зүйлийг одоо эсвэл дараа худалдан авахаар шийдвэр гаргадаг. Хэрэв дараа худалдан авахаар шийдвэр гаргаж байгаа бол та илүү ихийг төлөх болно.
Хүүний түвшний эрсдэл	Хүүний түвшний өөрчлөлт таны зээлийн хүү болон хадгаламж, хөрөнгө оруулалтын хүүнд нөлөөлдөг. Хүүний түвшин өсөхөд өмнө авсан бага хүүтэй зээл танд давуу тал болно. Харин хөвөгч (хувьсах) хүүтэй зээлийн хувьд илүү их төлбөр төлөх болно. Хэрэв хүүний түвшин буурч байхад хадгаламж хийвэл бага өгөөж хүртэнэ.
Орлогын эрсдэл	Хэрэглээний зардлын өөрчлөлт болон технологийн ашиглалт нэмэгдэхэд ажилгүй болж болох юм. Хувь хүн ажилгүйдлийн эрсдэлд өртөхгүйн тулд хадгаламжтай байх, өөр ажилд орох чадвар эзэмшсэн байх шаардлагатай.
Хувь хүний эрсдэл	Худалдан авалт болон санхүүгийн шийдвэртэй холбоотой нэмэгдэл зардал, хадгалалтын эрсдэл, эрүүл мэндийн эрсдэл хамаарна.
Хөрвөх чадварын эрсдэл	Зарим хадгаламж, хөрөнгө оруулалт өндөр орлоготой байдаг. Гэсэн хэдий ч мөнгө болон хувирах чадвар сул, хугацаанаас нь өмнө үнэ цэнийг нь алдагдуулахгүй борлуулахад хэцүү байдаг.

Санхүүгийн төлөвлөлтийн мэдээллийн эх үүсвэр: Бид хэзээ нэгэн цагт хаа нэг тийшээ аялахад газрын зураг хамгийн чухал хэрэгтэй байдаг шиг санхүүгийн шийдвэр гаргалтын үе шат болгонд холбогдох мэдээлэл шаардлагатай. Хувь хүний, нийгмийн, эдийн засгийн өөрчлөлт мэдлэгээ байнга тасралтгүй дээшлүүлж, шинэчилж байхыг шаарддаг.

5. Санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх. Санхүүгийн төлөвлөлтийн энэ үе шат бол зорилгодоо хүрэх үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэнэ. Жишээ нь, зардлаа багасгах эсвэл нэмэлт ажил хийх замаар орлогоо нэмэгдүүлж, хадгаламжаа өсгөж болох юм. Богино хугацааны шууд зорилгодоо хүрэхэд дараагийн хамгийн чухал зорилго тодорхой болж байдаг. Санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд бусдын туслалцаа хэрэг болж болно. Жишээ нь, эд хөрөнгийн даатгалд хамрагдахад даатгалын зуучлагчийн үйлчилгээ, харин хувьцаа, бонд худалдан авахад хөрөнгө оруулалтын брокерын үйлчилгээ авч болох юм.

6. Санхүүгийн төлөвлөгөөг хянах. Санхүүгийн төлөвлөлт бол тодорхой нэг үйл явдлаар төгсөшгүй, тасралтгүй үйл явц юм. Та санхүүгийн шийдвэрээ байнга үнэлж байхаас гадна жилдээ ядаж нэг удаа санхүүдээ иж бүрэн хяналт тавих ёстой. Хувь хүний, нийгмийн, эдийн засгийн хүчин зүйл өөрчлөгдөх хэрээр байнгын тогтмол үнэлгээ илүү их шаардлагатай болдог.

Амьдралын нөхцөл байдлаас санхүүгийн хэрэгцээ хамаардаг тул санхүүгийн төлөвлөлтийн үйл явц нь дээрх өөрчлөлтүүдэд нийцэх ёстой. Санхүүгийн шийдвэр гаргалтдаа тогтмол хяналт тавих нь амьдралын нөхцөл байдалд тохирсон санхүүгийн зорилгоо хэрэгжүүлэхэд тусална.

⁶ Jack R. Kapoor, Les R. Dlabay, Robert J. Hughes "Personal Finance", 2008. p 5

2.2. Хувь хүний санхүүгийн зорилго

Хувь хүний санхүүгийн сэтгэл хангалуун байдал зөв, оновчтой санхүүгийн зорилгоос эхэлдэг. Дэлхийн хамгийн баян улс орны хүн амд ч мөнгөний асуудал байсаар байна. Асуудал 2 зүйлд байна. Эхнийх нь муу төлөвлөлт болон зээл авч үндсэн хэрэглээгээ хангах зэрэг сул мөнгөний удирдлага бол нөгөө нь борлуулалтын идэвхжүүлэлт, зар сурталчилгаанаас болж байна.

Таны ирээдүйн санхүүгийн хүсэл тэмүүлэлд ерөнхийдөө 2 хүчин зүйл нөлөөлдөг. Нэгдүгээрт, зорилгодоо хүрэхэд шаардагдах цаг хугацаа. Хоёрдугаарт, хэрэгцээнд нийцсэн санхүүгийн зорилгын төрөл хэлбэр.

1. **Зорилгын хамрах хугацаа:** Маргааш юу хиймээр байна? Та маргааш юу хийхээ өнөөдөр аль хэдийнэ мэдэж байгаа юу? Эсвэл үгүй юу? Ерөнхийдөө зорилгыг хугацаанаас нь хамааруулан гурван хэсэгт хуваадаг.

- **Богино хугацааны зорилго:** Бага хэмжээний өр зээлээ төлөх эсвэл амралтандаа зориулан мөнгө хадгалах зэрэг ойрын ирээдүйд хүрчихсэн байх зорилго
- **Дунд хугацааны зорилго:** 2-5 жил хүртэлх хугацааны зорилго
- **Урт хугацааны зорилго:** Тэтгэвэрт гарсан хойноо хэрэглэх зорилгоор эсвэл хүүхдийнхээ боловсролд зориулан мөнгө хадгалах, тавилга эд хогшил худалдаж авах зэрэг таван жилээс дээш хугацааны зорилго

Урт хугацааны зорилго богино болон дунд хугацааны зорилготой уялдаж төлөвлөгдөх ёстой. Богино хугацаанд тавьсан зорилгодоо хүрэх нь урт хугацааны зорилгыг хангах суурь болдог. Жишээ нь: хаус худалдаж авах дунд хугацааны зорилгодоо хүрэхийн тулд хадгаламж хийх нь урт хугацааны зорилгыг хангах нөөц болно. Зорилгын давтамж санхүүгийн төлөвлөлтийн үйл явцад зайлшгүй өөр өөр байдаг. Цагаан сар болон шинэ жилийн бэлэг бэлдэх, амрах зэрэг зарим зорилго жил бүр давтагддаг бол их дээд сургуульд сурах, машин, орон байр худалдаж авах зорилго маш цөөн давтамжтай. Магадгүй, зарим хүн энэ зорилгодоо хүрдэг бол зарим нь хүрч чадахгүй байх ч тохиолдол бий.

2. **Санхүүгийн хэрэгцээний зорилго:** Жил бүр автомашины татвар, даатгалаа төлөх мөнгө хадгалах зорилгоос ахисан түвшний мэргэжил эзэмших сургалтын зорилго мэдээж өөр.

ШИГТГЭЭ

Санхүүгийн 3 гол зорилго:

1. Санхүүгийн хэд хэдэн зорилгоос эрэмбэлж, хамгийн чухал цөөн хэдийг сонгох.
2. Мөнгө, санхүүгээ өсгөх зөв арга хэрэгсэл сонгох. (Хадгаламж, хөрөнгө оруулалт хийх гэх мэт)
3. Өөрчлөлтөд бэлдэх. Нас ахихын хэрээр хүсэл, хэрэгцээ тань өөр болно.

Өргөн хэрэглээний эд зүйлстэй холбоотой зорилго хоол хүнс, хувцас хунар, шоу цэнгээн зэрэг ихэвчлэн богино хугацаанд ашиглагдах эд зүйлсийг хамардаг. Зарим болчимгүй буруу худалдан авалт таны санхүүгийн нөхцөл байдалд сөргөөр нөлөөлнө. Жишээ нь: Хагас сарынхаа цалингаар 1 өдрийн шоунд оролцвол яах вэ? Удаан эдэлгээтэй эд зүйлстэй холбоотой зорилго ихэвчлэн тавилга эд хогшил, спортын хэрэгсэл (гүйлтийн зам) зэрэг харьцангуй өндөр үнэтэй байнга худалдан авах шаардлагагүй эд зүйлстэй холбоотой. Эдгээр хөрөнгийг биет хөрөнгө гэж нэрлэдэг. Биет бус худалдан авалтын зорилго хувь хүний харилцаа холбоо, эрүүл мэнд, боловсрол, чөлөөт цагтай холбоотой. Хүний амьдралын нөхцөл байдлаас үүдсэн зорилго бүр тухайн хүндээ зайлшгүй чухал, хэрэгжүүлэх шаардлагатай зүйл байх ёстой.

Зорилгод суурилсан удирдамж

Ямарваа зорилго тавих нь санхүүгийн шийдвэр гаргалтын цөм юм. Санхүүгийн зорилго нь төлөвлөлт, гүйцэтгэл, зарцуулалт, хадгаламж, хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны үр дүн, ахиц дэвшлийг хэмжих гол үндэс, суурь болдог.

Санхүүгийн зорилго дараах хүчин зүйлд тулгуурлах ёстой. Үүнд:

1. **Бодитой байх.** Орлого, амьдралын нөхцөл байдалд үндэслэсэн. Хэрэв та өдрийн ангийн оюутан бол шинэ машин худалдаж аваад жил бүр солино гэдэг бодитой бус зорилго юм.

ШИГТГЭЭ

“Та өөртөө зорилго тавих нь таны хэдэн настай, амьдралын ямар нөхцөлд байгаагаас үл хамааран биелэх боломжтой зүйл юм. Учир нь таны чадварын 90 хувь нь хэрэглэгддэггүй, олж нээгддэггүй байдаг. Энэ бол маш том боломж”.

Тим Хансэл

2. **Нарийн тодорхой, цаг хугацаагаар хэмжигдсэн байх:** Яг ямар зорилго гэдэгээ мэдэх нь зорилгодоо хүрэх зохион байгуулалттай төлөвлөгөө хийхэд тусалдаг. Жишээ нь: “Хөрөнгө оруулалтын санд мөнгө хийх” гэсэн зорилгоос “3 жилийн дотор 5`000`000 төгрөг хуримтлуулах” зорилго бол төлөвлөлт хийхэд илүү тодорхой зөв хөтөч болно.
3. **Тодорхой цаг хугацааны хязгаарт суурилсан байх:** Зорилгыг хэрэгжүүлэх цаг хугацааны хүрээ хязгаар тавих нь санхүүгийн зорилгын үр дүн, ахиц дэвшлийг тодорхойлоход тусална.
4. **Үйл ажиллагаанд чиглэсэн байх:** Таны санхүүгийн зорилго бол янз бүрийн санхүүгийн үйл ажиллагаа хэрэгжих суурь юм. Жишээ нь: “Зээлийн картын өрөө багасгах” зорилго нь зээлийн хэрэглээг бууруулна.

2.3. Алдагдсан боломжийн өртөг


Ямар нэг зүйлийг хүсч, олж авахын тулд бие сэтгэлээ зориулсан үед л санхүүгийн шийдвэр гаргавал зохистой. Жишээ нь: Ирээдүйн худалдан авалт болон урт хугацааны санхүүгийн аюулгүй байдлаа хангахын тулд өнөөдрийн шаардлагагүй худалдан авалтаас татгалзаж сурах хэрэгтэй.

Хувь хүний алдагдсан боломжийн өртөг нь нэг зүйлийг хийхэд нөгөө зүйлийг хийж чадахгүй байх цаг хугацаагаар илэрхийлэгддэг. Бид цаг хугацааг сурах боловсрох, ажиллах, дэлгүүр хоршоо явах, фейсбүүк ашиглах зэрэг хэрэгтэй, хэрэггүй зүйлээр өнгөрөөж байдаг. Гэтэл цаг хугацаа ч тэр ямар нэг шийдвэрээр хуваарилагдаж байх ёстой юм. Хэрэгцээгээ хангах, зорилгодоо хүрэх, хувь хүнийхээ хувьд сэтгэл хангалуун байхын тулд цаг хугацааг зөв сонгож, ашиглах хэрэгтэй.

Хувь хүний алдагдсан боломжийн өртөг мөн эрүүл мэндтэй холбоотой. Чанаргүй муу хоол хүнс, нойргүйдэл, хөдөлгөөний дутагдал нь өвчлөлд хүргэж, сургууль болон ажлаасаа завсардах улмаар эрүүл мэндийн зардлыг нэмэгдүүлж, санхүүгийн аюулгүй байдлыг алдагдуулдаг. Санхүүгийн нөөцтэй адил хувь хүний нөөц (цаг хугацаа, эрч хүч, эрүүл мэнд, авъяас, мэдлэг чадвар) мөн оновчтой, зөв удирдлагыг шаардана.

Бид үргэлж төрөл бүрийн санхүүгийн шийдвэрээс сонголт хийж байдаг. Ийнхүү сонголт хийхдээ мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг (номын II бүлгийн 4-р сэдвээс дэлгэрүүлэн уншаарай) тооцох нь зүйтэй юм. Өнөөдөр 1 төгрөгөө зарцуулахын оронд хадгаламж, хөрөнгө оруулалт хийх нь ирээдүйн 1 төгрөгнөөс илүү ихийг олох боломжийг олгоно.

Зураг 2-2. Санхүүгийн шийдвэр гаргалт: Алдагдсан боломжийн өртөг болон санхүүгийн үр дүн⁷



⁷ Jack R. Kapoor, Les R. Dlabay, Robert J. Hughes "Personal Finance", 2008. p 15

Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ:
Хүүний өгөөжийн үр дүнд өсөх мөнгөний хэмжээ.

Бид цаг үргэлж зарцуулж, хадгалж, хөрөнгө оруулж эсвэл мөнгө зээлдэж байхдаа мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн зэрэгцээ алдагдсан боломжийн өртгийг тооцох хэрэгтэй болдог.

Тухайлбал, хадгаламжийн данснаасаа мөнгөө авч зарцуулснаар хүүний орлого алдах хэдий ч илүү орлого олох зүйлд хөрөнгө оруулалт хийвэл өгөөж нь илүү байх болно. Зээлээр худалдан авалт хийснээр өнөөдрийн шаардлагатай хэрэгцээгээ хангах ач холбогдолтой боловч алдагдсан боломжийн өртгийн нэг хэлбэр болох зээлийн хүүний зардал төлөхөд хүрдэг. Хангалттай мөнгөтэй байхын тулд тэтгэврийн дансанд жил бүр мөнгө нэмэх нь ашигтай хөрөнгө оруулалтаас олж болох орлогыг алдахад хүргэнэ. Шинэ машин эсвэл эд хогшил худалдаж авах нь хадгаламж, хөрөнгө оруулалтаас олж болох байсан орлогыг алдах шалтгаан болно.

2.4. Санхүүгийн зорилгод хүрэхүй


Бидний амьдралын үндсэн зорилго бол санхүүгийн нөөц эх үүсвэрийг ухаалаг сэтгэл хангалуун ашиглах явдал юм. Санхүүгийн төлөвлөлт тэрхүү нөөцийг хэрхэн олж авах, хадгалах хамгаалах, хуваарилах асуудлыг шийдвэрлэдэг. Хувь хүн санхүүгийн төлөвлөлтийн дагуу үйл ажиллагаагаа зохион байгуулснаар мөнгөтэй холбоотой гардаг энгийн алдаанаас зайлсхийж чадна.

ТАНЫ МЭДЛЭГТ

Хэрвээ та 31 наснаасаа эхлэн жил бүр жилийн 9 хувийн хүүтэй, 2 сая төгрөг хадгалуулбал 65 насандаа 470`429`000 төгрөгтэй болно. Харин 22 наснаасаа 31 нас хүртлээ ердөө 9 жилийн турш жил бүр 2 сая төгрөг, жилийн 9 хувийн хүүтэй хадгалбал 65 насандаа 579`471`000 төгрөгтэй болно. Хамгийн чухал нь: Ямарваа хөрөнгө оруулалтыг яг одоо эхлэх.

Мөн санхүүгийн зорилгоо биелүүлэхэд зохион байгуулалттай төлөвлөлт, оновчтой шийдвэр чухал.

Хувь хүний санхүүгийн төлөвлөлтийн бүрэлдэхүүнийг Зураг 2-3-аас харна уу.

Зураг 2-3. Хувь хүний санхүүгийн төлөвлөлтийн бүрэлдэхүүн хэсэг⁸

Санхүүгийн нөөц бүрдүүлэх: Та ажил хөдөлмөр, бизнес эрхлэх болон хөрөнгө оруулалт хийх замаар санхүүгийн нөөц эх үүсвэрээ олж авдаг. Санхүүгийн нөөц эх үүсвэр бүрдүүлэх нь санхүүгийн төлөвлөлтийн үндэс суурь болох бөгөөд энэ үеэс л санхүүгийн үйл ажиллагаа идэвхждэг.

Төлөвлөлт хийх: Төсөвлөлтийн дагуу төлөвлөж зарцуулах нь ирээдүйн санхүүгийн аюулгүй байдлыг хангах болон зорилгодоо хүрэх түлхүүр. Санхүүгийн шийдвэр буюу зардлаа урьдчилан тооцох нь төлөх татвараа багасгахад ч дэмжлэг болно.

Хадгалах, хуримтлуулах: Урт хугацааны санхүүгийн аюулгүй байдал тооцоолоогүй өр төлбөрийг багасгах, их дээд сургуулийн боловсрол эзэмших, хаус, тансаг эд хогшил худалдан авах зэрэг онцгой тохиолдолд ашиглах тогтмол хадгаламжийн төлөвлөгөөнөөс эхлэх нь зүйтэй. Та хадгаламжийн төлөвлөгөөгөө хийчихсэн хэдий ч санхүүгийн өсөлтийг илүү их дэмжих хөрөнгө оруулалт хийж ч болох юм. Хадгаламжийн мөнгө өрхийн үндсэн хэрэгцээнээс илүү гарсан мөнгөний хэмжээнд байх ёстой.

Зээлдэх: Зээлийн худалдан авалтаар санхүүгийн зорилгодоо хүрэх боломжтой хэдий ч байнгын тогтвортой хяналт тавих шаардлагатай. Зээлийн хэрэглээ хувь хүний зээлээ төлөх чадвараас (номын II бүлгийн 5-р сэдвээс дэлгэрүүлэн уншина уу) шалтгаална.

⁸ Jack R. Kapoor, Les R. Dlabay, Robert J. Hughes “Personal Finance”, 2008. p 21

Дампуурал: *Өр, зээлээ төлөх чадваргүй болсноос хөрөнгө, мөнгөө алдах үйл явц.*

Хувь хүн муу⁹ зээлтэй холбоотойгоор сэтгэл шаналах, санхүүгийн байдал хүндэрч, улмаар дампуурах, зээлийн муу түүхтэй болж, нэр хүндээ алдахад хүргэнэ.

ШИГТГЭЭ

2015 оны эцсийн байдлаар Монгол Улсын хэмжээгээр чанаргүй зээлийн өрийн үлдэгдэл 869`840`60 сая. төгрөг байна.

Зарцуулах: Санхүүгийн төлөвлөлт амьдралын сэтгэл хангалуун байдалд саад болохоор зохион байгуулагдаагүй, харин ч хүссэн зүйлээ олж авахад тусална. Та зардлын төлөвлөгөөндөө суурилан хэрэглээний зардал болон санхүүгийн бусад үүрэг хариуцлагаа тодорхойлох нь зүйтэй. Олсноосоо багыг зарцуулж байж л урт хугацааны санхүүгийн аюулгүй байдлаа хангана.

Эрсдэлээ удирдах: Хувь хүний санхүүгийн төлөвлөлтийн нэг гол бүрэлдэхүүн хэсэг даатгалд үр дүнтэй хамрагдах явдал юм. Манай улсын хувьд цалингаас шууд суутгадаг нийгмийн даатгалаас¹⁰ гадна авто машины даатгалд заавал даатгуулахаас бусад сайн дурын даатгалд хүмүүс тэр бүр хамрагдахгүй байна.

Хөрөнгө оруулах: Хүмүүс үндсэн 2 шалтгаанаар хөрөнгө оруулалт хийдэг. Нэг нь тогтмол ногдол ашиг, хүү төлөх *өнөөгийн орлого* бүхий хөрөнгө оруулалтыг сонирхдог. Нөгөө нь ирээдүйд үнэ цэнэ нь өсөх үл хөдлөх хөрөнгө, хувьцаа зэрэг *урт хугацаанд өсөх* хөрөнгө оруулалтыг сонгодог. Хувьцаа, бонд, үл хөдлөх хөрөнгө, ховор зоосны цуглуулга зэрэгт хөрөнгө оруулах замаар хөрөнгөө тараан байршуулж болно.

Тэтгэврийн болон өв хөрөнгийн төлөвлөлт хийх: Ихэнх хүмүүс тэтгэвэрт гарсны дараах санхүүгийн аюулгүй байдлаа өнөөдрөөс хангахыг хүсдэг. Тэтгэврийн төлөвлөлт бас өрхийн нөхцөл байдал, амралт чөлөөт цаг, хагас цагийн болон сайн дурын ажлын талаар бодоход хүргэнэ. Мөн мөнгө эд хөрөнгийг өв хэлбэрээр бусдад шилжүүлэхдээ хэрэв боломжтой бол бусдын хүлээн авах санхүүгийн нөөцийн үр ашгийг өсгөх, татварын дарамтыг багасгах цаг хугацааг тооцох ёстой. Хөрөнгийн шилжүүлэг хийх талаар мэдлэгтэй байх нь өнөөгийн болон ирээдүйн амьжиргааны зардал, боловсролын зардал, тэтгэвэрт гарсны дараа үр хүүхдийнхээ хэрэгцээг санхүүжүүлэх хамгийн зөв арга замыг сонгоход тусална.

⁹ Монгол Улсын банкны тухай хуулийн хүрээнд зээлийн өр төлбөр 360-аас дээш хоногт төлөгдөхгүй бол муу зээл гэж үздэг.

¹⁰ Нийгмийн даатгал нь эрүүл мэндийн, тэтгэвэрийн, тэтгэмжийн, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний, ажилгүйдлийн даатгалаас бүрддэг.

ШИГТГЭЭ

Санхүүгийн төлөвлөгөөтэй хүмүүс (өөрсдөө эсвэл мэргэжлийн түвшинд хийдэг) төлөвлөгөөгүй хүмүүсээс илүү их хэмжээний хадгаламжтай байдаг.


Санхүүгийн төлөвлөлтийг хэрэгжүүлэх. Санхүүгийн төлөвлөлт хийснээр мөнгөний удирдлагаа оновчтой хэрэгжүүлэх боломжтой. Санхүүгийн төлөвлөгөөгөө хэрэгжүүлэхээс өмнө санхүүгийн зорилгоо тодорхойлж, өнөөгийн нөхцөл байдлаа үнэн зөв тодорхойлох ёстой гэдгийг эргэн саная.

Амжилт дагуулах хамгийн чухал стратеги бол богино хугацаанд сэтгэл хангалуун байх, урт хугацааны санхүүгийн аюулгүй байдлыг хангах дараах дадал зуршлыг хэвшүүлэх явдал юм. Үүнд:

1. Сайтар тооцоолсон зардлын төлөвлөгөө нь ирээдүйд хөрөнгө оруулах, хадгалах орлого бүрдүүлэх нөхцөлийг хангана. Санхүүгийн хүндрэлийн уг сурвалж бол хэрээс хэтэрсэн зарцуулалт.
2. Тохирсон даатгалын хамгаалалттай байх нь санхүүгийн хүндрэлд өртөхөөс хамгаална.
3. Хөрөнгө оруулалт болон татварын талаар мэдээлэлтэй байх нь санхүүгийн нөөц эх үүсвэрээ өргөжүүлэхэд туслана.

Санхүүгийн зорилгодоо хүрэхэд хүсэл тэмүүллээ мэдэх, мэдээллийн оновчтой эх үүсвэр гэсэн 2 зүйл шаардлагатай. Хүсэл тэмүүллээ судлах нь мэдээллийн оновчтой эх үүсвэр сонгоход дэм болно.

Зураг 2-4. Санхүүгийн төлөвлөлт



Сэдвийн дүгнэлт

Санхүүгийн шийдвэр гаргахад хувь хүний санхүүгийн төлөвлөлтийн үйл явц болох одоогийн нөхцөл байдлаа тодорхойлох, санхүүгийн зорилгоо хөгжүүлэх, үйл ажиллагааны арга замаа оновчтой тодорхойлох, арга замаа үнэлэх, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлэх, санхүүгийн төлөвлөгөөг хянах зэргийг хэрэгжүүлэхэд янз бүрийн мэдээллийн эх үүсвэр ашиглах шаардлагатай.

Санхүүгийн зорилго бодитой байх, цаг хугацаагаар хэмжигдэхүйц, үр дүнд суурилсан байх, тодорхой цаг хугацааны хүрээ хязгаартай, үйл ажиллагааг илэрхийлсэн байх ёстой. Хувь хүний алдагдсан боломжийн өртөгт цаг хугацаа, хичээл зүтгэл, эрүүл мэндийн асуудал хамаарна.

Санхүүгийн алдагдсан боломжийн өртөг мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн тооцоололд суурилдаг. Ирээдүйн болон өнөөгийн үнэ цэнийн тооцооллыг хадгаламж, хөрөнгө оруулалт, зээлжүүлэлт, худалдан авалтын шийдвэрийн өсөн нэмэгдэж байгаа үр дүнг тооцоход ашиглах боломжтой.

Санхүүгийн амжилттай төлөвлөлт хувь хүний нөхцөл байдал, нийгэм эдийн засгийн хүчин зүйл ялангуяа инфляци, хүүний хувь хэмжээнд суурилсан хуваарилалт, хадгаламж, хөрөнгө оруулалт, зээлийн стратегитай холбоотой тодорхой зорилгыг шаарддаг.

Бататгах асуултууд:

1. Санхүүгийн шийдвэртэй холбоотой ямар эрсдэл учирдаг вэ?
2. Үр ашигтай санхүүгийн зорилгын 4 үндсэн шинж чанар юу вэ?
3. Найз нөхөд, хамаатан саднаасаа богино болон урт хугацаат санхүүгийн зорилгынх нь талаар асуугаарай. Хүн бүрийн хувьд байдаг энгийн зорилго юу байна вэ?
4. Хувь хүний санхүүгийн шийдвэр гаргалтын дараа яагаад дахин үнэлгээ хийх шаардлагатай вэ?
5. Хувь хүний санхүүгийн төлөвлөлтийн үндсэн бүрэлдэхүүн юу вэ?
6. Санхүүгийн төлөвлөгөөний үндсэн зорилго юу вэ?

СЭДЭВ 3. АЖИЛ МЭРГЭЖЛИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Сэдвийг судлахын ач холбогдол, үр дүн

Энэ сэдвийг судалснаар ажил мэргэжлийн сонголт, төлөвлөлт, шийдвэрт нөлөөлөх хүчин зүйлсийг ойлгож, ажил мэргэжлээ зөв төлөвлөж, оновчтой шийдвэр гаргах чадварыг эзэмшинэ.

Тулгуур ойлголт

- Ажил мэргэжлийн сонголт
- Мэргэжил

3.1. Ажил мэргэжлийн сонголт, түүнд нөлөөлөх хүчин зүйл

Аз жаргалтай хүн сэтгэл хангалуун ажилдаа явж, баяр хөөртэй гэртээ харьдаг гэдэг. Хувь хүний санхүүгийн шийдвэр гаргалтад мэргэжил сонголт болон ажил мэргэжлийн хувьд өсөх боломжтой төлөвлөгөө зайлшгүй чухал. Тиймээс ажил мэргэжлийн сонголтдоо дахин хянаж үзэх хэрэгтэй. Хувь хүнийхээ болон санхүүгийн хувьд сэтгэл хангалуун байх ажлыг сонгох хэрэгтэй хэдий ч зөвхөн мөнгө олох ажил сонгосон хүмүүс сонирхол, боломж, ололт амжилтаа харгалзахгүй ажилладаг. Гэтэл мэргэжлийн хувьд өсөх, дахин суралцах боломжтой мэргэжлийг сонгох боломж бололцоо үргэлж байдаг.

Ажил мэргэжлийн сонголт, шийдвэр гаргалт

***Мэргэжил:** Мэргэжлийн хувьд өсөх, үргэлжлүүлэн сурч боловсрох шаардлагатай, амьдралын баталгаат зүйл.*

Бидний амьдралын дадал, хэвшил, санхүүгийн сонголт олон хүчин зүйлээс хамаардаг боловч хөдөлмөр эрхлэлтийн байдал өдөр тутмын шийдвэрт хамгийн их нөлөөлдөг. Ашиг орлого, ажил төрлийн харилцаа холбоо, чөлөөт цаг маань хүртэл ажлаас шууд хамааралтай.

Ажил мэргэжлийн сонголт, мэргэжлийн хувьд хөгжих боломж ч мөн бусад шийдвэр гаргалттай адил эрсдэл, алдагдсан боломжийн өртөг дагуулдаг. Ажил мэргэжлийн сонголт хувь хүн, нийгэм, эдийн засгийн хүчин зүйлсээс хамаараад тогтмол үнэлгээ хийхийг шаардаж байна. Тухайлбал, зарим хүмүүс мөнгөнөөс илүү сэтгэл хангалуун байх ажлыг сонгодог. Зарим нь хөдөө орон нутагт ажиллах, илүү цагаар хөдөлмөрлөхөд олгох нэмэгдэл шагнал урамшууллаас илүү гэр бүлдээ цаг зав гаргахыг илүүд үзэж байна. Харин зарим гэр бүлийн ээжүүд хүүхдүүдтэйгээ ихэнх цагаа өнгөрөөх зорилгоор зураг хатгамал, оёдол зэрэг гэр бүлийн бизнес эрхэлдэг. Мөн олон арван хүмүүс эрүүл, аюулгүй ажлын байрыг хүсч байна. Энэ мэтчилэн хувийн болон нийгэм эдийн засгийн хүчин зүйлс өөрчлөгдөх тухай бүр ажил мэргэжлийн сонголтдоо дахин үнэлж үзэх хэрэгтэй болдог.

Боловсролын түвшин дээшлэхэд санхүүгийн боломж нэмэгддэг. Түүнээс гадна, боловсрол мэдлэг нэмэгдэх хэрээр ажилгүй болох эрсдэл буурч, ирээдүйн боломжит орлогын хэмжээ өснө. Сургалт, боловсролын үр дүнд олж авах чадварыг хоёр ангилж¹¹ болно. Үүнд:

- 1. Техник ур чадвар:** Тусгай мэргэжлийн сургалт тодорхой мэргэжлийн техник ур чадварыг дээшлүүлдэг. Мэдээллийн технологи, санхүү нягтлан бодох бүртгэл, хууль эрх зүй, эрүүл мэндийн халамж, үйлчилгээ, боловсрол, үл хөдлөх хөрөнгийн үнэлгээ, даатгал, хууль сахиулах салбарын ажил зайлшгүй тусгай мэдлэг мэргэжил, ур чадвар шаардана.
- 2. Ерөнхий чадвар:** Менежер, ажил олгогч, мэргэжлийн зөвлөх үйлчилгээ үзүүлэгсэд мэргэжлийн боловсролоос гадна тодорхой чадвартай байх хэрэгтэй. Эдгээр чадварын заримыг сургуулиас олж болох ч зарим нь зайлшгүй байгууллага, ажлын дадлага, туршлагатай холбоотой байдаг.

Ажилдаа амжилт гаргадаг хүмүүсийн эзэмшсэн нийтлэг ур чадварыг дурдвал:

- Янз бүрийн нөхцөлд байдалд бусадтай хамтран ажиллах чадвартай
- Хийж чадахаасаа илүү сайн хийх хүсэл эрмэлзэлтэй
- Өргөн хүрээний мэдээ, мэдээлэл уншиж судлах сонирхолтой
- Аливаа өөрчлөлтөнд дасан зохицох чадвартай
- Санхүү, нягтлан бодох бүртгэл, маркетингийн суурь мэдлэгтэй
- Компьютер, программ хангамжийн зохих мэдлэгтэй
- Аливаа асуудлыг бүтээлчээр шийдвэрлэх багаар ажиллах чадвартай
- Судалгааны арга техник эзэмшсэн, судалгаа хийх чадвартай
- Бичгийн болон аман харилцааны хэл чадвар сайтай
- Хувь хүний сэтгэл зүй болон бусад учир шалтгааныг ойлгох чадамжтай

Эдгээр ур чадварыг эзэмшсэн хүмүүс хаана ч ажиллах чадвартай байдаг байна.

Хувь хүн ажил, мэргэжлийнхээ хувьд сэтгэл хангалуун байх эсэх нь тухайн хүний авъяас чадвар, сонирхол, төлөвшлөөс шууд хамаардаг. Ер нь хүний өссөн орчин, эзэмшсэн мэдлэг боловсрол, амьдралын хүрээ хувь хүн хэн болохыг тодорхойлдог. Авъяас чадвар бол хувь хүний байгалийн өгөгдөл. Гэхдээ аливаа амжилтын 1 хувь нь авъяас, 99 хувь нь хөдөлмөр гэдэг.

Ачаалал даах, асуудал шийдвэрлэх болон сэтгэн бодох чадвар мөн төрөлхийн байхаас гадна өсч төрсөн орчин, төлөвшилтэй холбоотой байдаг. Харин тухайн хүний ажилдаа хандах дур сонирхлоос сэтгэл хангалуун байдлыг тодорхойлж болно. Мөн тухайн хүний төрөлх зан ааш, төлөв байдал (темпрамент¹²) мэргэжил

¹¹ Jack R. Kapoor, Les R.Dlabay, Robert J. Hughes "Personal Finance" tenth edition, 2010. p 42

¹² Эртний грекийн эмч Гиппократ темпраментийг хүний анатоми физиологийн болон сэтгэл зүйн хувийн байгалийн онцлог гэж үзсэн ба сангвиник бол сэргэлэн эрэмгий хэв шинжийн хүн, флегматик бол тайван дөлгөөн, холерик бол тогтворгүй шаралхуу, цочмог ууртай, меланхолик нь бүрэг номой, буурьтай дүнсгэр хэв шинжийн хүн гэж үзэж байсан байна.
http://chrit_child.blog.gogo.mn/read/entry291818 (Нийтлэлч Т.Ганбат)

сонголт болон ажлын байрыг тодорхойлоход чухал нөлөөтэй. Тухайлбал, хүчтэй нийгмийн хандлага бүхий хүмүүс сургалт, судалгаа шинжилгээ хийх, мөрдөн байцаах ажилд илүү амжилт гаргадаг байна.

Хүн ам зүйн болон газар нутгийн чиг хандлага ажлын байранд зайлшгүй нөлөөлдөг. Тухайлбал, уул уурхайн салбарт эрчүүд ажиллах хандлага илүү бол эрүүл мэндийн салбарт эмэгтэйчүүд илүү их ажилладаг. Хөдөлмөрийн зах зээлд нөлөөлж буй хүн ам зүйн чиг хандлагаас дурдвал:

- Өрх толгойлсон эцэг, эхийн тоо өсөх хэрээр хүүхдээ асран хамгаалах, хүмүүжүүлэх зайлшгүй шаардлагын зэрэгцээ нэмэлт орлого олох давхар ажлын хэрэгцээ үүсдэг
- Хүн амын янз бүрийн бүлгийн чөлөөт цаг нэмэгдэхийн хэрээр хувь хүний эрүүл мэндэд чиглэсэн бие бялдар, амралт чөлөөт цагийн бүтээгдэхүүн, үйлчилгээний хэрэгцээ нэмэгддэг.
- Хүмүүс урт насалж, удаан амьдрах тусам аялал жуулчлал, эрүүл мэндийн бүтээгдэхүүн үйлчилгээний эрэлт өсдөг
- Ажил олгогчдоос ажилтан албан хаагчдадаа зориулсан сургалт нэмэгдэхийн хэрээр багш, тодорхой чиглэлийн сургагч нар болон холбогдох мэргэжлийн хүмүүст илүү боломж олгоно

Мөн газар нутаг, мэргэжил, салбарын онцлогоос хамааран цалингийн түвшин ялгаатай байдаг. Тухайлбал, манай орны хувьд өнөөгийн байдлаар уул уурхайн салбар, шүүхийн байгууллагын цалин хөлс харьцангуй өндөр байна. Хүүний түвшин нэмэгдэх (тухайлбал бодлогын хүү¹³), үнэ өсөх болон бараа ажил, үйлчилгээний эрэлт буурах нь зайлшгүй ажил мэргэжилд нөлөөлдөг. Жишээ нь: Орон сууцны үнэ харьцангуй өндөр¹⁴, зээлийн шаардлага хэт өндөр, борлуулалт бага байгаатай холбоотой барилгын салбарын хөдөлмөр эрхлэлт өмнөх үетэй харьцуулахад харьцангуй буурч байна.

3.2. Ажил мэргэжлийн төлөвлөлт хийх

Аливаа хүн ажил мэргэжлээ дараах үе шатаар төлөвлөх нь зүйтэй. Үүнд:

1. Хувь хүний зорилго, боломж чадвараа үнэлэх
2. Хөдөлмөрийн зах зээл болон тодорхой ажлын байрны эрэлт хэрэгцээг үнэлэх
3. Боломжит ажлын байранд хүсэлт гаргах, холбогдох материалаа хүргүүлэх
4. Ярилцлаганд орох, ярилцлагынхаа үр дүнг үнэлэх

¹³ Монгол банк бодлогын хүүгээ 10.5 хувиас 15 хувь болгож өсгөсөнөөр арилжааны банкууд зээл гаргах мөнгөө Төв банкинд хадгалах сонирхолтой болж, улмаар иргэд, байгууллагын авах зээлийн хүү нэмэгдэх хандлагатай болно. Энэ нь бизнес эрхлэлт, улмаар хөдөлмөрийн зах зээлд сөргөөр нөлөөлдөг. Тухайлбал, аливаа бизнесийн зардал нэмэгдвэл үнэ өсч, улмаар бараа, ажил, үйлчилгээний эрэлт буурна.

¹⁴ Өнгөрсөн үетэй харьцуулахад харьцангуй буурч байгаа ч худалдан авах чадвартай харьцуулахад өндөр байсаар байна.

5. Санал болгосон ажлын байрны санхүүгийн болон бусад хүчин зүйлсийн үнэлгээ хийх
6. Ажил мэргэжлийн хувьд ахиж дэвших хөтөлбөр төлөвлөх, хэрэгжүүлэх.

Ийнхүү ажилд орсны дараа магадгүй дахиад ажил мэргэжлээ өөрчлөх эсвэл өөр салбарт хүч үзэх, албан тушаал ахих шаардлага гарч болно. Хүмүүс дараах 2 шалтгааны улмаас өөрийн бизнесийг эхлүүлэх сонирхол төрж эхэлдэг байна.

- (1) Тухайн ажил мэргэжлийн хүрээнд ажил эрхлэх боломж буурах;
- (2) Ажиллах орчиндоо өөрөө хяналт тавьж, удирдахыг хүсэх

ТАНЫ МЭДЛЭГТ

Жижиг, дунд бизнес эрхлэгч аж ахуйн нэгжүүд хамгийн ихдээ II ажилтантай бөгөөд улсын хэмжээгээр 1-9 ажилтантай 57`198 (2016 оны II улирал) аж ахуйн нэгж байна.

Хэрвээ та бизнес эрхлэхээр төлөвлөж байгаа бол гурван гол зүйлийг анхаарах хэрэгтэй. Нэгдүгээрт, эрхлэх гэж байгаа бизнес бүтээгдэхүүн, үйлчилгээнийхээ талаар мэдлэгтэй болох. Хоёрдугаарт, боломжит худалдан авагчдыг тодорхойлох, тохиромжтой байршлыг сонгох болон өрсөлдөгчөө судлах. Эцэст нь, санхүүгийн оновчтой эх үүсвэр сонгоход анхаарлаа хандуулах нь зүйтэй. Ер нь бизнес эрхлэгчдийн амжилтын гол үндэс бол бизнес төлөвлөгөө гэдгийг анхаарах хэрэгтэй. Бизнес төлөвлөгөө нь санхүүгийн тооцоо таамаглал, бараа бүтээгдэхүүний тоо мэдээлэл, маркетингийн төлөвлөгөөний хэсгээс бүрддэг. Мөн ирээдүйн бизнестээ амжилт гаргахад шинжлэх ухааны болон техникийн сэтгүүл, санхүүгийн мэдээ мэдээлэл уншиж судлах, харилцааны ур чадвараа дээшлүүлэх нэн тэргүүний шаардлагаас гадна компьютер болон хэлний мэдлэгээ нэмэгдүүлэх хэрэгтэй.

Ажил хайж байгаа хүмүүсийн нийтлэг асуудал нь ажлын дадлага туршлага дутмаг байдагтай холбоотой. Ялангуяа одоо үед дийлэнх байгууллага 2-оос доошгүй жил ажилласан байхыг шаарддаг. Тэгэхээр оюутан ахуй цагтаа цагийн болон сайн дурын ажил, хөдөлмөр эрхэлж, дадлага туршлага хуримтлуулах нь зүйтэй. Нийгмийн болон хүмүүнлэгийн аливаа сайн дурын ажилд оролцох нь зохион байгуулах ур чадварыг тань нэмэгдүүлж байдаг. Мөн суралцаж байх хугацаандаа үйлдвэрлэлийн дадлага хийх нь танд туршлага болно. Одоо ихэнх их, дээд сургуулиуд тухайн мэргэжлийн чиглэлээр хийх танилцах болон үйлдвэрлэлийн дадлагыг сургалтын хөтөлбөртөө тусгасан байна. Түүнээс гадна их, дээд сургуулиудын профессорын судалгаанд туслах судлаачаар ажиллах нь зорилготой болох, үйл ажиллагааг төлөвлөх, зохицуулах, хяналт тавих, багаар ажиллах, судалгаа шинжилгээ хийх дадал эзэмших ач холбогдолтой.

Аливаа хүний эзэмшсэн мэргэжил насан туршийнх нь хоол олох чухал зэмсэг учраас мэргэжлээ өөрийн болгож, эзэмших нь хамгийн чухал. Ажил, мэргэжилдээ ахиж дэвших асуудал зөвхөн таниас л шалтгаалах болохоор мэдлэг, чадвараа

байнга дээшлүүлж, дуртай ажлаа хийх нь хамгийн чухал. Өөртөө зорилго тавьж, зорилт дэвшүүлэн цаг хугацааг оновчтой удирдах нь таны амжилтын гол түлхүүр байх болно.

Цаг тухайд нь ажлаа чанартай гүйцэтгэх нь магтаал сайшаал, шагнал урамшууллыг харамгүй дагуулдаг. Цаг хугацаа улирахын хэрээр ажил олгогчид илүү чадварлаг боловсон хүчин шаардах болсон нь өрсөлдөгчдөөсөө илүү боловсрол мэдлэг эзэмших хэрэгтэйг танд сануулж байна. Ажил мэргэжилдээ ахиц гаргах, санхүүгийн эрх чөлөөнд хүргэх гол чухал зүйл бол чадварлаг эзэмшсэн мэдлэг, мэргэжил байдаг болохоор сайн сурч, боловсрохын сацуу өдөр тутам шинийг мэдэж, эх дэлхийтэйгээ хөл нийлүүлэх хэрэгтэй. Өнөөдөр шинжлэх ухаан технологийн дэвшлийн ачаар сурч, боловсрох боломж асар их, мэдлэг, мэргэжлээ дээшлүүлэх боломж маш олон байна. Тухайлбал,

- Мэргэжлийн байгууллагаас санал болгодог семинар, хөтөлбөрт хамрагдах
- Их, дээд сургуулийн ахисан түвшний сургуульд суралцах зэрэг албан ёсны боломж
- Хамт олонтойгоо хамтран хэлэлцэх, зангиагүй ярилцлага хийх, ном, сонин, сэтгүүл уншиж судлах, судалгаа шинжилгээ хийх зэрэг албан бус аргууд ч байдаг

Ажил мэргэжлээ өөрчлөх нөхцөл боломж, шаардлага

Санхүүгийн шийдвэрийн нэг адил, ажил мэргэжлийн сонголт нийгэм эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж өөрчлөгддөг. Ажил мэргэжлээ өөрчлөх, ахиц дэвшихтэй холбоотой тухайн салбарынхаа мэргэжлийн хүний дэмжлэг авах нь туйлын чухал. Ялангуяа, та шинээр бизнес эрхлэх гэж байгаа бол менторын дэмжлэг авах хэрэгтэй. Ментор гэдэг бол сургалт судалгааны байгууллагад ажилладаг, таны бизнесийн хөтөч гэж хэлж болох юм. Ментор зөвхөн танд зориулсан сургалт явуулж, хүнд хэцүү цаг үед чинь сэтгэл санааны дэмжлэг үзүүлж чадна.

Одоо ихэнх байгууллага шинэ ажилтны ажил, үр дүнг үнэлэх зорилгоор туршлагатай ажилтанд шинэ ажилтныг дагалдуулж байна. Мөн их, дээд сургууль, боловсролын байгууллагад өөрсдийн мэдлэг, туршлагаа хуваалцах хүсэлтэй тэтгэвэрт гарсан эрдэмтдийг татан оролцуулж байна. Ихэнх хүмүүс амьдрал ахуйгаа дээшлүүлэх зорилгоор ажлын байраа өөрчилдөг. Гэсэн хэдий ч энэ нь өмнөхөөс илүү хүнд ажил байхыг үгүйсгэх аргагүй. Ялангуяа сэтгэл санааны дарамтад орох, бие махбод өвдөх аюул учирч болзошгүй учраас сайн бодож шийдвэрлэх хэрэгтэй. Дараах үзүүлэлт ажил мэргэжлээ өөрчлөх цаг болсон эсэхийг харуулдаг. Үүнд:

- ✓ Та ажилдаа явахдаа сэтгэл тань бага зэрэг л хөдөлдөг
- ✓ Ажлаасаа болж биеийн болон сэтгэл санааны хүндрэл амсдаг

- ✓ Үр дүнгийн үнэлгээ тасралтгүй муудаж байгаа
- ✓ Хамт олны уур амьсгал хүйтэн хөндий
- ✓ Цалин суутгахаас бус нэмэгдэл шагнал урамшуулал байхгүй
- ✓ Албан тушаал ахих тухай саналтгүй
- ✓ Удирдах албан тушаалтантайгаа муу харилцаатай
- ✓ Авч буй цалиндаа сэтгэл хангалуун бус байдаг
- ✓ Ажлын ачаалал их
- ✓ Илүү цагаар ажиллах боловч үнэлэмж байхгүй
- ✓ Өөрийгөө хөгжүүлэх боломж байхгүй
- ✓ Ажиллагсдын нийгмийн асуудлыг анхаардаггүй
- ✓ Ажил үүргийн хуваарь давхардалтай
- ✓ Удирдах албан тушаалтан харилцааны соёлгүй

Дээрх үзүүлэлтийн ихэнхтэй та санал нийлж байвал ажлаа өөрчлөх цаг болжээ. Гэхдээ та шинэ ажилд орохоосоо өмнө тухайн ажил мэргэжлийн чиг баримжаа олгох сургалтанд хамрагдах нь их чухал гэдгийг анхаарах хэрэгтэй. Мөн түүнээс гадна дахиад шинэ ажилд орох өмнөхөөс чинь илүү хэцүү гэдгийг санахад илүүдэхгүй. Тиймээс, хэрвээ та ажлаа өөрчлөх гэж байгаа бол дараах зааврыг дагаарай.

Нэгдүгээрт, өрх гэрийн болон өөрийнхөө зорилго, хэрэгцээтэй холбоотой ажил мэргэжил өөрчлөгдөхөд гарах өртөг зардал,¹⁵ үр ашгийг маш зөв үнэлэх хэрэгтэй. Хоёрдугаарт, ажил мэргэжил өөрчлөгдөхөд таны болон гэр бүлийн гишүүдийн зорилго, хэрэгцээ өөрчлөгдөх эсэхийг тодорхойлох хэрэгтэй. Эцэст нь эргэлзээгүй шийдсэн бол шинэ ажлын байраа хайхдаа дараах зүйлсэд анхаарал хандуулах нь зүйтэй.

- ✓ Тохиромжтой хоол идэх, унтах, дасгал сургууль хийх
- ✓ Олон нийтийг хамарсан үйл ажиллагаанд оролцох, албан ёсны сургалтад хамрагдаж, мэдлэг мэргэжлээ дээшлүүлэх
- ✓ Ашгийн өндөр өсөлттэй салбар болон жижиг дунд бизнес эрхлэгчдийн хүрээнд судалгаа хийх
- ✓ Ашгийн бус байгууллага, засгийн газрын агентлаг, гэрээт ажил болон зөвлөх үйлчилгээний ажилд орох боломж байгаа эсэхийг тодорхойлох
- ✓ Тухайн байгууллагын хэрэгцээнд нийцэх дадлага туршлага, чадвар эзэмших хэрэгтэй

¹⁵ Санхүүгийн хувьд гарах өртөг, зардлаас гадна бие махмодын хувьд гарах хүндрэлийг тооцох хэрэгтэй.

Сэдвийн дүгнэлт

Хувь хүний сонирхол, чадвар сэтгэл хангалуун амьдралын үндэс суурь гэдгийг ойлгох нь чухал. Ажил хөдөлмөр эрхлэх боломж, мэргэжил сонголтод хувь хүний зорилго, чадвар, сонирхол, дадлага туршлага, мэдлэг боловсролоос гадна нийгэм эдийн засаг, хүн ам зүйн хүчин зүйлс нөлөөлнө.

Ажил мэргэжлийн төлөвлөлт, амжилтад хүрэх үйл ажиллагаа нь хувь хүний зорилго, боломжийг үнэлэх, хөдөлмөрийн зах зээл болон тодорхой мэргэжлийн ажил эрхлэх боломжийг үнэлэх, боломжит ажлын байранд хүсэлт гаргах, тодорхой мэргэжлийн албан тушаалтантай ярилцлагад орох, танд санал болгож байгаа ажлын байранд санхүүгийн болон бусад үнэлгээ хийх, ажил мэргэжлийн хувьд ахиц дэвших төлөвлөгөө боловсруулж, хэрэгжүүлэх гэсэн үе шатаас хамаардаг.

Бататгах асуултууд:

1. Ажил, мэргэжлийн сонголт, шийдвэр гаргалттай холбоотой гарах алдагдсан боломжийн өртгийг тодорхойлно уу.
2. Ажил эрхлэхэд шаардлагатай хамгийн үнэ цэнэтэй чадвар юу вэ?
3. Ажил, мэргэжлийн сонголтод нөлөөлөх хүн ам зүйн болон нийгэм эдийн засгийн хүчин зүйлсийг тодорхойлно уу.
4. Ажил, мэргэжлийн хувьд ахиц, дэвшил гаргахад шаардлагатай зүйлсэд юу орох вэ?
5. Ажил, мэргэжлээ өөрчлөхөөс өмнө хувь хүний анхаарах зүйлсийг дэлгэрүүлэн тайлбарлана уу.

БҮЛЭГ II. МӨНГӨ, МӨНГӨНИЙ ҮНЭ ЦЭНЭ

СЭДЭВ 4. МӨНГӨНИЙ ЦАГ ХУГАЦААНЫ ҮНЭ ЦЭНЭ

Сэдвийг судлахын ач холбогдол, үр дүн

Энэ сэдвийг судалснаар инфляцийн үзүүлэх нөлөө, хүү, түүний тооцоолол, мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн талаар ойлголттой болж, уг мэдлэгээ санхүүгийн шийдвэр гаргахдаа ашиглах чадварыг эзэмшинэ.

Тулгуур ойлголт

- Мөнгө
- Инфляци
- Дефляци
- Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ
- Ирээдүйн үнэ цэнэ
- Өнөөгийн үнэ цэнэ
- Нэрлэсэн хүү
- Бодит хүү
- Энгийн хүү
- Нийлмэл хүү
- Хэрэглээний зардал
- Хүү

4.1. Мөнгөний мөн чанар, үүрэг

Мөнгө нь нийгмийн харилцааны чухал сэдэв болохыг өмнө дурдсан билээ. Хүн төрөлхтний түүхийн явцад хөдөлмөрийн хуваарь нарийсах тусам барааг бараагаар солих явдал солилцооны үйл явцыг хүндрүүлэх болсон учир түгээмэл солилцооны хэрэгслийн үүргийг гүйцэтгэж чадах ямар нэг барааг сонгон авч, ашиглах шаардлага зүй ёсоор үүсчээ. Хүн төрөлхтөн ийм үүрэг гүйцэтгэж чадах хэрэгслийг бий болгосон нь мөнгө юм.

Мөнгө: Түгээмэл тэнцэгчийн үүрэг гүйцэтгэгч, хэрэгцээний өртөг бүхий онцгой таваар

Түүхэн хөгжлийнхөө явцад мөнгө нь эд бараан, металл, зоосон, цаасан, дансны, электрон мөнгө гэх мэт хэлбэрүүдийг дамжин хөгжиж иржээ.

Мөнгө бол бараа, үйлчилгээний үнэ, өр төлөхөд ашигладаг хэрэгсэл юм. Мөнгийг худалдаж, арилжиж болох бүх зүйлтэй солигдох онцгой таваар гэж хэлж болно.

Мөнгө нь дараах үндсэн шинж чанарыг агуулдаг. Үүнд:

- Бүх нийтэд хүлээн зөвшөөрөгдсөн байх
- Авч явахад хялбар, овор хэмжээний хувьд бага байх
- Тоологдохуйц байх
- Нэг төрлийн байх
- Үнэ цэнэтэй байх ёстой

Мөнгөний мөн чанар нь түүний ямар үүрэг гүйцэтгэж байгаагаар тодорхойлогддог.

Мөнгө нь дараах хэрэгслийн үүргүүдийг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Өртгийн хэмжүүр буюу тооцооны
2. Гүйлгээний буюу арилжааны
3. Төлбөрийн
4. Хуримтлалын

Аливаа бараа бүтээгдэхүүн, ажил үйлчилгээ өөрийн гэсэн өртөг, үнэтэй байдаг бөгөөд түүнийг мөнгөөр илэрхийлдэг. Энэ нь эдийн засгийг нэг хэмжүүрээр илэрхийлэхэд тусална.

Харин бараа, ажил үйлчилгээг мөнгөөр сольж арилжиж байгаа нь мөнгө гүйлгээний хэрэгслийн үүрэгтэй болохыг илтгэнэ. Мөнгө арилжааны хэрэгслийн үүрэг гүйцэтгэснээр цаг хугацаа болоод бусад зардлыг бууруулах замаар эдийн засгийн үр ашигтай байдлыг нэмэгдүүлнэ.

Зээл, хүүний төлбөрийг мөнгөөр төлдөг. Энэ нь мөнгө өр, төлбөрийг төлөх хэрэгсэл болохыг харуулна.

Мөнгө нь хуримтлал үүсгэх үндсэн хэрэгсэл болдог. Учир нь мөнгө хөрвөх чадвар хамгийн өндөртэй санхүүгийн хэрэгсэл юм.

ШИГТГЭЭ

Морь унаж, сэлэм барьсан баатар эрийн дүртэй цаасан мөнгөн тэмдэгтийг Чингис хаан 1227 онд гүйлгээнд гаргасан тухай Хятадын эрдэмтэн Фэн Син Вей, Японы эрдэмтэн И.Кого (Дорнод Азийн мөнгөний дипломи бичиг 1938) нар батлан бичжээ. Иймээс Монголчууд дэлхийд анх удаа цаасан мөнгө гаргасан гэж үзэх үндэслэлтэй юм.

Мөнгө нь хувь хүний санхүүгийн шийдвэр гаргалтад өөрийн гэсэн үүргийг гүйцэтгэнэ. Тухайлбал, бараа, үйлчилгээг худалдах, худалдан авах, хуримтлал үүсгэх, хөрөнгө оруулалт хийх, зээл болон бусдад өгөх өглөгийг төлөх, өөрийн санхүүгийн төлөвлөгөө, төсөв зохиох гэх мэт бүхий л үйл ажиллагаанд мөнгө өөрийн үүргийг гүйцэтгэж байдаг. Иймээс мөнгөний мөн чанар, үүргийн талаар ойлгож мэдэх нь санхүүгийн зөв шийдвэр гаргахад чухал ач холбогдолтой.

Эдийн засаг: *Хязгааргүй хэрэгцээг хязгаарлагдмал нөөцөөр хэрхэн хангах талаар судалдаг шинжлэх ухаан.*

Хувь хүний санхүүгийн шийдвэр гаргалтад нөлөөлдөг нэг чухал хүчин зүйл нь эдийн засгийн нөхцөл байдал юм.

Эдийн засаг нь хөрөнгө баялаг хэрхэн үүсч, хуваарилагддаг талаар судалдаг шинжлэх ухаан. Санхүү, мөнгөний үйл ажиллагааг зохицуулж, бодлого тодорхойлдог Засгийн газрын байгууллага аль ч улс оронд ажилладаг. Манай орны хувьд Төв банк (Монголбанк) төрийн мөнгөний бодлогыг тодорхойлж, хүүний ерөнхий түвшин болон зайлшгүй байх нөөцийн хувь хэмжээг тогтоох, үнэт цаас гаргаж нээлттэй зах зээл дээр үйл ажиллагаа явуулах замаар мөнгөний бодлого хэрэгжүүлдэг. Төв банкны мөнгөний бодлогын дээрх арга хэрэгслүүд шууд болон дам байдлаар хувь хүний хадгаламж болон авах зээлийн хэмжээнд нөлөөлдөг байна.

4.2. Мөнгөний ханш уналт, түүний үр нөлөө

Өнөөдөр хэдэн арван жилийн өмнө 100 төгрөгөөр тэр үед авч байсан хэмжээний зүйлийг худалдан авах боломжгүй болсныг бүгд мэднэ. Өөрөөр хэлбэл бүх зүйлийн үнэ нэмэгдэж, мөнгөний ханш унасан байна. Ханш уналт бол эдийн засгийн бодлого боловсруулдаг хүмүүс болон эдийн засагчдад тулгардаг хамгийн эдрээтэй асуудал бөгөөд мөнгөний үнэ цэнийн өөрчлөлтөөр дамжин хүмүүсийн амьжиргааны зардалд нөлөөлдөг.

Хэрэглээний үнийн индекс: Өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн жилийн өсөлтийг хэмждэг үзүүлэлт.

Хүн амын амьжиргааны зардал болон мөнгөний үнэ цэнийн өөрчлөлтийг хэрэглээний үнийн индекс (цаашид ХҮИ гэх) гэсэн үзүүлэлтээр хэмждэг. Өөрөөр хэлбэл, ХҮИ нь таны түрийвчинд байгаа мөнгөний үнэ цэнэ хэрхэн өөрчлөгдөж байгаа талаар мэдээлдэг.

Ихэнх хүмүүс зайлшгүй үндсэн хэрэгцээндээ (хоол хүнс, эрүүл мэнд, түлш шатахуун) дийлэнх мөнгөө зарцуулдаг тул өргөн хэрэглээний бус бусад барааны үнийг бодвол өргөн хэрэглээний барааны үнэ илүү их өсөх хандлагатай байдаг. Хэрэглээний үнийн индексийн мэдээллийг Статистикийн эмхэтгэл болон www.1212.mn сайтаас авч болно. ХҮИ-ийг дараах томъёогоор олно.

$$\text{ХҮИ} = \frac{\text{тухайн оны үнээр тооцсон хэрэглээний сагсны өртөг}}{\text{суурь оны үнээр тооцсон хэрэглээний сагсны өртөг}} \times 100$$

ХҮИ-ийг өөр өөр цаг хугацааны мөнгөний ханшийг харьцуулахад ашигладаг. Жишээ нь: 2011 оны 500`000 төгрөгийн цалин 2014 оны хэдэн төгрөгийн цалинтай тэнцэх вэ? Үүнийг тооцоход 2010 оны болон 2014 оны үнийн түвшин буюу ХҮИ-ийг мэдэх хэрэгтэй. Статистикийн мэдээллээс үзэхэд 2011 оны ХҮИ 108.9 хувь, 2014 оны ХҮИ 154.3 хувь байна. 2011 оны 500`000 төгрөгийн орлогыг 2014 оны ханшаар илэрхийлбэл,

$$\begin{aligned} \text{2014 оны цалин} &= \frac{\text{2011 оны цалин} \times \text{2014 оны үнийн түвшин}}{\text{2011 оны үнийн түвшин}} \\ &= \frac{500`000 \times 154.3}{108.9} = 708`448\text{₮} \end{aligned}$$

Энэ нь 2011 оны 500`000 төгрөгийн цалин нь 2014 оны 708`448 төгрөгтэй тэнцүү байна гэсэн үг.

Үнийн тогтвортой байдал гэж мөнгө үнэ цэнээ тогтвортой хадгалж, үнэ тогтмол байхыг хэлнэ. Гэтэл ямар ч улсын эдийн засаг дахь хэрэглээний үнэ байнга тогтвортой байдаггүй тул бараа, ажил, үйлчилгээний үнэ өөрчлөгдөж байдаг. Ханш уналтын үр нөлөө нь мөнгөний үнэ цэнийг өөрчилдөг. Ханш уналт өндөр байх нь хүмүүсийн орлого болон хадгаламжийн бодит үнэ цэнэ буурч үнэгүйдэж байна гэсэн үг. Энэхүү өөрчлөлтийг инфляци, дефляци гэсэн үзүүлэлтээр илэрхийлдэг.

Инфляци: Үнийн ерөнхий түвшний өсөлт.

Дефляци: Инфляцийн эсрэг зүйл бөгөөд үнийн ерөнхий түвшин буурах үйл явц.

Инфляци нэмэгдэхийн хэрээр төгрөгийн худалдан авах чадвар буурна. Инфляцийн үндсэн шалтгаан нь бараа, үйлчилгээний эрэлтийг нийлүүлэлт нь хангаж чадахгүй байх явдал юм.

Инфляцийн өсөлт тогтмол орлоготой хүмүүст илүү хүчтэй нөлөөлдөг. Хэрэв инфляцийн үед хүмүүсийн орлого тогтмол байвал худалдан авах бараа, үйлчилгээний хэмжээ нь багасдаг. Инфляци мөнгө зээлдүүлэгчдэд сөрөг нөлөөтэй. Инфляци ихтэй үед зээлдүүлсэн мөнгөний худалдан авах чадвар буурч, зээлдүүдэгчид өндөр хүүтэй зээл олгохоос өөр аргагүй болдог. Өөрөөр хэлбэл, зээлдүүлэгч инфляцийн түвшнээс өндөр хүүтэй зээл олгохгүй бол түүнд ашиг гарахгүй. Энэ шалтгааны улмаас инфляцийн түвшин өндөр үед хүүний түвшин зайлшгүй өсдөг.

ТАНЫ МЭДЛЭГТ

Манай улсын инфляцийн түвшин 1992 оны эцэст 325.5 хувьд хүрсэн нь хамгийн өндөр үзүүлэлт юм. Харин 1998 онд нэг оронтой тоонд буюу 6 хувьд хүрч байжээ. Инфляцийн хувь хэмжээг хугацаан цуваагаар www.1212.mn сайт буюу статистикийн эмхэтгэлээс авна уу.

Инфляцийн түвшин янз бүр байж болох ч тухайн жилийн инфляцийн хувиар тооцвол үнэ хэдэн жилийн дараа 2 дахин өсөхийг 72-ын дүрэм¹⁶ ашиглан тооцох боломжтой.

ТАНЫ МЭДЛЭГТ

“72-ын дүрэм”-ийг ашиглан тооцвол, жилийн инфляци 4 хувь байхад 18 жилийн дараа ($72:4=18$) үнэ 2 дахин өснө. Хэрэв 6 хувийн хүүтэй хадгаламж хийвэл таны мөнгө 12 жилийн дараа ($72:6=12$) 2 дахин өсөх болно.

Харин дефляци бол ард иргэдийн худалдан авах эрэлт хэрэгцээ буурснаас шалтгаалж, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчид бараа, ажил үйлчилгээнийхээ үнийг хямдруулж, алдагдал хүлээхэд хүрдэг үйл явц. Дефляци нь инфляцийг бодвол хувь хүний амьжиргаанд эергээр нөлөөлөх мэт боловч ажил олгогчдын алдагдал нь ажилтан албан хаагчдынхаа тоог цөөлөхөд хүргэж, улмаар эдийн засагт ажилгүйдэл нэмэгдэн, ядуурлын түвшинг өсгөхөд хүргэдэг.

Хэрэглээний зардал: Эдийн засаг дахь бараа, үйлчилгээний нийт эрэлт.

Эдийн засаг дахь бараа, үйлчилгээний нийт эрэлт нь хүн амын ажил эрхлэлт, орлогын түвшнээс хамаардаг.

¹⁶ Jack R. Kapoor, Les R. Dlabay, Robert J. Hughes “Personal Finance”, 2008. p 14.

Хувь хүний санхүүгийн нөөц нэмэгдэхийн хэрээр хэрэглэгчийн худалдан авалт өсдөг бол компанийн санхүүгийн нөөц багасснаар ажилгүйдэл нэмэгдэж, түүний үр дүнд хэрэглээний зардал буурдаг.

4.3. Хүү, түүний тооцоолол

Энгийнээр тодорхойлвол, хүү нь мөнгөний үнийг илэрхийлдэг. Хүү бол мөнгө (зээл, хадгаламж, хөрөнгө оруулалт)-ний үнэ бөгөөд мөнгө, хөрөнгө эзэмшигчдийн хувьд орлого, ашиглагчийн хувьд зардал юм. Хадгаламж эзэмшигчдийн хувьд хүлээж авах хүүний орлого хүлээгдэж байгаа инфляци, хадгаламж эргэн төлөгдөхгүй байх эрсдэл зэргийг тооцож, тухайн эх үүсвэрийг ашиглан урт хугацаанд орлого олж байгаа зээлдэгчдийн төлж буй шагнал юм.

Хүү: Бусдын мөнгийг ашигласны төлөө өгч буй төлбөр.

Мөнгөний нийлүүлэлт нэмэгдэхэд хүүний түвшин буурах хандлагатай байдаг бол мөнгөний эрэлт нэмэгдэхэд хүүний түвшин өсөх хандлагатай болдог.

Мөн олгосон зээлийн (муу, дунд, сайн зээл) чанараас хамаарч хүүний түвшин өөрчлөгдөж болно.

Хүүний хэмжээ нь үндсэн 3 хүчин зүйлээр тодорхойлогддог буюу эдгээр нь зээлдэх (хадгалуулах, хөрөнгө оруулах) мөнгөний үндсэн дүн (цаашид үндсэн дүн гэнэ), хүүний хувь буюу түвшин, хугацаа зэрэг болно.

- **Хүүний хувь (түвшин):** Хүүг хувиар илэрхийлж, жилээр тогтооно. Жишээлбэл, 12 хувь (12%) гэх буюу эсвэл индекс хэлбэрээр 0.12 (12/100) гэж тэмдэглэнэ.
- **Үндсэн дүн:** Хадгаламж, зээл, хөрөнгө оруулалтын хүүг оролцуулаагүй жинхэнэ хэмжээ буюу хадгаламж (зээл, хөрөнгө оруулалт)-ийн хүү бодогдож байгаа мөнгөн дүн юм.
- **Хугацаа:** Хүүг тооцоходоо жилээр тооцох учир жил гэсэн ойлголтыг хугацааны хэмжүүрээр хэрэглэнэ. Энэ аргачлалын хувьд жилийг 360 хоногоор төлөөлүүлэн тооцно. Хэрвээ жилээс бага хугацааны буюу өдрөөр илэрхийлэгдэх хүүг бодох бол өдрийн тоог жилийн хоногийн тоонд (360 өдөрт) харьцуулан тооцно. Мөн хугацааны сараар илэрхийлсэн тоог жилд шилжүүлж болох ба ингэх тохиолдолд 12 сарыг нэг жил, 3 сарыг 3/12 буюу 1/4 жил гэж илэрхийлнэ.

Хадгалуулсан болон зээлдүүлсэн мөнгө нь хүүний хэмжээнээс хамаарч цаг хугацааг дагаж өөрчлөгдөнө.

*Эргэн төлөгдөх дүн:
Хадгаламж эзэмшигчид
(зээлдүүлэгчид) эргүүлэн төлөх
нийт мөнгөний дүн.*

Тодорхой хугацааны дараа хүүний хамт эзэндээ буцаж очих өнөөдрийн хадгаламж болон зээлийн нийт хэмжээг эргэн төлөгдөх дүн гэнэ.

Өөрөөр хэлбэл, хадгаламж, зээлийн эргэн төлөгдөх дүн нь хадгалуулсан (зээлдүүлсэн, хөрөнгө оруулсан) мөнгөний үндсэн дүн болон хүүний нийлбэр байна.

$$\text{Эргэн төлөгдөх дүн} = \text{Үндсэн дүн} + \text{Хүүний хэмжээ}$$

Хүүг энгийн хүү, нийлмэл хүү (хүүний хүүгээр өсөн нэмэгдэх хүү) гэсэн хоёр аргаар бодож болно.

Энгийн хүү: Мөнгөний үндсэн дүнгээс тооцсон хүү.

Энгийн хүүг тооцохдоо мөнгөний үндсэн дүн, хүүний хувь, хугацааг үржүүлнэ.

Үүнийг томъёогоор илэрхийлбэл:

$$\text{Энгийн хүүний хэмжээ} = \text{Үндсэн дүн} \times \text{Хүүний хувь} \times \text{Хугацаа}$$

$$I = P \times R \times T$$

Энд: *I* - Энгийн хүүний хэмжээ
P - Үндсэн дүн

R - Хүүний хувь
T - Хугацаа

Жишээ нь, 100`000 төгрөгийг жилийн 12 хувийн хүүтэй зээлдүүлсэн (хадгалуулсан) бол хоёр жилийн хүүний хэмжээ нь 24`000 төгрөг болно.

$$I = 100`000 \times 0.12 \times 2 = 24`000 \text{ ₮}$$

Нийлмэл хүү: Үндсэн дүн болон өмнөх хугацаанд бодогдсон хүүний нийлбэрээс тооцсон хүү.

Энгийн хүүг бодохдоо жил бүр үндсэн дүнгээс ижил хэмжээгээр тооцдог бол нийлмэл хүүг бодохдоо үндсэн дүн, өмнө бодогдсон хүүний дүнгийн нийлбэрээс тооцно.

Хадгаламж, зээл болон үнэт цаасны хүүг нийлмэл хүүний аргаар тооцож байгаа тохиолдолд эргэн төлөгдөх дүнг дараах томъёогоор тодорхойлно.

$$\text{Эргэн төлөгдөх дүн} = \text{Үндсэн дүн} \times (1 + \text{Хүүний хувь})^{\text{Хугацаа}}$$

$$F = P \times (1 + R)^T$$

Энд: *F* - Эргэн төлөгдөх дүн

Эргэн төлөгдөх дүн нь өнөөдрийн мөнгөний ирээдүйн үнэ цэнийг илэрхийлдэг. Зөвхөн нийлмэл хүүний хэмжээг олох бол эргэн төлөгдөх дүнгээс үндсэн дүнг хасна. Үүнийг томъёогоор илэрхийлбэл:

$$\text{Нийлмэл хүүний хэмжээ} = \text{Үндсэн дүн} \times (1 + \text{Хүүний хувь})^{\text{Хугацаа}} - \text{Үндсэн дүн}$$

$$I_c = P \times (1 + R)^T - P$$

Энд: *I_c* - Нийлмэл хүүний хэмжээ

Өмнөх жишээг нийлмэл хүүний аргаар тооцвол нийт хүүний хэмжээ 244`440 төгрөг болж байна.

$$I_c = 100'000 \times (1 + 0,12)^2 - 10'000 = 24'440\text{₮}$$

Эндээс үзэхэд хүүний хувь адил нөхцөлд нийлмэл хүүний аргаар тооцсон хүү өндөр байна. Иймээс санхүүгийн шийдвэр гаргахдаа хүүний хувь, хүү тооцох арга зэргийг сайтар анхаарах нь зүйтэй.

Мөнгөний худалдан авах чадварын буюу ханшийн өөрчлөлттэй холбоотойгоор хүүг нэрлэсэн ба бодит хүү гэж ангилдаг. Хэрэв та банкинд 100'000 төгрөгөө 10 хувийн хүүтэй, нэг жилийн хугацаатай хадгалуулахад жилийн дараа таны мөнгө 10 хувиар нэмэгдэж 110'000 төгрөг болсон байх болно. Гэтэл таны 100'000 төгрөгөөр худалдан авдаг байсан барааны үнэ жилийн дараа 120'000 төгрөг болж нэмэгдсэн бол бодит байдалд таны мөнгөний худалдан авах чадвар 10'000 төгрөгөөр буурсан байна. Энэ тохиолдолд арилжааны банкны зарласан хүү нь нэрлэсэн хүү болох ба бодит хүү нь инфляцийг тооцсон хүү болдог.

***Нэрлэсэн хүү:** Банкуудын зарласан хүү.*

***Бодит хүү:** Инфляцийн түвшинг тооцсон хүү.*

Бодит хүү нь хүүний орлогоос олсон мөнгө үнийн өсөлтийг гүйцэж чадаж байгаа эсэхийг харуулна. Бодит хүүг нэрлэсэн хүүнээс инфляцийн түвшинг хасч тооцдог.

$$r = i - \pi$$

Энд: r - Бодит хүү

π - Ханш уналтын буюу инфляцийн түвшин

i - Нэрлэсэн хүү

Ханш уналтын түвшин нэрлэсэн хүүнээс бага нөхцөлд нэрлэсэн хүү нь бодит хүүнээс ямагт дээгүүр байна. Ханш уналт нэрлэсэн хүүнээс давсан нөхцөлд бодит хүү сөрөг утгатай болно. Бодит хүү нь инфляцийг тооцсон байдаг тул үнийн өсөлт болон бодит өгөөжийг харуулж чаддаг, харин нэрлэсэн хүү тэдгээрийг илэрхийлж чаддаггүй.

4.4. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ

Та сонголт хийх бүртээ ямар нэгэн зүйл алддагаа мэддэг үү? Ямар нэгэн сонголт хийснээр өөр нэг боломжит сонголтоо алдаж байдаг. Жишээ нь: Ирээдүйд хэрэглэх зорилгоор мөнгөө хадгалснаар өнөөдөр худалдан авалт хийх боломжоо эсвэл өнөөдөр үнэтэй зүйл худалдан авснаар ирээдүйн хэрэглэх боломжоо алддаг. Эдгээр нь алдагдсан боломжийн өртгийн тухай асуудлыг хөнддөг.

Алдагдсан боломжийн өртөгтэй холбоотой нэг чухал асуудал бол цаг ашиглалт юм. Хэрвээ нэг зүйлд цагаа зарцуулвал өөр үйл ажиллагаанд зарцуулж болох байсан цагаа алдана. Нэгэнт үр ашиггүй өнгөрөөсөн цагийг өөр зүйлд дахин зарцуулах боломжгүй. Иймээс цагийг өөрийгөө хөгжүүлэх, зорилгоо биелүүлэх болон зайлшгүй хэрэгцээтэй зүйлд зарцуулах нь зүйтэй.

Мөн буруу хооллолт, нойр болон хөдөлгөөний дутагдал өвчин үүсгэх аюултай бөгөөд сурч мэдэх, ажиллаж хөдөлмөрлөхөд зарцуулах цагийг багасгаж, тодорхой хэмжээний мөнгөн орлого олох боломжийг алдахад хүргэдэг. Үүнээс үзэхэд, алдагдсан боломжийн өртөг гэдэг нь ямар нэг боломжийг алдсанаар олж болох байсан мөнгөний хэмжээ, хийж болох байсан хөдөлмөр, авч болох байсан зүйлийн үнэ, өртөгийг илэрхийлэх ойлголт юм.

Алдагдсан боломжийн өртөг: Өөр сонголт хийсэн бол олж болох байсан мөнгөний хэмжээ буюу тухайн сонголтыг хийснээр алдаж буй орлого, ашигийн хэмжээ.

Хувь хүн мөнгөө зарцуулах, хадгалах, хөрөнгө оруулах, зээлдүүлэх зэргээр санхүүгийн шийдвэр гаргах бүртээ алдагдсан боломжийн өртгийг тооцох хэрэгтэй. Жишээ нь:

- Өнөөдөр зайлшгүй хэрэгцээт зүйл худалдан авах нь мөнгөн хадгаламж нээлгэж, ирээдүйд хүүний орлого олох боломжийг алдаж байгаа хэрэг юм.
- Бага эсвэл бараг эрсдэлгүй зүйлд хөрөнгө оруулах нь өндөр эрсдэлтэй, өндөр хүүтэй хөрөнгө оруулалтаас олох орлогыг алдана.

Тэтгэврийн дансанд жил бүр мөнгө хийх нь ирээдүйд учирч болох санхүүгийн хүндрэлийн үед нэмэгдэн гарах зардлыг бууруулах боловч илүү ашигтай хөрөнгө оруулалтаас олж болох байсан орлогыг алдана. Алдагдсан боломж нь мөнгөний цаг хугацааны үнэ цэнэтэй салшгүй холбоотой. Учир нь өнөөдрийн нэг төгрөг ирээдүйн нэг төгрөгтэй тэнцдэггүй. Өнөөдрийн нэг төгрөгийг хэрхэн зөв зарцуулснаас ирээдүйн орлого, ашгийн хэмжээ хамаардаг. Иймээс хувь хүний санхүүгийн шийдвэр гаргалтад **мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн** тооцоолол чухал ач холбогдолтой. Тухайлбал, өнөөдөр байгаа мөнгө тодорхой цаг хугацааны эцэст (ирээдүйн үнэ цэнэ) хэдий хэмжээтэй болж өсөхийг, ирээдүйд тодорхой хэмжээний мөнгөтэй болохын тулд өнөөдөр (өнөөгийн үнэ цэнэ) хэдэн төгрөг зарцуулахыг мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг тооцсоноор мэдэж чадна.

Ирээдүйн үнэ цэнэ: Тодорхой хугацааны дараа өнөөдөр хадгалуулсан мөнгөний өсөх дүн.

Энэ нь өнөөдөр байгаа мөнгийг ирээдүйн үнэ цэнээр тооцвол тодорхой хугацааны дараа үеийн хэдэн төгрөгтэй тэнцэхийг харуулна.

Үүнийг дараах томъёогоор тооцож болно. Үүнд:

$$FV = PV \times (1 + i)^n$$

Энд: *PV* – Өнөөгийн үнэ цэнэ
FV - Ирээдүйн үнэ цэнэ

i – Хүүний хувь буюу түвшин
n - Хугацаа

Жишээ нь: 100`000 төгрөгийг жилийн 15 хувийн хүүтэй хадгалуулбал жилийн дараа 115`000 төгрөг болж өснө.

$$\text{Ирээдүйн үнэ цэнэ} = 10`000 \times (1 + 0.15)^1 = 115`000\text{₮}$$

Энэ мэтчилэн 2, 3...20, 30 жилээр тооцооллыг үргэлжлүүлж болно. Мөнгөний цаг хугацааны хүснэгтийг ашиглан ирээдүйн үнэ цэнийг хялбар аргаар тооцох боломжтой. Жишээ нь: 650`000 төгрөгийг 8 хувийн хүүтэй, 10 жилийн хугацаатай хадгалуулвал ирээдүйн үнэ цэнэ нь 1`403`350 төгрөг ($650`000 \times 2`159^{17}$) болно. Ирээдүйн үнэ цэнэ нь анхны суурь үнийн дүнгээс ямагт их байдаг. Хүснэгт 4-1А-аас ирээдүйн үнэ цэнийн хүчин зүйл ямагт 1-ээс их гэдгийг харж болно. Ирээдүйн үнэ цэнийн тооцоолол хүүнээс хүү боддог нийлмэл хүүгээр (компаундинг) илэрхийлэгддэг. Зөвхөн суурь дүнгээс хүү тооцдог энгийн хүүг бодвол нийлмэл хүү нь хадгаламжийн ирээдүйн үнэ цэнийг илүү өсгөдөг.

Тогтмол хадгаламжийн ирээдүйн үнэ цэнэ

Аннуити: Хадгаламж, зээлийн төлбөрийн жигд, тогтмол хэмжээ.

Хадгаламж эзэмшигч, хөрөнгө оруулагчид ихэвчлэн тогтмол хадгаламж хийдэг.

Жил тутмын тогтмол хэмжээтэй хадгаламжийн ирээдүйн үнэ цэнийг тодорхойлоход (Хүснэгт 4-1В)-г ашигладаг.

Хэрэв жил тутам 50`000 төгрөгийг, жилийн 7 хувийн хүүтэй, 6 жил хадгалуулбал 6 жилийн эцэст 357`665 ($50`000 \times 7153$) төгрөгтэй болно.

Нэг удаагийн мөнгөний өнөөгийн үнэ цэнэ

Ирээдүйд олохыг хүсч байгаа мөнгөний өнөөгийн үнэ цэнийг тодорхойлоход мөнгөний цаг хугацааны өөр нөхцөлийг ашигладаг.

Өнөөгийн үнэ цэнэ: Тодорхой хүү болон хугацаанд суурилан тооцсон ирээдүйн мөнгөний өнөөгийн үнэ цэнэ.

Энэ нь ирээдүйд орж ирэх мөнгийг өнөөгийн үнэ цэнээр тооцвол өнөөдрийн хэдэн төгрөгтэй тэнцэхийг харуулна.

Өнөөгийн үнэ цэнийн тооцоолол бол ирээдүйд олохыг хүсч байгаа нийт мөнгөний төлөө одоо хичнэнийг хадгалахыг тодорхойлох арга бөгөөд түүнийг мөн дискаунтинг гэж нэрлэдэг. Мөнгөний өнөөгийн үнэ цэнийг дараах томъёог ашиглан тооцно. Үүнд:

$$PV = \frac{FV}{(1 + i)^n}$$

Жишээ нь: 5 жилийн дараах 10`000 төгрөг хүүний түвшин жилийн 10 хувь байхад өнөөдрийн хэдэн төгрөгтэй тэнцэх вэ?

$$PV = \frac{10`000}{(1 + 0.10)^5} = 6209.21\text{₮}$$

¹⁷ Хүснэгт 4-3-аас нэг удаагийн мөнгөний ирээдүйн үнэ цэнийн хүснэгтээс 8 хувийн хүү болон 10 жилийн хугацаанд харгалзах утга 2159 болохыг харж болно.

Өнөөгийн үнэ цэнийн тооцоолол хийхэд мөнгөний цаг хугацааны хүснэгт (Хүснэгт 4-1С)-ийг ашиглаж болно.

Хэрэв 5 жилийн дараа 10 сая төгрөгтэй болно гэвэл одоо 7'840'000 төгрөгийг ($10'000'000 \times 0.784$) 5 хувийн хүүтэй хадгаламжид хийвэл зохистой. Ирээдүйд олохыг хүсч байгаа мөнгөний өнөөгийн үнэ цэнэ ирээдүйн үнэ цэнээс ямагт бага болохыг (Хүснэгт 4-1С-ийн хүчин зүйл 1-ээс бага) харж болно.

Тогтмол хадгаламжийн өнөөгийн үнэ цэнэ

Тогтсон хугацаанд тодорхой хэмжээний мөнгийг данснаасаа тогтмол авч байхын тулд өнөөдөр хичнээнийг хадгалах зохистой талаар тооцоход өнөөгийн үнэ цэнийн тооцооллыг мөн ашигладаг.

Жишээлбэл, хэрэв 9 жилийн турш, жил бүр хөрөнгө оруулалтын данснаасаа 400'000 төгрөг авахыг хүсч байгаа бол өнөөдөр жилийн 8 хувийн хүүтэй хадгаламжинд 2'498'750 төгрөг ($400'000 \times 6.247$) хийх хэрэгтэй болохыг Хүснэгт 4-1D-ээс харах боломжтой.

Сэдвийн дүгнэлт

Мөнгө бол онцгой таваар бөгөөд өртгийн хэмжүүрийн, гүйлгээний, төлбөрийн, хуримтлалын хэрэгслийн үүрэг гүйцэтгэдэг.

Хэрэглээний үнийн тогтвортой бус байдал, инфляци, дефляци, хэрэглээний зардал болон хүүний түвшин өөрчлөгдөх нь мөнгөний ханшид нөлөөлж, улмаар энэ нь хувь хүний амьжиргаанд зайлшгүй нөлөө үзүүлдэг.

Санхүүгийн алдагдсан боломжийн өртөгийг тооцоход мөнгөний цаг хугацааны үнэ цэнийн тооцоололд суурилдаг. Ирээдүйн болон өнөөгийн үнэ цэнийн тооцооллыг хадгаламж, хөрөнгө оруулалт, зээлжүүлэлт, худалдан авалтын шийдвэрийн өсөн нэмэгдэх үр дүнг тооцоход ашиглах боломжтой.

Бататгах асуултууд:

1. Мөнгөний үүргүүдийн талаар дэлгэрүүлэн ярилцана уу?
2. Хувь хүний санхүүгийн нөхцөл байдалд инфляцийн үзүүлэх нөлөөллийг тайлбарлана уу?
3. Энгийн болон нийлмэл хүүний ялгаа юунд орших вэ?
4. Мөнгөний үнэ цэнийг тооцох ямар ач холбогдолтой вэ?
5. Өнөөгийн болон ирээдүйн үнэ цэнийг яаж тооцох вэ?

Хүснэгт 4-1. Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ

А. Дан (Нэг удаагийн) мөнгөний ирээдүйн үнэ цэнэ					
Жил	5%	6%	7%	8%	9%
5	1.276	1.338	1.403	1.469	1.539
6	1.340	1.419	1.501	1.587	1.677
7	1.407	1.504	1.606	1.714	1.828
8	1.477	1.594	1.718	1.851	1.993
9	1.551	1.689	1.838	1.999	2.172
10	1.629	1.791	1.967	2.159	2.367
В. Тогтмол мөнгөн урсгалын ирээдүйн үнэ цэнэ (аннуити)					
Жил	5%	6%	7%	8%	9%
5	5.526	5.637	5.751	5.867	5.985
6	6.802	6.975	7.153	7.336	7.523
7	8.142	8.394	8.654	8.923	9.200
8	9.549	9.897	10.260	10.637	11.028
9	11.027	11.491	11.978	12.488	13.021
10	12.578	13.181	13.816	14.487	15.193
С. Дан (Нэг удаагийн) мөнгөний өнөөгийн үнэ цэнэ					
Жил	5%	6%	7%	8%	9%
5	0.784	0.747	0.713	0.681	0.650
6	0.746	0.705	0.666	0.630	0.596
7	0.711	0.665	0.623	0.583	0.547
8	0.677	0.627	0.582	0.540	0.502
9	0.645	0.592	0.544	0.500	0.460
10	0.614	0.558	0.508	0.463	0.422
D. Тогтмол мөнгөн урсгалын өнөөгийн үнэ цэнэ (аннуити)					
Жил	5%	6%	7%	8%	9%
5	4.329	4.212	4.100	3.993	3.890
6	5.076	4.917	4.767	4.623	4.486
7	5.786	5.582	5.389	5.206	5.033
8	6.463	6.210	5.971	5.747	5.535
9	7.108	6.802	6.515	6.247	5.995
10	7.722	7.360	7.024	6.710	6.418

СЭДЭВ 5. МӨНГӨН ХӨРӨНГИЙН УДИРДЛАГА, ӨРХИЙН ТӨСӨВ

Сэдвийг судлахын ач холбогдол, үр дүн

Энэ сэдвийг судалснаар төсөв, түүний бүтцийн талаар онолын мэдлэгтэй болж, хувь хүний болон өрхийн төсөв, түүнийг удирдах арга барилд суралцана. Мөн өрхийн төсвөө төлөвлөх, шинжилгээ хийх, санхүүгийн оновчтой шийдвэр гаргах, түүнийгээ хэрэгжүүлэх мэдлэг, чадвартай болно.

Тулгуур ойлголт

- Төсөв
- Төсвийн бүтэц
- Өрхийн орлого
- Тогтмол орлого
- Нэмэгдэл орлого
- Өрхийн зардал
- Тогтмол зардал
- Хувьсах зардал
- Өрхийн тайлан тэнцэл
- Өрхийн актив
- Зээл
- Зээлжих коэффициент
- Хөрвөх чадварын коэффициент
- Хувь хүний санхүүгийн төлөвлөлт
- Хувь хүний санхүүгийн төсөв зохиох

5.1. Хувь хүний төсөв, түүний бүтэц

Төсөв нь хувь хүн, өрх, аж ахуйн нэгж, улсын бүх түвшинд байна. Дээрх бүх төсвийн нийтлэг шинж нь юу вэ? Аль ч түвшний төсөв орлого, зарлагаас тогтдог. Өөрөөр хэлбэл, хувь хүн, өрх гэр, аж ахуйн нэгжүүд болон улс нь орлого олж, түүнийгээ зарцуулдаг.

***Төсөв:** Хувь хүний шийдвэрийн дагуу мөнгөн орлогыг бүрдүүлэх, түүнийг ашиглахтай холбоотой гарч байгаа харилцаа.*

Хувь хүн олсон орлогоо хэрэглэх эсвэл хуримтлуулах зорилгоор яаж хуваарилах талаар цаг ямагт ухамсартайгаар болон ухамсарлаагүй байдлаар шийдвэр гаргадаг.

Хувь хүний санхүүгийн шийдвэр нь хувь хүний төсөвтэй холбоотой эдийн засгийн харилцааны нэгдэл байдаг. Мөнгөн хөрөнгө хэрхэн бий болгох, түүнийгээ хэрэглээ, хадгаламж, хөрөнгө оруулалтын хооронд зохистой хуваарилах, түүнчлэн хөрөнгө оруулалтыг орлого олох чадвараар нь оновчтой багцлахад төсвийн удирдлагын зорилго оршино.

Хувь хүний болон өрхийн төсвийн бүтэц мөнгөний эх үүсвэр, тэдгээрийг ашиглах чиглэлийг тодорхойлж байдаг.

ШИГТГЭЭ

Орос хэл дээр бичигдсэн санхүүгийн ном, зохиолуудад “Өрхийн санхүү” (Финансы домашних хозяйств), “Хувь хүний санхүү” (Личные финансы), “Хүн амын санхүү” (Финансы населения) гэсэн ойлголт хэрэглэгддэг. Англи хэл дээр бичигдсэн ном зохиолуудад “Хувь хүний санхүү” (Personal finance), “Өрхийн санхүү” (Household finance), “Хэрэглэгчийн санхүү” (Consumer finance), “Гэр бүлийн санхүү” (Family finance) гэсэн нэр томъёонууд хэрэглэгддэг. Их, дээд сургуулийн оюутнуудад зориулсан сурах бичгийн тухайн бүлэгт хувь хүн, өрх гэрийн санхүүтэй холбоотой шийдвэрийг хувь хүн гаргадаг учраас дээрх хоёр субъект нэг нэгнийгээ бүрэн орлох боломжтой юм. Иймээс хувь хүний болон өрхийн төсөв, санхүү ижил утга илэрхийлнэ.

Хувь хүний төсөв нь дээр тайлбарласнаар дараах бүтэцтэй байна. Үүнд:

1. Хувь хүний орлого
2. Хувь хүний зарлага

Хувь хүний орлого, түүний ангилал

Эдийн засгийн онолоор орлогыг 2 түвшинд авч үздэг. Үүнд:


Хувь хүний орлого: Цалин, тэтгэвэр, оюутны тэтгэлэг, үндсэн хөрөнгө түрээслүүлсний орлого, хадгаламжийн хүү, гэрээгээр ажил гүйцэтгэсний хөлс гэх мэт хэлбэрээр хувь хүнд орж буй мөнгө.

1. Микро эдийн засгийн түвшинд: Орлого нь үйлдвэрлэлийн аль нэг хүчин зүйлийг өмчилсөнтэй уялдан, хэн нэг хүний гарт орж ирж буй мөнгөний нийлбэр
2. Макро эдийн засгийн түвшинд: Улсын төсвийн татварын орлого, үндэсний орлого г.м

Хувь хүний орлогыг нилээд хэдэн шинж чанараар ангилдаг. Зураг 5.1-ийг харна уу.


- **Үндсэн орлого:** Цалин, хөдөлмөрийн хөлс, тэтгэвэр, оюутны тэтгэлэг, тэтгэмжийн хэлбэрээр сар бүр эсвэл тогтоосон хугацаанд авч буй мөнгөн орлогууд хамаарна.
- **Нэмэгдэл орлого:** Шагнал, урамшуулал, бэлэг, хандив эд зүйлс худалдан борлуулсны болон туслах аж ахуйгаас орох орлого бөгөөд цаг үеийн шинж чанартай орлогууд багтана.

Зураг 5-1. Орлогын ангилал



- **Тогтмол орлого:** Сар бүр ижил хэмжээгээр орж ирдэг орлого. Тухайлбал, хадгаламжийн хүүний орлого, хүүхдийн мөнгө, тэтгэвэр зэрэг нь тогтмол дүнтэй орлого юм.
- **Хувьсах орлого:** Дүн нь сар бүр өөр байдаг орлогыг хэлнэ. Жишээ нь: Бараа худалдан борлуулсны орлого, компанийн үйл ажиллагааны төлөв байдлаас хамаарч энгийн хувьцаанд олгож байгаа ногдол ашиг гэх мэт.

Зураг 5-2. Хувь хүний орлогын эх үүсвэр



Хувь хүн орлогоо өдөр тутмын хэрэгцээт зүйл (хүнс, хувцас, орон сууцны төлбөр гэх мэт) худалдан авах, нийгмийн даатгалын шимтгэл, татвар төлөх, хуримтлал үүсгэх гэх мэт зүйлд зарцуулдаг.

Өрхийн зарлага: Өрхийн зарлага нь өрхийн гишүүн бүрийн хэрэгцээг хангахад зориулагддаг. Айл өрхийн гишүүн бүрийн хэрэгцээ харилцан адилгүй байдаг. Зарим нь аль болох цөөн тооны хямд хэрэглээг сонгож байхад, зарим нь олон тооны өндөр үнэтэй зүйлийг сонгон хэрэглэдэг. Үүнээс үзэхэд өрх бүрийн хэрэгцээ, хэрэглээ олон янз байж болно. Тухайлбал, зайлшгүй хэрэгцээ, нэг удаагийн


хэрэгцээ, тансаг хэрэглээ, тогтмол хэрэглээ гэх мэт. Үүнтэй уялдаатайгаар өрхийн зарлагыг ч гэсэн дээрх байдлаар ангилж болно. Өрхийн зарлага нь тухайн гэр бүлийн гишүүдийн хэрэгцээг хангахад шаардагдах хөрөнгийн зарцуулалтыг хэлдэг. Зайлшгүй зардал гэдэгт айл өрх оршин тогтнож, амьдрахын тулд шаардагдах наад захын хэрэгцээг хангах /өдөр тутмын/ зардлууд багтана. Бусад зардал буюу цаг үеийн зардалд нэг удаагийн буюу үргэлж давтагддаггүй зардлууд багтана.

Өрхийн зардлын төрлийг Зураг 5-3-аас харж болно.

Өрхийн тогтмол зардалд орон сууцны төлбөр, зээлийн төлбөр, даатгалын хураамж гэх мэт тогтмол дүнтэй зардлууд орно.

Өрхийн хувьсах зардалд хүнс, хувцас, гутал, утасны төлбөр, нийтийн тээврийн тасалбар буюу төлбөр, эрүүл мэндийн үйлчилгээний хөлс гэх мэт тухайн үеийн хэрэглээнээс хамаарч гардаг зардлууд багтана.

Зураг 5-3. Өрхийн зардлын төрөл



Өрхийн болон хувь хүний нийт зардалд эзлэх тогтмол болон хувьсах зардлын хувийн жин ам бүлийн тоо, эцэг, эхийн эрхэлж байгаа ажил, бизнесийн төрөл зэрэг олон хүчин зүйлээс хамаарч өөр өөр байна.

5.2. Өрхийн төсвийн удирдлагын аргууд

Мөнгөн орлого, зардлын бүртгэл хөтлөх, төлөвлөгөөний дагуу захиран зарцуулах үйл ажиллагааг төсвийн удирдлага гэнэ. Өрхийн төсвийн удирдлага нь өрхийн гишүүдийн материаллаг болон соёлын /оюун санааны/ хэрэгцээг хязгаарлагдмал нөөцөөр бүрэн дүүрэн хангахад чиглэгдэнэ. Хувь хүний санхүүгийн төлөв байдалд дүгнэлт өгч, шинжилгээ хийх нь санхүүгийн удирдлагын нэг арга юм. Хувь хүний санхүүгийн төлөв байдлын шинжилгээ хувь хүний санхүүгийн зорилгыг

тодорхойлох, түүнийг биелүүлэх санхүүгийн төлөвлөгөө болон төсвийг зохиох, тэрчлэн, төлөвлөсөн орлого болон зарлагад хяналт тавих үе шатуудаас бүрдэнэ.

Хувь хүн хадгаламжтай болох нь хувь хүний санхүүгийн удирдлагын нэг чухал зорилт юм. Банк, бусад хадгаламж зээлийн байгууллагад байршуулсан болон түрийвчинд байгаа мөнгөө оновчтой зохицуулан удирдахыг мөнгөний урсгалыг удирдах гэж нэрлэдэг. Орлого хязгаарлагдмал, хэрэгцээ хязгааргүй байдаг тул өрхийн санхүүгийн удирдлага зайлшгүй чухал юм. Хувь хүн болон өрхийн төсвийн удирдлагад дараах аргууд түгээмэл ашиглагддаг. Үүнд:

- А. Орлого, зарлагаа бүртгэх
- Б. Хувь хүний болон өрхийн тайлан тэнцэл гаргах
- В. Хувь хүний санхүүгийн төлөвлөлт хийх
- Г. Хувь хүний санхүүгийн төсөв боловсруулах

Төсвийн удирдлагын эдгээр аргуудаас эхний хоёрыг дэлгэрэнгүй авч үзье.

А. Орлого, зардлаа бүртгэх

Өрх гэр орлого, зардлаа бүртгэх нь өрхийн санхүүгийн удирдлагын эхний чухал алхам байдаг. Орлогыг бүртгэхдээ эх сурвалж, он сартай нь бүртгэнэ. Ингэснээр сард тухайн өрхийн олж байгаа орлогын дүн гарна.

Зардлыг өдөр бүр бүртгэх хэрэгтэй. Мөн зардлыг бүртгэхдээ зардлын бүлэг, төрлөөр ангилж бүртгэх нь өрхийн төсвийн төлөвлөлт хийхэд хэрэглэгддэг. Зардлын төрлийг ангилахдаа хэрэглээний сагсны бүлгээр хийх нь зүйтэй.

ШИГТГЭЭ

Үндэсний статистикийн хорооноос айл өрхийн хэрэглээ, түүний хэв маягт судалгаа хийсний үндсэн дээр хэрэглээний барааны сагсны бүтцийг тодорхойлдог. Өнөөдрийн байдлаар Монгол Улсын хэрэглээний сагс нийт 12 бүлгийн 329 бараа, үйлчилгээнээс бүрдэж байна.

Монгол Улсын хэрэглээний сагсны бүтэц:

- | | |
|---------------------------------------|---|
| 1. Хүнсний бараа, ус ундаа | 8. Холбооны хэрэгсэл, шуудангийн үйлчилгээ |
| 2. Сөгтууруулах ундаа, тамхи | 9. Амралт, чөлөөт цаг, соёлын бараа үйлчилгээ |
| 3. Хувцас, бөс бараа, гутал | 10. Боловсролын үйлчилгээ |
| 4. Орон сууц, ус, цахилгаан, түши | 11. Зочид буудал, зоогийн газар, дотуур байр |
| 5. Гэр ахуйн тавилга, гэр ахуйн бараа | 12. Бусад бараа үйлчилгээ |
| 6. Эм тариа, эмнэлгийн үйлчилгээ | |
| 7. Тээвэр | |

Хэрэглээний сагсанд хамаарагддаг 329 төрлийн бараанууд дээрх 12 бүлэгт хуваарилагдаж, бүлэг тус бүр нь дэд бүлэг болон ангилагддаг. Жишээ нь: хүнсний бараа, ундаа, ус гэсэн 1-р бүлэгт дараах бараа орно. Үүнд:¹⁸

- | | |
|----------------------------|--------------------------|
| 1. Сүү, сүүн бүтээгдэхүүн | 5. Төрөл бүрийн тос, өөх |
| 2. Мах, махан бүтээгдэхүүн | 6. Сахар, жимс |
| 3. Хүнсний бүтээгдэхүүн | 7. Сөгтууруулахгүй ундаа |
| 4. Талх, гурил будаа | |

Ингэж бүртгэх нь зардлын бүтцийг тодорхой мэдэх боломжийг олгодог. Тухайн хүн нийт зардлынхаа хичнээн хувийг юунд зарцуулснаа мэдснээр хэмнэх зардлаа тодорхойлох боломжтой болдог. Тэрчлэн, дараа дараагийн сарын өрхийн төсвийн төлөвлөгөөг зохиох суурь нь болох ач холбогдолтой. Өрхийн төсвийн удирдлагын нэг арга болох орлого, зардлын бүртгэлийг бүлэглэхээс гадна өдөр бүр хөтөлж, долоо хоног болон сараар нэгтгэн дүгнэх нь чухал. Доор толилуулж буй “Өрхийн хувийн зардлыг бүртгэх хүснэгтийн маягт” дээр үзүүлсэн байдлаар өрхийн зардлыг хөтөлж болно. Хүснэгт 5-1-ийг харна уу.

Б. Өрхийн тайлан тэнцэл, түүнийг гаргах

Хувь хүн болон өрх гэр өөрийн хөрөнгийн хэмжээг тодорхойлох, орлого болон зардлаа хянахад тайлан тэнцэл чухал ач холбогдолтой юм.

¹⁸ Монгол Улсын статистикийн эмхэтгэл, 2015, х 148.

Тайлан тэнцэл (баланс): Өрхийн хөрөнгө, санхүүгийн эх үүсвэрийг харуулсан баримт.

Тайлан тэнцэл нь тухайн өрхийн санхүүгийн үйл ажиллагааны дүр зургийг харуулдаг.

Тайлан тэнцэл нь актив (хөрөнгө), пассив (эх үүсвэр) гэсэн 2 хэсэгтэй. Тайлан тэнцлийн актив, пассив хоёр тэнцэж байдаг.

Хүснэгт 5-1. Өрхийн болон хувийн зардлыг бүртгэх маягт

№	Үзүүлэлтүүд	Даваа	Мягмар	Лхагва	Пүрэв	Баасан	Бямба	Ням
Хүнсний бараа	Талх, гурил, будаа							
	Мах, махан бүтээгдэхүүн							
	Сүү, сүүн бүтээгдэхүүн							
	Сахар, жимс							
	Төрөл бүрийн тос, өөх							
	Согтууруулахгүй ундаа							
	Хүнсний ногоо							
	Согтууруулах ундаа							
	Тамхи							
Хувцас	Эрэгтэй							
	Эмэгтэй							
	Хүүхдийн							
Орон сууц	Байрны төлбөр							
	Ус							
	Цахилгаан							
Гэр ахуйн бараа								
Эм тариа								
Тээвэр	Такси							
	Нийтийн тээвэр							
	Шатахуун							
Үйлчилгээ	Үсчин							
	Гар утас							
	Суурин утас							
	Сургалтын төлбөр							
	Ном, хэвлэл, үзвэр							
Ахуйн хэрэглээний бараа								
Зээлийн төлөлт								
Амралт, зугаа цэнгэл								
Бусад								
Нийт зардал								
Тэмдэглэл								

Эх сурвалж: “Өрхийн төсөв дэвтэр” 2012-“Эрдэм мэдлэг түгээх төв” ТББ. Улаанбаатар хот.

Тайлан тэнцлийн актив тал нь тухайн өрхийн болон хувь хүний мөнгө хаана, ямар хэлбэртэйгээр байршиж байгааг харуулдаг. Жишээ нь, тухайн өрхийн мөнгө банкны хугацаатай, хугацаагүй хадгаламж, хашаа, мал сүрэг, машин, тавилга гэх зэрэг хэлбэртэй болсон байдаг ба эдгээрийг тайлан тэнцлийн актив талд тэмдэглэнэ. Харин пассив талд мөнгөний эх үүсвэрийг харуулдаг. Банкны зээл нь орон сууц худалдан авах зэрэгт тухайн өрхийн зарцуулсан мөнгөний эх үүсвэр болдог. Өрхийн тайлан тэнцэл, төсөв хоёр нь хоорондоо нарийн холбоотой ч хоёр өөр ойлголт юм. Үүнийг дараах хүснэгтээр харуулав.

Хүснэгт 5-2. Өрхийн тайлан тэнцэл болон өрхийн төсвийн хоорондох ялгаа

	Өрхийн тайлан тэнцэл	Өрхийн төсөв
Зорилго	Өрхийн хөрөнгийн хэмжээг тодорхойлох	Орлого болон зардлыг хянах
Хамрах хугацаа	Урт (улирал, жилээр) хугацааг хамарна.	Богино (өдөр, сар, улирал) хугацааг хамарна.

Хүснэгт 5-3. Өрхийн тайлан тэнцлийн жишиг загвар

№	Актив	Дүн	№	Пассив	Дүн
1	Банкин дах хугацаатай болон хугацаагүй хадгаламж		1	Үл хөдлөх хөрөнгийн зээл	
2	Худалдан авсан хадгаламжийн сертификат		2	Банкны зээл	
3	Засгийн газрын үнэт цаас		3	Хэрэглээний зээл	
4	Худалдан авсан хувьцаа		4	Боловсролын зээл	
5	Амьдралын даатгал		5	Зээлийн картын хэрэглэх лимит	
6	Орон сууц		6	Бусад өглөг	
7	Орлого олох зорилготой үл хөдлөх хөрөнгө				
8	Урлагийн болон эртний эд зүйлс				
9	Удаан эдэлгээтэй эд зүйлс (автомашин, тавилга, мал сүрэг, хувийн усан онгоц)				
10	Бусад хөрөнгө				
A	Нийт актив = 1+2+3 ... +10		Б	Нийт пассив = 1+2+3+4+5+6	
			В	Цэвэр хөрөнгө = А - Б	

Тайлан тэнцэл зохиох гол зорилго нь дээр дурдсанаар хувь хүний (өрхийн) хөрөнгийн хэмжээг тодорхойлоход оршино. Хэрэв баланс эерэг гарч байвал (актив > пассив байвал) зээлээ төлөх чадвартай байна гэсэн үг бөгөөд хувь хүний санхүү тогтвортой гэдгийг илтгэдэг. Эсрэгээрээ, хэрэв сөрөг гарвал

(актив < пассив байвал) хувь хүнд дампуурах аюул нүүрлэж байгааг харуулах ба хадгаламжаа нэмэгдүүлэх, хөрөнгө оруулалтын үр ашгийг нэмэгдүүлэх тал дээр арга хэмжээ авахыг сануулж байдаг.

Өрхийн цэвэр хөрөнгө нь өрхийн нийт хөрөнгөөс нийт өр төлбөрийг хассантай тэнцүү.

$$\text{Өрхийн цэвэр хөрөнгө} = \text{Актив} - \text{Пассив}$$

Хувь хүний хөрөнгийн өөрчлөлт нь түүний санхүүгийн байр суурийг илэрхийлдэг. Хувь хүний хөрөнгийг дараах хоёр (зээлжилтийн коэффициент, хөрвөх чадварын коэффициент) үзүүлэлтээр тодорхойлох боломжтой.

Зээлжилтийн коэффициент*:
Нийт пассивыг (өр төлбөр) цэвэр хөрөнгөд харьцуулсан харьцаа.

Зээлжилтийн коэффициент буурах нь хувь хүний санхүүгийн байдал сайжирч байгааг харуулна.

Жишээ нь, 1,0 сая төгрөгийн зээлтэй хүний цэвэр хөрөнгө нь 0,5 сая төгрөг гэвэл түүний зээлжилтийн коэффициент 2-той тэнцүү. Харин зээл 0,5 сая төгрөг, цэвэр хөрөнгө нь 1,0 сая төгрөг бол зээлжүүлэлтийн коэффициент 0.5 болно. Хувь хүний амьдралын мөчлөгийн явцад зээлжилтийн коэффициент байнга өөрчлөгдөж байдаг. Амьдралын мөчлөгийн эхний шатанд боловсрол олох, хэрэглээний болон үл хөдлөх хөрөнгийн зээл авах хандлага их байдаг учраас зээлжилтийн коэффициент өндөр гардаг. Харин идэр насны үед (40-50 насанд) зээлжилтийн коэффициент буурч эхэлнэ. Хувь хүний санхүүгийн удирдлагын гол зорилго нь тухайн хүн тэтгэвэрт гарахаасаа өмнө энэхүү коэффициентийг 1-ээс бага байлгахад оршдог. Хувь хүний санхүүгийн тогтвортой байдал нь тэтгэвэрт гарахаас өмнө үеийн цэвэр хөрөнгийн хэмжээгээр тодорхойлогдоно.

Хөрвөх чадварын коэффициент:
Хөрвөх чадвартай хөрөнгийг өр төлбөрт харьцуулсан харьцаа.

Хөрвөх чадварын коэффициентыг¹⁹ тооцохын тулд хөрвөх чадвартай хөрөнгүүдийг (актив) зөв тодорхойлох хэрэгтэй.

Хөрвөх чадвартай хөрөнгөд банкинд байгаа харилцах данс, хугацаатай, хугацаагүй хадгаламж болон бэлэн мөнгө хамаарна. Хөрвөх чадвартай активт даатгалыг бас хамруулж үзэх нь зүйтэй. Хөрвөх чадвартай актив болон өр төлбөр тэнцүү бол хөрвөх чадварын коэф 1-тэй тэнцүү гэсэн үг. Энэхүү коэффициент 1-ээс их байвал сайн.

¹⁹ Хувь хүний санхүүгийн хүрээнд ашиглагддаг санхүүгийн шинжилгээний арга хэрэгслүүдэд дараах үзүүлэлтүүд хамаарагдана. Үүнд: Зээлжилтийн коэффициент, хөрвөх чадварын коэффициент, хувийн хэрэглээний индекс (ХХИ), хувийн хэрэглээний индексийг хэрэглээний үнийн индекстэй (ХҮИ) харьцуулсан харьцаа, зээл авах өөр боломжууд, даатгалын хэлцэл гэх мэт. Оюун.Л, Биндэръяа.Л Хувь хүний санхүүгийн онол, арга зүй. 2016. УБ.

5.3. Хувийн (өрхийн) төсөв зохиох аргачлал

***Төсөв зохиох:** Гэр бүлийн гишүүдийн хэрэгцээнд шаардагдах орлогын эх үүсвэр, түүний зарцуулалт, үр дүнг урьдчилан харж мөнгөөр илэрхийлэн тооцох үйл ажиллагаа.*

Төсвийг зөвхөн айл өрхийн хэмжээнд зохиодог бус байгууллага, улс орны хэмжээнд, тодорхой нэгэн үйл ажиллагааны төсвийг хэрэгжүүлэх зориулалтаар зохиодог.

Өрх гэрийн төсвөө, зохиож сурах нь гэр бүлийн нийт гишүүдийн сэтгэл ханамжийг дээшлүүлэх, хүртээмжтэй хуваарилалт хийхэд ихээхэн ач холбогдолтой юм. Жишээлбэл, өрх гэр бүлийн сарын, жилийн нийт орлогын хэмжээ, зардлын төрөл, зарцуулалтын онцлог, зайлшгүй шаардлагатай хэрэгцээ, цаашид ямар хэрэглээг сонгож болох, орлогыг нэмэгдүүлэх ямар боломж байж болох, улмаар орлого, зардлаа зөв удирдах, мөнгөө үр ашигтай зарцуулах арга хэрэгслийг хайж эхлэхэд өрхийн төсөв ихээхэн ач холбогдолтой байдаг.

Өрхийн төсвийн төлөвлөлтийн нэг гол зорилго нь хадгаламжтай болох байдаг. Иймээс хадгаламжийн төлөвлөгөө зохиох нь өрхийн төсвийн төлөвлөлтийн нэг зорилго юм. Хадгаламжийн төлөвлөгөөг хийхэд тухайн үеийн санхүүгийн нөхцөл байдал нөлөөлдөг. Тухайлбал, төлөвлөсөн орлогоос зардлаа нөхөөд мөнгө үлдэж байвал өрхийн төсвийн зарлагаас давсан орлого гэж үзнэ. Зарлагаас давсан орлого нь тухайн цаг хугацааны /сар, жилийн/ тэр өрхийн хуримтлал буюу дараагийн хугацаанд ашиглах нэмэгдэл эх үүсвэр болдог.

Хуримтлал болон нэмэгдэл эх үүсвэрийг дараах байдлаар ашиглаж болно. Үүнд:

1. Өрхийн орлогыг ашигтай байдлаар нэмэгдүүлэх зорилгоор:
 - Банкинд хадгалуулах, хуримтлалтай болох
 - Хувьцаа, үнэт цаас худалдаж авах
 - Бусдад зээлдүүлэх гэх мэт
2. Өрхийн гишүүдэд оюуны хөрөнгө оруулалт хийх зорилгоор:
 - Мэргэжил эзэмшүүлэх сургалтын төлбөр төлөх
 - Хэлний сургалтын төлбөр төлөх
 - Мэргэжлийн зэрэг ахиулах сургалтын төлбөр төлөх гэх мэт
3. Амьдралын нөхцөлөө сайжруулах зорилгоор:
 - Гэр бүлдээ хэрэгцээтэй хөдлөх болон үл хөдлөх эд хөрөнгө худалдаж авах (байр, машин, зурагт, хөргөгч гэх мэт)
4. Хэрэглээний сонголт өөрчлөх зорилгоор:
 - Хоёрдогч хэрэгцээгээ нэмэгдүүлэх
 - Машиныхаа төрөл чанарыг өөрчлөн сайжруулах
 - Тансаг хэрэглээний гоо сайхны барааг сонгож хэрэглэх
 - Аялал, зугаалга, амралт сувилалд явах гэх мэтээр ашиглах боломжтой

Өрхийн төлөвлөсөн орлогоос зарлага давсан тохиолдолд дараах арга хэмжээг авч болно. Үүнд:

1. Илүү гарсан зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг эрж олох шаардлага тавигдана.
 - Мэргэжил, мэдлэгээ дээшлүүлэх замаар, ажил, албан тушаалаа өөрчлөх
 - Давхар ажил хийх
 - Өрхийн бизнес эрхлэх
 - Банк болон бусад байгууллага, иргэдээс зээл авах
 - Илүүдэл хөрөнгө, эд зүйлийг худалдан борлуулах
2. Хэрэглээг хямдруулах:
 - Аль болох хямд үнэтэй эд зүйлийн хэрэглээг сонгох
 - Зарим өндөр үнэтэй үсчин, угаалга, хими цэвэрлэгээ, ахуйн засвар зэрэг үйлчилгээнээс татгалзаж аль болох өөрсдийн хүчээр гүйцэтгэх
 - Биеийн эрүүл мэндэд анхаарч өвдөхгүй, эм тарианд илүү зардал гаргахгүй байх
3. Зарим хэрэглээнээс татгалзах:
 - Архи, тамхи зэрэг муу зуршлаа болих
 - Баяр ёслолыг өндөр зардлаар тэмдэглэхээс татгалзах зэрэг аргуудыг нэрлэж болно


5.4. Хувь хүн, өрх, аж ахуйн нэгж ба улсын төсвийн уялдаа холбоо

Дээр дурдсанчлан хувь хүн, өрх гэр, аж ахуйн нэгж болон улс бүр төсөвтэй байдаг. Тэдгээрийн ижил тал нь бүх түвшний төсөв орлого, зарлагаас тогтдогт оршдог. Хувь хүн, өрх гэр, аж ахуйн нэгж болон улсын төсвүүд өөр хоорондоо харилцан хамааралтай, нэг нь нөгөөдөө нөлөөлж байдаг. Хэдийгээр дээрх төсвүүдийн уялдаа холбоог маш тодорхой зааглахад төвөгтэй ч, нөгөө талаас тэдгээрийн заагийг гаргах нь хөгжлийн зүй тогтлыг нээх, хөгжлийн хандлагыг тодорхойлох практик ач холбогдолтой.

Аль нэг төсвийн орлого, зарлагад гарч байгаа өөрчлөлт нь нөгөө түвшний төсөвт өөрчлөлт оруулж байдаг. Жишээ нь, Аж ахуйн нэгж ажилтнууддаа цалин олгох нь аж ахуйн нэгжийн төсвийн хувьд зардал болно. Энэ цалин нь ажилтны (хувь хүн, өрхийн) төсвийн орлого болох ба ажилтан авсан цалингаасаа хэрэглээний эд зүйлс худалдан авах нь өрхийн төсвийн хувьд зардал болно. Харин энэ нь аж ахуйн нэгжийн төсвийн хувьд орлого болж (борлуулалтын орлого) бүртгэгдэнэ. Үүнтэй адил аж ахуйн нэгжийн төсвийн төлж байгаа татварууд нь байгууллагын хувьд зардал болдог. Харин татвар нь улсын төсвийн хувьд орлогыг бүрдүүлж, улс энэхүү орлогоороо нийгмийн халамж зэрэг шилжүүлэх төлбөрүүдийг санхүүжүүлж байдаг. Ийм маягаар бүх түвшний төсвийн орлого, зарлагууд хоорондоо харилцан уялдаа, холбоотой байдаг.


Хувь хүн, өрх, аж ахуйн нэгж болон улсын төсвийн уялдаа холбоог дараах бүдүүвчээр харуулъя.

Зураг 5-4. Хувь хүн, өрх, аж ахуйн нэгж болон улсын төсвийн уялдаа, холбоо



Улсын төсөв нь аж ахуйн нэгж, өрхийн төсвөөс бүрдэнэ. Харин аж ахуйн нэгж, өрхийн төсөв нь хувь хүний төсвөөс бүрдэнэ. Дээрх төсвүүд харилцан бие биенээ бүрдүүлж байдаг нь тэдгээрийн харилцан хамааралтай гэдгийг мөн харуулж байна. Хувь хүн, өрх гэр, аж ахуйн нэгж болон улсын төсвийн харилцан хамаарлыг Зураг 5.5-аас харж болно.

Зураг 5-5. Улс, аж ахуйн нэгж, өрх болон хувь хүний төсвийн уялдаа холбоо



ТАНЫ МЭДЛЭГТ

Өрхийн төсөв зохиоход анхаарах зүйлс.

1. Өрхийн төсөвтэй байх хэрэгтэй гэдгийг гэр бүлийн гишүүдэд ойлгуулах их чухал. Эс тэгвэл гэр бүлд хүйтэн уур амьсгал тогтох аюултай. Аз жаргалгүй, хүйтэн уур амьсгалтай гэр бүл байснаас өрхийн төсөвгүй байсан нь дээр.
2. Өрхийн төсвийг зохиоходоо гэр бүлийн гишүүдтэйгээ хамтран хийх. Өрхийн аль нэг гишүүн (зөвхөн ээж, эсвэл аав) өрхийн төсөв зохиогоод түүнийгээ бусад гишүүдээрээ хэрэгжүүлэх даалгавар өгөх нь тухайн хүний дарамт гэр бүлд бий болох орчин бүрдэнэ. Үүнээс зайлсхийх хэрэгтэй.
3. Өрхийн төсвийг зохиоход бүх гишүүд оролцох нь дараах ач холбогдолтой.
 - i. Зохиосон төсөв бодитой болно.
 - ii. Гишүүд нэг зорилготой болно.
 - iii. Хэрэгжих боломжийг хангана.
4. Өрхийн төсвийг бодит болоход өрхийн гишүүн бүр эхлээд тодорхой хугацаанд, дор хаяж 3 сар зардлаа тус тусдаа тэмдэглэж долоо хоног тутам нэгтгэж байх хэрэгтэй. Дараа нь өрхийн төсөв зохиоходоо бүх гишүүдийн зардал, хэрэгцээн дээр үндэслэнэ.
5. Өрхийн төсөв зохиоходоо нэг нийтлэг зорилго тавьж өгөх хэрэгтэй. Тодорхой зорилго нь өнөөдрийнхөөс илүү тансаг амьдрах боломж бий болгосон зорилго байх хэрэгтэй. Энэ нь өрхийн гишүүд өрхийн төсвөө хэрэгжүүлэх сонирхлыг бий болгоно.
6. Өрхийн төсөв зохиоходоо хуримтлалын төлөвлөгөө гаргах хэрэгтэй. Олсон орлогын 10 хүртэлх хувь, нэмэгдэл орлогын (гэнэтийн буюу төлөвлөөгүй орлогын) 60 хүртэлх хувийг хуримтлалд хийх хэрэгтэй.
7. Өрхийн төсвийг зохиоходоо зайлигүй шаардлагатай хэрэглээний зардлыг хэмнэж болохгүй. Эрүүл хоол хүнс зэрэг биет хэрэглээнээс гадна үзвэр үзэх, ном, сонин худалдан авах зэрэг оюуны хэрэглээг хэмнэж болохгүй.
8. Нэгэнт өрхийн төсөв зохиосон бол түүнийг хэрэгжүүлэх хэрэгтэй. Хичээл, зүтгэл гаргах хэрэгтэй. Хэрэгжүүлэхгүй бол төлөвлөгөө, төсөл зохиох нь утгагүй.
9. Төсвөө хэрэгжүүлэхдээ зардлын төлөвлөгөө гаргана. Үүнд өдөрт, долоо хоногт, сард, улиралд, жилд зориулах мөнгөний тоог гаргах хэрэгтэй болно.
10. Ингэснээр хуримтлалын төлөвлөгөөг хэрэгжүүлж чадна.

Сэдвийн дүгнэлт

“Өрхийн санхүү” гэдэг ухагдахууныг өрхийн төсвөөр төлөөлүүлж болох бөгөөд тэр нь үндэсний эдийн засгийн онцгой нэгж болох өрхийн хүрээний орлого, зарлагын нийлбэр цогцыг илэрхийлдэг. Аливаа үйлдвэрлэл хэрэглээг хангахад чиглэдэг бөгөөд улс оронд ч нийтийн хэрэглээг хангадаг хамтын (гудамжны гэрэл, явган хүний болон авто машины зам гэх мэт) хэрэглээ байдаг. Энэ нь нийгмийн хөгжлийг шийдвэрлэх хүчин зүйлийн нэг ч эцсийн дүндээ хүмүүст зориулагдсан байдаг.

Хувь хүн, өрх гэр, аж ахуйн нэгж болон улсын төсвүүд харилцан бие биедээ нөлөөлж байдаг.

Ихэнх судлаачид өрхийн санхүү нь санхүүгийн тогтолцооны суурь болдог ба өрхийн санхүүгээ удирдах хувь хүний шийдвэр макро эдийн засгийн бодлого ямар байгааг илэрхийлээд зогсохгүй, түүнд идэвхитэй нөлөө үзүүлдэг гэдэг дээр үзэл бодол нэгтэй байдаг.

Өрхийн төсөвт хандах 2 хандлага байна. Үүнд:

- Өрхийн эдийн засаг бол жижигрүүлсэн улсын эдийн засаг, улсын эдийн засаг бол томруулсан өрхийн эдийн засаг
- Өрхийн эдийн засаг улсын эдийн засгийн эд эс буюу улсын эдийн засгийг бүрдүүлэгч гэсэн зарчмыг баримтлан аливаа шийдвэр гаргах нь зүйтэй

Жишээ нь, Өрхийн санхүүг удирдахад хэн яаж оролцох вэ? гэдгийг макро эдийн засагтай харьцуулан шийдвэрлэвэл өрхийн гишүүн нэг бүрийн үүрэг хариуцлага тодорхой болно. Эсрэгээрээ макро эдийн засгийн шийдвэр гаргахад өрхийн түвшинд буулган шийдвэр гаргаж болно. Жишээ нь: Монгол Улсыг нэг өрх гэж үзэж, хөрш болон бусад улс орнуудтай харилцах харилцааг өрх, гэр бүл, хөршүүдтэйгээ харилцах зарчмаар шийдвэрлэж болно. Эдийн засагт төрийн оролцоог эцэг, эхчүүд, хүүхдүүдийнхээ амьдралд оролцох хэм хэмжээгээр тодорхойлж болно.

Өрх, гэр бүлд 3 үеийнхэн амьдардаг. Үүнд: Үр хүүхдүүд, аав, ээж, эмээ өвөө. Эдгээрийг улсын түвшинд харвал, хүүхэд, ажил эрхлэгчид, тэтгэврийн насныхан. Өрх гэрт аав, ээжүүд хүүхдүүдээ өсгөх, сурах, боловсроход үүрэг, хариуцлага хүлээдэг шиг төр мөн ийм үүргийг мөн хүлээх ёстой.

Бататгах асуултууд:

1. Өрхийн төсөв болон аж ахуйн нэгж, улсын төсвийн уялдаа юугаар илэрдэг вэ?
2. Өрхийн төсвийн бүтцийг нэрлэж, хувь хүний болон өрхийн түвшинд ярилцана уу.
3. Өрхийн төсвөө зохиож хөтлөхийн ач холбогдлыг тайлбарлан ярилцана уу.
4. Өрхийн төсвийн удирдлагын аргуудыг нэрлэж, санхүүгийн харьцааны тооцооллыг хийнэ үү.
5. Өрхийн орлого нь зардлаа давсан, зардал нь орлогоосоо хэтэрсэн үед авах арга хэмжээнүүдийг нэрлэж, тухайн үзүүлэлт юу илэрхийлж байгааг ярилцана уу.
6. Өрхийн төсөв зохиоход анхаарах зүйлс болон зорилгын талаар хэлэлцэж, дүгнэлт гаргана уу.

СЭДЭВ 6. ХУВЬ ХҮНИЙ ТАТВАРЫН УДИРДЛАГА

Сэдвийг судлахын ач холбогдол, үр дүн

Энэ сэдвийг судалснаар хувийн санхүүгийн төлөвлөлтөд татварын асуудал чухал ач холбогдолтойг ойлгохын зэрэгцээ татварын талаар онолын мэдлэгтэй болж, татвар ногдох орлого, татвар ногдуулах орлого, татварын өглөгөө тодорхойлох, хувийн татварын тайлан гаргах чадварыг эзэмшинэ.

Тулгуур ойлголт

- Татвар
- Шууд татвар
- Тогтмол татвар
- Шууд бус татвар
- Албан татвар
- Төлбөр
- Хураамж
- Түгээмэл татвар
- Цаг үеийн шинжтэй татвар
- Татвар ногдох орлого
- Шууд бус орлого
- Татвар ногдуулах орлого
- Татвар ногдох орлогоос хасагдах зардал
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт
- Татвараас зугатах
- Татвараас зайлсхийх

6.1. Татварын мөн чанар, түүний төрлүүд

Татвар нь эртний Грекийн “Gift” гэсэн үгнээс гаралтай бөгөөд анх өргөл барьц гэсэн агуулгыг илэрхийлж байжээ. Түүхийн явцад энэ нь төрд зайлшгүй төлөх татвар болсон бөгөөд орчин үед татвар төлөгчид өөрөө татвараа тодорхойлон төлөх зарчим үйлчилж байна.

***Татвар:** Татвар төлөгчдийн орлого, ашиг, эд хөрөнгийн үнийн дүнгээс хамааруулан хуульд заасан хувь, хэмжээгээр төрөөс хураан авч байгаа мөнгө.*

Төрөөс татвар төлөгчдийн орлого, ашиг, эд хөрөнгийн үнийн дүнгээс хамааруулан хуульд заасан хувь, хэмжээгээр хураан авч улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгийг татвар гэнэ.

Өөрөөр хэлбэл, татвар нь татвар төлөгчдийн орлогын зохих хэсгийг төрийн мэдэлд төвлөрүүлэх явцад төр болон татвар төлөгчдийн хооронд үүсч байгаа мөнгөн харилцаа юм.

Та үүнийг мэдэх үү?

Та олсон төгрөг тутмынхаа гуравны нэг орчим хувийг татварт зарцуулдаг.

Татварын гол зорилго нь Засгийн газрын үйл ажиллагааг санхүүжүүлэх эх үүсвэрийг бүрдүүлэхэд оршино. Татвар дараах ерөнхий шинжийг агуулдаг. Үүнд:

- ♦ Албадлагын шинжтэй.
- ♦ Татвараар дамжин мөнгөн хөрөнгийн өмчлөл өөрчлөгдөж байдаг.

- ◆ Татварын харилцаа нь тэнцвэрт бус буюу нэг талын буцалтгүй мөнгөн урсгал хөдөлгөөнийг илэрхийлдэг.

Товчоор хэлбэл, татварын гол шинж нь төрийн мэдэлд санхүүгийн нөөц эх үүсвэрийг төвлөрүүлэх зорилгоор байгууллага, иргэдийн орлогын тодорхой хэсгийг албан журмаар буцалтгүй хураан авах харилцаан дээр үндэслэдэг.

Татварын харилцаанд татварын объект, субъект гэсэн ойлголт чухал ач холбогдолтой. Татвар ногдох орлого, эд хөрөнгө, ажил, үйлчилгээ, эрх, байгалийн баялаг зэрэг зүйлс нь татварын объект юм. Татварын объектыг эзэмшиж, ашиглаж байгаа аливаа хувь хүн, хуулийн этгээд хуулийн дагуу татвар төлөх субъект болно.

Монгол Улсын иргэн хуулиар ногдуулсан албан татвар төлөх үндсэн үүрэгтэй²⁰. Татвар нь хүн бүрийн өдөр тутмын санхүүгийн үйл ажиллагааны салшгүй нэг хэсэг юм. Ихэнх хүмүүс тээврийн хэрэгслээ улсын үзлэгт оруулах, хил гаалиар бараа бүтээгдэхүүн оруулж ирэхдээ татвар төлдөг гэж боддог. Гэтэл бодит байдалд худалдан авалт хийх бүртээ татвар төлдөг тэр бүр мэддэггүй. Хамгийн энгийн жишээ бол бидний худалдан авч буй талхны үнэд нэмэгдсэн өртгийн албан татвар шингэсэн байдаг бөгөөд талх худалдан авч байгаа хүн бүр талхны үнээр дамжуулан уг татварыг төлж байдаг байна. Иймээс хувийн санхүүгийн төлөвлөлтийн нэг бүрэлдэхүүн хэсэг нь татварын төлөвлөлт болдог.

Хувь хүний татварын төлөвлөлтийн зорилго нь хувийн болон санхүүгийнхээ нөхцөл байдалд тохирсон байхын зэрэгцээ татвараа үнэнч шударгаар төлөхөд чиглэх ёстой. Учир нь хувь хүний төлсөн татварын мөнгө төсөвт төвлөрч, хүн амын боловсрол, эрүүл мэнд, улс орныг батлан хамгаалах, нийгмийн хэв журмыг сахиулах зэрэг төрийн чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагаанд зарцуулагддаг. Өөрөөр хэлбэл, аливаа хүмүүсийн төлсөн татвар эргээд ард иргэдийнхээ нийгмийн асуудлыг шийдвэрлэхэд зориулагдана. Иймээс иргэн бүр татвараа үнэн зөв тодорхойлж, цаг хугацаанд нь төлснөөр улс орны эдийн засгийг хөгжүүлэх, улмаар нийгмийн ард иргэдийн амьдралын түвшинг дээшлүүлэх, сайн сайхан амьдрах нөхцөл боломжийг хангах санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд Засгийн газартаа тусалж байна гэсэн үг.

Хувь хүний татварын төлөвлөлт нь одоо мөрдөгдөж байгаа татварын хуулиудтай танилцаж, судлахаас эхлээд дараах зорилтуудыг агуулсан байвал зохистой. Үүнд:

1. Холбогдох татварын хууль, тогтоомжийг судалж мэдэх
2. Төлбөл зохих татварын иж бүрэн бүртгэл хөтлөх
3. Татварын өглөгийг хих татварын иж бүрэн бүртой худалдан авалтын болон хөрөнгө оруулалтын шийдвэр гаргах

Татвар нь маш олон төрөлтэй. Тухайлбал, татварыг ногдуулах арга зүйгээс нь шалтгаалан шууд ба шууд бус татвар гэж ангилдаг.

²⁰ Монгол Улсын Үндсэн хууль. 17.1.3-р зүйл.

Шууд татвар: Татвар төлөгчдийн орлого ашиг, эзэмшиж байгаа хөрөнгийн үнийн дүнд ногдуулж байгаа татвар.

Шууд татварын онцлог нь татвар ногдуулбал зохих орлого, үр дүн тодорхой болсон нөхцөлд татварын объектын үнийн дүнгээс нь хамааруулан ногдуулдаг.²¹

Жишээ нь, Хувь хүний орлогын албан татвар, нийгмийн даатгалын шимтгэл, өв залгамжлал болон бэлэглэлийн албан татвар гэх мэт. Энэ төрлийн татварыг татвар ногдох орлого олсон болон татвар ногдох эд хөрөнгө эзэмшиж ашиглаж байгаа хувь хүн, хуулийн этгээд төлнө.

Тогтмол татвар: Орлогыг тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээнд мөнгөн дүнгээр ногдуулдаг татвар.

Шууд татварын нэг төрөл нь тогтмол татвар юм. Энэ татварын онцлог нь хуульд заасан тогтмол мөнгөн дүнгээр ногдуулдаг оршдог.

Энэ татварын зорилго нь татвар хураах зардлыг багасгах, татвар төлөгчдийг бүртгэл хөтлөх ажлаас чөлөөлөх, хувийн жижиг үйлдвэрлэл үйлчилгээг төрөөс дэмжихэд чиглэдэг.

Шууд бус татвар. Бараа, үйлчилгээний үнэ тарифаар дамжуулан авч байгаа татвар

Шууд бус татвар нь татвар төлөгчдийн үйл ажиллагааны үр дүнгээс үл хамаарах татвар юм. Энэ татварыг өсгөх нь бараа, үйлчилгээний үнийг нэмэгдүүлдэг.

Энэ төрлийн татварыг бараа үйлчилгээний эцсийн хэрэглэгч төлдөг учраас хэрэглээний татвар гэж бас нэрлэдэг. Дээрх ангиллаас гадна:

- Түгээмэл буюу байнгын татвар
- Түр буюу цаг үеийн шинжтэй татвар²² гэж ангилна

Түгээмэл шинжтэй, түүхийн явцад шалгаран удаан хугацаагаар хэрэглэж ирсэн татварыг байнгын татвар гэнэ. Жишээ нь, аж ахуйн нэгжийн орлогын албан татвар (цаашид ААНОАТ гэх). Тухайн үеийн онцлог нөхцөл байдалд тохируулан богино хугацаанд түр хэрэглэдэг татварыг цаг үеийн шинжтэй татвар гэнэ. Жишээ нь, 1920-1930-аад оны үед Монгол Улсад хэрэглэж байсан “Лам нарын татвар” болон “Зарим бүтээгдэхүүний үнийн өсөлтийн албан татвар” гэх мэт.

Монгол Улсын татварын тогтолцоо албан татвар, төлбөр, хураамжаас бүрдэнэ. Эдгээрийг ерөнхийд нь татвар гэж нэрлэдэг.

Албан татвар: Татвар төлөгчдийн орлого, эд хөрөнгөөс хуулийн дагуу албадан авч байгаа татвар.

Үүнд хувь хүний орлогын албан татвар (ХХОАТ) гэх мэт татварууд хамаарна. Албан татварыг хураан авч зохих шатны төсөвт оруулдаг.

²¹ Оюунцэцэг, Д. (2010). Санхүүгийн үндэс. х.206.

²² Лувсанцэрэн, Д. (2008). Макро эдийн засгийн төрийн зохицуулалт, санхүү-мөнгөний бодлого. х.139.

Төлбөр: Төрийн өмчийн байгалийн баялгийг ашиглуулсны төлөө авч байгаа татвар.

Төрийн өмчийн байгалийн баялагт газар, газрын хэвлий, түүний баялаг ой, усны нөөц зэрэг орно. Төрийн өмчийн байгалийн баялгийг ашигласан иргэн, хуулийн этгээд энэ татварыг төлдөг.

Төлбөрийг улсын төсөв болон тусгай зориулалттай санд оруулдаг. Жишээ нь: *Ойгоос хэрэглээний мод, түлээ* бэлтгэж *ашигласны төлбөр* гэх мэт.

Хураамж: Төрийн байгууллагаас үйлчилгээ үзүүлснийхээ төлөө авч байгаа татвар.

Төрийн өмчийн байгууллагаас иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад үйлчилгээ үзүүлснийхээ төлөө уг татварыг хураан авч, улсын төсөвт оруулна. Жишээ нь: Улсын тэмдэгтийн хураамж гэх мэт.

Монгол Улсын татварыг төсөвт төвлөрөх хэлбэр, үйлчлэх хүрээнээс нь хамааруулж улсын ба орон нутгийн татвар гэж ангилдаг. Улсын татварын хувь хэмжээг УИХ, Засгийн газраас тогтоодог бөгөөд Монгол Улсын нутаг дэвсгэр дээр нийтлэг үйлчилдэг. Харин орон нутгийн татварын хувь хэмжээг УИХ-аас баталсан хязгаарт багтаан тухайн орон нутгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлаас тогтоож, зөвхөн тухайн нутаг дэвсгэрт үйлчилдэг.


Хувь хүмүүсийн төлж байгаа албан татвар үндсэндээ дараах дөрвөн төрөлд хуваагддаг. Үүнд:

1. **Худалдан авалтын буюу хэрэглээний татвар:** Энэ нь шууд бус татвар бөгөөд ихэвчлэн тодорхой бараа, үйлчилгээний нэр төрөлд ногдуулдаг. Үүнд: Онцгой албан татвар, гаалийн албан татвар, нэмэгдсэн өртгийн албан татвар зэрэг хамаарна.
2. **Хөрөнгийн татвар:** Энэ төрлийн татвар орон нутгийн засаг захиргааны байгууллагын орлогын гол эх үүсвэр болдог. Уг татварт үл хөдлөх хөрөнгийн татвар, газрын төлбөрөөс гадна зарим улс оронд тээврийн хэрэгслийн татвар, эд хогшлын татвар, аж ахуйн тоног төхөөрөмжийн татвар зэрэг багтдаг.
3. **Өв залгамжлал, бэлэглэлийн татвар:** Өв залгамжлалын татварыг нас барсан этгээдийн эд хөрөнгийг албан ёсоор өвөлж авсан хүн буюу өв залгамжлагч төлнө.
4. **Орлогын татвар:** Хувь хүний орлогын татварын хоёр гол хэлбэр нь нийгмийн даатгалын шимтгэл, хувь хүний орлогын албан татвар болдог. Нийгмийн даатгалын шимтгэл нь тэтгэвэрт гарах, өвдөх зэрэг хөдөлмөрийн чадваргүй болсон үедээ орлогоор хангагдах, нийгмийн хамгаалалд хамрагдах боломжийг бүрдүүлдэг. Орлогын татвар бол хувь хүний татварын төлөвлөлтийн хамгийн гол хүчин зүйл байдаг. Хувь хүний орлогын албан татварыг ажил олгогч ажил албан хаагчдын цалин, түүнтэй адилтгах хөдөлмөрийн хөлснөөс суутган авч, харъяа дүүргийн татварын байгууллагад төлөх замаар улсын төсөвт төвлөрүүлдэг. Хэрэв хувь хүн хувиараа өөрийн бизнесийг эрхэлдэг бол татвараа өөрөө тодорхойлж, төлөх үүрэгтэй.

6.2. Татварын тооцоолол хийх арга зүй

Аливаа хүн бүр хуулийн дагуу татвараа үнэн зөв тодорхойлж, төлөх үүрэгтэй. Энэ үүрэг нь татварын төлөвлөлт хийж, татвар ногдох орлого ба татвараа тодорхойлох, жилийн эцэст төлбөл зохих болон төлсөн татваруудаа харьцуулан татварын тооцоогоо эцэслэн хийхийг шаарддаг. Татварын төлөвлөлт хийнэ гэдэг нь татварын тооцооллоо үнэн зөв, бодитой хийж, өглөгөө тооцно гэсэн үг. Татварын тооцооллыг дараах хэд хэдэн үе шатаар хийдэг. Татварын тооцоолол нь татвар ногдох орлогын хэмжээг тодорхойлохоос эхэлнэ. Энэ нь хуулийн дагуу татвар ногдох бүх орлогынхоо нийлбэрийг олно гэсэн үг. Татварын тооцоолол хийх үе шатыг Зураг 6-1-т харууллаа.

Зураг 6-1. Татварын өглөг тодорхойлох



1. Татвар ногдох нийт орлогоо тодорхойлох:

Татвар ногдох орлого: Хуулийн дагуу татвар ногдуулбал зохих орлогын дүн

Хувь хүний олсон ихэнх орлого татварын объект болдог. Хувь хүний нийт орлогыг дараах үндсэн төрөлд хуваадаг. Үүнд:

- *Хөдөлмөр эрхэлсний орлого:* Энд цалин, хөдөлмөрийн хөлс, нэмэгдэл, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах орлого багтана
- *Хөрөнгө оруулалтын орлого:* Зарим тохиолдолд энэ төрлийн орлогыг багцын орлого, хөрөнгийн орлого гэж нэрлэдэг. Үүнд: Хүү, ногдол ашиг, түрээс, эрхийн шимтгэлийн орлого хэлбэрээр хүлээн авч байгаа мөнгөн орлого багтана
- *Хөрөнгө борлуулсны орлого:* Үүнд: Үл хөдлөх болон хөдлөх хөрөнгө, хувьцаа, үнэт цаас борлуулсны орлого орно
- *Үйл ажиллагааны орлого:* Хуулийн этгээд байгуулахгүйгээр хувиарааа үйл ажиллагаа явуулж олсон мэргэжлийн болон үйлдвэрлэл, үйлчилгээний орлого үүнд багтана
- *Шууд бус орлого:* Бизнесийн үйл ажиллагаанд идэвхитэй оролцолгүйгээр олох орлогыг шууд бус орлого гэнэ

Хураамж: Төрийн байгууллагаас үйлчилгээ үзүүлснийхээ төлөө авч байгаа татвар.

Цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал дээр ажил олгогчоос нэмж олгож байгаа тухайн ажилтны албан үүргээ гүйцэтгэхэд шууд холбогдолгүй бэлнээр олгосон хоолны мөнгө, бусад этгээдэд төлөх өр барагдуулсны төлбөр зэрэг бараа, үйлчилгээний орлогын албан татвар ногдох шууд бус орлогод хамруулна.

2. Нийт орлогын тохиргоо хийх:

Татвар төлөгчийн зарим төрлийн орлогыг татвараас чөлөөлөх тухай татварын хуульд заасан байдаг. Тухайлбал, Засгийн газрын бондын хүүний орлого гэх мэт. Иймд татвар ногдох нийт орлогын дүнгээс хуульд заасан татвараас чөлөөлөгдөх орлогын дүнг хасч, тохируулагдсан орлогын хэмжээг тодорхойлно.

3. Татвар ногдуулах орлогыг тодорхойлох:

Татвар ногдуулах орлого: Татвар төлөгчийн татвар ногдох орлогоос хуулийн дагуу хасагдах зардлуудыг хассаны дараах орлогын дүн.

Өөрөөр хэлбэл, хуульд заасан хувь, хэмжээгээр татвар тооцон авч байгаа орлогын хэмжээ юм. Үүнийг тооцохдоо тохируулагдсан орлогын дүнгээс татварын хуульд заасан хасагдах зардлуудыг хасна.

Татвар ногдох орлогоос хасагдах зардал: Татвар ногдуулах орлогыг тодорхойлохын тулд татвар төлөгчийн нийт орлогоос хасч тооцдог зардал.

Татвар ногдуулах орлогыг тодорхойлох зорилгоор татвар төлөгчийн нийт орлогоос хасч тооцдог хуулиар зөвшөөрсөн, зардлуудыг татвар ногдох орлогоос хасагдах зардал гэнэ.

Монгол Улсын “Хувь хүний орлогын албан татварын хууль”-д зааснаар хувь хүний албан татвар ногдуулах орлогыг тодорхойлохдоо:

- Цалин хөдөлмөрийн хөлсний орлогоос нийгмийн даатгалын шимтгэлийг
- Үйл ажиллагааны орлогоос түүхий эд материалын зардал гэх мэт хуульд заасан зардлуудыг
- Хувьцаа болон үнэт цаас борлуулсны орлогоос худалдан авсан үнийг
- Хөдлөх хөрөнгө борлуулсны орлогоос тухайн хөрөнгийг худалдан авсан үнэ болон худалдан авахтай холбоотой гарсан баримтаар нотлогдох зардлыг тус тус хасч тооцно²³ гэж заажээ

²³ ХХОАТ-ын тухай хууль. (2006). 4-р бүлэг.

4. Татвараа тооцох:

Татвар ногдуулах орлогоос хуульд заасан хувь хэмжээгээр татвар төлнө. Үүний тулд, татвар ногдуулах орлогын дүнг тухайн нэр төрлийн татварын хувь хэмжээгээр үржүүлж, мөнгөн дүнгээр илэрхийлнэ. Жишээ нь: Үл хөдлөх хөрөнгө борлуулсны албан татварыг 2 хувиар ногдуулдаг. Хэрэв та өөрийн өмчлөлд байдаг орон сууцаа 100.0 сая төгрөгөөр борлуулсан гэвэл төлөх татварын хэмжээ нь $100.0 \text{ сая.төг} \times 2\% = 2.0 \text{ сая.төг}$ болно. Татварын нийт хэмжээ нь тухайн төрлийн орлого тус бүрт ногдох татварын нийлбэрээр тодорхойлогдоно.

5. Татварын цэвэр өглөг тооцох:

Татварын цэвэр өглөгийг тодорхойлохдоо тооцсон татвараас татварын хөнгөлөлтийг хасна. Харин татварын тайлан гаргаж байгаа бол бусдад суутгуулсан татварын дүнг мөн хасч, татварын цэвэр өглөгөө тодорхойлно.

Хүснэгт 6-1. Татварын цэвэр өглөг тодорхойлох аргачлал

ЖИШЭЭ: ТАТВАРЫН ЦЭВЭР ӨГЛӨГ ТОДОРХОЙЛОХ	
Сарын нийт орлого (цалин, хүүний орлого)	2`500`000 ₮
Татвараас чөлөөлөгдөх орлого: Засгийн газрын бондын хүүний орлого	20`000 ₮
Татвар ногдох орлого	2`480`000 ₮
Нийгмийн даатгалын шимтгэл ($2`480`000₮ \times 10\%$)	248`000 ₮
Татвар ногдуулах орлого ($2`480`000₮ - 248`000₮$)	2`232`000 ₮
Хувь хүний орлогын албан татвар ($2`232`000₮ \times 10\%$)	223`200 ₮
Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт ($84`000₮/12$)	7000 ₮
Суутгуулсан татвар (Ажил олгогч цалинг тавьж олгохдоо суутгаж, төсөвт төлнө)	216`200 ₮
Татварын нийт цэвэр өглөг	0 ₮

Тайлбар: Цалин хөлс, шагнал, урамиуулал болон тэдгээртэй адилтгах орлогод ногдох жилийн албан татвараас 84`000 төгрөгийн албан татварыг хөнгөлдөг. Сард үзүүлэх татварын хөнгөлөлтийн хэмжээ 7000 төгрөг болно.

Засгийн газрын явуулж буй татварын бодлого нь улсын төсвийн орлогыг бүрдүүлэхийн зэрэгцээ татвар төлөгчдийн бизнесийн үйл ажиллагааг дэмжих, иргэдийн бодит орлогыг нэмэгдүүлэх замаар хүн амын сайн сайхан амьдралыг дээшлүүлэхэд чиглэдэг. Энэ нь татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогоор дамжин хэрэгждэг.


Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт:
Хуульд заасан үндэслэлээр татвар төлөгчдийн төлбөл зохих татварыг бууруулах үйл ажиллагаа.

Энэ нь:

1. Татвар төлөгчийн олсон орлогыг татвараас чөлөөлөх
2. Төлбөл зохих татварыг нь багасгах гэсэн 2 хэлбэрээр хэрэгждэг

Тухайлбал, ХХОАТ-ын хуульд зааснаар хувь хүний тэтгэвэр, тэтгэмжийн болон НӨАТ-ын урамшууллаас орсон орлогыг албан татвараас чөлөөлдөг бол хувиараа үр тариа, төмс, хүнсний ногоо, жимс, жимсгэнэ, тэжээлийн ургамал үйлдвэрлэсэн буюу тариалсан Монгол Улсад оршин суугч хувь хүний зөвхөн тухайн үйлдвэрлэлээс олсон орлогод ногдуулах албан татварыг 50 хувиар хөнгөлдөг. Ийнхүү татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн бодлогыг хэрэгжүүлэх нь татвар төлөгч төдийгүй, улс орны нийгэм, эдийн засгийн хөгжилд чухал ач холбогдолтой.

Зураг 6-2. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн зорилго, ач холбогдол



Хувь хүн татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхийн тулд хүсэлтээ бичгээр гаргаж, хөнгөлөлт, чөлөөлөлтийг ямар хэлбэрээр эдлэх тухайгаа тодорхой зааж өгнө. Хүсэлтэндээ хөнгөлөлт, чөлөөлөлт эдлэхэд шаардлагатай дараах баримтыг бүрдүүлж хавсаргана. Үүнд:

- Татвар төлөгч иргэний орлого, татварын бүртгэлийн дэвтэр, хуулбарын хамт
- Нийгмийн даатгалын дэвтэр, хуулбарын хамт
- Ажлын газрын цалингийн тодорхойлолт
- Иргэний өөрийн данс, банкны нэр
- Татвар төлөгчийн иргэний үнэмлэхийн хуулбар

Эдгээр нийтлэг бичиг, баримтаас гадна татварын ямар төрлийн хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлж байгаагаас хамаарч зарим нэмэлт баримт бүрдүүлдэг. Тухайлбал, сургалтын төлбөр төлсөн, баримтаар нотлогдож байгаа төлбөрийн хэмжээгээр албан татварын хөнгөлөлт эдлэхэд дараах нэмэлт баримтыг бүрдүүлнэ. Үүнд:

1. Тухайн оюутныг төрсөн буюу үрчилсэн хүүхэд гэдгийг нотлох баримт
2. Оюутны суралцаж буй сургуулийн тодорхойлолт
3. Эцэг, эхээс хүүхдийнхээ сургалтын төлбөр төлсөн тухай орлогын баримт
4. Оюутны “Иргэний үнэмлэх”-ийн баталгаажуулсан хуулбар

6.3 Татварыг тайлагнах, төсөвт төлөх

Хувь хүний орлогын албан татварыг ажил олгогч суутгаж төсөвт оруулах, эсвэл хувь хүн өөрөө иргэний орлого тодорхойлох хуудсаар тайлагнаж, төсөвт төлөх гэсэн аргаар төлдөг. Харин жилийн эцэст, татварын хөнгөлөлт, чөлөөлөлт болон татварын тооцооллыг дахин хянаж үзсэний эцэст татварын илүү, дутуу төлөлтийг тодорхойлдог. Монгол Улсын “Хувь хүний орлогын албан татварын тухай хууль”-д зааснаар татвар төлөгч өөрөө албан татвар ногдуулах орлогоо үнэн зөв тодорхойлж, дор дурдсан хугацаанд²⁴ албан татварыг төсөвт төлнө. Үүнд:

- Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсны орлогод ногдох албан татварыг 2 хувиар ногдуулан дараа улирлын эхний сарын 15-ны дотор
- Түрээсийн орлогод ногдох албан татварыг 10 хувиар ногдуулан дараа улирлын эхний сарын 15-ны дотор
- Үйл ажиллагааны орлого, өмчлөл, эзэмшилд байгаа хөрөнгийг бусдад ашиглуулснаас олсон орлого, хөдлөх эд хөрөнгө ба хувьцаа, үнэт цаас борлуулсны орлогод 10 хувиар тооцон улирал тутам албан татвар ногдуулан дараа улирлын эхний сарын 15-ны дотор төсөвт төлнө

Хувь хүний төлсөн татварыг албан татвар төлөгчийн орлого, татварын бүртгэлийн дэвтэрт тухай бүр бүртгэн харьяа татварын албаар баталгаажуулах бөгөөд татварын жилийн эцэст уг албатай татварын тооцоо хийнэ. Хэрэв албан татвар ногдох орлогын чөлөөлөлт, татварын хөнгөлөлт эдлэх бол төсөвт төлөх албан татвар, албан татвар ногдох орлогоос хасч тооцно. Тухайн жилд хийх хасалтын хэмжээ нь мөн хугацаанд төлбөл зохих албан татварын дүнгээс их байвал татварын алба дараах байдлаар зохицуулдаг. Үүнд:

1. Дараагийн сар, улирал, жилд төлөх албан татварт шилжүүлэн тооцох
2. Дараагийн тайлант хугацааны албан татвар ногдох орлогын дүнд шилжүүлэн тооцох
3. Хууль тогтоомжийн дагуу орон нутгийн төсөвт төлөх бусад төрлийн албан татварын төлбөрт шилжүүлэн тооцох
4. Илүү төлсөн албан татварыг албан татвар төлөгчид буцаан олгох
Хэрэв албан татварыг илүү төлсөн бол татварын тайлан тушаах үедээ түүнийг буцаан авах хүсэлтээ харьяалах татварын албанд бичгээр гаргасны үндсэн дээр татварын алба хянаж, буцаан олгоно

Тухайн хүн орлогын албан татвар төлсөн тайланг “Хувь хүний орлогын албан татварын тайлан”-гийн хуудсаар (Маягт ТТ-06(А), ТЕГ-ын даргын 2011 оны 12 дугаар сарын 08-ны өдрийн 728 дугаар тушаалын 1 дүгээр хавсралт) гаргаж, дараа оны 02 дугаар сарын 15-ны дотор татварын албанд хүргүүлнэ. Тайлангийн хуудсыг бөглөхдөө татварын тооцоолол хийх аргачлалын дагуу (“Хувь хүний орлогын албан

²⁴ ХХОАТ-ын тухай хууль. (2006). 27-р зүйл

татварын тайлан”, ТТ-06(А) маягтыг нөхөх зааврыг мөрдлөг болгож) татвараа тооцоолж, холбогдох мөрүүдийн 3-р баганад мянгачилсан дүнгээр бичнэ. Хувь хүний орлогын албан татварын тайлангийн хамт “Хувь хүний орлогын албан татварын хөнгөлөлт, чөлөөлөлт эдэлсэн орлогын дэлгэрэнгүй мэдээний хуудас”-ыг (Маягт ТТ-06(Б)) тухайн тайлант хугацаанд татварын хөнгөлөлт, чөлөөлөлт үзүүлсэн орлого тус бүрээр дэлгэрэнгүй нөхөж, харьяа дүүргийн татварын албанд хүргүүлнэ.

Хэрэв тухайн иргэн татварын жилийн хугацаанд өөрийн өмчлөлд байсан үл хөдлөх хөрөнгийг борлуулсан бол “Үл хөдлөх эд хөрөнгө борлуулсан иргэний орлогын албан татварын тайлан”-г (Маягт ТТ-14) мөн гаргана. Уг тайланд үл хөдлөх хөрөнгө худалдсан болон худалдан авсан иргэд, борлуулсан эд хөрөнгийн талаарх мэдээлэл байна. Мөн үл хөдлөх хөрөнгө борлуулснаас олсон орлого, ногдуулсан татар, төлсөн болон дутуу төлсөн татварын дүнг мянган төгрөгөөр илэрхийлж тайлагнана.

6.4. Татварын төлөвлөлт хийхэд анхаарах зүйлс

Ихэнх хүмүүс татвараа шударгаар төлдөг. Гэхдээ татварын талаарх мэдлэг, практик туршлагадаа үндэслэн хуулиас гажилгүй татвараа бууруулах боломж бий. Эсрэгээр зарим хүмүүс хууль бус аргаар татвараас зугатах, татвараа бууруулах оролдлого хийдэг. Татвараас зайлсхийх (бууруулах оролдлого) ба татвараас зугатах нь ялгаатай ойлголт юм.

Татвараас зайлсхийх: Хууль ёсны арга хэрэгсэл ашиглан татвараа бууруулах оролдлого.

Татвараас зугатах: Татвар төлөхгүй байх, татвараа бууруулах зорилготой хууль бус үйлдэл

Хууль ёсны аргуудыг хэрэглэн төлөх татвараа бууруулахыг татвараас зайлсхийх гэж нэрлэдэг. Энэ нь хуулийн хүрээний боломжит аргуудыг ашиглан татварын өглөгөө бууруулах зорилготой үйл ажиллагаа юм. Энэ боломжийг нягтлан бодогч болон татварын мэргэжилтнүүд илүү сайн ашигладаг.

Харин татвараа төлөхгүй байх, татвараа бууруулах зорилготой хууль бус үйлдлийг татвараас зугатах гэнэ²⁵. Үүнд: Санаатайгаар орлогоо нуун дарагдуулах, зардлаа өсгөж тайлагнах замаар татварын тайланг буруу гаргаж, татвараа бууруулах зорилготой үйл ажиллагаа хамаарна. Энэ үйлдэл нь хуулийн хариуцлага хүлээх үндэслэл болно. Иймээс хуулийн хүрээнд татвараа бууруулах боломжуудыг мэдэх нь татварын үр ашигтай төлөвлөлт хийх үндсэн нөхцөл юм. Татварын өглөгөө бууруулахад дараах аргуудыг ашиглаж болно. Үүнд:

²⁵ Jack r. Kapoor, Les r. Dlabay, Robert j. Hughes. (2012). Personal finance/Tenth edition. McGraw-Hill/Irwin, New York, p.129.

1. Хэрэв дараагийн жилд татварын түвшин буурна гэж тооцож байгаа бол татварын хөнгөлөлт чөлөөлөлт эдлэх эрхээ энэ ондоо багтаж хэрэгжүүлэх хэрэгтэй.
2. Хэрэв дараагийн жилд татварын түвшин бага байна гэж үзэж байгаа бол хүлээж авах орлогоо дараа жил хүртэл хойшлуул. Энэ нь тухайн орлогод ногдох татварыг бууруулах боломжийг олгоно.
3. Хэрэв татварын түвшин нэмэгдэнэ гэж үзэж байгаа бол татварын хасалтаа ашиг авчиртал хойшлуул. Жишээ нь, тухайн онд татварын түвшин 10 хувь байхад татвар ногдох орлогоос хасагдах 100`000 төгрөгийн зардал нь татварын өглөгийг 10`000 төгрөгөөр бууруулна. Харин дараа онд татварын түвшин 12 хувь болж өссөн тохиолдолд төлөх татварын хэмжээ 12`000 төгрөгөөр багасах болно.
4. Хэрэв дараа онд татварын хувь хэмжээ нэмэгдэнэ гэж үзэж байгаа бол хүлээн авах ёстой орлогуудаа яаралтай цуглуулж, тайлагнах хэрэгтэй. Татварын түвшин бага байгаа үед тухайн орлогод ногдох татвараа төлбөл илүү татвар төлөхөөс зайлсхийх нэг арга болно. Тухайлбал, та ирэх жил Япон улсаас суудлын автомашин худалдан авах төлөвлөгөөтэй байсан гэж үзье. Гэтэл суудлын автомашинд ногдох гаалийн албан татварын хэмжээг дараа оны 1 дүгээр сарын 1-нээс нэмэх шийдвэр Засгийн газар гаргажээ. Энэ тохиолдолд татвар нэмэхээс өмнө автомашинаа оруулж ирэх нь төлөх татварын хэмжээг бууруулж чадна.

Сэлвийн дүгнэлт

Татвар нь татвар төлөгчдийн орлого, эд хөрөнгө зэргээс хуулийн дагуу хураан авч, төсөвт оруулж байгаа мөнгөн хөрөнгө юм. Хувь хүний өдөр тутмын санхүүгийн амьдралын салшгүй нэг хэсэг нь татварын харилцаа. Хүмүүс өөрсдийн хийсэн худалдан авалт тутамдаа татвар төлж байдаг. Иймээс татварын төлөвлөлт хийх нь хувийн санхүүгээ амжилттай удирдах нэг нөхцөл болно. Хувь хүний татварын төлөвлөлтийн зорилго нь хувийн болон санхүүгийн нөхцөл байдалд тохирсон байхын зэрэгцээ татвараа үнэнч шударгаар төлөхөд чиглэх ёстой.

Татварын тооцоолол хийнэ гэдэг нь үндсэндээ татвар ногдуулах орлогоо тодорхойлж, төлөх татварынхаа хэмжээг тооцно гэсэн үг. Үүний тулд татвар ногдох нийт орлогоос татвараас чөлөөлөгдөх орлого, хасагдах зардлуудыг хасаж татвар ногдуулах орлогоо тооцно. Уг дүнгээс зохих хувиар татвар тооцох бөгөөд татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийг хасаж татварын цэвэр өглөгийг тодорхойлдог. Хувь хүн холбогдох татварын тайлангийн маягтын дагуу татвараа үнэн, зөв тайлагнаж, хуульд заасан хугацаанд төсөвт төлөх үүрэгтэй. Татварын тайлан гаргах үйл ажиллагаа нь татварын тооцоолол хийх аргачлалын дагуу хийгдэх ёстой. ХХОАТ ногдох зарим орлогыг ажил олгогч байгууллага нь суутгаж төсөвт төлдөг.

Хуулийн хүрээнд татвараа бууруулах боломжуудыг мэдэх нь татварын үр ашигтай төлөвлөлт хийх үндсэн нөхцөл болно. Харин татвараас зугатах оролдлого нь хууль бус үйлдэл бөгөөд хуулийн дагуу хариуцлага хүлээх үндэслэл болдог.

ШИГТГЭЭ

АНУ-ын иргэд татварын хуулийг хэрхэн өөртөө ашигтайгаар хэрэглэдэг вэ?

Өөрийн гэрт бизнес эрхлэх: Өөрийн орон сууцны нэг хэсгийг бизнесийн зориулалтаар ашиглах нь мөргэйжийн зээлийн болон түрээсийн төлбөрийн зардлыг бууруулах боломжийг олгодог. Энэ нь бизнесээ эхлэх, бизнесээ үргэлжлүүлэхэд шаардлагатай зайлиггүй гарах зардлыг бууруулна.

Тусдаа амьдарч байгаа (салсан) гэр бүл: Хүүхдийн тэтгэврийн орлогоос татвар авдаггүй ч хүүхдийн тэтгэвэр нь төлж байгаа хүний татвар ногдох орлогоос хасагдах зардалд ордог тул төлөх татварын хэмжээг бууруулна.

Ганц бие эцэг, эх: Ажил хийж байгаа өрх толгойлсон ганц бие эцэг, эхчүүд хүүхэд асрахад зориулсан татварын хөнгөлөлт эдлэх эрхтэй. Мөн бага орлоготой бол цалингийн орлогод ногдох татварын хөнгөлөлтийг эдэлж болдог.

Тэтгэврийн насны хүмүүс: Хувь хүн татвар ногдох орлогоосоо ирээдүйн хэрэгцээндээ зориулж тэтгэврийн данс нээхийг зөвшөөрдөг. Дансны мөнгөө тэтгэвэрт гарсны дараа ямар нэг шимтгэлгүй буцаан авч болно. Данснаас буцаан авсан мөнгийг тухайн хүний ердийн орлого гэж үзэн татвар ногдуулдаг. Гэхдээ тэтгэврийн насны хүний орлого нь хөдөлмөрлөж байсан үеийнхийг бодвол бага учраас төлөх татварын хэмжээ буурдаг.

Бататгах асуултууд:

1. Татварын шинж чанарыг тайлбарлана уу.
2. Татварын төрөл тус бүрийн онцлог, ялгаа юунд орших вэ?
3. Татварын тооцооллыг хэрхэн хийх вэ?
4. Татварын хөнгөлөлт, чөлөөлөлтийн ач холбогдлыг тайлбарлана уу.
5. Татварын тайланг ямар хугацаанд гаргаж, хаана тушаах вэ?
6. Татварын илүү, дутуу төлөлтийг хэрхэн зохицуулдаг вэ?

СЭДЭВ 7. САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ ДЭХ ХУВЬ ХҮНИЙ ОРОЛЦОО

Сэдвийг судлахын ач холбогдол, үр дүн

Энэ сэдвийг судалснаар санхүүгийн зах зээлийн талаар онолын мэдлэгтэй болж, санхүүгийн зах зээл, санхүүгийн зуучлагч байгууллагуудын тусламжтайгаар хувийн болон өрхийн санхүүгээ удирдах ур чадварыг эзэмшинэ.

Тулгуур ойлголт

- Санхүү, санхүүгийн тогтолцоо
- Санхүүгийн зуучлал
- Санхүүгийн зах зээл
- Мөнгөний зах зээл
- Өрийн бичиг
- Хадгаламжийн сертификат
- Хөрөнгийн зах зээл
- Валютын зах зээл
- Валютын ханш
- Спот зах, спот арилжаа
- Форвард
- Фьючерс
- Опцион
- Своп
- Хадгаламжийн байгууллага
- Хадгаламжийн бус байгууллага

7.1. Санхүүгийн зах зээлийн тухай ойлголт, түүний төрлүүд

Санхүүгийн зах зээлийн тухай ойлголт, онцлог

Санхүүгийн зах зээлийн талаар ойлголт өгөхийн өмнө санхүүгийн тогтолцооны тухай товч авч үзье.

Санхүү: Мөнгөн хөрөнгийг хуримтлуулах, хуваарилах, ашиглахтай холбогдон үүсч байгаа эдийн засгийн мөнгөн харилцаа.

Санхүүгийн харилцааны онцлог нь ямагт мөнгөөр илэрч байдагт оршдог. Бид санхүүгийн талаар эхний бүлэгт тодорхой үзсэн.


Санхүүгийн байгууллага, санхүүгийн зах зээлийн нэгдлийг **санхүүгийн тогтолцоо** гэх бөгөөд түүний бүтцийг Зураг 7-1-ээс харна уу.

Санхүүгийн зуучлал: Мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй хэсгээс мөнгөн хөрөнгийн дутагдалтай хэсэг рүү шилжүүлэн хуваарилах үйл явц.

Санхүүгийн зуучлалгүй эдийн засгийг төсөөлж үзвэл, мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй хэсэг мөнгөн хөрөнгийн дутагдалтай хэсгийг хайж олоход цаг хугацаа, зардал ихээхэн зарцуулна.

Мөн зээлдүүлэх мөнгөний хэмжээ, хүү, эргэн төлөгдөх хугацааны хувьд тохиролцоход хүндрэлтэй асуудал тулгарна. Талууд харилцан тохиролцож чадсан ч зээлдэж авсан мөнгөө эргүүлээд төлөхгүй байх, төлсөн ч мөнгө нь үнэ цэнээ алдах гэх мэт эрсдэл үүсч болзошгүй. Харин эдийн засгийн хувьд оролцогч бүх талуудад ач холбогдолтой, зардал, эрсдэл багатай, өгөөжтэй байх мөнгөний урсгал нь санхүүгийн зуучлагчаар дамжин хийгдэнэ.

Зураг 7-1. Санхүүгийн тогтолцооны бүтэц



Эх сурвалж: Frederic S. Mishkin, Stanley G. Eakins. *Financial markets and institutions, eighth edition, New Jersey, 2014*

Мөнгөний илүүдэлтэй болон дутагдалтай талуудад хууль эрх зүйн үндэслэлтэйгээр тохиролцож, зардлаа хэмнэх, үр ашгаа нэмэгдүүлэх, эрсдэлээ бууруулах боломжийг санхүүгийн зах зээл дээр санхүүгийн зуучлагч байгууллагууд олгодог. Иймээс санхүүгийн зуучлагчтай эдийн засагт санхүүгийн тогтолцоо итгэлцэл дээр суурилдаг байна. Зураг 7-1-д үзүүлснээр санхүүгийн тогтолцоог нэг талаас санхүүгийн зах зээл, нөгөө талаас санхүүгийн байгууллага бүрдүүлэх бөгөөд

байгууллага нь зуучлалын үйл ажиллагаа явуулж, зах зээл дээр санхүүгийн хэрэгсэл арилжаалагддаг. Санхүүгийн зах зээл нь бараа, бүтээгдэхүүн арилждаггүйгээрээ бусад зах зээлээс ялгаатай бөгөөд мөнгөн хөрөнгийг орлохуйц санхүүгийн хэрэгслүүдийг арилждаг онцлогтой.

Санхүүгийн зах зээл: Санхүүгийн хэрэгслүүдийг арилжих үйл ажиллагаа явуулж байгаа зах зээл.

Энэ нь нэг талаас мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй хэсэг, нөгөө талаас, мөнгөн хөрөнгийн дутагдалтай талууд санхүүгийн хэлцэл хийж, зээлэх, зээлдүүлэх хэрэгцээгээ хангах боломжийг олгодог зах зээл юм.

Санхүүгийн зах зээл нь иргэд болон байгууллагад урт, дунд, богино хугацаанд илүүдэл мөнгөө санхүүгийн хэрэгсэл болгох, санхүүгийн хэрэгслээ буцаагаад бэлэн мөнгө болгох бүхий л боломжийг олгодог.

Санхүүгийн зах зээлийг ямар төрлийн, хэдий хугацаатай, ямар санхүүгийн хэрэгсэл арилжаалж байгаагаас хамааруулж олон төрөлд хуваадаг бөгөөд энэ хэсэгт бид зах зээлийн үндсэн төрлүүдийн талаар авч үзнэ.

Мөнгөний зах зээл

Мөнгөний зах зээл:
Нэг жилээс богино хугацаатай үнэт цаасны арилжаа явагдаж байгаа зах зээл.

Мөнгөний зах зээл (цаашид МЗЗ гэх) дээр мөнгө (валют) арилжаалдаггүй, мөнгөний захын хэрэгслүүдийг арилжаална.

МЗЗ-ийн онцлог нь хөрвөх чадвар өндөртэй, богино хугацаатай (1 жил ба түүнээс бага), эрсдэл багатай байдаг. Мөнгөний захад Засгийн газар (цаашид ЗГ гэх), арилжааны банкууд, бизнесийн байгууллагууд, хувь хүмүүс оролцож болно. ЗГ болон төв банк санхүүгийн эх үүсвэр босгох зорилгоор богино хугацаатай үнэт цаас гаргаж, түүнийг нь арилжааны банкууд, компаниуд, хувь хүмүүс худалдан авах замаар богино хугацаанд илүүдэл хөрөнгөө мөнгөний зах зээлд байршуулж, хөрөнгөө өсгөх боломжтой. МЗЗ-ийн хөрөнгө оруулагчид богино хугацаанд хөрөнгөө өсгөх боломжтой бол МЗЗ-ээс санхүүжигчид богино хугацаанд шаардлагатай санхүүгийн эх үүсвэр олж авах боломжтой юм.

МЗЗ дээр арилжаалагдаж байгаа үнэт цаас нь ихэвчлэн хөнгөлөлттэй байдаг бөгөөд үнэт цаасыг нэрлэсэн үнээс нь бага үнээр хямдруулан худалддаг. Харин үнэт цаас эзэмшигчид төлбөрийг эргэн төлөхдөө нэрлэсэн үнээр хийдэг. Үүнийг хөнгөлөлттэй үнэт цаас буюу үнэт цаасыг хямдруулан худалдах үйл ажиллагаа гэж ойлгож болно.

Хөрөнгийн зах зээл

Хөрөнгийн зах зээл: Нэг жилээс дээш хугацаатай, хөрөнгө оруулалтын зориулалттай үнэт цаасыг арилжаалж буй зах зээл.

Хөрөнгийн зах зээл (цаашид ХЗЗ гэх) дээр 1 жилээс дээш хугацаатай үнэт цаасууд арилжаалагддаг. Заримдаа хөрөнгийн зах зээлийг дангаар нь үнэт цаасны зах зээл гэж нэрлэдэг.

ХЗЗ нь бондын (өрийн) болон хувьцааны (өмчийн) зах зээлийг агуулж байдаг ба эдгээр зах зээл нь харьцангуй том байдаг тул бид тус тусад нь авч үзэх болно. “Хөрөнгийн зах зээл” болон “Үнэт цаасны зах зээл” гэсэн нэр томъёог ижил утгаар ойлгож, хэрэглэх хандлага байдаг. Хөрөнгийн зах зээл нь илүү өргөн утгатай бөгөөд үл хөдлөх хөрөнгөтэй холбоотой зуучлалын үйл ажиллагааг ч давхар агуулж байдаг тул бид цааш ХЗЗ гэдгээр нь авч үзэх болно.

Мөнгөний болон хөрөнгийн зах зээл нь арилжаалж буй үнэт цаасны хугацаа, зах зээлд оролцогч талуудын зорилгоороо ялгагддаг. МЗЗ-д оролцогчид нэг талаас богино хугацааны илүүдэл хөрөнгөдөө өгөөж хүртэх, богино хугацааны санхүүжилтийн дутагдлаа нөхөх зорилгоор оролцдог. Харин ХЗЗ-д иргэд болон байгууллагууд нь урт хугацаат хөрөнгө оруулалтаас өгөөж хүртэх, урт хугацааны санхүүгийн эх үүсвэр бүрдүүлэх зорилгоор оролцдог.

Жишээ нь: *Нэгэн компанийн бүтээгдэхүүний эрэлт нэмэгдэж байгаатай холбоотойгоор шинээр үйлдвэр барихаар төлөвлөжээ. Уг үйлдвэрийг барьж ашиглалтад оруулахад урт хугацааны санхүүжилт шаардлагатай болсон. Байгууллага үйлдвэрийн санхүүжилтийг МЗЗ дээр богино хугацаатай өрийн хэрэгсэл болох өрийн бичиг гаргаж санхүүжүүлсэн гэж үзье. Энэ тохиолдолд тус өрийн бичгийн хугацаа дуусахад дахин шинэ өрийн бичиг гаргах замаар урт хугацаанд санхүүжилт авах шаардлагатай болох юм. Үнэт цаас гаргаж арилжаалахтай холбоотой аливаа зардал гардаггүй, хүүний түвшин өсөхгүй гэж үзвэл тус байгууллага богино хугацаатай өрийн бичиг гаргах нь зөв сонголт болж болох юм.*

Харин нэг талаас хүүний түвшин өссөн тохиолдолд магадгүй байгууллага өрийн бичгийн хүү болон үндсэн төлбөрөө төлж чадахгүйд хүрч болзошгүй. Нөгөө талаас богино хугацаатай өрийн бичгээ борлуулах үед үнэ буурах эрсдэл ч үүсч болзошгүй. Энэ тохиолдолд байгууллага төлбөрийн чадварын хүндрэлд орох, эсвэл шаардлагатай санхүүжилтээ татаж чадахгүй болно.

Харин үйлдвэрийг барихад шаардлагатай санхүүжилтийг урт хугацааны санхүүгийн хэрэгсэл болох бондоор санхүүжүүлсэн тохиолдолд тус байгууллагын одоогийн урт хугацаат санхүүжилтийн өртгөөр санхүүжилт татах боломжтой. Урт хугацаат өрийн өртөг богино хугацаат өрийн өртгөөс их байдаг. Хэдийгээр байгууллага өртөг өндөртэй санхүүжилт авсан хэдий ч бондын хугацаанд хүүний түвшний өөрчлөлт нь байгууллагад хүндээр нөлөөлөхгүй байж болно.

Үнэт цаас гаргагчид	Үнэт цаасны хамгийн том худалдан авагч
Засгийн газар Орон нутгийн удирдлага Засгийн газрын агентлаг Компаниуд	Хөрөнгийн зах зээлд компани, тэтгэврийн сан, хамтын сан, хөрөнгө оруулалтын сан гэх мэт санхүүгийн байгууллагууд томоохон хөрөнгө оруулагчид нь болж байдаг. Гэсэн хэдий ч эцсийн дүндээ хамгийн том хөрөнгө оруулагч нь өрх гэр, хувь хүмүүс байдаг. Жишээ нь: Хамтын сангийн эзэмшигчид нь олон тооны жижиг хөрөнгө оруулагчид буюу өрх гэр, хувь хүмүүс юм.

Санхүүгийн зуучлагчид

Хөрөнгийн зах зээлийн арилжаа

Хөрөнгийн зах зээлийн арилжаа нь анхдагч болон хоёрдогч зах зээл дээр явагдаж байдаг.

Анхдагч зах зээл²⁶: Байгууллагууд үнэт цаасаа хөрөнгийн зах зээл дээр олон нийтэд санал болгох замаар арилжаалж, санхүүгийн эх үүсвэр олох үйл ажиллагаа явагдаж буй зах зээл.

Аль нэг байгууллагын гаргасан үнэт цаасыг иргэд болон байгууллагууд санхүүгийн зуучлагч байгууллагаар дамжуулан худалдан авах, тогтоосон хугацаанд үнэт цаасны хүүний орлого, хувьцааны ногдол ашиг хүртэх боломжтой болно.

Энэ зах зээл дээр хөрөнгө оруулалтын банкууд үнэт цаасны үнийг тодорхойлон, олон нийтэд арилжаалах үйл ажиллагаа хийдэг бөгөөд үүнийг **андеррайтинг** гэнэ.

Иргэд болон байгууллагууд санхүүгийн зуучлагч байгууллагаар дамжуулан худалдан авсан үнэт цаасаа хоёрдогч зах зээлийн арилжаагаар зарах, эсвэл өөрийн байгууллагын үнэт цаасыг худалдан авах боломжтой бөгөөд үнэт цаасаа зарах, борлуулахтай холбоотойгоор үнийн зөрүүнээс орлого олох боломжтой юм.

Хоёрдогч зах зээл²⁷: Анхдагч зах зээл дээр өмнө нь гаргасан үнэт цаасыг дахин арилжаалах үйл ажиллагаа явагдаж буй зах зээл.

Энэ зах зээл дээр үнэт цаас эзэмшигчдийн хооронд гүйлгээ хийгддэг. Санхүүгийн зуучлалын гол үүргийг **брокер²⁸, дилер²⁹** гүйцэтгэнэ.

ХЗЗ-ийн арилжаа нь биржийн (зохицуулалттай) болон биржийн бус замаар хийгдэнэ. Биржийн арилжаа нь төвлөрсөн газар, зохион байгуулалттайгаар хийгддэг. Жишээ нь, Монголын хөрөнгийн бирж, Нью-Йоркийн хөрөнгийн бирж

²⁶ Монгол Улсын хууль, 2013. Үнэт цаасны зах зээлийн тухай, 4.1.4-р заалт

²⁷ Монгол Улсын хууль, 2013. Үнэт цаасны зах зээлийн тухай, 4.1.5-р заалт

²⁸ Харилцагчийн хөрөнгөөр, түүний нэрийн өмнөөс, түүний даалгавараар үнэт цаасыг худалдах, худалдан авахтай холбоотой зуучлалын үйлчилгээг гэрээний үндсэн дээр эрхлэнэ

²⁹ Өөрийн нэрийн өмнөөс, өөрийн хөрөнгөөр үнэт цаасыг худалдах, худалдан авах үйл ажиллагаа эрхлэнэ

гэх мэт. Харин биржийн бус арилжаа нь дилерүүд өөр өөрийн албан өрөөнөөс арилжаа хийх боломжийг олгодог.

Валютын зах зээл³⁰

Валютын зах зээл: Валютыг худалдах, худалдан авах үйл ажиллагаа явагдаж буй зах зээл

Валютын захыг ямар нэг байшин, газраар төсөөлж болохгүй. Учир нь валютын гүйлгээг банк, санхүүгийн байгууллагууд харилцаа холбооны технологи ашиглан явуулдаг.

Валютын зах зээл (цаашид ВЗЗ гэх) нь валютын ханшийг тодорхойлогч санхүүгийн зах зээл юм. Валютын ханш нь дотоодын болон гадаадын бараа таваарын үнэд нөлөөлдөг тул чухал нөлөөтэй зах зээл болдог байна. Жишээ нь, тухайн улсын валютын ханш чангарахад (тухайн валютын үнэ цэнэ нэмэгдэх) импортын барааны үнэ буурч, дотоод зах зээлд давуу талыг авчрах боловч, харин нөгөө талаар экспортын барааны үнэ өсөх сул талтай юм. Валютын арилжаа нь ихэнхдээ биржийн бус арилжаагаар хийгдэж байна.

Валютын ханш, түүний ач холбогдол

Валютын ханш нь аливаа хөрөнгийг өөр улсын мөнгөн тэмдэгтээр илэрхийлсэн солилцооны ханш юм.

Валют арилжааны ханшийн үндсэн хоёр хэлбэр байдаг. Үүнд:

- **Спот ханш, спот хэлцэл** - Спот зах нь хамгийн энгийн зах бөгөөд хамгийн хурднаар валют солилцох ханш буюу спот (зарласан) ханшаар арилжаа хийгддэг.
- **Форвард ханш, форвард хэлцэл** – Форвард ханш нь форвардын гэрээнд ашиглаж буй (тохиролцсон) ханш бөгөөд ирээдүйн, тодорхой хугацааны дараах ханш юм.

Мөн валют арилжааны төвүүд болон арилжааны банкуудад тухайн валютыг авах (bid) болон зарах ханш (ask) гэж байдаг. Жишээ нь: ААА арилжааны банкны ам.долларыг арилжаалахаар санал болгож буй ханшийг доор харуулав. ААА банкны хувьд 1 ам долларыг 2100 төгрөгөөр худалдан авч, 2128 төгрөгөөр зарахаар тавьсан ханш юм.

	Bid (Авах)	Ask (Зарах)
USD – АНУ-ын доллар	2100	2128

Хэрвээ харилцагч ам доллар худалдаж авах бол банкны зарах ханшаар (2128), харин ам доллар зарах (2100) бол банкны авах ханшаар тооцож арилжаа хийх юм. Валютын ханш сулрах болон чангарах гэсэн ойлголтыг гадаад ВЗЗ-д түгээмэл

³⁰ Оюунцаирал,З. (2003). Банкны удирдлага, Бүлэг 8, хуудас 232-256.

ашигладаг бөгөөд ханш сулрах гэдэг нь тухайн валютын үнэ цэнэ буурч байгааг, ханш чангарах гэдэг нь тухайн валютын үнэ цэнэ нэмэгдэж байгааг хэлж буй хэрэг юм. Жишээ нь:

Одоогийн ханш	Тодорхой хугацааны дараах ханш	
\$1 = 1917₮	\$1 = 2100₮	Ам долларын ханш чангарсан буюу төгрөгийн ханш суларсан
	\$1 = 1850₮	Ам долларын ханш суларсан буюу төгрөгийн ханш чангарсан

ТАНЫ МЭДЛЭГТ

Жишээ: Валютын ханишийн ач холбогдлыг энгийн жишээгээр авч үзье. Бат нэгэн төрийн сургуульд суралцдаг бөгөөд жилийн сургалтын төлбөр нь 1`780`000 төгрөг байна. Түүний ээж Туяа Солонгос улсад ажилладаг. 1 сард 980`000 вонын орлоготой бөгөөд сарын цалингаараа хүүгийнхээ сургалтын төлбөрийг төлөхөөр болжээ. Бат ээжээсээ ирүүлсэн мөнгийг авсан даруйдаа 1.83 ханшаар зарж, 1`793`400 (980`000*1.83) төгрөгтэй болох боломжтой байв. Гэвч Бат ханш өснө гэж үзээд мөнгөө солиулалгүй 1 сар хүлээсэн боловч 1 вон 1.54 төгрөгтэй тэнцэх болжээ. Бат 1 сарын өмнө воныг төгрөг уруу шилжүүлж төлбөрөө төлөх боломжтой байсан хэдий ч, воны ханишийн уналт, төгрөгийн ханишийн чангаралтаас шалтгаалж 980`000 воноо 1.54 ханшаар хөрвүүлж, нийт 1`509`200 төгрөгтэй болжээ. Бат ханишийн өөрчлөлтөөс шалтгаалж 284`200 төгрөгийн алдагдал хүлээж байна.

Уламжлагдсан зах зээл³¹

Санхүүгийн уламжлагдсан (үүсмэл) зах зээл нь гадаад валют, үнэт цаас, алт, нефть, үнэт металл гэх мэт хөрөнгийг урьдчилан тохиролцсон үнээр, тодорхой хугацааны дараа арилжаалах (худалдан авах, худалдах) хэлцэл хийгдэж буй зах зээл юм. Уламжлагдсан зах зээл дээр үүсмэл санхүүгийн хэрэгсэлүүд арилжаалагдах бөгөөд арилжаа нь биржийн болон биржийн бус хэлбэрээр хийгдэнэ. Энэ зах зээлд тусгай зөвшөөрөл бүхий санхүүгийн байгууллагууд оролцдог тул иргэд болон байгууллагууд хөрөнгийн үнийн эрсдэлээс хамгаалахын тулд харилцагч санхүүгийн байгууллагаар дамжин оролцоно.

Уламжлагдсан зах зээлд дараах хэрэгсэлүүдийг арилждаг. Үүнд:

Форвард хэлцэл: Тодорхой хөрөнгийг, тодорхой хугацааны эцэст, урьдчилан тохиролцсон үнээр худалдан авах, худалдах хэлцэл.

Форвардын арилжаа нь форвардын зах зээл дээр явагдах бөгөөд урьдчилан тохирсон үнийг форвард ханш гэнэ.

³¹ Оюунцаирал,З. (2003). Банкны удирдлага, Бүлэг 8, хх 257-267

Форвард арилжаа нь биржийн бус хэлбэрээр хийгдэх нь элбэг бөгөөд хатуу сонголттой форвард хэлцлийн хувьд зохион байгуулалттай биржээр арилжаалагдана. Биржийн бус арилжаа нь цаг хугацаа, орон зай, хил хязгаар харгалзахгүй хийгдэх бөгөөд арилжааны зардал бага, хүссэн хэмжээгээрээ арилжаа хийх боломжтойгоороо онцлог, давуу талтай хэдий ч, арилжааны эрсдэл буюу хэлцэл хийсэн аль нэг тал нь үүргээ биелүүлэхгүй байх эрсдэлтэй байдаг. Арилжаанд оролцогч хоёр тал ирээдүйд нэг тал нь хөрөнгийн үнэ өсөх, нөгөө тал нь буурах гэсэн таамаглалтай байх нөхцөлд хөрөнгийн үнийг урьдчилан тохиролцох бөгөөд ирээдүйд хөрөнгийн зах зээлийн үнэ өсөх, эсвэл буурахаас хамаарч аль нэг талд үнийн эрсдэлийг үүсгэнэ. Үнийн эрсдэлд орсон тал гэрээний үүргээ биелүүлэхгүй байх магадлалтай хэдий ч, мэргэжлийн ёсзүйн хэм хэмжээг олон улсын түвшинд мөрдөх нь нийтлэг байдаг.

Фьючерсийн хэлцэл: *Тодорхой хөрөнгийг, тодорхой хугацааны эцэст, урьдчилан тохиролцсон үнээр худалдан авах, худалдах үүрэг бүхий хэлцэл.*

Фьючерсийн арилжаа нь фьючерсийн зах дээр явагдах бөгөөд урьдчилан тохирсон үнийг фьючерсийн ханш гэнэ. Фьючерсийн арилжаа нь зохион байгуулалттай бирж дээр хийгддэг.

Арилжаалах хөрөнгө, хугацаа, хэмжээний хувьд стандарттай байдгаараа форвард хэлцэлээс ялгаатай байдаг. Зохион байгуулалттай бирж дээр арилжаа хийгддэг учир арилжааны зардал өндөр хэдий ч, арилжаанд оролцогч талууд гэрээний үүргээ биелүүлэхгүй байх магадлал бага байдаг.

Опцион хэлцэл: *Тодорхой хэмжээний хөрөнгө арилжаалах эрхийг олгож буй хэлцэл.*

Опционы эрх нь форвард болон фьючерстэй төстэй боловч хөрөнгийг худалдан авах, худалдах эрх олгож буйгаараа онцлог юм.

Өөрөөр хэлбэл, опционы эрх нь фьючерсийн зах зээлийн адил зохион байгуулалттай биржээр арилжаалагдах бөгөөд арилжаалах хөрөнгө, хугацаа, хэмжээний хувьд стандарттай байдгаараа фьючерсийн хэлцэлтэй ижил юм. Опционы эрх нь хөрөнгийг худалдан авах, худалдах эсэхээс хамаарч call, put гэсэн хэлбэртэй байх ба эрхийг худалдаж буй талыг опцион бичигч, эрхийг худалдан авч буй талыг опцион эзэмшигч гэнэ.

Своп хэлцэл: *Хэлцэлд оролцогч талууд өөрсдийн эзэмшиж буй төлбөрөө солилцох гэрээ.*

Валютын своп хэлцэл: *Нэг валютаар нэрлэсэн төлбөрийг нөгөө валютаар илэрхийлсэн төлбөрөөр солилцох хэлцэл.*

Ижил валютаар нэрлэсэн хүүний төлбөрийг хэлцэлд оролцогч талууд солилцох хэлцлийг хүүний түвшний своп хэлцэл гэдэг. Хүүний түвшний свопын хамгийн нийтлэг хэлбэр нь энгийн своп (plain vanilla swap) юм.

7.2. Санхүүгийн байгууллагуудын онцлог, үзүүлэх үйлчилгээ

Банкны байгууллага, түүний онцлог, үйлчилгээний тухай

Зураг 7-1-д үзүүлснээр санхүүгийн тогтолцоо нь санхүүгийн зах зээл болон санхүүгийн байгууллагуудаас бүрддэг гэж үзсэн билээ. Санхүүгийн байгууллагыг үзүүлж буй үйлчилгээнээс хамааруулан ерөнхийд нь 2 ангилдаг. Үүнд:

1. Хадгаламжийн байгууллагууд
2. Хадгаламжийн бус байгууллагууд

Хадгаламжийн байгууллага:
Байгууллага болон хувь хүмүүсээс хадагаламж төвлөрүүлэх эрх бүхий байгууллага.

Хадгаламжийн байгууллагууд нь харилцагчдаас хадагаламж хэлбэрээр мөнгөн хөрөнгө төвлөрүүлж, санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа явуулдаг.

Энд арилжааны банкууд болон хадгаламж зээлийн хоршоод орно.

- **Банк:** Хувьцаа эзэмшигчийн оруулсан хөрөнгөөс бүрдсэн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, хувьцаа эзэмшигч нь эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээдэг, бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг Төв банкны (Монголбанк) зөвшөөрөлтэйгээр эрхэлдэг, ашгийн төлөө хуулийн этгээдийг банк гэнэ³². Банк нь хувь нийлүүлсэн хөрөнгийн өмчлөлийн хэлбэрээс хамаарч төрийн, хувийн болон холимог, үүсгэн байгуулагдсан хэлбэрээс хамаарч хязгаарлагдмал хариуцлагатай болон хувьцаат, үйл ажиллагаа явуулах чиглэлээс хамаарч төрөлжсөн болон нийтлэг гэсэн хэлбэртэй байна. Монгол Улсын хувьд нийт 14 банк үйл ажиллагаа явуулж байгаагаас төрийн өмчлөлийн 1, хувийн 13, бүгд хязгаарлагдмал хариуцлагатай болон нийтлэг үйл ажиллагаатай банкууд байна. Банкны эрхлэх болон хориглох үйл ажиллагааг банкны тухай хуулиар тогтоох бөгөөд түүнд нь хяналт тавих үүргийг тухайн улсын төв банк³³ хүлээдэг.
- **Хадгаламж зээлийн хоршоо:** Гишүүдийнхээ эдийн засгийн болон нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор гишүүддээ хадгаламж, зээлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үзүүлэх ардчилсан удирдлага, хамтын хяналт бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээдийг хадгаламж зээлийн хоршоо гэнэ³⁴. Иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэж, хоршооны гишүүн болсноор санхүүгийн хэрэгцээгээ богино хугацаанд хангах боломж нэмэгдэнэ. Монгол Улсын хэмжээнд 2016 оны 3 сарын байдлаар 271 хадгаламж зээлийн хоршоо үйл ажиллагаа эрхэлж байна (СЗХ, 2016). ХЗХ-ны эрхлэх болон хориглох үйл ажиллагааг “Хадгаламж, зээлийн хоршооны тухай” хуулиар

³² Монгол Улсын хууль, (2010). Банкны тухай, шинэчилсэн найруулга, 3.1.1-р заалт

³³ Монгол Улсын хэмжээнд төрийн мөнгөний бодлогыг хэрэгжүүлэх эрх бүхий байгууллага юм.

³⁴ Монгол Улсын хууль, (2011). Хадгаламж, зээлийн хоршооны тухай, 3.1.1-р заалт

тогтоох бөгөөд түүнд хяналт тавих үүргийг Санхүүгийн зохицуулах хороо (цаашид СЗХ гэх) хүлээнэ.

Хадгаламжийн бус байгууллага:

Хадгаламж хэлбэрээр иргэд болон байгууллагаас мөнгөн хөрөнгө татан төвлөрүүлэх эрхгүй санхүүгийн байгууллага.

Хадгаламжийн бус байгууллагууд нь хадгаламж хэлбэрээр иргэд болон байгууллагаас мөнгөн хөрөнгө татан төвлөрүүлэлгүйгээр бусад эх үүсвэрээр үйл ажиллагаагаа явуулдаг.

Энд даатгалын компани, брокер, дилер, андеррайтингийн үйл ажиллагаа эрхлэгч байгууллагууд, санхүүгийн компаниуд багтана. Хадгаламжийн бус байгууллагуудын үйл ажиллагаа, онцлогийн талаар товч авч үзье.

- **Даатгалын компани:** Даатгалын гэрээний дагуу даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй ашгийн төлөө бизнесийн байгууллага юм. Эрх бүхий байгууллагаас тусгай зөвшөөрөл авсан даатгалын компанийг даатгагч³⁵ гэх бөгөөд даатгалын компанийн эрхлэх болон хориглох үйл ажиллагааг даатгалын тухай хуулиар тогтоох бөгөөд түүнд хяналт тавих үүргийг СЗХ хүлээнэ. Монгол Улсын хэмжээнд 2016 оны 3 сарын байдлаар нийт 17 даатгалын компани байгаагаас ердийн даатгалын 15, урт хугацааны даатгалын 1, давхар даатгалын 1 компани даатгалын үйл ажиллагаа эрхлэж байна (СЗХ, 2016).
- **Банк бус санхүүгийн байгууллага (цаашид ББСБ гэх):** СЗХ-ноос олгосон тусгай зөвшөөрөлтэйгөөр банк бус санхүүгийн үйл ажиллагаа эрхлэгч этгээдийг ББСБ³⁶ гэх бөгөөд бусдаас хадгаламж хэлбэрээр хөрөнгө татан төвлөрүүлэлгүйгээр, өөрийн хөрөнгө болон бусад санхүүжилтийн эх үүсвэр ашиглан иргэд, байгууллагад зээл, факторинг, төлбөрийн баталгаа, төлбөр тооцооны хэрэгсэл гаргах, валютын арилжаа, итгэлцлийн үйлчилгээ, цахим төлбөр тооцоо, мөнгөн гуйвуулга хийх, үл хөдлөх эд хөрөнгө барьцаалахтай холбоотой санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа эрхэлнэ. ББСБ-ын эрхлэх болон хориглох үйл ажиллагааг банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай хуулиар тогтоох бөгөөд түүнд хяналт тавих үүргийг СЗХ хүлээнэ. Монгол Улсын хэмжээнд 2016 оны 3 сарын байдлаар 463 ББСБ үйл ажиллагаа явуулж байгаагаас 88.3% нь зээлийн үйл ажиллагаа эрхэлж байна (СЗХ, 2016).
- **Үнэт цаасны компани:** ХЗЗ дээр үнэт цаасны арилжаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий мэргэжлийн байгууллагууд байх бөгөөд СЗХ-ноос зохицуулалттай үйл ажиллагаа эрхлэх хуулийн этгээд байна. Зохицуулалттай үйл ажиллагааны төрлөөс хамаарч үнэт цаасны брокерын, үнэт цаасны дилерийн, хөрөнгө оруулалтын сангийн, үнэт цаасны хөрөнгө оруулалтын зөвлөхийн, үнэт цаасны итгэмжлэн удирдах, андеррайтерын, үнэт цаасны

³⁵ Монгол Улсын хууль, (2015). Даатгалын тухай, шинэчилсэн найруулга, 4.1.1, 4.1.2-р заалт

³⁶ Монгол Улсын хууль, (2002). Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай, 4.1.1, 6.1-р заалт,

өмчлөх эрхийн бүртгэлийн, үнэт цаасны арилжааны тооцооны, үнэт цаасны арилжааны төлбөрийн, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн, кастодианы, үнэт цаасны арилжаа эрхлэх зэрэг үйл ажиллагааг явуулна. Үнэт цаасны компани нь эдгээр үйл ажиллагааг хуульд зааснаар хавсран хийж болно³⁷. Үнэт цаасны компанийн эрхлэх болон хориглох үйл ажиллагааг үнэт цаасны зах зээлийн тухай хуулиар тогтоох бөгөөд түүнд хяналт тавих үүргийг СЗХ хүлээнэ.

Зураг 7-2. Үнэт цаасны компаниудын хавсран хийх үйл ажиллагаа



Эх сурвалж: Монгол Улсын хууль, (2015). Үнэт цаасны зах зээлийн тухай, шинэчилсэн найруулга.

- **Зээлийн батлан даалтын сан:** Зээлийн батлан даалтын сан (цаашид ЗБДС гэх) нь банк, санхүүгийн байгууллагаас зээл авахыг хүссэн боловч зээлийн барьцаа хөрөнгө нь хүрэлцэхгүй байгаа жижиг, дунд үйлдвэр (цаашид ЖДҮ) эрхлэгчид зээлийн 60 хүртэлх хувьд, мөн ЖДҮ эрхлэгчээс гаргасан хаалттай өрийн бичгээс банк, санхүүгийн байгууллага худалдан авсан тохиолдолд уг худалдан авсан өрийн бичигт батлан даалт гаргах үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий ашгийн төлөө бус төрийн болон төрийн бус байгууллага, олон улсын байгууллага, иргэн, хуулийн этгээд ЗБДС-г үүсгэн байгуулж болно³⁸.
- **Тэтгэврийн сан:** Ажил олгогч болон ажилчдын хувь оролцоогоор бий болсон, сангийн хөрөнгө оруулалтыг удирдах зорилгоор ажил олгогчийн байгуулсан сан. Тэтгэврийн сан нь урт хугацааны тогтвортой өсөлтийг бий болгох активын багц бөгөөд ажилчдын ажиллах хугацаа дуусч, тэтгэвэрт суух үед тэдний тэтгэврийн эх үүсвэр болдог³⁹. Тэтгэврийн сан нь ХЗЗ дээр хувьцаа, бонд, хамтын сан болон үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх замаар сангийн орлогоо нэмэгдүүлнэ.

³⁷ Монгол Улсын хууль, (2015). Үнэт цаасны зах зээлийн тухай, шинэчилсэн найруулга, 51.1-р заалт

³⁸ Монгол Улсын хууль, (2012). Зээлийн батлан даалтын сангийн тухай, 4.1, 6.1, 9.1-р заалт

³⁹ Монголбанк, (2015). Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь, 128-р хуудас

7.3. Санхүүгийн зах зээл дэх хувь хүний оролцоо

Хувь хүний санхүүгийн зах зээлд оролцох боломж, давуу тал

Энэ сэдвийн хүрээнд хөрөнгийн зах зээлд жирийн иргэн хэрхэн оролцох, Хөрөнгийн биржийн үүрэг, хөрөнгө оруулагчдын эрх ашиг хэрхэн хамгаалагддаг талаар ойлголттой болохоос гадна хувийн санхүүгийн төлөвлөгөө зохиох, хэрэгжүүлэх, түүний ач холбогдлын талаар мэдэх болно. Аливаа зах зээлийг нэг талаас эрэлт, нөгөө талаас нийлүүлэлт үүсч буй талбар гэж энгийнээр ойлгож болох юм. Чөлөөт зах зээлийн онцлог нь худалдагч, худалдан авагчдын чөлөөт сонголт, итгэлцэл дээр суурилсан байдаг. Үүний сонгодог жишээ бол санхүүгийн зах зээл юм. Санхүүгийн зуучлалтай эдийн засгийн хувьд санхүүгийн зах зээл нь нэг талаас санхүүжилт шаардлагатай байгаа, нөгөө талаас мөнгөө өсгөх гэж буй талуудын уулзаж буй талбар гэж үзэж болно.

Хуримтлал үүсгэж, хүүний орлого олох зорилгоор иргэд, байгууллага банкинд мөнгөө хадгалуулдаг бол иргэд санхүүгийн дутагдлаа нөхөх зорилгоор, байгууллагууд бизнесийн үйл ажиллагаагаа санхүүжүүлэх зорилгоор банкнаас зээл хүсдэг. Үүний адилаар хөрөнгийн бирж дээр мөнгөний хэрэгцээтэй байгууллагууд хувьцаа, бонд зэрэг үнэт цаас гаргадаг бол нөгөө талаас, мөнгөө өсгөж ашиг олох зорилгоор иргэд, байгууллагууд тухайн хувьцаа, бондыг худалдан авах замаар хөрөнгө оруулалт хийдэг. Энэ үйл ажиллагаа нь хөрөнгийн биржээр дамжиж хэрэгжинэ. Мөн ирээдүйд учирч болзошгүй гэнэтийн эрсдэлийг бууруулах зорилгоор иргэд болон байгууллагууд даатгалд хамрагддаг бөгөөд эрсдэл үүссэн тохиолдолд даатгалын компаниас нөхөн төлбөр авах замаар эрсдэлээ бууруулдаг. Харин ирээдүйд хөдөлмөрийн чадвараа алдсан үедээ санхүүгийн хараат байдалд орохгүйн тулд иргэд тэтгэврийн санд хөрөнгө оруулалт хийж, ирээдүйд урт хугацааны туршид санхүүгийн хэрэгцээгээ хангах боломжийг бий болгодог.

Эдгээр санхүүгийн зуучлалын үйл ажиллагаа нь харилцан итгэлцэл дээр тогтдог учир маш эмзэг зах зээл юм. Нэг талаас, зээлдэгч банкнаас авсан зээлээ төлөхгүй бол банк иргэдийн хадгаламжийг эргүүлэн өгөх боломжгүй болно. Энэ үед зээлдэгч банкны итгэлийг алдаж, банк хадгаламж эзэмшигч иргэний итгэлийг алдах болно. Санхүүгийн зах зээлээс бусад зах зээлийн хувьд худалдан авагч нь худалдагч талд итгэлгүй болсон тохиолдолд бараагаа өөр худалдагчаас сонгох, эсвэл өөр төрлийн бараагаар орлуулах боломж байдаг бол санхүүгийн зах зээлийн хувьд банкинд итгэл алдарсан иргэн өөр аль нэг банкнаас хадгаламжийн мөнгөө авах ямар ч боломж байхгүй. Бусад хадгаламжтай иргэд ч нөгөө банкууд итгэл алдаж магадгүй гэж болгоомжилж эхэлдэг. Иймээс энэ нь нэг банкны асуудал биш, салбарын хэмжээгээр эрсдэл үүсгэж, цаашлаад тухайн улсын эдийн засагт ч сөргөөр нөлөөлдөг. Нөгөө талаас, иргэд, байгууллага санхүүгийн зуучлагчид итгэж хөрөнгөө байршуулж хөрөнгө оруулалт хийх, зээл авах зэргээр санхүүгийн хэрэгцээгээ хангахгүй бол санхүүгийн зах зээлийн мөнгөний урсгал хаагдаж, улсын эдийн засагт өсөлт бий болохгүй. Тиймээс санхүүгийн зах зээлд иргэн таны

оролцоо маш чухал юм. Иргэн та санхүүгийн зах зээлд итгэл даасан харилцагч байхын тулд хувийн, өрхийн санхүүгээ оновчтой төлөвлөж, хэрэгжүүлэх зайлшгүй шаардлагатай болно.

Санхүүгийн хэрэгсэлүүдийг ашиглан орлогоо нэмэгдүүлэх боломж, эрсдэл

Манай орны санхүүгийн тогтолцоонд банкны салбар давамгайлан хөгжсөн хэдий ч бусад санхүүгийн байгууллагууд хөгжөөгүй нөхцөлд нэг байрандаа эргэлдсээр л байх болно. Тиймээс санхүүгийн зах зээлийн тулгын 3 чулуу болсон банк, даатгал, хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг нэг түвшинд хүргэх нь чухал юм. Манайд хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаа бусад орнуудтай харьцуулахад төдийлөн сайн хөгжөөгүй боловч 2011 оноос хойш хөрөнгийн зах зээлийг сонгомол утгаар нь хөгжүүлэхийн тулд зах зээлтэй холбоотой хууль эрх зүйн орчинг шинэчилж, таатай нөхцөлийг бүрдүүлж, иргэдийн идэвхтэй оролцоо нэмэгдэж байгаа нь хөрөнгийн зах зээл хөгжих бодит боломжийг нээж байна. Өнөөдөр санхүүгийн зах зээл дэвшилтэт технологи ашиглан цахим хэлбэрт шилжин орон зай, цаг хугацаанаас үл хамааран дэлхийн зах зээлд оролцох бололцоо нэмэгдсээр байна.

Мөнгөний зах зээлд ихэвчлэн ЗГ, Төв банк, арилжааны банкууд болон томоохон хөрөнгө оруулагч байгууллагууд оролцдог. Мөнгөний зах зээлд арилжаалагддаг үнэт цаас нь харьцангуй бага эрсдэлтэйд тооцогддог ба ихэвчлэн нэг жил хүртэл хугацаатай, хөрвөх чадвар сайтай байдаг ч бусад үнэт цаастай харьцуулахад хүү буюу өгөөж багатай байдаг. Хөгжингүй орнуудад хувь хүмүүс ихэвчлэн ЗГ-ын үнэт цаас худалдаж авах, эсвэл хамтын санд хөрөнгө оруулж, түүгээр дамжуулан мөнгөний зах зээлд оролцдог. Манай улсад мөнгөний зах зээл төдийлөн сайн хөгжөөгүй байгаа хэдий ч ЗГҮЦ-ыг иргэд худалдан авах боломжийг нээсэн нь том давуу тал болсон юм.

ТАНЫ МЭДЛЭГТ

2016 оны 1-р улирлын байдлаар ЗГҮЦ-ны арилжааны 84.9% нь Монгол банкаар, 15.1% нь Монголын хөрөнгийн бирж (цаашид МХБ гэх)-ээр дамжин хийгдсэн бөгөөд тухайн тайлант хугацаанд МХБ-ээр дамжин ЗГҮЦ-ны анхдагч зах зээлийн арилжаа нийт 12 удаа явагдаж, 12, 28, 38, 52 долоо хоногийн хугацаатай нийт 392.9 мянган ширхэг үнэт цаас арилжаалснаас иргэд 4.6%-ийг худалдан авсан байна (СЗХ, 2016).

Хүснэгт 7-1. МХБ-ээр хийгдсэн ЗГҮЦ-ны арилжаа

Д/д	Харилцагчийн төрөл	Харилцагчийн тоо	Хэлцлийн тоо	Үнэт цаасны тоо	Үнийн дүн (төг)
1	Арилжааны банк	3	7	218'469	21'035'766'700
2	Иргэн	61	90	18'153	1'690'306'708
3	Төрийн бус байгууллага	1	1	1000	96'974'000
4	Аж ахуйн нэгж	15	28	155'366	14'578'283'173
5	Нийт	80	126	392'988	37'401'330'581

Эх сурвалж: Санхүүгийн зохицуулах хороо

Ихэвчлэн Монгол банк болон арилжааны банкууд мөнгөний зах зээлд арилжаа хийж байна. Цаашид санхүүгийн зах зээл хөгжсөнөөр иргэд мөнгөний зах зээлд оролцох боломж улам нэмэгдэх болно. Засгийн газар тодорхой төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэх, төсвийн алдагдлыг нөхөх болон хувийн компаниуд бизнесээ санхүүжүүлэх хөрөнгө босгох зорилгоор ХЗЗ дээр үнэт цаас арилжаалдаг.

Санхүүгийн зах зээлд оролцох арга ажиллагаа


Иргэд, байгууллагууд хөрөнгийн зах зээлд оролцохын тулд энэ зах зээлийн ажиллах ерөнхий зарчмыг мэдэх хэрэгтэй.

- **Санхүүгийн Зохицуулах Хороо (СЗХ)** нь санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, холбогдох хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих, хөрөнгө оруулагч, үйлчлүүлэгчдийн эрх ашгийг хамгаалах чиг үүрэг бүхий төрийн байгууллага⁴⁰ юм.
- **Хөрөнгийн Бирж (ХБ)** нь үнэт цаасны арилжаа эрхлэх үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл бүхий хуулийн этгээд байна⁴¹. Манай улсад ЗГ-ын 1991 оны 1 дүгээр сарын 18-ны өдрийн шийдвэрээр хувьцаат компаниудын үнэт цаасыг тодорхой шалгуурын дагуу бүртгэн авч ангилал тогтоох, үнэт цаасны арилжааг ил тод, нээлттэй, шударга явуулж, олон нийтийг үнэт цаасны арилжааны мэдээ, мэдээллээр хангаж, хөрөнгө оруулагчдын нийтлэг эрх ашгийг хамгаалах үндсэн чиг үүрэгтэй МХБ-ийг зохион байгуулсан бөгөөд 1994 онд төрийн өмчийн, ашгийн төлөө бус хуулийн этгээдийн статустай болгож, 2015 оны 10 сарын 13-ны өдрийн СЗХ-ны ээлжит бус хуралдаанаар МХБ-ийг “Өөрийгөө зохицуулах байгууллага”⁴² болгон бүртгэжээ. ЗГ-ын газрын 2015 оны 147-р тогтоол, Сангийн сайдын 2015 оны 280-р тушаалын дагуу 2016 оны 4 сарын 18 өдрөөс үнэт цаасны арилжаа эрхлэх, тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий “Монголын үнэт цаасны бирж” ХХК байгуулагджээ.

⁴⁰ Монгол Улсын хууль, (2005). Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай, 4.1-р зүйл

⁴¹ Монгол Улсын хууль, (2015). Үнэт цаасны зах зээлийн тухай, шинэчилсэн найруулга, 4.1.28-р заалт

⁴² Зохицуулалттай хуулийн этгээд болон хуулийн хүрээнд эрх авсан мэргэжилтнүүдээс бүрдсэн гишүүнчлэлтэй, тэдгээрийн эрх ашгийг хамгаалах, мэргэжлийн үйл ажиллагаа болон ёс зүйн нийтлэг журмыг тогтоох, гишүүдийнхээ чадавхийг дээшлүүлэх, үнэт цаасны зах зээлийг хөгжүүлэх, тогтвортой байдлыг хангах үндсэн зорилго бүхий мэргэжлийн холбоо, хөрөнгийн бирж, үнэт цаасны тооцооны байгууллага болон үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага байна.




Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж ХХК

- “Үнэт цаасны төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн төв” ХХК (цаашид ҮЦГТТХТ гэх) нь үнэт цаасны төлбөр тооцоо, хадгаламжийн гэсэн үндсэн хоёр үйл ажиллагааг дагнан эрхэлдэг байсныг ЗГ-ын 2015 оны 147-р тогтоол, Сангийн сайдын 2015 оны 280-р тушаалын дагуу 2016 оны 4 сарын 18-ны өдрөөс байгууллагын хадгаламжийн үйл ажиллагаанд үнэт цаасыг гэрээний үндсэн дээр төвлөрсөн хадгаламжид хадгалах, үнэт цаас эзэмшигчдийн бүртгэл хөтлөх, төвлөрсөн хадгаламжид данс нээх, хаах, өмчлөх эрхийн бүртгэлд өөрчлөлт оруулах болон үүргийн гүйцэтгэл хангуулахтай холбогдсон үйлчилгээг эрхлэхээр болгожээ.
- **Брокер, дилерийн компани** (цаашид БДК гэх) нь үнэт цаасны зах зээл дэх арилжааны үнэ ханшийн талаар мэдээлэл өгөх, тухайн өмчлөгчийн өмчлөл дэх үнэт цаасыг худалдах болон худалдан авах захиалга авч, биелүүлэх үндсэн үйл ажиллагаа эрхэлдэг.

ХЗЗ-ийн арилжаанд хэрхэн оролцох талаар ЗГҮЦ-ыг жишээ болгон тайлбарлая. Монгол Улсын ЗГ-аас иргэд, байгууллагад зориулж жижиглэнгийн үнэт цаас нэгж бүр нь 100`000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 12 сарын хугацаатай, жилийн 15 хувийн хүүтэй гаргасан. Иргэн “Д” 1`500`000 төгрөгийн хуримтлалтай бөгөөд үнэт цаасны арилжаанд оролцох хүсэлтэй байгаа гээ. ЗГҮЦ-ны арилжаанд иргэн “Д” оролцох дарааллыг зураг 7-4-д харууллаа.

Зураг 7-4. Хөрөнгийн зах зээлд оролцох нь



Эх сурвалж: Монголын хөрөнгийн бирж ХХК

- 1. Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төвд данстай эсэхээ шалгана.** Дансаа шалгахдаа www.sched.mn цахим хаягаар орж, иргэд гэсэн цэст дарж ороод, регистр гэсэн холбоосыг дарж өөрийн регистрийн дугаараа хийснээр та данстай бол аль Брокер, дилерийн компанид данс тань бүртгэлтэй байгаа болон эзэмшиж буй үнэт цаасны тухай мэдээлэл танд харагдана. Хэрэв та дансаа нээлгээгүй бол www.sched.mn цахим хаягт БДК-ийн холбоос дээр дарж, СЗХ-ноос зөвшөөрөлтэй үйл ажиллагаа явуулж буй брокер, дилерийн компаниудын мэдээллийг авч, өөрт хамгийн ойр байрлах компанид хандаж, үнэт цаасны хадгаламжийн дансаа нээлгэх шаардлагатай болно.
- 2. Шинээр үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн данс нээлгэх.** Та иргэний үнэмлэхээ аваад ҮЦТХТ-д өөрөө очих юмуу аль нэг БДК-д хандан дансаа нээлгэж арилжаанд оролцох эрхтэй болно. (Мөн данс нээлгэх хураамжийн мөнгө, банкны дансны дугаар, хүүхдэд данс нээлгэх бол төрсний гэрчилгээ, эцэг, эхийн иргэний үнэмлэх шаардлагатай) Дансаа нээлгэснээр МХБ-д

бүртгэлтэй үнэт цаасыг худалдан авах эсвэл өөрийн эзэмшлийн үнэт цаасаа арилжаалах зэрэгт ашиглагдах зориулалт бүхий данстай болно.

3. **ЗГҮЦ худалдан авах захиалга өгөх.** Өөрийн сонгосон БДК-д хандан ЗГ-ын 12 сарын хугацаатай үнэт цаас худалдан авах захиалга өгнө. Ингэхдээ ойр байгаа банкинд хандан ЗГҮЦ худалдан авах мөнгө болон худалдан авах захиалгын шимтгэл (арилжааны үнийн дүнгийн ойролцоогоор 0.05%)–ийн хамт нийт 1`500`750 төгрөгийг дансандаа байршуулна.
4. **БДК таны үнэт цаас худалдан авах захиалгыг МХБ-ийн тогтолцоод оруулах.** Таны өгсөн захиалга биелсэн тохиолдолд таны банкны данснаас мөнгө хасагдаж, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн дансанд 15 ширхэг ЗГҮЦ бүртгэгдэнэ.
5. **Иргэн “Д” ЗГҮЦ эзэмшигч болох.** Арилжаа хийгдсэнээр ЗГҮЦ эзэмшигч болж, хугацааны эцэст “Д”-ийн анх оруулсан 1`500`000 төгрөг дээр үнэт цаасны хүү болох 225`000 төгрөг нэмэгдэж, нийт 1`750`000 төгрөгтэй болно.
6. **Иргэн “Д” ЗГҮЦ-ийг эзэмшсэнээр доорх давуу талуудыг хүртэх бөгөөд давуу талаа ашиглан ЗГҮЦ-аа бүхэлд нь эсвэл хэсэгчилэн бусдад зарж, богино хугацаанд үүссэн бэлэн мөнгөний хэрэгцээгээ хангах боломжтой.**
7. **БДК-даа хандан үнэт цаасаа зарах захиалга өгөх.** “Д” өөрийн эзэмшиж байсан 15 ширхэг ЗГҮЦ-аа 6 сарын дараа зарахаар шийдсэн гэвэл өөр иргэн, эсвэл байгууллага худалдан авах захиалга өгснөөр “Д”-ийн захиалга биелэнэ.
8. **БДК таны үнэт цаас зарах захиалгыг МХБ-ийн тогтолцоонд оруулах.** Зарах захиалга биелсэн тохиолдолд “Д”-ийн үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн данснаас 15 ширхэг ЗГҮЦ хасагдаж, банкинд хадгаламжийн дансанд “Д”-ийн анх үнэт цаас худалдан авсан үнэ болох 1`500`000 төгрөг дээр эхний 6 сарын үнэт цаасны хүү болох $(1`500`000 * 0.15 / 12 * 6)$ 112`500 төгрөгийн хүү нэмэгдэж, нийт 1`612`500 төгрөг орно. Харин үлдэх 6 сарын хүү нь “Д”-ээс үнэт цаас худалдан авсан иргэн, байгууллагын дансанд орно.

ТАНЫ МЭДЛЭГТ

Хөрөнгийн зах зээл дээр 2016 оны 2-р улирлын байдлаар хөрөнгийн бирж 2, төлбөр тооцоо, төвлөрсөн хадгаламжийн байгууллага 1, брокер, дилер, андеррайтерийн 115 компани СЗХ-оос олгосон тусгай зөвшөөрлийн дагуу үйл ажиллагаа явуулж байна. Нийт 300 хувьцаат компанийн үнэт цаас СЗХ-нд бүртгэлтэй байна.

Хөрөнгийн зах зээлд оролцогч иргэд, байгууллагын эрх ашгийн хамгаалалт: Хөрөнгийн зах зээлийн гол оролцогчид болох үнэт цаас гаргагч компани, зах зээлийн мэргэжилтнүүдийн хууль бус үйлдлээс хөрөнгө оруулагчдыг хамгаалах зорилгоор төрийн хяналт, зохицуулалтыг СЗХ хийдэг. СЗХ нь зах зээлийн үйл ажиллагааг ил тод, шударга явуулах үүднээс төрөөс хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагааг зохицуулсан хууль, тогтоомж гаргадаг бөгөөд одоогоор “Үнэт цаасны

зах зээлийн тухай”, “Компанийн тухай”, “Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай” зэрэг хуулийн хүрээнд хөрөнгийн зах зээлийн үйл ажиллагаа явагдаж байна. Санхүүгийн зохицуулах хорооноос эдгээр хууль, тогтоомжид нийцүүлэн нарийвчилсан журмууд гаргаж, хууль, тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавьж, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлдэг. Хөрөнгийн бирж нь өөрийн гишүүд болон бүртгэлтэй компаниудын үйл ажиллагааг зохицуулах дүрэм, журам баталж мөрдүүлдэг. Эдгээр дүрэм, журам нь хөрөнгийн биржид бүртгэлтэй, хувьцаа, бондоо худалдаж байгаа компани болон арилжаанд оролцогч брокер дилерийн компаниуд хуулийн хүрээнд шударгаар ажиллах эрх зүйн зохицуулалтын нэг хэсэг болдог. Түүнчлэн олон нийтээс санхүүжилт авах зорилгоор хувьцаа эсвэл бонд гаргах компани нь холбогдох хууль болон СЗХ, МХБ-ээс гаргасан дүрэм, журмын тодорхой нөхцөл, болзлыг хангасан байх ёстой. Эдгээр нөхцөл, шаардлага нь нийтэд зориулан гаргаж байгаа үнэт цаасны найдвартай, эрсдэл багатай байх нөхцөлийг бүрдүүлж, хөрөнгө оруулагчид болон иргэдийн эрх ашгийг хамгаалахад чиглэгдсэн байдаг.

Санхүүгийн зах зээлд оролцогч хувь хүний хариуцлага: Аливаа гэрээ, хэлцэл хийхдээ туйлын хариуцлагатай хандах шаардлагатай. Гэрээ, хэлэлцээрт гарын үсэг зурахын өмнө уг гэрээ, хэлэлцээр нь тухайн үед хүчинтэй байгаа хууль, дүрэмтэй нийцэж буй эсэхийг нягтлан шалгаж байх хэрэгтэй. Учир нь санхүүгийн зах зээлд оролцогчийн хувьд шийдвэр гаргалт бүр мөнгөтэй холбоотой байдаг. Тиймээс шаардлагатай тохиолдолд бусдаас зөвлөгөө авч болно. Тухайлбал, банктай зээл болон хадгаламжийн гэрээ байгуулах, брокерын пүүсээ сонгох, даатгалын гэрээнд гарын үсэг зурах үед иргэд өөрсдийн хайхрамжгүй байдлаас болж хожим нь сөрөг үр дагаварт хүрэх заалт, хэлцлийг анзаарахгүй өнгөрөх тохиолдол элбэг байдаг. Түүнчлэн бэлэн маягт, өргөдөл, гэрээний загвар нь тухайн байгууллагын эрх ашгийн үүднээс бэлтгэгдсэн байх магадлалтайг санаж байх нь чухал. Гэрээний нөхцөлийг санхүүгийн байгууллагын ажилтны аман тайлбартай харьцуулж үзэхэд илүүдэхгүй.

Сэдвийн дүгнэлт

Санхүүгийн тогтолцоог санхүүгийн байгууллага, санхүүгийн зах зээлийн нэгдэл гэж болох бөгөөд эдийн засагт эргэлдэх мөнгө, санхүүгийн урсгалыг тасралтгүй явуулах чухал үүргийг хүлээж байдаг.

Санхүүгийн зуучлалгүй эдийн засгийг төсөөлөхөд ч бэрх. Тэрхүү бэрхшээлийг банк, даатгал, брокер, дилерийн компани, хөрөнгө оруулалтын болон хамтын сан, тэтгэврийн сан, ББСБ-ууд зуучлалын үйл ажиллагаагаараа дамжуулан эдийн засгийн өсөлт бий болоход дэмжлэг болж байдаг. Эдгээр санхүүгийн зуучлагч байгууллагууд нь олон төрлийн санхүүгийн зах зээлийн хэрэгслүүдийг ашиглан иргэд, байгууллагуудад санхүүгийн үйлчилгээ үзүүлдэг.

Санхүүгийн зах зээл нь иргэд болон байгууллагад урт, дунд, богино хугацаанд илүүдэл мөнгөө санхүүгийн хэрэгсэл болгох, санхүүгийн хэрэгслээ буцаагаад бэлэн

мөнгө болгох бүхий л боломжийг олгодог. Санхүүгийн зах зээлийг ямар төрлийн, хэдий хугацаатай, ямар санхүүгийн хэрэгсэл арилжаалж байгаагаас хамааруулж олон төрөлд хуваадаг.

Санхүүгийн зуучлалын гол онцлог нь итгэлцэлд суурилдаг учир нэг хүний итгэлийг алдахад салбараараа хямрах аюул ойрхон байдаг. Тиймээс иргэн хүний хувьд санхүүгийн зах зээлд оролцсон тохиолдолд эрсдэлийг даван туулж, орлого, өгөөж, ашгаа нэмэгдүүлэх боломж таны гарт бий. Санхүүгийн зах зээл танд дараах давуу тал, боломжийг олгоно. Үүнд:



Боломжийг нэмэгдүүлнэ

- Хөрөнгө оруулалтын өндөр өгөөж хүртэх
- Зардал багатай санхүүжилтийн эх үүсвэр татах гэх мэт

Эрсдэлийг бууруулна

- Хөрөнгө оруулах, санхүүжилт татах аль ч тохиолдолд мэргэжлийн санхүүгийн байгууллагыг сонгох нь цаг хугацаа, мэдээллийн, мөнгөний үнэ цэнийн эрсдэлийг бууруулдаг

Сонголтыг таны гарт өгнө

- Таны итгэлд тулгуурлан мэргэжлийн үйлчилгээг үзүүлнэ

Бататгах асуултууд:

1. Санхүүгийн зуучлалтай болон санхүүгийн зуучлалгүй эдийн засгийн ялгаа юу вэ?
2. Иргэд өргөнөөр оролцох боломжтой санхүүгийн зах зээлийг нэрлэж, учир шалтгааныг тайлбарлана уу.
3. Манай улсын хувьд банкны салбар давамгайлан хөгжихөд юу нөлөөлсөн байж болох вэ?
4. Хөрөнгийн хоёрдогч зах зээлийн арилжаанд иргэд оролцож болохгүй гэдэгтэй та санал нийлэх үү? Яагаад? Учир шалтгааныг тайлбарлана уу.
5. Хувь хүн, өрхийн хувьд санхүүгийн зах зээлд оролцсоноор ямар давуу талыг олж авах вэ?

СЭДЭВ 8. ЗЭЭЛИЙН ТӨРӨЛ, АНГИЛАЛ

Сэдвийг судлахын ач холбогдол, үр дүн

Энэ сэдвийг судалснаар зээл, түүний мөн чанар болон үйл ажиллагаагаа өргөжүүлэхэд шаардлагатай санхүүжилтийн хамгийн түгээмэл, хүртээмжтэй санхүүжилтийн төрөл нь зээл болохыг мэддэг болно. Хамгийн гол нь зээлийг орлого бүтээхэд ашигласнаар зээл эргэн төлөхөд учирч болох хүндрэлээс зайлсхийх боломжтой болох юм. Зээлийн ангилал, зарчим, нөхцөлүүдийг ойлгож, зээлийн шийдвэр гаргахдаа хэрэглэх чадвар эзэмшинэ.

Тулгуур ойлголт

- Зээл, түүний мөн чанар
- Зээлийн зайлшгүй шаардлага
- Зээлэнд хандах хандлага
- Зээлийн ангилал
- Орон сууцны зээл
- Автомашины зээл
- Оюутны зээл
- Хэрэглээний зээл
- Зээлийн үүрэг
- Зээлийн хэмжээ
- Зээлийн хугацаа
- Зээлийг эргэн төлөх хуваарь

8.1. Зээлийн тухай ойлголт

Зээл: Бусдаас тодорхой хэмжээний хүү, хугацаа, эргэн төлөх нөхцөлтэйгээр авч ашиглаж буй мөнгө.

Зээл бол мөнгө зээлдүүлэх, зээлдэхтэй холбоотой зээлдүүлэгч, зээлдэгчийн хооронд үүсч байгаа мөнгөн харилцаа юм.

Ямар нэг зүйл худалдан авах, бизнес эрхлэх, түүнийгээ өргөжүүлэхэд өөрийн мөнгө, хөрөнгө хүрэлцэхгүй үед бусдаас эргүүлж төлөх нөхцөлтэйгөөр авч ашиглаж буй мөнгийг зээл гэж ойлгоно. Зээлийн үйл ажиллагаа нь зээлдэгч, зээлдүүлэгч хоёр талын хоорондын харилцааны явцад хэрэгждэг. Зээлийг зээлдэгчийн талаас, зээлдүүлэгчийн талаас тодорхойлж болно. Зээлдэгчийн талаас авч үзвэл зээл нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх зориулалтаар авч байгаа санхүүжилтийн хэлбэр юм. Харин зээлдүүлэгчийн талаас авч үзвэл бараа, үйлчилгээнийх нь нэг төрөл болдог.

Санхүүгийн байгууллагын зээлийн үйлчилгээ буюу бүтээгдэхүүн нь өөрийн онцлогтой. Санхүүгийн байгууллагууд (банк) бусдын мөнгийг өөрийн нэрийн өмнөөс эргэлтэд оруулж орлого, ашиг олж, санхүүжилт хийж байгаа үйлчилгээний нэг хэлбэр.

Зээл бол арилжааны банкны орлого олдог үндсэн үйлчилгээ юм. Зээлийн харилцааны дүнд банк орлого олдог бол аж ахуйн нэгж болон зээлдэгчид нь орлого, ашиг авчрах бараа, үйлчилгээ үйлдвэрлэх санхүүгийн эх үүсвэртэй болдог. Зээл

авсан нийт аж ахуйн нэгжүүдийн бүтээн байгуулалтаар улсын эдийн засгийн хөгжил явагдана. Үүнд зээлийн ач холбогдол оршдог.

Банк дараах шалтгааны улмаас зайлшгүй зээл олгодог. Үүнд:

1. Монгол Улсын “Банкны тухай хууль”-д банкны үндсэн үүргийн нэг нь “зээл” олгох гэж заасан байдаг. Иймээс банкууд хуулийн хүрээнд зайлшгүй зээл олгох үүрэг хүлээнэ.
2. Банкны үйл ажиллагаа явуулахад тодорхой хэмжээний зардал гардаг ба эдгээр зардлыг нөхөхөд шаардлагатай орлогыг олох гол үйлчилгээний нэг нь зээл юм.
3. Банк нь бизнесийн байгууллага бөгөөд ашгийн төлөө үйл ажиллагаа явуулдаг. Зээл нь ашиг авчирдаг гол үйлчилгээ юм.

Харин аж ахуйн нэгж, иргэд дараах зайлшгүй шаардлагын үүднээс зээл авдаг. Үүний үндэслэл нь дараах зүйлд оршино. Үүнд:

1. Нийгмийн хөгжлийг дагаад нийгмийн шинэ шинэ хэрэгцээ бий болж байдаг. Эдгээр хэрэгцээг хангахын тулд бизнесийн үйл ажиллагааг өргөжүүлэн тэлэх шаардлага зүй ёсоор урган гардаг. Үүнд санхүүжилт хэрэгтэй. Энэхүү санхүүжилтын түгээмэл нэг хэлбэр нь банкны зээл болдог.
2. Аж ахуйн нэгжүүд орлого, ашгаа нэмэгдүүлж, зах зээлд эзлэх байр сууриа өргөтгөхийн тулд үйл ажиллагаагаа өргөжүүлэх шаардлагатай байдаг. Үүнд нэмэлт санхүүгийн эх үүсвэр шаардагдах бөгөөд үүнийг хангах эх үүсвэр нь зээл болдог. Нийгмийн хөгжлийн түүхээс харахад бидний мэдэх том том компаниуд зээл авч, түүнийг үр ашигтай ашиглан, орлого бүтээж, ашиг хүртэж өдий зэрэгт хүрсэн гэдгийг дурдах ёстой.
3. Иргэд өөрийн хэрэгцээт зүйлийг худалдан авах, ахуй амьдралын нөхцөлөө сайжруулахад шаардлагатай санхүүгийн эх үүсвэр хүрэлцэхгүй тохиолдолд зээл авдаг. Бизнес эрхэлдэг иргэдийн хувьд аж ахуйн нэгжийн хөгжлийн зүй тогтолтой адил зээл авах зайлшгүй хэрэгцээ үүсдэг.

Үүнээс үзэхэд, зээл бол үйл ажиллагааг өргөжүүлэхэд зориулагддаг хамгийн хүртээмжтэй санхүүжилтийн хэлбэр төдийгүй банкны хувьд орлого олох гол арга хэрэгсэл болдог. Энэ бүхэн нь зээлийн зайлшгүй хэрэгцээ, шаардлагыг тодорхойлж байгаа юм.

ШИГТГЭЭ

Үйл ажиллагааг эхлэх болон өргөжүүлэхэд шаардлагатай мөнгийг хэд хэдэн эх үүсвэрээр бүрдүүлж болдог ба эдгээр нь тус тусдаа давуу болон сул талтай. Үүнийг хүснэгтээр харуулбал

Санхүүгийн эх үүсвэр олох хэлбэрүүд, тэдгээрийн харьцуулалт

Санхүүгийн эх үүсвэр олох хэлбэрүүд	Давуу тал	Сул тал
Эцэг эх, ах дүү, найз нөхдөөс мөнгө авах	Хүүгүй	Тэр болгон мөнгөтэй байдаггүй.
Өөрийн хуримтлуулсан ашиг	Хүүгүй	Ашгаа хуримтлуулж байгаад хөрөнгө оруулна гэвэл цаг алдана.
Төсөв (улсын, орон нутгийн)	Буцааж өгөх хэрэггүй, хүүгүй	Тодорхой зориулалттай байдаг.
Төсөл (олон улсын байгууллагуудаас хэрэгжүүлдэг. Жишээ нь малжуулах төсөл г.м.)	Буцааж өгөх хэрэггүй, хүүгүй	Тодорхой зориулалттай байдаг.
Банкны зээл	Хүртээмжтэй	Стандартаар олгогддог.
Үнэт цаасны зах зээл	<ul style="list-style-type: none"> Зардал багатай. Их хэмжээний мөнгө олох боломжтой 	Бусад танигдсан, том компаниуд л энэ захаас санхүүгийн эх үүсвэр олж авч чадна.

Санхүүгийн эх үүсвэр олж авах бусад хэлбэрүүдтэй харьцуулбал банкны зээл нь их хэмжээний мөнгийг, бүх төрлийн үйл ажиллагаанд зориулж авч болдог хамгийн хүртээмжтэй хэлбэр юм.

8.2. Арилжааны банкны зээлийн ангилал, төрөл

Арилжааны банкуудын олгож байгаа зээлийг олон шинж чанараар ангилдаг. Ангилалыг Зураг 8.1-ээс харна уу. Зурагт үзүүлсэн ангилал нь зээлийн бодлого хэрэгжүүлэхэд ашиглагддаг ба ангилал тус бүр нь зээлийн төрлүүдийг тодорхойлно. Зээлийн төрлүүдийн эзлэх хувийн жин буюу бүтцийг оновчлох замаар банк ямар зээлийг түлхүү олгох вэ? гэдэг асуудлыг шийдвэрлэж, оновчтой зээлийн багцаа бүрдүүлнэ. Тухайлбал, зээлийг хэмжээгээр нь том, дунд, жижиг хэмжээтэй гэж ангилаад, нийт зээлийн дүнд төрөл тус бүрийн эзлэх хувийн жинг тодорхойлдог. Жижиг зээл эсвэл том хэмжээний зээлийг илүү түлхүү олгохоо банк зээлийн бодлогоороо тодорхойлдог.

Зээлийг зориулалтаар нь үл хөдлөх хөрөнгийн, үндсэн хөрөнгийн, хэрэглээний, эргэлтийн хөрөнгийн гэх зэргээр ангилж болно.

Хугацаагаар нь урт, дунд, богино гэж ангилна. Энэхүү ангиллын хугацааг банк бүр өөрийн зээлийн бодлогын хүрээнд шийдвэрлэдэг. Зарим банкны хувьд богино хугацаат зээлийг сараар хэмждэг бол зарим банк 3 хүртэлх жилийн зээлийг богино

хугацаатай гэж үздэг. Дунд болон урт хугацааг ч банк бүр өөр өөрийнхөөр тогтоодог.

Зээлийг хэмжээгээр нь том, дунд, жижиг гэж ангилж үздэг. Зээлийн хэмжээг банк бүр өөр өөрөөр тогтоодог. Зарим банкны хувьд том хэмжээний зээлийг тэрбум төгрөгөөр тодорхойлдог бол зарим нь саяар (жишээ нь 500`000 сая г.м.) хэмждэг байна. Бага хэмжээтэй зээл зарим банкинд 5.0 сая төгрөг байдаг бол заримд нь 1.0 сая төгрөгийн хэмжээтэй зээл хамаардаг.

Зээл олгож буй валютаас хамаарч зээлийг төгрөгийн, долларын, бусад валютын гэж ангилдаг.

Хүүгээр нь зээлийг тогтмол хүүтэй, хувьсах хүүтэй гэж ангилдаг. Урт хугацаатай зээлийн хүү ихэнхдээ хувьсах хүүтэй байдаг.

ШИГТГЭЭ


Манай оронд орон сууцны зээлийн жилийн хүүг 8%- (+1),(-1) гэж тэмдэглэдэг. Энэ нь инфляци өсвөл +1% -аар зээлийн хүүний нормыг өсгөж, жилийн 9% болгох ба эсрэгээрээ инфляци буурвал жилийн 7% болгоно гэсэн үг юм.

Зээлийн хүүг хэзээ өөрчлөх вэ? гэдгээ зээлийн гэрээн дээр зааж өгсөн байх ба ийм заалтгүйгээр нэг тал (ихэнхдээ банк) өөрчлөх эрх зүйн орчин бүрдэхгүй.

Барьцаагаар нь зээлийг биет барьцаатай, гэрээт барьцаатай гэж ангилах ба биет барьцааг дотор нь бодит болон гэрээт гэж ангилан авч үздэг. Тухайлбал, автомашиныг барьцаалж зээл олгоход зээлдэгч машинаа унаад явж болдог бол гэрээт барьцаатай зээл, унаж явж болохгүй, банк барьцааг өөрийн граждаа хадгалах нөхцөлтэй бол бодит барьцаатай зээл гэж үзнэ.

Мөн бизнесийн байгууллагын үйл ажиллагааг нь барьцаалан зээл олгож болно. Ийм барьцаатай зээлийн эрсдэл хамгийн бага байдаг. Учир нь бараа үйлдвэрлэх, үйлчилгээ үзүүлэх үйл ажиллагаа явуулж байгаа үед борлуулалт хийгдэж, орлого олж, ашиг хүртэх нь тодорхой байдаг. Иймээс зээл төлөх магадлал өндөр юм.

Зураг 8-1. Зээлийн барьцааны ангилал



Үйл ажиллагааны барьцаатай зээлийг банк олон жил хамтран ажилласан түншүүддээ олгодог. Учир нь банк зээлдэгчийн үйл ажиллагаа цаашид ч тогтвортой ажиллана гэдгийг ойлгож, мэдэж байгаатай холбоотой.

Зээлдэгчээр нь зээлийг Засгийн газрын, компанийн, иргэдийн гэх мэт ангилдаг.

ШИГТГЭЭ

1990-ээд оны эхэн үед улсын үйлдвэрийн газрын авсан зээл нь нийт зээлд өндөр хувийг эзэлж байсан бол сүүлийн үед түүний эзлэх хувийн жин маш бага болж, хувийн компаниудын авсан зээл ихэнх хувийг эзэлж байна.


Салбараар нь зээлийг ангилахдаа зээлдэгчийн эдийн засгийн ангиллыг ашигладаг. Хөдөө аж ахуйн, түүн дотроо мал аж ахуй, газар тариалан гэж ангилж үздэг. Барилгын салбарын, дэд бүтцийн, боловсролын гэх мэтээр ангилж болдог. Ямар салбарт зээлийг түлхүү олгох нь тухайн банкны бодлогоор тодорхойлогддог.

Төлөгдөх байдлаар нь сар бүр тогтмол төлөлттэй, сар бүр үндсэн зээлийг ижил хэмжээгээр төлдөг, хугацааны эцэст бөөнөөр төлөх, хэсэгчлэн төлөх гэх мэтээр ангилдаг.

Чанараар нь зээлийг хугацаандаа байгаа, хугацаа хэтэрсэн, хэвийн бус, эргэлзээтэй, найдваргүй, муу гэж ангилдаг.

Арилжааны банкны зээлийн ангиллыг нэгтгэн Зураг 8-2-г харууллаа.

Зураг 8-2. Арилжааны банкны зээлийн ангилал



8.3. Зээлийн нийгэм эдийн засгийн ач холбогдол

Арилжааны банкуудын олгож байгаа зээл бүр нийгэм эдийн засгийн нэг асуудлыг шийдвэрлэж байдаг. Өөрөөр хэлбэл, зээл бүр микро болон макро түвшинд ач холбогдолтой байдаг. Харин ямар нэг ач холбогдолгүй зээл нь нийгэмд хор уршиг тарьдаг байна. Зээлийн зориулалт бүрээр тэдний шийдвэрлэж байгаа нийгэм эдийн засгийн асуудал юу болохыг авч үзье.

Орон сууцны зээл

Орон сууцны зээлийн нийгэм эдийн засгийн мөн чанар, ач холбогдол нь хүмүүсийн амьдрах орчинг сайжруулахад чиглэхээс гадна утаа, хөрсний бохирдол зэргийг бууруулах асуудлыг шийдвэрлэдэгт оршино. Ихэнх хүмүүст орон сууц худалдан авах мөнгө хуримтлуулахад ихээхэн хугацаа шаардагдах бөгөөд хангалттай мөнгө бүрдүүлсний дараа орон сууц авах нь амьдралын нөхцөлийг сайжруулах шийдэл болж чаддаггүй. Насан туршдаа тав тухгүй орчинд амьдарч байгаад насан туршдаа хураасан мөнгөөрөө насны эцэст байранд орох нь учир дутагдалтай юм.

Зээл авч орон сууц худалдан авснаар нэг төрлийн хуримтлалтай болох боломж бүрддэг. Үл хөдлөх хөрөнгийн үнэ урт хугацаанд өсдөг нь хувь хүн, өрх гэр хөрөнгөтэй болохоос гадна, баялгаа нэмэгдүүлэх боломжийг олгодог нь энэхүү зээлийн нийгэм эдийн засгийн мөн чанар, бас нэг ач холбогдлыг тодорхойлж байна.

ШИГТГЭЭ

Монгол Улсад ЗГ-аас хэрэгжүүлж буй хөтөлбөрийн орон сууцны зээлийн хүү бусад зээлтэй харьцуулахад хамгийн бага буюу жилийн 5-8% байгаа нь хүмүүс орон сууцтай болох боломжийг бүрдүүлж байна. Манай орны хувьд орон сууцны зээлийн урьдчилгаа төлбөр нь худалдан авч байгаа орон сууцны үнийн 30 хүртэлх хувь байдаг. Хугацаа нь 15-30 жил. Орон сууцны зээлд хамрагдахын тулд тогтмол орлоготой байх, нийгмийн даатгал төлдөг байх шаардлага тавигддаг. Энэ нь мөн хүмүүсийг ажил эрхлэх сонирхолтой болгохоос гадна, нийгмийн даатгал төлүүлж, тэтгэвэрт гарах үед нь тэтгэвэр авах боломж бүрдүүлж өгч байгаагаараа ач холбогдолтой. Орон сууцны зээл олгосноор орон сууцны эрэлт үүсч, үүнийг дагаад орон сууцны нийлүүлэлт нэмэгдэж, барилгын салбар эрчимтэй хөгжих боломж бүрддэг. Үүнд орон сууцны зээлийн нийгэм эдийн засагт үзүүлж буй ач холбогдол оршино.

Хэрэглээний зээл

Хувь хүний зээлийг дотор нь хэрэглээний зээл, боловсролын зээл гэж ангилж болдог. Хэрэглээний зээл нь өндөр үнэтэй удаан эдэлгээтэй эд зүйлсийг худалдан авахад зориулагдана. Хэрэглээний зээлийхоёр хандлага байдаг. Эхний хандлага нь тус зээл орлого бүтээдэггүй учир зээлийн эргэн төлөлтөд бэрхшээл учруулдаг гэж

үзэх үзэл. Хоёрдох хандлага нь тус зээл хэрэглээгээр дамжуулж эдийн засгийн өсөлтийг дэмждэг гэж үздэг үзэл.

ШИГТГЭЭ

Манай орны хувьд хэрэглээний зээлийг төрөл бүрийн электрон бараа, зурагт, тавилга зэргийг худалдан авахад хэрэглэдэг. Хэрэглээний зээлд шүүмжлэлтэй хандахад, импортын барааны борлуулалтыг дэмждэг нь ямар нэг хэмжээгээр үндэсний үйлдвэрлэлийн өсөлтөд сөрөг нөлөө үзүүлж байна. Жишээ нь, зээлээр гадны орнуудын тавилга (гал тогооны тавилга, буйдан) худалдан авч, гэр орноо тохижуулж байгаа нь ижил төстэй дотоодын тавилгын борлуулалтыг хязгаарлана. Үүний оронд үндэсний үйлдвэрлэлийн барааг хэрэглээний зээлээр худалдан авах боломж бүрдсэн байвал үйлдвэрийн газруудын орлого нэмэгдэж, үйл ажиллагаагаа өргөжүүлэх мөнгө, санхүүжилт орж ирэх, тэр хэмжээгээр үндэсний үйлдвэрлэл хөгжих хөрс бүрдэх боломжтой.

Боловсролын зээл

Сургалтын төлбөр төлөхөд зориулагддаг зээлийг сургалтын төлбөрийн, оюутны эсвэл боловсролын зээл гэж нэрлэдэг. Дээрх зориулалттай зээлийн хугацаа нь дунд болон урт хугацаатай байдаг. Тус зээлийг авагч нь эзэмшсэн мэргэжлийн дагуу ажилд орж, цалингаараа зээлээ эргүүлэн төлөх нөхцөлтэй байдаг. Сургалтын (боловсролын) зээлийн нийгэм, эдийн засгийн мөн чанар (ач холбогдол) нь залуучуудыг хариуцлагатай болж төлөвшүүлдэгт оршино. Өндөр хөгжилтэй орнуудын амьдралаас харахад залуучууд их, дээд сургуульд орохдоо төлбөрөө өөрөө хариуцдаг ба банкууд ч сургалтын төлбөрт зориулсан зээл өгдөг ажээ.

Оюутнууд авсан сургалтын төлбөрийн зээлээ төлөхийн тулд хурдан ажилд орох сонирхолтой байхаар зээлийн эргэн төлөх хуваарийг хийсэн байх нь сургалтын зээлийн нэг нөхцөл юм. Сургалтын төлбөрийн зээлийн өөр нэг нөхцөл нь оюутнууд ажил олгогчдын шаардлагад нийцэх сонирхолын үүднээс хичээлдээ шамдаж, сургалтын чанартаа анхаарахад түлхэц болдог. Ингэснээр чанартай, өндөр боловсролтой мэргэжилтэн бэлтгэгдэх ба тэр хэмжээгээр эдийн засгийн хөгжилд боловсролын нөлөөлөл гарч хүмүүн капитал бүрэлдэн бий болдог байна. Ингэж хариуцлагатай иргэн бэлтгэснээр улс орны хөгжилд олон талын эерэг үр дүн гардаг.

ШИГТГЭЭ

Манай оронд нийт оюутнуудын 80-96 хувь нь сургалтын төлбөрөө эцэг эх, ах дүү хамаатан садангаараа төлүүлдэг гэсэн дүн судалгаагаар* гарсан. Эцэг эхчүүдээс авсан судалгаа ч үүнийг нотолж байгаа бөгөөд авсан зээлийн зориулалт нь “хүүхүүдийнхээ сургалтын төлбөрийг төлөх”-д байсан байдаг. Сургалтын төлбөрийн дүр зураг ийм байгаа нь хэд хэдэн шалтгаантай холбоотой байж болохоор байна. Үүнд:

Нэгд, манайд ихэнх арилжааны банкууд ийм төрлийн зээл олгодоггүй.

Хоёрт, манайд 3 банк (ХАС, Ариг, Голомт банк) сургалтын зээл олгодог ч тухайн зээлийн нөхцөл нь шаардлага хангадаггүй. Тэдгээр зээл нь богино хугацаатай, хүү өндөртэй байдаг нь хэрэгцээг хангадаггүй гэж оюутнууд, эцэг эхчүүд үздэг.

Гуравт, эцэг эхчүүдэд цалингийн болон тэтгэврийн зээл олгодог.

АНУ-ын ерөнхийлөгч Обамагийн амьдралын тэмдэглэлт үйл явдлын товчооноос харахад ерөнхийлөгч болохоосоо 8 жилийн өмнө сургалтын төлбөрийн зээлээ төлж дуусан байдаг. Эндээс сургалтын төлбөрийн зээлийн хугацаа нь дундаас дээш хугацаатай байгаа нь харагдаж байна.

Хятадад оюутнууд сургалтын төлбөрийн зээл авахад барьцаанд нь эцэг эхчүүд орон байраараа тусалдаг. Тэдний өмнөөс төлбөрийг нь төлөхийн оронд залуучуудыг өөрөө өөрийгөө хариуцаж сургах нэг арга гэж дүгнэж болно.

АНУ-д залуучууд уралдаант шалгалтад тэнцэж, их, дээд сургуульд элсэн орсон захирлын тушаал гаргахад сургалтын төлбөрийн зээл авах эрх нь шууд нээгддэг байна. Өөрийн элсэн орсон сургуулийн харилцагч банкнаас оюутнууд сургалтын төлбөрийн зээлээ авдаг нь зээл авахад бүрдүүлдэг материалыг багасгаж, зээл хөөцөлдөх цаг хугацааг богинсгож, зээлийн эрсдэлийг ч бууруулдаг сайн талтай юм билээ.

Боловсролын зээл олгодог орнуудад оюутнуудад ажил эрхлэх боломж олгодог ба оюутнууд зуны амралтаараа ажил хийн, мөнгө олж түүгээрээ суралцаж байх хугацаандаа амьдрах мөнгөө бэлтгэж авах ба сурлагадаа илүү анхаарлаа хандуулах арга барилтай болдог байна. Мөн тэдний туршилагаас харахад суралцах улиралдаа ажил хийх боломжтой байдаг ба өглөө эрт, оройдоо ажил хийж хичээл таслахгүй байх нөхцөлөө бүрдүүлдэг байна. Герман улсад оюутныг цагаар ажиллуулж байгаа компаниудад татварын хөнгөлөлт үзүүлж, оюутны ажил эрхлэлтийг дэмжих тогтолцоотой ажээ.

Манай оронд оюутныг ажил эрхлүүлэх хөтөлбөрийг “Ажил эрхлэгчдийн холбоо” зохион байгуулдаг. Ажил олгогчид ажлын байрны захиалгыг хөлөмөрийн биржид өгдөг ба тэдгээр ажилд оюутан ажиллах боломжтой байдаг. Оюутнууд өдөрт 4-6 цагаас илүү ажиллаж болохгүй бөгөөд мэргэжлээрээ бол 6 цаг, мэргэжлийн биш ажил байвал 4 цаг ажиллахаар гэрээ хийдэг. Оюутан ажиллуулж байгаа нөхцөлд цагийн хөлсийг 1500-2000 төгрөг байхаар тогтоодог. Мэргэжлээрээ ажиллаж байгаа бол цагийн 2000 төгрөг, мэргэжлээрээ биш 1500 төгрөгний цалин авахаар зохицуулагдсан байдаг.

**2000, 2014, 2016 онуудад хийсэн “Сургалтын төлбөрийн зээл” сэдэвт судалгааны ажлуудаар гарсан үр дүн өөрчлөгдөөгүй.*


Автомашины зээл

Автомашин худалдан авахад зориулж олгож байгаа зээлийг автомашины зээл гэнэ. Худалдан авч байгаа автомашины зориулалт нь хувийн хэрэглээнд эсвэл орлого олох үйл ажиллагаанд зориулагдаж байдаг. Хэрэв хэрэглэх (гэр, ажил хоёрын хооронд явах, хүүхдээ хүргэж өгөх) гэж худалдан авч байгаа бол тус зээлийг эргүүлэн төлөхөд хүндрэл учирч болох юм. Харин хүн, ачаа тээвэрлэх замаар орлого олох зорилгоор тус зээлийг авч, автомашин худалдан авч байгаа бол олсон орлогоороо зээлийг хүүтэй нь хамт төлөхөд боломжтой гэж үзэж болно.

ШИГТГЭЭ

Автомашин худалдан авч унах гэж байгаа бол олон зүйлийг тооцоолж үзэх хэрэгтэй. Машины засвар, дугуй нөхөх зардал, бензин, шатах, тослох материалын зардал зэрэг нэмэгдэл зардал гардаг гэдгийг тооцоолж, машинтай болсноор олох орлого, хэмнэх зардлыг харьцуулан шийдвэр гаргах хэрэгтэй. Зарим хүмүүс хэт их шатахуун “иддэг” машин худалдан авах тохиолдол байдаг.

Зураг 8-3. Арилжааны банкуудын автомашины зээлийн дээд хэмжээний харьцуулалт



Зээлийн нийгэм, эдийн засагт гүйцэтгэх үүрэг нь арилжааны банкуудын олгож байгаа зээлийн нөхцөлүүдээр дамжин хэрэгждэг. Жишээ нь, Монгол Улсад утаа багасгаж, агаарын бохирдлыг бууруулахад хуучин биш, шинэ машин чухал учраас шинэ машин худалдан авахад зориулж байгаа зээлийн нөхцөл нь зээлдэгчдэд хуучин машин худалдан авахад зориулж олгож байгаа зээлийн нөхцөлөөс илүү тааламжтай байхаар тохируулдаг. Шинэ машины зээлийн хэмжээ их, хүү бага, хугацаа урт байх жишээтэй.

Тухайлбал, шинэ машин худалдан авахад зориулж арилжааны банкны олгох зээлийн дээд хэмжээ 150.0 сая төгрөг байхад хуучин машин худалдан авахад зориулж олгох зээлийн дээд хэмжээ нь 40.0 сая төгрөг байна.


Шинэ машин худалдан авахыг арилжааны банкуудын олгох зээлээр хэрхэн дэмжиж байгааг Зураг 8-4-т харууллаа.

Автомашинуудыг зээл олгодог банкууд худалдан авч байгаа машиныг хуучин, шинэ гэж ангилж үзэхээс гадна шинэ, хуучин машинуудыг дотор нь хүчин чадал болон насжилтаар нь ангилан үзэж, зээлийн нөхцөлийг өөр өөрөөр тогтоож өгдөг.

Жишээлбэл: ХХХХ банкны хуучин болон шинэ машин худалдан авахад зориулан олгож буй зээлийн хэмжээг Зураг 8-2-т харуулав.

Машины төрөл бүрт олгогдох зээлийн хэмжээ өөр өөр байгаа нь машины хэрэглээг зохицуулахад чиглэгддэг болно.


Зураг 8-4. ХХХХ банкны автомашины зээлийн хэмжээ




ХХХХ банкинд шинэ машины зээлийн сарын хүү 1.9%, хуучин машины зээлийн хүү 2.1% байна. Шинэ машин худалдан авахад зориулж 40.0-150.0 сая хүртэл төгрөгийн зээл олгодог бол хуучин машинд худалдан авахад зориулж 20.0-150.0 сая төгрөгийн зээл олгож байна.

Зураг 8-5. Арлжааны банкуудын автомашины зээлийн хүүний харьцуулалт.

А. Шинэ машины зээлийн хүү




Б. Хуучин машины зээлийн хүү




ХХБ-ны шинэ машины зээлийн хугацаа 36 сар байхад хуучин машиных 24 сар байна. Зураг 8.6-г харна уу.

Зураг 8-б. Арилжааны банкуудын автомашины зээлийн хугацааны харьцуулалт

А. Шинэ машины зээлийн хугацаа



Б. Хуучин машины зээлийн хугацаа



Дэлгүүрүүдэд ижил бараанууд өөр өөр үнэтэй байдгийн адилаар банкуудад ч ижил төрлийн үйлчилгээнүүд өөр өөр нөхцөлтэй байдаг. Иймээс зээлийн сонголт хийхдээ зээлийн нөхцөлийг харьцуулсны үр дүнд сонголт хийх нь зүйтэй.

Сэдвийн дүгнэлт

Бусдаас тодорхой хэмжээний хүү, хугацаа, эргэн төлөх нөхцөлтэйгээр авч ашиглаж буй мөнгийг зээл гэнэ. Зээлдэгчийн талаас авч үзвэл зээл нь үйл ажиллагаагаа өргөжүүлэх зориулалтаар авч байгаа санхүүжилтийн хэлбэр юм. Харин зээлдүүлэгчийн талаас авч үзвэл, бараа, үйлчилгээний нэг төрөл болдог. Зээл нь үйл ажиллагааг өргөжүүлэхэд зориулагддаг хамгийн хүртээмжтэй санхүүжилтийн хэлбэр төдийгүй банкны хувьд орлого олох гол арга хэрэгсэл болдог.

Арилжааны банкуудын олгож байгаа зээлийг олон шинж чанараар ангилдаг. Зээлийн ангилал нь зээлийн бодлого хэрэгжүүлэхэд ашиглагддаг. Зээлийн төрлүүдийн эзлэх хувийн жин буюу бүтцийг оновчлох замаар банк ямар зээлийг түлхүү олгох вэ? гэдэг асуудлыг шийдвэрлэж, оновчтой зээлийн багцаа бүрдүүлнэ.

Бататгах асуултууд:

1. Үйл ажиллагааг тэлэх, өргөжүүлэх нь зайлшгүй гэдгийг батлана уу?
2. Үйл ажиллагааг өргөжүүлж, тэлэхэд өөрөөр хэлбэл хөгжихөд шаардлагатай санхүүжилт хийх эх үүсвэрүүдийг тоочиж, давуу болон сул талуудыг ярилцана уу?
3. Арилжааны банкуудын олгодог зээлүүдээс аль нэгийг сонгон түүний нийгэм эдийн засагт гүйцэтгэдэг үүргийг ярилцана уу?
4. Арилжааны банк оршин тогтнодог үндэслэлийг зээлтэй холбон тайлбарлана уу.
5. Арилжааны банкны зээлийн сонголт хийхдээ юуг нь харьцуулах вэ?

СЭДЭВ 9. ЗЭЭЛИЙН УДИРДЛАГА

Сэдвийг судлахын ач холбогдол, үр дүн

Энэ сэдвийг судалснаар зээлийн эрсдэл, түүнд нөлөөлдөг хүчин зүйлс, зээлийн эрсдэлээс сэргийлэх арга замын талаар онолын мэдлэгтэй болж, зээлд хандах хандлага төлөвших болно.

Энэ сэдвээр эрсдэлгүй зээл байдаггүйг ойлгож, зээлийн эрсдэлээс сэргийлэх арга замуудтай танилцана. Банкны хувьд зээлийн эрсдэлээс хамгаалж шинжилгээ хийдэг бөгөөд уг шинжилгээний дагуу зээлдэгч өөрийгөө бэлтгэх боломжтой. Зээлийн нөхцөл болон зээлийн зарчимтай танилцсанаар зээл авахдаа юуг анхаарах вэ? гэдгийг мэддэг болно.

Зээлийн түүх нь зээлдэгчдийн хариуцлагыг харуулдаг гол үзүүлэлт бөгөөд үүнийг зээлийн эрсдэлийн үнэлгээнд шууд хэрэглэдэг тул зээлдэгчид хариуцлагатай хандах эрмэлзэлтэй болно. Мөн зээлдэгчийн үйл ажиллагаа явуулж байгаа салбар, орон зайн шинжилгээ нь зээлийн эрсдэлийг тодорхойлох аргачлалд чухал байр суурь эзэлдэгийг ойлгож авна.

Тулгуур ойлголт

- Зээл
- Зээлийн ангилал
- Зээлийн эрсдэл
- Зээлийн эрсдэлд нөлөөлдөг хүчин зүйлс
- Зээлийн нөхцөл
- Зээлийн зарчим
- Зээлийн шинжилгээ
- Зээлийн чанарын шинжилгээ
- Зээлийн тоон шинжилгээ
- Зээлдэгчийн шинж чанар
- Зээлийн барьцаа
- Орлого олох чадвар
- Зээлийн түүх
- Салбарын шинжилгээ

9.1. Зээлийн эрсдэл, түүнд нөлөөлөх хүчин зүйлс

Зээлийн эрсдэл: Зээл гэрээнд заасан хуваарийн дагуу хүүний хамт хугацаандаа төлөгдөхгүй байх магадлал.

Зээлийн эрсдэлд маш олон хүчин зүйлс нөлөөлдөг бөгөөд ерөнхийд нь 2 бүлэгт хуваадаг. Үүнд:

- a. Объектив хүчин зүйлс
- b. Субъектив хүчин зүйлс

Зээлийн эрсдэлд нөлөөлдөг бодит хүчин зүйлс нь хүний үйл ажиллагаанаас үл хамааран зээлийг эрсдэлд оруулдаг хүчин зүйлс байдаг. Зээлийг эрсдэлд оруулдаг бодит хүчин зүйлсийг дараах байдлаар ангилж үздэг. Үүнд:

1. Байгалийн хүчин зүйлс
2. Эдийн засгийн ерөнхий төлөв байдал
3. Улс төрийн хүчин зүйлс

4. Хууль эрх зүйн хүчин зүйлс
5. Бусад:
 - Соёл
 - Зан заншил
 - Шүтлэг гэх мэт


Байгалийн хүчин зүйлс: Ган, зуд, үер, газар хөдлөлт, гал түймэр гэх мэт хүчин зүйлс хамаарагдах ба эдгээр хүчин зүйлс нь бизнесийн үйл ажиллагаанд ноцтой хохирол учруулдаг. Иймээс энэ төрлийн эрсдэлээс хамгаалах, түүнийг удирдахын тулд даатгалыг өргөн ашигладаг. Жишээ нь, Мал сүргийг байгалийн буюу зудын гамшгаас хамгаалахын тулд малын индексжүүлсэн даатгалд даатгуулна. Газар тариаланд ган гачиг ихээхэн хохирол учруулдаг тул мөн даатгалд хамруулж, хохирлыг барагдуулах боломжтой. Зээлдэгчийн үйл ажиллагаа нь байгалийн давагдашгүй хүчин зүйлд өртөмтгий салбарт, тухайлбал, хөдөө аж ахуйн салбарт хамаарагдах бол даатгалд хамруулж, эрсдэлийг шилжүүлэх арга хэмжээ авах хэрэгтэй байдаг.

Эдийн засгийн ерөнхий төлөв байдал: Эдийн засгийн ерөнхий төлөв байдал зээлдэгчийн үйл ажиллагаанд зайлшгүй нөлөө үзүүлдэг. Эдийн засаг өсч байвал хүмүүсийн орлого нэмэгдэж, борлуулалтаар дамжин үйлдвэрлэл, үйлчилгээний хэмжээ өсдөг тул зээлийн эргэн төлөлтөд эерэг нөлөөтэй. Эсрэгээрээ эдийн засаг уналттай, хямралтай байвал орлого хумигдах ба энэ нь хэрэглээг бууруулж, үйлдвэрлэлийг хязгаарладаг тул зээлийн эргэн төлөлт муудна.

Улс төрийн хүчин зүйлс: Улс төр тогтвортой байгаа эсэхээс бизнесийн үйл ажиллагаа хамаардаг. Улс төр тогтворгүй байвал эдийн засгийн бодлого тодорхойгүй болж, улмаар бизнесийн байгууллагууд хүлээлтийн байдалд ордог. Улс төрийн тогтворгүй байдал засгийн газрын тогтворгүй, ойр ойрхон солигддог байдлаар илэрнэ. Эсрэгээрээ улс төр тогтвортой байвал улс орныг хөгжүүлэх бодлого тодорхой байх ба бизнесийн орчин тогтвортой, бизнесийн үйл ажиллагаа тодорхой болдог. Олон улсын туршлагаас харахад, зээлдэгч нь улс төрийн тогтворгүй байдлын үед үүсэх эрсдэлийг удирдахын тулд юуны өмнө бизнесийн стратеги төлөвлөгөөгөө шинэ нөхцөл байдалд нийцүүлэн өөрчлөх арга хэмжээг авах хэрэгтэй болно.

Хууль, эрх зүйн хүчин зүйлс: Зээлийн эргэн төлөлтөд хууль, эрх зүйн орчин маш их нөлөөтэй. Хууль, эрх зүйн хүчин зүйлийн хамгийн тодорхой жишээ бол барьцааны гэрээ бөгөөд “зээлийн барьцаанд үл хөдлөх хөрөнгө авснаар зээл эрсдэлд ороход барьцаанд байгаа эд хөрөнгийг үл маргах журмаар банк эзэмшинэ” гэсэн заалт байдаг. Гэтэл зээл төлөгдөхөө болих үед барьцааны эд зүйлсийг шүүхийн шийдвэрээр банк авах хууль, эрх зүйн заалт үйлчилдэг ч муу зээлийг шүүхээр хэлэлцэх үед зээлдэгч бүх шатны шүүхээр давж заалдан, барьцааны гэрээний хөрөнгийг барьцаалагчид үл маргах журмаар шилжүүлэх заалт биелэгдэхгүй байдал үүсдэг.

Зураг 9-1. Зээлийн эрсдэлд нөлөөлөх хүчин зүйлс



Зээлийн эрсдэлд нөлөөлөх бусад хүчин зүйлс: Үүнд тухайн улсын соёл, зан заншил, шашин шүтлэг гэх мэт хүчин зүйлс хамаарах ба зээл авсан бол төлөх ёстой, зээлийн эх үүсвэр бол хадгаламж эзэмшигчдийн мөнгө гэдгийг ойлгохгүй байх зэрэг нь зээлийн эргэн төлөлтөд сөргөөр нөлөөлдөг.

Зээлдэгч зээлээ асуудалгүй эргэн төлөхийн тулд хүний үйл ажиллагаанаас үл хамаардаг объектив хүчин зүйлс тохиолдох үед авах арга хэмжээг төлөвлөсөн байх ёстой. Зээлийн эрсдэлд нөлөөлдөг субъектив хүчин зүйлс нь хүний үйл ажиллагаанаас хамааран зээлийг эрсдэлд оруулдаг хүчин зүйлс юм. Зээлийг эрсдэлд оруулдаг субъектив хүчин зүйлсийг дараах байдлаар ангилдаг. Үүнд:

1. Зээлдэгчээс хамаарсан хүчин зүйлс
2. Зээлдүүлэгчээс хамаарсан хүчин зүйлс

Зээлдэгчээс хамаарсан эрсдэл:

Зээлдэгчийн буруутай үйл ажиллагаанаас зээл эргэн төлөгдөхгүй байх эрсдэл.

Зээлдэгч тооцоогоо буруу хийсэн, урьдчилж харах боломжгүй нөхцөл байдал үүссэн эсвэл зээлээ эргэн төлөх сэдэлгүй үед зээл эргэн төлөгдөхгүй байхыг зээлдэгчээс хамаарсан эрсдэл гэнэ.

Мөн зээлдүүлэгчээс хамаарч зээл эрсдэлд орж болно.

Зээлийн нөхцөл тохироогүйгээс үүсэх эрсдэл: *Зээл олгож байгаа нөхцөл нь зээлийг ашиглаж байгаа нөхцөлтэй тохирохгүйгээс үүсч буй эрсдэл.*

Зээлийн нөхцөл тохироогүйгээс үүсэх эрсдэл (underwrite risk) банкны үйл ажиллагаатай холбоотой бөгөөд үүнд зээлийн эдийн засагчийн мэргэжлийн ур чадвар, банкны зээлийн бодлого зэрэг зүйлс нөлөөлдөг.

Зээлийн эрсдэлд нөлөөлдөг объектив хүчин зүйлстэй холбоотойгоор эрсдэлгүй зээл гэж байдаггүй. Харин зээлийн эрсдэлийн хэмжээ харилцан адилгүй байдаг. Гэхдээ зээлийн эрсдэлд нөлөөлдөг хүний хүчин зүйлтэй холбоотой субъектив хүчин зүйлсийг удирдаж болно. Зээлийн эрсдэлийг бууруулахын тулд зээлдүүлэгчийн зүгээс зээлийн шинжилгээ хийдэг. Зарим банкуудад эрсдэлийн удирдлагын газар зээлд тохиолдож болох эрсдэлүүдийг тооцоолж, ажилладаг. Зээл өгч байгаа нөхцөл нь зээлийг ашиглах нөхцөлтэй тохирохгүй байх нь зээлийн эрсдэлийг нэмэгдүүлдэг.

9.2. Зээлийн нөхцөл, зарчим

Арилжааны банк нь “арилжааны” гэж нэрлэгддэг нэг үндэслэл нь зээлийн нөхцөлтэй холбоотой юм. Учир нь зээл гэдэг барааг нэг тал зарж, нөгөө тал худалдан авч байгаа үед арилжаа явагдаж байна гэж ойлгож болно. Мөн банк нь зээлдэгчтэйгээ зээлийн нөхцөлийн талаар харилцан ярилцаж тохиролцдог тул банк арилжааны гэдэг нэр авсан болно.

Зээлийн нөхцөл: *Зээлийн гэрээнд тусгагдсан зүйлс.*

Зээлийн нөхцөлд зээлийн хэмжээ, хугацаа, зээлийг эргэн төлөх хуваарь, хүү гэх мэт хамаардаг.

Зээлийн хэмжээ нь хэрэгжүүлэх гэж байгаа төслийн санхүүжилтэд тохирсон байх ёстой. Хэрэв “хэрэгцээнээс”-ээ илүү хэмжээгээр зээл авбал илүү авсан зээлийн хүүг төлж, зээлийн үр ашиг буурах болно. Эсрэгээрээ зээлийн хэмжээ нь шаардлагатай хэмжээнээс бага байвал төслөө амжилттай хэрэгжүүлэх боломжгүйд хүрнэ. Энэ нь мөн зээлийн эргэн төлөлтөд хүндрэл учруулж, зээлийн эргэн төлөгдөх магадлалыг бууруулна. Өөрөөр хэлбэл, зээлийн хэмжээ нь зээлдэгчийн үйл ажиллагааг санхүүжүүлэх шаардлагатай нийцэж байж л зээлийн эргэн төлөгдөх магадлал нэмэгддэг. Жишээ нь, нэг зээлдэгчдэд 5,0 сая төгрөг хэрэгтэй байхад 3,0 сая төгрөгийн зээл өгвөл төлөвлөсөн орлогоо олох боломжгүй болно. Эсвэл 5,0 сая төгрөг биш 8,0 сая төгрөг зээлдүүлбэл илүүдэл 3,0 сая төгрөгтөө хүү төлж, бизнест илүү зардал гарснаар олох орлого, авах ашгийн хэмжээ буурахад хүрнэ.

Зээлийн хугацаа нь төсөл хэрэгжих хугацаатай уялдаатай. Төсөл хэрэгжих хугацаа урт байвал зээлийн хугацаа урт, богино байвал богино байх ёстой.

Зээл хугацаатай байх шалтгаан нь юуны өмнө зээлийн эх үүсвэр хугацаатай хадгаламжийн мөнгө байдагтай холбоотой. Мөн зээл зориулагдаж байгаа үйл

ажиллагаа, төсөл нь үр ашгаа өгөхүйц хугацаатай байх ёстой. Зээлийн хугацаа нь бизнесийн мөчлөгтэй уялдан тогтоогдох ёстой. Хэрэв зээлийн хугацаа шаардлагатай хугацаанаас багаар тогтоогдвол зээл төлөхөд хүндрэл гарна. Учир нь бизнест мөнгө орж ирээгүй байхад зээл төлөх боломжгүй, зээл төлөхөд хүндрэл учирдаг. Эсрэгээрээ зээлийн хугацааг шаардлагатай хугацаанаас илүү урт тогтоовол зээлдэгч илүү хүү төлөх магадлал өндөрсөж, зээлийн өгөөж багасах, үр ашиггүй хөрөнгө оруулалт нэмэгдэх хандлагатай.


Зээлийн эргэн төлөгдөх хуваарь

Зээлдэгчийн орлого орж ирж байгаа цаг хугацааны байдлаас хамааруулж зээлийн эргэн төлөлтийн хуваарийг тогтоодог. Ер нь зээл эргэн төлөгдөх 18 төрлийн хуваарь байдаг. Хамгийн өргөн хэрэглэгддэг хуваарь сар бүр ижил хэмжээгээр төлөх хуваарь юм. Энэ хуваариар эргүүлэн төлөх мөнгөнөөс хүүд төлж байгаа хэсэг нь их, үндсэн зээлээс төлөгдөж байгаа хэсэг бага байдаг. Учир нь зээлийн үлдэгдлээс хүүний төлбөрийг тооцдогтой холбоотой.

Сар бүр ижил хэмжээгээр зээлийг эргэн төлөхийн давуу тал нь зээлдэгч мөнгөө удирдахад хялбар байдаг. Өөрөөр хэлбэл, зээлдэгч сар бүрийн төлөх мөнгөний тогтмол хэмжээг мэдэж байдаг.


Зураг 9-2-т үзүүлсэн шулуун зураасаас дээших хэсэг нь хүүний төлбөрийн, харин дооших хэсэг нь үндсэн зээлийн төлбөрийн мөнгөн дүнгийн хэмжээг илэрхийлнэ.

Зураг 9-2. Сар бүр ижил хэмжээгээр зээл төлөх хуваарь



Мөн сар бүр үндсэн зээлийг ижил хэмжээгээр төлөх хуваарь байж болно. Энэ үед сар бүр төлөх мөнгөний хэмжээ ижил биш байна. Учир нь ашигласан мөнгөний хэмжээгээр хүү төлдөг учир эхний саруудад хүү нь өндөр, сүүлрүүгээ бага болдогтой холбоотой. Дээрх хуваариар зээл эргэн төлөх үед хүү нь өндөр байх ба төлж байгаа хүүний хэмжээнээс хамаарч сард төлөх мөнгөний дүн өөр өөр байдаг. Зураг 9-3-ийг харна уу.

Зураг 9-3. Үндсэн зээлийг сар бүр ижил хэмжээгээр төлөх хуваарь



Шулуун зураасаар сар бүр төлөх үндсэн зээл тогтмол 300`000 төгрөгийг харуулсан ба сар бүр төлөх нийт мөнгөн дүн өөр өөр байна.

Зээл эргэн төлөх хугацаа орлого олох цаг хугацаатай уялдаатай байх нь зохистой. Зээл эргэн төлөх хугацааг тодорхойлохдоо үйл ажиллагааны нөхцөлтэй холбож үздэг. Худалдаа эрхэлдэг хэн нэгэн бараагаа бөөнөөр авч, жижиглэнгээр зардаг байлаа гэхэд зээл төлөх хугацааг бараа нь зарагдахаас өмнө төлөгдөхөөр хийж болохгүй. Харин бараа нь зарагдах хэмжээгээр зээл төлөх хуваарь гаргавал зээлийн эрсдэл буурна. Барилгын компани орон сууцны барилга барихаар зээл авлаа гэж бодоход байраа зарж эхэлснээр зээлээ төлж эхлэх боломжтой. Тэгэхээр байр зарагдах бүрт зээлээ төлөхөөр хуваарь хийж болно. Гэхдээ зарагдсан байрны бүх мөнгөөр зээл төлүүлэх хуваарь хийж болохгүй. Учир нь тус компани ажилчдынхаа цалинг олгохоос гадна бусад олон төрлийн зардал гаргана. Иймээс компанид орж байгаа мөнгөний тодорхой хэсгээр зээлийг төлүүлэх хуваарь хийх нь зөв юм.

Зээлийн хүү: Арилжааны банкны зээлийн үйлчилгээний үнэ.

Хэрэв зээлийн эрсдэл их бол хүүг өндөр тогтооно. Эсрэгээрээ эрсдэл нь бага гэж үнэлж байгаа бол зээлийн хүүг багаар тогтооно.

Үүний нэг тод жишээ бол давтан авч байгаа зээлийн хүү юм. Өмнө нь авсан зээлээ гэрээний дагуу амжилттай төлбөл, дараа давтан авч байгаа зээлийн хүүг бууруулж тогтоодог. Аливаа бараа үйлчилгээний үнэ нь түүний эрэлт нийлүүлэлтээс хамаарч тогтдогтой ижил зээлийн хүү нь зээлийн эрэлтээс хамаарч тогтоогддог.

Нөгөө талаас зээлийн хүү нь эрсдэлийн хэмжүүр болдог. Хэрэв зээлийн эрсдэл их бол хүүг өндөр тогтооно. Эсрэгээрээ эрсдэл нь бага гэж үнэлж байгаа бол зээлийн

хүүг багаар тогтооно. Үүний нэг тод жишээ бол давтан авч байгаа зээлийн хүү юм. Өмнө нь авсан зээлээ гэрээний дагуу амжилттай төлбөл, дараагийн давтан авч байгаа зээлийн хүүг бууруулж тогтоодог. Энэ нь зээлдэгч үйл ажиллагаа явуулж, орлого олж байгаа гэдгээ өмнөх зээлээрээ баталсан учраас энэ удаагийн зээлийн эрсдэлийг бага гэж үзэн бууруулж байгаа гэсэн үг. Ийм маягаар арилжааны банкууд давтан авч байгаа дараа дараагийн зээлийн хүүг 0.1-0.5 пунктээр бууруулж байдаг.

Зээлийн хүү нь нийгэм, эдийн засгийн хөгжилд зохицуулагчийн үүрэг гүйцэтгэдэг. Тухайлбал, архи болон согтууруулах ундааны хэрэглээг бууруулах бодлого явуулж байгаа бол тийм чиглэлийн үйл ажиллагаанд зориулсан зээлийн хүү бусад зээлийнхээс илүү өндөр байна. Ингэснээр архи болон согтууруулах ундааны үнэ өсч, хэрэглээг хязгаарлахад нөлөөлнө.

Зээлийн хүү нь зээлийн үйлчилгээний үнэ болох талаасаа дараах хүчин зүйлээр тодорхойлогддог. Үүнд:

1. Зээлийн эх үүсвэрийн зардал
2. Зээл олгохтой холбоотой гарч байгаа банкны зардал
3. Банкны ашиг (Банк бол ашгийн төлөө ажилладаг хувийн бизнесийн нэг төлөөлөл)
4. Инфляци (зээлийн хүү нь инфляцийн түвшинг шингээсэн байх ёстой)

Зээлийн зарчим

Зээл олгохдоо зээлийн эрсдэлийг бууруулахын тулд дараах зарчмуудыг баримталдаг. Үүнд:

1. Зээл зориулалттай байх
2. Зээл хэмжээтэй байх
3. Зээл хугацаатай байх
4. Зээл хүүтэй байх
5. Зээл барьцаа, баталгаатай байх
6. Зээл төлөх эх үүсвэр нь зээлийг ашиглаж олсон орлого байх

Зээл заавал зориулалттай байдаг. Зээл зориулалтын дагуу ашиглагдаж байж эрсдэл буурна. Банк зээл олгохдоо тухайн мөнгө юунд зориулагдаж, ямар орлого, ашиг олох талаар судалж байж зээл олгодог. Хэрэв зээл зориулалтаараа ашиглагдахгүй, өөр зүйлд зориулагдвал зээлийн эргэн төлөгдөх магадлал буурдаг. Зээл болгон өөрийн гэсэн зориулалттай тул банкуудын олгож байгаа зээл бүр тодорхой зориулалтын нэртэй байдаг.

ШИГТГЭЭ

Монгол Улсын арилжааны 14 банк 70-аад төрлийн зээл олгож байна. Банк бүр өөрийн онцлогтой зээл олгодог ба гурваас дээш банк нь нийт 20-иод төрлийн зээл олгож байна.

Банкуудын олгож байгаа зээлүүдийг дор тоймлон харуулав. Үүнд:

- | | |
|---------------------------------------|----------------------------------|
| 1. Өрхийн зээл | 11. Тэтгэврийн зээл |
| 2. Хадгаламж барьцаалсан зээл | 12. Орон сууц худалдан авах зээл |
| 3. Тэтгэврийн зээл | 13. Хашаа байшин барих зээл |
| 4. Шинэ автомашины зээл | 14. Эргэлтийн хөрөнгийн зээл |
| 5. Хуучин автомашины зээл | 15. Хөрөнгө оруулалтын зээл |
| 6. Амины орон сууц худалдан авах зээл | 16. Зээлийн шугам |
| 7. Амины орон сууц барих зээл | 17. Орон сууц барьцаалсан зээл |
| 8. Хашаа байшин худалдан авах зээл | 18. Бичил бизнесийн зээл |
| 9. Цалингийн зээл | 19. Орон сууцны 8%-н зээл |
| 10. Хадгаламж барьцаалсан зээл | 20. Өрхийн зээл |

Эх сурвалж: 2016 оны 6-р сарын байдлаар арилжааны банкуудын цахим хуудсууд. Үүнд:

[1. www.golomtbank.com](http://www.golomtbank.com)

[2. www.khanbank.mn](http://www.khanbank.mn)

[3. www.capitron.mn](http://www.capitron.mn)

[4. www.capitalbank.mn](http://www.capitalbank.mn)

[5. www.ckbank.mn](http://www.ckbank.mn)

[6. www.transbank.mn](http://www.transbank.mn)

[7. www.tdbm.mn](http://www.tdbm.mn)

[8. www.arigbank.mn](http://www.arigbank.mn)

[9. www.ubcbank.mn](http://www.ubcbank.mn)

[10. www.statebank.bn](http://www.statebank.bn)

[11. www.nibank.mn](http://www.nibank.mn)

[12. www.creditbank.mn](http://www.creditbank.mn)

[13. www.chingiskhanbank.mn](http://www.chingiskhanbank.mn)

[14. www.xasbank.mn](http://www.xasbank.mn)

Зээл хэмжээтэй байх ёстой. Зээлдэгчийн хэрэгжүүлэх гэж байгаа төслийн санхүүжилтэд зориулж байгаа учир түүнд тохирсон санхүүжилт байх нь төлөвлөсөн орлого, ашгаа олох боломжийг бүрдүүлнэ.

Зээл хугацаатай байх ёстой. Зээлийн эх үүсвэр нь хадгаламжийн мөнгө байдаг учраас эзэд нь буцааж авах, банк буцааж өгөх ёстой. Түүнээс гадна зээлийн мөнгө нь тодорхой хугацааны дараа ашгаа өгөх тул тэр хугацаанд зээлээ эргүүлэн төлөх ёстой. Иймээс зээл хугацаатай байх ба хэрэв хугацаагүй бол бэлэг болно.

Зээл хүүтэй байх ёстой. Банк ашгийн төлөө бизнесийн байгууллага бөгөөд зээлийн хүүний орлогоор зээлийн эх үүсвэрийн (хадгаламжийн хүүг) зардлыг нөхөөд ашигтай үлдэж байж оршин тогтноно. Иймээс зээл нь заавал хүүтэй байх ёстой. Зээл бол хандив тусламж биш.

Зээл нь барьцаа, баталгаатай байх ёстой. Зээлийн эрсдэлээс сэргийлэх нэг арга нь зээлийн барьцаа юм. Зээлийн барьцаа нь зээл эргэн төлөгдөхгүй болсон үед зээлдүүлэгчийн эрсдэлийг хаах хэрэгсэл болдог. Мөн зээлдэгч зээлээ төлж чадахыг баталсан гуравдагч этгээдийн баталгаа гаргуулан авах нь зээлийн эрсдэлийг бууруулна.

Зээл төлөх эх үүсвэр нь зээлийн ашиглалтаас олсон орлого байх ёстой. Зээл нь орлого бүтээх зүйлд зориулагдах хэрэгтэй ба ингэж чадсан тохиолдолд дарамтгүй төлөгдөнө. Зээлдэгч зээлийг хэрэглээндээ зарцуулбал зээл төлөх эх үүсвэргүй болох ба өрийн дарамт үүсэх гол үндэс болно. Иймээс хэрэглээний зээлийг авахгүй байх хэрэгтэй гэсэн хандлага ч бий.

9.3. Зээлийн шинжилгээ

Зээлийн эрсдэлийг бууруулах нэг гол арга бол зээлийн шинжилгээ байдаг. Зээлийн шинжилгээг 2 чиглэлээр хийдэг. Үүнд:

1. Чанарын шинжилгээ
 - a. 5 Си-гийн шинжилгээ
 1. Character- Зээлдэгчийн шинж чанар
 2. Capital – Хөрөнгө
 3. Capacity- Орлого олох чадвар
 4. Collateral – Барьцаа
 5. Conditions – нөхцөл байдал
 1. Макро
 2. Микро
 - b. Зээлийн түүх
 - c. Хөрөнгө хуваарилалтын мөчлөг
 - d. Салбарын шинжилгээ
2. Тоон шинжилгээ
 - a. Санхүүгийн баримтын шинжилгээ.
 1. Тайлан тэнцэл
 2. Орлого үр дүнгийн тайлан
 3. Мөнгөн гүйлгээний тайлан
 4. Санхүүгийн харьцаа
 - b. Санхүүгийн төсөөллийн шинжилгээ

Зураг 9-4. Зээлийн эрсдэлийн удирдлага



Зээлийн эрсдэлийг бууруулахад чиглэсэн эдгээр шинжилгээг хийхэд хоёр тал (зээлдүүлэгч, зээлдэгч) аль аль нь нэг ижил шалгуурын хоёр талд зогсож байдаг. Нэг талаас, банк эрсдэлийг бууруулах шалгуур тавьж, түүнийг биелүүлж байна уу,

үгүй юу гэдгийг шинжилдэг ба эдгээр шалгуурт зээлдэгч тэнцсэн байх ёстой. Өөрөөр хэлбэл, банк зээлдэгч дээр шинжилгээ хийж байгаа тул зээлдэгч банкнаас зээл авахад учрах эрсдэлийг бууруулах арга хэмжээг банкны шинжилгээн дээр үндэслэн авна гэж ойлгож болно. Жишээлбэл, чанарын шинжилгээний “5 Си”-гийн эхнийх болох “зээлдэгчийн шинж чанар”-ын шинжилгээ зээлдэгчийн шударга эсэхийг тодорхойлоход чиглэгдэнэ.

Зээлдэгчийн шударга эсэхийг тодорхойлдог арга нь ярилцлагын арга байдаг ба зээлдэгч худал, үнэн ярьж байгааг илрүүлэхэд чиглэдэг. Илрүүлэх олон арга байдаг ба хамгийн түгээмэл хэрэглэгддэг нь ижил нэг хариулттай байх асуултыг олон янзаар, өөр өөр газар тавьдаг. Хэрэв зээлдэгч үнэхээр зээл авах үйл ажиллагаагаа (төслөө) мэдэж, эрхэлж байвал асуултын хариулт хаана ч, хэзээ ч нэг л байдаг. Иймд зээлдэгч үнэхээр тодорхой үйл ажиллагааг эрхлэхийн тулд зайлшгүй зээл авах хэрэгтэй. Худлаа ярьж, зээлийг зориулалтын бус хэрэглэхгүй байх ёстой. Зээлийг зориулалтын дагуу хэрэглэх нь зээлийн эргэн төлөлтөнд аливаа хүндрэл гарахгүй байх магадлалыг өсгөдөг. (Магадгүй зээлдэгчээс хамаарахгүй хүчин зүйлс болох байгалийн гамшиг зэрэг тохиолдохгүй бол зээл эргэн төлөх тэр орлогыг зээлийн эх үүсвэрийг ашиглан бүтээнэ гэсэн үг.)

Capital – Хөрөнгө

Зээлдэгч хөрөнгөтэй байх ёстой. Банк хэзээ ч ямар ч төслийг 100 хувь санхүүжүүлдэггүй. Төсөл хэрэгжүүлэгчийн хөрөнгө нь бизнесийн үйл ажиллагаанд оролцсоноор зээлийн эрсдэл маш их хэмжээгээр буурдаг. Учир нь зээлдэгч өөртөө хөрөнгөө оруулснаар зээлээ эргүүлэн төлөх хариуцлага асар их нэмэгддэг. Туршлагаас харахад банкны зээлээр 100 хувь санхүүжүүлсэн үйл ажиллагааны эрсдэл өндөр байдаг байна. Иймээс зээлдэгч өөрийнхөө хөрөнгөөс хэрэгжүүлэх гэж байгаа төсөлдөө хөрөнгө оруулах чадвартай байх ёстой. Нөгөө талаас зээлдэгчийг хөрөнгөтэй байхыг шаардах нь түүнийг ажил хэрэгч хүн гэдгийг баталдаг. Өнөөдрийг хүртэл ямар ч хөрөнгөгүй байгаа хүн зээл аваад бүтээлч хандана гэхэд эргэлзээтэй гэж дүгнэдэг.

Capacity- орлого олох чадвар

Олон улсын туршлагаас харахад зээлдэгч орлого олох чадвартай эсэх нь дараах хүчин зүйлтэй холбоотой байдаг. Үүнд:

1. Нас
2. Мэргэжил
3. Туршлага

Эдгээр хүчин зүйлсийг оноогоор үнэлж, эрсдэлийн хэмжээг тодорхойлдог. Эрсдэл их байх хэрээр оноо өндөр байхаар аргачлал боловсруулна. Жишээ нь, зээлдэгчийн нас эрсдэлд хэрхэн нөлөөлөхийг дараах байдлаар үнэлж оноо өгдөг. Хэт залуу бөгөөд хөгшин бол өндөр оноо өгнө. Зээлдэгч залуу байх тусам туршлага бага, настай байх тусам туршлагатай ч эрүүл мэндийн хувьд эрсдэл өндөр гэж үнэлдэг

байна. Зээлдэгчийн нас идэр нас руу дөхөх тусам эрсдэл харьцангуй бага гэж үзэн оноог багасгана.

Аливаа бизнесийн амжилтад мэргэжил ихээхэн нөлөөлдөг. Иймээс эрхлэх гэж байгаа бизнес, үйл ажиллагаатай зээлдэгчийн мэргэжил хэр холбоотой байгаагаар нь оноо өгнө. Жишээ нь, эмч хүн хувийн эмнэлэг ажиллуулах, түүнийг өргөжүүлэх гэж байгаа бол эрсдэл бага байна гэж үнэлэн холбогдох оноог бага өгнө. Эсрэгээрээ эрхлэх гэж байгаа үйл ажиллагаатай зээлдэгчийн мэргэжил огт холбоогүй бол эрсдэл өндөр гэж үзнэ. Жишээ нь: эмч мэргэжилтэй хүн барилга барих зориулалтаар зээл хүсч байвал эрсдэл өндөр гэж үзнэ.

Зээлийн эрсдэлийг бууруулахад туршлага буюу тус бизнесийг эрхэлсэн хугацаа ихээхэн чухал. Бидний дээр дурдсан жишээнээс үзэхэд эмч мэргэжилтэй хүн олон арван жил барилгын салбарт амжилттай ажиллаж, олон байр, хороолол барьсан байвал зээлийн эрсдэлийг үнэлэх оноо бага байна.

Орлого олох чадварын шинжилгээг дүгнэхдээ зээлдэгчийн үзүүлэлт бүрээр авсан оноог нэгтгэж, бага бол зээл өгнө, тодорхой хязгаараас өндөр гарвал өгөхгүй гэдэг журмыг банк баримталдаг.

Collateral – барьцаа

Эрсдэлгүй зээл гэж байхгүй ч эрсдэлийнхээ хэмжээгээр ялгаатай байдаг. Иймээс зээл олгохдоо барьцаа авдаг ба барьцаанд ямар ч хөрөнгө байж болно. Гагцхүү хөрвөх чадвартай л байх ёстой. Банк бүр зээлийн барьцаанд авч болох хөрөнгө, авч болохгүй хөрөнгөө зааж өгсөн байдаг.

Conditions – нөхцөл байдал

Бизнесийн ч бай аливаа үйл ажиллагаанд орчин чухал үүрэгтэй. Иймээс зээлийн эрсдэлийг удирдахдаа орчны шинжилгээ хийдэг. Орчны шинжилгээг микро, макро түвшинд хийх ба зээлдэгчийн макро орчинд түүний бэлтгэн нийлүүлэгчид, худалдан авагчид болон өрсөлдөгчийг хамруулан судална. Дээрх субъектүүдийн үйл ажиллагаа нь зээлдэгчийн үйл ажиллагаанд шууд нөлөөлдөг. Бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчидтайгаа урт хугацаанд гэрээний үндсэн дээр ажилладаг бол эрсдэл бага, өрсөлдөгч олонтой бол зээлдэгчийн борлуулалт, орлого цаашлаад ашигт нөлөө үзүүлэх нь ойлгомжтой. Гэхдээ нэг зүйлийг анхаарах хэрэгтэй. Өрсөлдөгч хүчтэй байхын хэрээр үйл ажиллагаа эрчимждэг болохоор өрсөлдөгч бол хөгжлийн хөшүүрэг гэдгийг тэмдэглэх нь зүйтэй.

Зураг 9-5. Бизнесийн орчны шинжилгээ



Эрсдэлийг бууруулах зорилгоор хийдэг “5Си”-гийн шинжилгээ нь зээлдэгчийг үнэнч, шударга байж, орлого бүтээх зүйлд зээлийн хөрөнгөө зориулах хэрэгтэй гэдгийг харуулахаас гадна хөрөнгөтэй бай, мэргэжлээрээ бизнес хий, түншлэлийн зарчмыг баримтал гэдгийг хэлж байдаг.

Зээлийн түүх

Зээлийн эрсдэлийг бууруулахад нөлөөлдөг өөр нэг чухал хүчин зүйл бол зээлийн түүх. Иймээс ажил хэрэгч хүмүүс зээлийн сайн түүхийг бүтээх тал дээр ихээхэн анхаардаг. Зээлийн түүхийн агуулга нь “Нэр хугарахаар, яс хугар” гэдэг санаа илэрхийлдэг. Зээлийн түүхийн гол хэсэг нь өмнө авсан зээлийг хугацаандаа төлж байсан эсэх, хэр зэрэг хугацаа хоцруулж төлж байсан талаарх мэдээлэл юм. “Муу нэрийг хусавч арилахгүй, сайн нэрийг хүсэвч олдохгүй” гэж манай ухаант ард түмэн ярьдаг.

Салбарын шинжилгээ

Зээлийн чанарын шинжилгээнд салбарын шинжилгээ мөн чухал байр суурь эзэлдэг. Салбарын шинжилгээний зорилго нь салбарын эрсдэлийг тодорхойлох зорилготой бөгөөд зээлийн эрсдэлийг удирдахын тулд салбарын шинжилгээ заавал хийх хэрэгтэй. Тухайлбал, уул уурхайн салбарт үйл ажиллагаа явуулж байгаа зээлдэгчийн эрсдэлд дэлхийн түүхий эдийн зах зээлийн үнийн уналт нөлөөлж, тухайн салбарын зээлдэгчдийн эрсдэл өснө.

Зээлийн тоон шинжилгээ

Зээлийн эрсдэлийг бууруулахын тулд зээлдэгчийн санхүүгийн баримт дээр шинжилгээ хийдэг. Борлуулалт өсч байна уу? Нэгж бараа, үйлчилгээний зардал буурч байна уу? Ашиг өсч байна уу? гэдгийг тоогоор харахаас гадна өөрийн хөрөнгө нь өсч байна уу? Нэгж хөрөнгөөс хичнээн хэмжээний орлого олж байна гэх зэрэг мэдээллийг авч судлах хэрэгтэй. Ийнхүү тоон шинжилгээг наад зах нь сүүлийн 3 жилийн санхүүгийн баримт дээр хийх нь зээлдэгчийн үйл ажиллагааны хандлагыг тодорхойлоход тустай юм.

ШИГТГЭЭ

Банк олгох гэж байгаа зээлдээ чанарын болон тоон шинжилгээ хийдэг. Тоон шинжилгээг санхүүгийн баримт (аж ахуйн нэгжийн тайлан тэнцэл, орлого үр дүнгийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан) дээр хийдэг. Тоон шинжилгээ нь санхүүгийн баримтын үзүүлэлтүүдийг ашиглан тооцоолол хийнэ гэсэн үг. Тоон шинжилгээ 2 зорилготой. Үүнд:

1. Зээлийн эрсдэлийг тодорхойлох. (Эрсдэлгүй зээл гэж байдаггүй ба эрсдэлийн хэмжээгээрээ зээлүүд ялгаатай.)
2. Зээлийн нөхцөлийг (зээлийн хэмжээ, хугацаа, хүү, эргэн төлөх хуваарийг) тодорхойлох.

Сэдвийн дүгнэлт

Зээл гэрээнд заасан хуваарийн дагуу хүүний хамт хугацаандаа төлөгдөхгүй байх магадлалыг зээлийн эрсдэл гэнэ. Зээлийн эрсдэлд зээлдэгчийн болон зээлдүүлэгчийн үйл ажиллагаа нөлөөлдөг.

Зээлийн эрсдэлээс хамгаалах зорилгоор зээл нь хүүтэй, эргэн төлөгдөх хугацаатай, хэмжээтэй, зориулалттай, барьцаатай, зээлийг ашиглан бий болгосон орлогоор эргэн төлөгддөг байх гэсэн зарчим баримтладаг.

Зээлийн эрсдэлийг бууруулах нэг гол арга бол зээлийн шинжилгээ байдаг. Зээлийн шинжилгээг чанарын ба тоон гэсэн 2 чиглэлээр хийнэ. Чанарын шинжилгээнд “5Сн”-гийн шинжилгээ, зээлийн түүх, салбарын шинжилгээ хамаардаг бол тоон шинжилгээнд санхүүгийн баримтын болон төсөөллийн шинжилгээ багтдаг.

Бататгах асуултууд:

1. Зээлийн удирдлагын зорилгыг тодорхойлно уу.
2. Зээлийн эрсдэлийг бага байлгах гэдэг санааг хэлэлцэнэ үү.
3. Зээлийн эрсдэлийг бага байлгахын тулд авдаг арга хэмжээг тоочно уу.
4. Зээлдэгч яагаад шударга байх ёстой талаар ярилцана уу.
5. Зээл зориулалтаараа ашиглагдахгүй байхад ямар эрсдэл, яагаад үүсдэг вэ?
6. Банкны хийдэг “5 Сн”-гийн шинжилгээг мэдэхийн ач холбогдол юу вэ?
7. Зээлдэгчийн салбарын шинжилгээний үүрэг юу вэ?

БҮЛЭГ IV. ХУВИЙН САНХҮҮГИЙН ШИЙДВЭР ГАРГАЛТ

СЭДЭВ 10. ХАДГАЛАМЖИЙН ШИЙДВЭР ГАРГАЛТ

Сэдвийг судлахын ач холбогдол, үр дүн

Энэ сэдвийг судалснаар хуримтлал, хадгаламж, тэдгээрийн төрөл, онцлог, хадгаламжийн орлогын тооцооллын талаар онолын мэдлэгтэй болж, харьцуулалт хийх замаар хадгаламжийн оновчтой шийдвэр гаргах чадварыг эзэмшинэ.

Тулгуур ойлголт

- Хуримтлал
- Санхүүгийн хуримтлал
- Хадгаламж
- Хадгаламжийн даатгал
- Хугацаагүй хадгаламж
- Хугацаатай хадгаламж
- Хадгаламжийн хүү
- Хадгаламжийн өгөөж

10.1. Хуримтлалын тухай ойлголт, мөн чанар

Хуримтлалын зорилго, ач холбогдол

Хуримтлал гэдэг нь үгийнхээ хувьд хуримтлах үйлийн нэр бөгөөд юмтай болох, бага багаар нэмэгдэж, арвижин их болох⁴³ гэсэн утгыг илэрхийлдэг бол агуулгын хувьд ямар нэгэн зүйлийг ирээдүйд өөрт ашиглах (үнэ, цэнийг мэдрэх) боломжийг олж авахын тулд өнөөдөр үүсгэж буй нөөц (цуглуулга гэж үзэх нь ч буй) юм.

Хуримтлал: Ирээдүйд ашиглах зорилгоор өнөөдөр үүсгэж буй нөөц.

Хуримтлалыг нэг удаа хийгээд болчихдог зүйл биш, байнга өсгөн нэмэгдүүлж байх хэрэгтэй.

Хуримтлал олон хэлбэртэй (эдийн болон эдийн бус) байж болох ч бид энэ сэдвээр санхүүгийн болон мөнгөн хуримтлалын талаар авч үзнэ.

Санхүүгийн хуримтлалыг энгийнээр ирээдүйд ашиглах үүднээс урьдчилан хадгалсан (нөөцөлсөн) мөнгө буюу татварын дараах орлогоосоо хэрэглээний зардлаа хассан зөрүү мөнгө (Монголбанк, 2015) гэж ойлгож болно. Санхүүгийн хуримтлал нь таныг санхүүгийн эрх чөлөөнд хүргэх тасралтгүй үргэлжлэх үйлийн нэр. Өөрөөр хэлбэл, бага багаар нэмж, дадал, зуршил, хэвшил болгох шаардлагатай гэсэн үг.

Санхүүгийн хуримтлалыг ирээдүйд хэрэгцээтэй зүйлд зарцуулах зорилгоор одоогийн хэрэгцээгүй зүйлээс татгалзаж байж бий болгодог. Тиймээс хуримтлалтай болохын тулд тодорхой хэмжээний зүйлс (зайлшгүй хэрэгтэй бус зүйл)-ийг золиослох хэрэгтэй болно. Энэ нь танд хэмнэлтийг бий болгоод зогсохгүй, дадал, зуршлыг бий болгоно. Санхүүгийн хуримтлал нь танд ирээдүйд үүсэх санхүүгийн

⁴³ Шинжлэх ухааны академи, Хэл зохиолын хүрээлэн, (2015). Монгол хэлний их тайлбар толь

хэрэгцээгээ хангах боломжийг олгох ач холбогдолтойгоос гадна мөнгөө оновчтой удирдах урлагт сургана. Хуримтлал их байх албагүй, гол мөн чанар нь бага багаар нэмэгдүүлдэг байхад оршино.

Хуримтлал үүсгэх боломж, давуу тал



Мөнгөө хэмнэх, хуримтлал үүсгэх боломжийг өөртөө бий болгох хэрэгтэй. Боломж хүн бүрт байдаг, гагцхүү боломжоо ашиглах эсэх нь хувь хүнээс л хамаарна. Хуримтлал үүсгэх нь боломжгүй зүйл мэт санагдаж болох ч гэнэтийн тохиолдлоор өвдөх, гэнэт мөнгөний хэрэгцээ гарах үед мөнгө хадгалах, хуримтлуулахын ач холбогдол илүү ойлгогдоно.

Мэдээж илүү их ажил хийх, чухал шаардлагагүй зүйлд мөнгө үрэхгүй байх нь хуримтлалтай болох хамгийн энгийн бөгөөд хурдан арга зам байж болох юм. Гэхдээ хэт их ажилласнаас, ажлын ачаалал хэтэрснээр эрүүл мэндээрээ хохирох эрсдэл үүсч, зардал маань илүү нэмэгдэж болзошгүй. Тиймээс одоо байгаа орлогоо зайлшгүй хэрэгцээтэй зүйлдээ зарцуулж, бусад чухал биш зүйлээсээ хэсэг хугацаанд татгалзах нь илүү энгийн, үр дүнтэй арга байж болох юм.

Санхүүгийн зах зээлд хариуцлагатай, ухаалаг оролцогч болохын тулд өмнө авч үзсэн хувийн санхүүгийн төлөвлөлтийг зайлшгүй хийх шаардлагатай. Өрхийн орлого, зарлагаа бодитой төлөвлөх, өөрөөр хэлбэл, өрхийн төсвөө зохиох хэрэгтэй. Энэ нь тийм ч хэцүү зүйл биш бөгөөд олох орлого, гарах зардлаа л нэг бүрчлэн бичих, бүртгэх, түүнийгээ хянадаг байх үйл ажиллагаа юм.

Хувийн болон өрхийн санхүүгээ төлөвлөснөөр иргэн таны хариуцлага дээшилж, ашиг, орлогоо өсгөх боломж нэмэгдэнэ. Хувийн санхүүгээ төлөвлөснөөр хуримтлал хийх нь энгийн, хялбар болохыг мэдэх болно. Хуримтлалыг үүсгэх олон хэлбэр байж болох бөгөөд амьдралд илүү ойрхон хэдэн зөвлөмжийг танилцуулъя. Үүнд:

1. Зарцуулж буй мөнгөө бүртгэж сурах



Та сард олж буй мөнгө, зарж буй мөнгө хоёрын зөрүүг л хуримтлуулж чадах юм. Тэгвэл орлогоо нэмэгдүүлэхээс илүү зардлаа хянах нь боломжтой байдаг учраас өдөр тутмын зарцуулалтаа хянах нь зүйтэй. Дор хаяж нэг сарын хугацаанд таны олсон мөнгө юунд зарцуулагдсаныг нэг бүрчлэн бүртгэ.

Жижиг зардлуудаа ч үлдээхгүйгээр бүгдийг нэг бүрчлэн бич. Худалдан авалт, төлсөн өр, зээл гэх мэт бүх зардлыг (оюутны байрны төлбөр, утас, унаа, хоол хүнс, үзвэр үйлчилгээ гэх мэт) ангилан бүртгэ. Өдөр тутмын зарцуулалтаа хянах олон програмууд байдаг бөгөөд гар утсан дээрээ ч татаж ашиглах боломжтой.

2. Хэрэггүй зардлуудаа танах



Нэг, хоёр сар бүртгэсний дараа зарцуулалтаа нарийвчлан харж судал. Зарим зардлуудыг хэмнэх боломжтой болох нь илэрхий харагдах болно. Хэдий хэмжээний мөнгө хураах хэрэгтэй байгаагаас шалтгаалж хэцүү ч гэсэн зарим шийдвэрүүдийг гаргах л хэрэгтэй. Зайлшгүй зардлуудаа үлдээгээд зарим хэмнэх боломжтой зардлуудаа хэмнэ.

Эдгээр хэмнэлтүүд нь жилийн турш хэдий хэмжээний мөнгө болохыг тооцож үзэх хэрэгтэй бөгөөд ингэснээр та илүү урам зоригтойгоор төгрөг бүрийг хэмнэх болно. Тухайлбал,

- Элдэв зугаа, цэнгэл, баяр ёслолд аль болох мөнгө үрэхгүй байх;
- Хэрэгтэй хэрэггүй, таарсан таараагүй олон хувцас худалдан авахгүй байх;
- Гадуур хооллохгүй гэрээсээ хоолоо бэлтгэж ирэх;
- Хүнсээ бөөнөөр нь худалдан авснаар их мөнгө хэмнэх боломжтой.

3. Санхүүгийн төсвөө төлөвлөж сурах



Нэгэнт орлого, зарлагын (зайлшгүй гэдгийг дахин анхааруулья) зөрүүгээ сар бүр хийх хуримтлалтайгаа дүйцүүлж чадсан бол одоо нэг шат ахих хэрэгтэй. Цалин, орлогоосоо зарцуулах зүйлсээ урьдчилан тооцоолон бичиж, төсөв гарга. Хэмнэлт хийсэн зардлаараа ирэх сарын төсвөө хий.

Ингэснээр үе үе, өм цөм гардаг зардлуудаас урьдчилан сэргийлэх боломжтой болно.

4. Төлөвлөгөөний биелэлтийг хянах



Зардлаа бүртгэх, хэмнэх, өрхийн төсвөө гаргах зэргээр бөөн ажил болчихоод биелэлтээ, үр дүнгээ хянахгүй бол хэзээ ч хуримтлалтай болохгүй. Тиймээс багахан цаг гаргаад энэ сарын төсөв, төлөвлөгөө тооцоолсноос хэр зэрэг зөрсөн, юунаас болов гэдгийг нягталдаг байх хэрэгтэй.

5. Мөнгөө хуримтлуулж эхлэх



Сард хэдий хэмжээний орлого, зарлагатай, түүнээсээ хэдийг хэмнэх боломж байгаа вэ? гэдгээ мэддэг болсон бол одооноос ажил хэрэг болгож хуримтлал хийж эхэл.

Хуримтлал заавал өндөр дүнтэй байх албагүй. Хуримтлалын гол зарчим бол багаар, тогтмол байх явдал юм. Тиймээс заавал мөнгөтэй болохоороо, боломжтой үедээ гэж хойшлуулахгүйгээр одооноос л эхлэх хэрэгтэй.

6. Хуримтлалаа хадгаламж болгох



Бага хэмжээгээр ч гэсэн тогтмол хуримтлал хийх боломжийг өрхийн болон хувийн төсөвтөө суулгаж чадсан бол түүнийгээ хадгаламж болгох нь чухал. Хуримтлал, хадгаламжийн харьцуулалтыг Зураг 10-1-ээс үзнэ үү.

“Дуслыг хураавал далай, дуулсныг хураавал эрдэм”

Санхүүгийн хуримтлалыг хадгалах хэлбэр нь олон янз байж болно. Үүнд:

- Гэртээ болон ажил дээрээ (гудсан доороо, авдар савандаа, мөнгөний хайрцагт, номны завсар гэх мэтээр)⁴⁴
- Хэн нэгэнд итгэж өгөх (гэр бүлийнхэн, найз нөхөд)
- Эд хөрөнгийн хэлбэрт оруулж хадгалах (ирээдүйд үнэ цэнэд хүрч магадгүй гэсэн зүйлээ хямд дээр нь бага багаар авч, үнэ цэнэтэй болсон хойно нь зарж, мөнгөө гаргаад авна гэж боддог)
- Банкинд хадгаламж хэлбэрээр байршуулах (мөнгө найдвартай, баталгаатай, үнэ цэнээ алдахгүй)

Хүмүүс ихэвчилэн гэртээ хадгалах хэлбэрийг илүүд үздэг бөгөөд шалтгаан нь бага мөнгө учир их болгож байгаад банкинд хийх, эсвэл дахин дахин банк уруу явах, банкинд дугаарлах зэргээс төвөгшөөдөг.

Өөрт байхаар үрчих гээд байдаг, найдвартай газар байхгүй гэх мэт шалтгаанаар хэн нэгэнд итгэж мөнгөө өгдөг. Ялангуяа, гадаадад ажиллаж, амьдарч байгаа монголчууд цалингаасаа тогтмол мөнгө хуримтлуулаад буцаж ирээд байртай болох, сайхан амьдрах гэсэн мөрөөдөлтэй байдаг ч, хуримтлал нь ямар хэлбэрээр байгаагаас хамаарч эрсдэл дагуулах тал бий.

Өөрт хэрэггүй ч гэсэн хэн нэгэнд хэрэг болох, өнөөдөр хямд ч гэсэн ирээдүйд үнэ цэнэтэй болно гэж бодсон эд зүйлсийг багаар худалдан авч нөөцөлж, ирээдүйд мөнгөө гаргаж авна гэсэн бодлоор хандах. Энэ нь ихэвчилэн зүгээр мөнгөө хадгалж байхаар эд (бодитой хөрөнгө) болгох, мөнгөө найдвартай, үнэ цэнэтэй байлгах гэсэн шалтгаантай байдаг. Эдгээрээс эхний 3 хэлбэр хуримтлалаа хадгалах оновчтой хэлбэр биш юм. Учир нь таны байдгаараа хэмнэж байж хуримтлуулсан мөнгө хормын дотор юу ч биш болж магадгүй. Та сар бүр цалингаасаа тогтмол 5000 төгрөг цааш нь хийгээд байсан гэж үзье. Нэг жилийн дараа таны цуглуулсан мөнгө 60`000 төгрөг болсон байх болно. Та энэ хуримтлалаа гэртээ, найздаа, эд

⁴⁴ Гэртээ байгаа хамгийн найдвартай гэж үзсэн газарт нуудаг.

хөрөнгө болгосон аль нь ч байсан гэсэн мөнгө тань өсөхгүй, үнэ цэнээ алдсаар л байх болно. Мөн халдлагаас хамгаалж чадахгүй, хэн ч танд баталгаа өгөхгүй. Тиймээс энэ бүхэн таны хувьд эрсдэл байх болно.

Мөнгөний цаг хугацааны үнэ цэнийг ойлгосон (Сэдэв 4-т авч үзсэнээр) бол хуримтлалыг хадгаламж болгох зайлшгүй шаардлагатай болохыг мэдэх болно.

Хуримтлалыг хадгаламж хэлбэрээр үүсгэх тухай

Бэлэн мөнгөөр байгаа хуримтлалыг хадгаламж болгохын ач холбогдлыг мэдэхийн тулд дараах харьцуулалтыг авч үзье. (Зураг 10-1-ийг харна уу)

Зураг 10-1. Мөнгөн хуримтлал, хадгаламжийн энгийн харьцуулалт



Хүн нэгэнт хуримтлал үүсгэж чадсан бол зүгээр нэг хуримтлуулах биш, хадгаламж болгох хэрэгтэй. Учир нь бэлэн мөнгө хэлбэрээр хийсэн хуримтлал өсч, үржихгүй бөгөөд та хэдийг хуримтлуулсан тэр л хэвээрээ байна. Тооны хувьд гэдэг нь 10`000 төгрөг хуримтлуулаад шүүгээндээ хадгалсан бол 10`000 төгрөг чинь хэвээрээ, харин үнэ цэнээ алдсан (инфляцийн хэмжээгээр) байх болно. Мөн таны мөнгөө хуримтлуулж буй газар (хүмүүс ихэвчилэн гэртээ хадгалдаг) найдвар муу (хулгай, дээрэм, халдлага, гал түймэр гэх мэт аюулд өртөх)-тай байх талтай, болзошгүй аюулд хэн ч танд баталгаа өгөхгүй.

Харин хадгаламж хэлбэрээр хуримтлалаа хийж байгаа тохиолдолд хадгаламжийн хүүгээр таны мөнгө өсч, үржинэ, үнэ цэнээ алдахгүй, алдсан ч багаар (инфляци, хадгаламжийн хүүний зөрүүгээр) алдана. Тусгай харуул, хамгаалалттай газар (банк, санхүүгийн байгууллага) байх тул найдвартай, ямар нэг эрсдэл үүссэн тохиолдолд таны мөнгийг баталгаатай (хадгаламжийн даалтгалын сан) гаргаж өгнө. Тэгэхээр хуримтлал үүсгэж буй хүн сонголтоо хийх шаардлагатай болно. Сонголт зөвхөн таны гарт. Таныг хэн ч шахахгүй, шаардахгүй, хүчлэхгүй, харин та хуучин янзаараа хуримтлуулсаар байх уу? Хадгаламж хэлбэрээр хуримтлал хийх үү? Мэдээж хэрэг та **ухаантай хүн** болохоор хадгаламж хэлбэрээр хуримтлал үүсгэх сонголтыг хийнэ. Тэгвэл хадгаламж хэлбэрээр хуримтлал хийх болон хадгаламжийн талаар дараагийн хэсэгт дэлгэрэнгүй авч үзье.

10.2. Хадгаламжийн тухай ойлголт, мөн чанар

Хадгаламжийн тухай ойлголт, зорилго, ач холбогдол

Хадгаламж: Банк, санхүүгийн байгууллагад санхүүгийн данс нээлгэж байршуулсан мөнгөн хуримтлал.

Монгол Улсын болон гадаадын иргэн, харьяалалгүй хүн, хуулийн этгээдийн мөнгөн хадгаламжийн гэрээний үндсэн дээр банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээдэд хадгалуулсан үндэсний болон гадаад валютыг мөнгөн хадгаламж⁴⁵ (цаашид хадгаламж гэх) гэнэ.

Хадгаламжийг хадгалж байгаа этгээд (цаашид банк, санхүүгийн байгууллага буюу БСБ гэх) нь хадгалуулж байгаа этгээд (цаашид иргэд, байгууллага буюу хадгаламж эзэмшигч гэх)-тэй хадгаламжийн гэрээ байгуулах бөгөөд гэрээний нөхцөл, үүрэг, хариуцлага болон өөрийн үйл ажиллагаатай холбогдсон үнэн зөв мэдээллээр хангана. БСБ хадгаламжийн хүү, хугацааг нийтэд зарлах бөгөөд уг нөхцөлийг хүлээн зөвшөөрсөн хадгаламж эзэмшигч хадгаламжийн гэрээ байгуулж, мөнгөн хөрөнгөө хадгалуулна. Хадгаламжийн гэрээгээр банк, мөнгөн хадгаламжийн үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий хуулийн этгээд нь хадгалуулагчийн мөнгийг тухайн мөнгөн тэмдэгтээр хүүгийн хамт буцаан олгох үүрэг хүлээнэ⁴⁶. Хадгаламжийн гэрээнд хадгалалтын хугацаа, хүүний хэмжээ, хадгалуулах мөнгөн хөрөнгийн дүн, хүү тооцох журам, хадгаламжийн гэрээг цуцлах нөхцөл, гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгээгүйн төлөө талуудын хүлээх хариуцлагыг заасан байна. Хадгаламжийн гэрээ нь хадгаламжийн дэвтэр, сертификат зэрэг хэлбэртэй байж болох бөгөөд Иргэний хуулийн 454.3 дахь хэсэгт заасны дагуу заавал бичгээр хийгдэнэ.

Хадгаламжийн гэрээг тодорхой болон тодорхой бус хугацаагаар байгуулж болно⁴⁷.

Хугацаатай хадгаламж: Тодорхой хугацаа зааж хадгалуулсан мөнгө.

Хугацаагүй хадгаламж: тодорхой бус хугацаагаар хадгалуулсан мөнгө.

Хадгаламжийн гэрээг тодорхой бус хугацаагаар байгуулсан бол БСБ нь хадгаламж эзэмшигчийн хүссэн үед түүний хадгалуулсан мөнгийг буцаан өгч, хүү төлөх үүрэгтэй байдаг.

Хадгаламжийн гэрээг тодорхой хугацаагаар байгуулсан бол уг хугацаа дууссаны дараа БСБ нь хадгаламж эзэмшигчийн анхны шаардлагаар мөнгийг буцаан өгч, хүү төлөх үүрэгтэй.

Гэрээнд заасан хугацаа дууссан боловч хадгаламж эзэмшигч хадгалуулсан мөнгөө буцаан авах тухай, эсвэл гэрээг дахин сунгуулах шаардлага тавиагүй бол уг

⁴⁵ Монгол Улсын хууль, (1995). Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай, 3.1-р зүйл.

⁴⁶ Монгол Улсын хууль, (2002). Иргэний тухай, 454 дүгээр зүйлийн 1 дэх хэсэг

⁴⁷ Монгол Улсын хууль, (2002). Иргэний тухай, 455 дугаар зүйлийн 1 дэх хэсэг

хадгаламжийг хугацаагүй хадгаламжид тооцож, хүүг хугацаагүй хадгаламжийн адил хэмжээгээр бодно. Хэрэв хадгаламжийн гэрээнд заасан бол хугацаатай хадгаламжийн хугацаа дууссан тохиолдолд уг гэрээний хугацааг тодорхой хугацаагаар сунгаж болно. Хадгаламжийн гэрээний хугацааг дансанд орлогын гүйлгээ хийгдсэн өдрөөс эхлэн тоолж, зарлагын гүйлгээ хийгдсэн өдрөөр дуусгавар болгоно. Хугацаатай хадгаламжийн гэрээг тохиролцсон хугацаанаас өмнө хадгаламж эзэмшигчийн хүсэлтээр цуцлахад хадгалуулсан хугацаанаас нь хамааруулан хадгаламжийн хүүг гэрээнд заасан хэмжээгээр бууруулж тооцно. Хадгаламж эзэмшигч нь БСБ-аас үүргээ гүйцэтгээгүйгээс учирсан хохирол болон гэрээнд заасан бол анз⁴⁸ төлүүлэхээр шаардах эрхтэй байдаг.

Хадгаламжийн баталгаа

Монгол Улсын хувьд УИХ-аас 2013 оны 1 сард “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай” хуулийг баталснаар хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий “Хадгаламжийн даатгалын корпораци”-ийг хадгаламжийн даатгалын үйл ажиллагаа эрхлэн явуулах, ашгийн төлөө бус, төрийн өмчит хуулийн этгээд байхаар зохион байгуулсан. Хадгаламжийн даатгалын корпораци (цаашид ХДК гэх) Монголбанкнаас банкны үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлөө авсан арилжааны 13 гишүүн банктайгаар үйл ажиллагаа явуулж байна (ХДК, 2016).

Хадгаламжийн даатгал:

Хадгаламж татан төвлөрүүлдэг байгууллагын төлбөрийн чадвар муудан дампуурсан тохиолдолд хадгаламж эзэмшигчдийг алдагдлаас хамгаалах үйл ажиллагаа.

Банкны мөнгөн хадгаламж эзэмшигчдийн эрх ашгийг хамгаалах, санхүүгийн зах зээлийн тогтвортой байдлыг хангах зорилго бүхий банкин дахь мөнгөн хадгаламжийн албан журмын даатгалын эрх зүйн үндсийг тогтоосон байдаг.

Энэ үндсэн дээр хадгаламжийн даатгалын сангийн үйл ажиллагаатай холбогдсон харилцааг “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай”⁴⁹ хуулиар зохицуулна. Хадгаламжийн даатгалын тухай хуулиар хадгаламж, төлбөр тооцооны үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий банк хадгаламж эзэмшигчийн хадгаламжийг хадгаламжийн даатгалд заавал даатгуулж, даатгалын хураамжийг төлөхөөр заасан.

⁴⁸ Иргэний хуулийн 232.1 дэх хэсэгт зааснаар анз гэдэг нь хүлээсэн үүргээ биелүүлээгүй буюу зохих ёсоор гүйцэтгээгүй тал хууль болон гэрээнд зааснаар нөгөө талдаа төлөх ёстой мөнгөн төлбөрийг хэлнэ.

⁴⁹ Монгол Улсын хууль, (2013). Банкн дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай

Даатгалын нөхөн төлбөр:

Даатгалын тохиолдол бүрдсэн үед даатгалын сангаас хадгаламж эзэмшигчид олгох мөнгөн төлбөр.

Даатгалын тохиолдол⁵⁰ бүрдсэн нөхцөлд хадгаламж эзэмшигч ХДК-иас даатгалын нөхөн төлбөрийг шаардах эрхтэй.

ХДК хадгаламж эзэмшигчийн тухайн банкин дахь төгрөг ба валютын нийт 20 сая хүртэл төгрөгийн хадгаламжийг нөхөн төлөхөөр хуульд заасан байдаг. Хадгаламжийн даатгалд дараах хадгаламж хамаарахгүй. Үүнд:

1. Санхүүгийн байгууллагууд болон үл хөдлөх эд хөрөнгө зуучлалын байгууллага, наториатчийн нэргүй, дугаарласан, эсвэл хуурамч нэрээр нээсэн данс
2. Нэргүй хадгаламжийн сертификат болон бусад төрлийн нэргүй санхүүгийн хэрэгсэл
3. Нэрлэсэн үнээр эргэж төлөгдөхгүй хадгаламж
4. Мөн банк, төрийн байгууллага, нутгийн өөрөө удирдах болон нутгийн захиргааны байгууллага, эрүүл мэндийн, тэтгэврийн болон нийгмийн албан журмын даатгалын сан, банкны холбогдох этгээд, даатгалын тохиолдол бий болохоос өмнөх гурван жилийн хугацаанд банкны санхүүгийн тайланд аудит хийсэн аудитор болон аудитын байгууллага, Монголбанкны хяналт шалгалтын тайлангаар банкны санхүүгийн байдал муудахад нөлөөлсөн, банкны үйлчилгээ авахдаа санхүүгийн давуу эрх эдэлсэн нь тогтоогдсон хадгаламж эзэмшигчид

Даатгалын тохиолдол бий болоход Монгол Улсын “Эрүүгийн байцаан шийтгэх хууль”-ийн зохих зүйлд заасны дагуу битүүмжилсэн болон “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай” хуулийн зохих зүйлд заасны дагуу гүйлгээг нь түдгэлзүүлсэн дансны хадгаламж эзэмшигчид даатгалын нөхөн төлбөр олгохгүй байхаар хуульд заажээ.

Даатгалын нөхөн төлбөрийн хэмжээг тооцоходоо хадгаламж эзэмшигч бүрийн тухайн банкинд эзэмшиж байгаа нийт хадгаламжийн дүн болон гэрээний дагуу хуримтлагдсан хүүний дүнг даатгалын тохиолдол бий болсон өдрийн байдлаар нэгтгэж, хадгаламж эзэмшигчээс тухайн банкинд төлбөл зохих зээл, хүүгийн хамт хасч тодорхойлно.

БСБ нь дампуурах буюу татан буугдах тохиолдолд хадгаламж, түүний хүүг “Иргэний хууль”-ийн 32 дугаар зүйлийн 5 дахь хэсэг, “Банкны тухай хууль”-ийн 64 дугаар зүйлд заасан дараалал баримтлан олгоно.

Хадгаламжийн төрөл, онцлог

БСБ нь мөнгөн хөрөнгөө хадгалуулсан иргэн, хуулийн этгээд тус бүрт хадгаламжийн данс нээж, хадгаламж эзэмшигч хадгаламжийн сертификат зэрэг үнэт цаас авсан бол данс нээхгүй байж болдог. БСБ нь хадгаламж эзэмшигч мөнгөн хөрөнгийг хадгалахдаа хууль тогтоомж болон талуудын байгуулсан гэрээнд өөрөөр

⁵⁰ Монголбанкнаас тухайн банкыг албадан татан буулгасан тохиолдолд

заагаагүй бол харилцах данс нээж, түүний даалгавраар төлбөр гүйцэтгэж, харилцах дансны тогтвортой үлдэгдэлд нь хүү төлж болно.

Арилжааны банк бүрийн хадгаламжийн нөхцөл нь өөр өөр байдаг. Зарим хугацаатай хадгаламжид орлого нэмж, зарлага гаргаж болдог байхад заримд нь эдгээр гүйлгээг зөвшөөрдөггүй. Мөн зарим хугацаатай хадгаламжийн хүүг хугацааны эцэст авдаг бол заримдаа урьдчилан, эсвэл хэсэгчлэн авч болдог гэх мэт өөр өөр нөхцөлийг хадгаламж эзэмшигчдэд санал болгодог. Хадгаламж зээлийн хоршоо нь зөвхөн гишүүдээсээ хадгаламж татан төвлөрүүлэх бөгөөд хадгаламжийн нөхцөл мөн харилцан адилгүй байна. Иймээс хугацаатай хадгаламжийг сонгохдоо түүний нөхцөлүүдийг маш сайн анхаарах шаардлагатай.

Хадгаламжийн давуу тал болон боломжийг дараах зурагт харууллаа.

Зураг 10-2. Хадгаламжийн давуу тал болон боломж.



Хадгаламж нь БСБ-аас зарласан хүүний түвшнээр өсч, үржихээс гадна хулгай, дээрэм, халдлагаас найдвартай хамгаалалттай, банкинд хадгаламж хийсэн тохиолдолд ХДК-ийн баталгаатайгаар иргэд, байгууллагын мөнгөн хөрөнгийг хадгална.

Хадгаламжтай болсноор дараах боломжуудыг хадгаламж эзэмшигч эдэлнэ. Үүнд:

1. Богино хугацаанд бэлэн мөнгө болгох
2. Үнэ цэнээ алдахгүй байх
3. Хадгаламжаа барьцаалж зээл авах гэх мэт

Эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж сөрөг үр дагавар гарахыг үгүйсгэхгүй ч, хадгаламж эзэмшигчид санхүүгийн зуучлалын мөн чанарыг зөв ойлгож, хадгаламж хийх гэж байгаа банкныхаа найдвартай байдлыг санхүүгийн сахилга баттайгаар анхааралтай судалж сонголтоо хийх нь зүйтэй. Сонголт зөвхөн таны гарт бий.

Өөрөөр хэлбэл, таны санхүүг та л өөрөө удирдах учраас хүнд найдах биш, хариуцлагатайгаар өөрөө шийдвэрээ гаргаж, түүндээ хариуцлага хүлээх чадвартай байх ёстой.

Санхүүгийн сахилга бат:

Санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, түүнийхээ дагуу оновчтой шийдвэр гаргаж, гаргасан шийдвэртээ хариуцлага хүлээж, дүрэм журмыг дагаж, мөрдөх хүмүүжил.

Мөн аливаа эрх зүйн харилцаанд мөрдөгдөж байгаа хууль, дүрэм, журмыг дагаж, биелүүлдэг байх нь санхүүгийн сахилга баттай байхын гол үндэс болно. Иймд танд хуримтлуулсан мөнгөө хаана хадгалуулах вэ? гэсэн томоохон асуудал тулгарна.

Хадгаламжаа хаана хийх вэ?

Санхүүгийн тогтолцоог бүрдүүлэгчийнх нь хувьд санхүүгийн байгууллагыг хадгаламжийн болон хадгаламжийн бус гэж ангилдаг. Хадгаламжийн байгууллагад хадгаламж хэлбэрээр бусдаас хөрөнгө татан төвлөрүүлдэг байгууллагууд багтах бөгөөд хадгаламжийн бус гэхээр хадгаламж хэлбэрээр хөрөнгө татан төвлөрүүлдэггүй бусад санхүүгийн байгууллагуудыг авч үздэг тухай энэ номын Сэдэв-7-д авч үзсэн. Хадгаламж татан төвлөрүүлдэг байгууллагууд нь арилжааны банк, хадгаламж зээлийн холбоод байдаг.

Манай улсын хувьд иргэд болон байгууллагаас хадгаламж татан төвлөрүүлж, зээл олгох үйл ажиллагаа явуулж буй 2 төрлийн санхүүгийн байгууллага бий. Үүнд:

1. **Банк.** Хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдсэн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, хувьцаа эзэмшигч нь эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээдэг, бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлдэг, ашгийн төлөө хуулийн этгээдийг банк⁵¹ гэж тодорхойлсон. Банкны хадгаламжийн тухайд “Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай” хуулиар төрөөс баталгаа гаргаж байгаагаараа онцлог юм.
2. **Хадгаламж зээлийн хоршоо** (цаашид ХЗХ гэх). Гишүүдийнхээ эдийн засаг, нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор гишүүддээ хадгаламж зээлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үзүүлэх ардчилсан удирдлага, хамтын хяналт бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээд⁵² гэж тодорхойлжээ. ХЗХ-ны хадгаламжийн тухайд хоршоо өөрөө гишүүдийнхээ хадгаламжийн баталгааг хангах үүрэг хүлээнэ. ХЗХ-г найзууд, ах дүүс, нэг байгууллагын хамт олон, хамтран ажиллагсад, нэг байрны хөршүүд гэх мэтчилэн бие биенээ сайн мэддэг, итгэл хүлээлгэж чаддаг хүмүүс хамтран байгуулдаг.

Тэгэхээр та хуримтлалаа банкинд хийх үү? ХЗХ-нд хийх үү? гэдэг асуулттай тулгарна. Таны сонголтод олон хүчин зүйлс нөлөөлөх бөгөөд ихэнх тохиолдолд банк уу? ХЗХ юу? гэхээсээ илүү өндөр хүүтэй хадгаламжийг илүүд үзэх хандлага бий. Энэ нь таны санхүүгийн сахилга баттай салшгүй холбоотой бөгөөд шийдвэр гаргалтад тань нөлөөлөхүйц дараах зарчмыг өөртөө хэвшүүлээрэй.

⁵¹ Монгол Улсын хууль, (2010). Банкны тухай, шинэчилсэн найруулга, 3.1.1-р зүйл

⁵² Монгол Улсын хууль, (2011). Хадгаламж зээлийн хоршооны тухай, 3.1.1-р зүйл

ШИГТГЭЭ**Санхүүгийн сахилга баттай хадгаламж эзэмшигчийн баримтлах зарчим**

1. Байгууллагын удирдлагууд болон хувьцаа эзэмшигчдийн талаар тодорхой мэдээлэлтэй байх ба тухайн байгууллагын санхүүгийн чадвар, түүний давуу болон сул талыг бусад байгууллагуудтай харьцуулан судалж, байгууллагын цахим хуудас, сонин сэтгүүл, телевиз радиогоос өөрт хэрэгтэй мэдээллүүдийг олж авах;
2. Та мөнгөө хаана байршуулж байгаагаа маш сайн мэдэж байх ёстой. Байгууллагын бүтэц бүрэлдэхүүн, боловсон хүчний талаарх мэдээллийг нэрэлхэж цаараглалгүй асууж лавлан олж мэдэх;
3. Байгууллагаа зөв сонгох. Өөрийн эрэлт хэрэгцээнд тохирсон үйлчилгээтэйг нь сонгох. Төлбөр хураамжийн талаар мэдлэгтэй байх;
4. Хадгаламжийн дэвтэр, төлбөрийн карт зэрэг өөрийн санхүүтэй холбоотой бүхий л баримтуудыг цаг үргэлж найдвартай аюулгүй газар хадгалах. Шилжүүлэг, гүйлгээ хийх болгондоо хадгаламжийн дэвтэртээ бичилт хийлгэж байх;
5. Байгууллагаас ирсэн захиа, мэдээллийг цаг алдалгүй авч байхын тулд тантай холбоотой чухал мэдээлэл буруу хүнд очих зэргээс урьдчилан сэргийлж, өөрийн мэдээлэлд /цахим хаяг, утасны дугаар гэх мэт/ өөрчлөлт орох бүрийд шуурхай мэдээлж байх. Мөн байгууллагын ажилтнаас ажлын үнэмлэхээ танилцуулахыг хүсэх, гүйлгээг баталгаажсан эсэхийг асуухаас бүү төвөгшөөгөөрэй.
6. Иргэн та хэт өндөр хүү амласан, үнэнд нийцэхээргүй болзол, нөхцөлөөс зайлсхийгээрэй. Энэ нь илүү их эрсдэлийг дагуулах болно.

Та банк уу? ХЗХ юу? гэдэг сонголтоо хийсэн бол олон банк, ХЗХ-ноос яг алийг нь вэ? гэдэг сонголтыг хийх шаардлагатай. Үүний тулд төрөл бүрийн мэдээлэл авч харьцуулалт хийж, хариуцлагатайгаар дараагийн сонголтоо хийх хэрэгтэй.

1. **Байгууллагаа сонгох.** Банкууд улирал бүр хөндлөнгийн аудитаар баталгаажуулсан тайлан балансаа олон нийтэд зориулан нийтэлж, мэдээлэх үүрэгтэй байдаг. Тэр мэдээллийг өдөр тутмын сониноос, тухайн банкны цахим хуудаснаас олж үзэж болно. Мөн цахим хаягаар нь орж ямар төрлийн хадгаламжийн бүтээгдэхүүн үйлчилгээг, ямар нөхцөлтэйгээр иргэдэд хүргэж байгаа талаар олон чухал мэдээллүүдийг авах боломжтой. Банкны байгууллага нь бизнесийн зорилго, стратегиасаа хамаараад байгууллагуудад зориулсан бүтээгдэхүүн үйлчилгээг үзүүлж байгаа бол зарим нь иргэдэд түлхүү үйлчлэх зорилготой байдаг. Өөрөөр хэлбэл, зорилгоосоо хамаарч иргэд, байгууллагад хүргэх бүтээгдэхүүн, үйлчилгээ, түүний нэр төрөл, нөхцөл ялгаатай байдаг. Харин ХЗХ бол сайн дурын үндсэн дээр нэгдэн зохион байгуулагдсан, гишүүддээ л үйлчилдэг тул та өөрөө байгуулаад удирдаад явж болно, эсвэл байгаа хоршоонд гишүүнээр орж болно.
2. **Санхүүгийн зөвлөгөө авах.** Хэрэв та өөрийгөө санхүүгийн зохих мэдлэггүй гэж үзэж байгаа бол банк болон санхүүгийн байгууллагын ажилтнууд зэрэг мэргэжлийн хүнээс зөвлөгөө авч болно.

3. *Хадгаламжийн төрөл, нөхцөл өөр өөр учир сонголт хийх.* Банкууд хадгаламжийн хүү, хугацаа, төрөл зэрэг нөхцөлүүдээ өмнө хэлсэнчлэн өөрийн бодлогод нийцүүлэн хэрэгжүүлдэг тул хадгаламж хийхдээ банкуудын цахим хуудас болон тэдгээрийн харьцуулсан судалгаанд үндэслэн сонголтоо хийхэд илүүдэхгүй. Өгөөж өндөртэйг нь гол шалгуур болгон хамгийн өндөр хүү санал болгож байгаа банкинд мөнгөө хадгалуулахаар шийдэж болох ч өгөөж, эрсдэл хоёр ямагт шууд хамааралтай байдгийг бүү мартаарай. Иймээс өгөөжөөс гадна санхүүгийн чадавхийг нь зайлшгүй харгалзаж үзэх нь зүйтэй (ННФ, 2010).

Хадгаламжийн төрөл

Хадгаламжийг хугацаанаас хамааруулж хугацаагүй ба хугацаатай гэж ангилна.

1. **Хугацаагүй хадгаламж:** Хадгаламж эзэмшигч нь БСБ-тай тодорхой хугацаа заалгүйгээр хадгаламжийн гэрээ байгуулсан хадгаламжийн төрөл юм. Энэ төрлийн хадгаламжид хамгийн бага хүү төлдөг бөгөөд хадгаламж эзэмшигч хүссэн үедээ хадгаламжаасаа мөнгөө авах боломжтой. Тодорхой хугацаа заагаагүй учир хадгаламжаасаа хэзээ ч мөнгөө авсан хүү нь амласан хүүгээр бодогдоно.
2. **Хугацаатай хадгаламж:** Хадгаламж эзэмшигч нь БСБ-тай тодорхой хугацаа зааж хадгаламжийн гэрээ байгуулсан хадгаламжийн төрөл юм. Энэ төрлийн хадгаламжид хугацаанаас хамаарч хүү төлдөг бөгөөд хадгаламж эзэмшигч хүссэн үедээ хадгаламжаасаа мөнгөө авах боломжтой ч санхүүгийн хариуцлагын хувьд гэрээнд заасан хугацаанаас өмнө хадгаламжаасаа мөнгө авсан тохиолдолд гэрээнд заасан нөхцөлөөр торгууль төлнө. Торгууль нь таны хадгаламжид төлөх ёстой байсан хүүний төлбөрийг гэрээнд заасан нөхцөлөөр бууруулж ногдох хүүг танд төлнө. Ихэнхдээ торгуулийг хугацаагүй хадгаламжийн хүүний 50 хувиар тооцож олгохоор заасан байдаг хэдий ч тантай байгуулсан хадгаламжийн гэрээнд юу гэж тусгасныг заавал анзаарч харах хэрэгтэй. Энэ нь таны санхүүгийн сахилга баттай салшгүй холбоотой.

Хугацаатай хадгаламжийг:

1. Богино хугацаат
2. Дунд хугацаат
3. Урт хугацаат гэж ангилах бөгөөд хадгаламж эзэмшигч санхүүгийн хэрэгцээнээсээ хамааруулан хугацааны хувьд сонголтоо хийнэ

Богино хугацаат хадгаламж. Энэ төрлийн хадгаламж нь 1 хүртэл жилийн хугацаатай бөгөөд хүүний хувьд бусад төрлийн хадгаламжаас бага байна. Хугацаа богино учир хадгаламжийн хугацаа дуусаад дахин сунгуулах тохиолдолд танд амлаж байсан хүүний түвшин өөрчлөгдсөн байх магадлалтай. Манай банкуудын хувьд богино хугацаат хадгаламжийн төрөл зонхилдог бөгөөд энэ нь хадгаламж эзэмшигчдийн хэрэгцээ шаардлагатай уялдан 3, 6, 9 сарын хугацаатай хадгаламжууд байна.

Дунд хугацаат хадгаламж. Энэ нь санхүүгийн жилээр 1-5 хүртэл жилийн хугацаатай хадгаламж байх бөгөөд хүүний хувьд богино хугацаат хадгаламжаас арай илүү байдаг.

Урт хугацаат хадгаламж. Урт хугацаат хадгаламж нь 5–аас дээш жилийн хугацаатай байх бөгөөд банкны хувьд харьцангуй тогтвортой эх үүсвэр болдог учир илүү өндөр хүү амласан байдаг. Манай банкуудын хувьд сүүлийн жилүүдэд урт хугацааны хадгаламжаа нэмэгдүүлэх зорилгоор олон төрлийн бүтээгдэхүүнийг санал болгох болсон. Жишээлбэл, Ирээдүйн саятан, Унагалдай, Алтан түлхүүр гэх мэт хүүхдийн хадгаламж.

Хадгаламж хугацаанаасаа хамаарч ангилагдахаас гадна гэрээний нөхцөлөөсөө хамаарч ялгаатай байна. Үүнд:

- Хүссэн үедээ орлого хийгээд, зарлага гаргадаг
- Зөвхөн орлого хийж болдог, зарлага гаргадаггүй
- Орлого ч хийдэггүй, зарлага ч гаргадаггүй
- Зөвхөн хүүний орлогоо зарлагадах эрхтэй
- Хүүний орлогоо урьдчилж зарлагадах эрхтэй байдаг

Хадгаламж нь хэлбэрээсээ хамаарч дэвтрийн ба хадгаламжийн сертификатын гэж ангилагдана.

***Дэвтрийн хадгаламж :** Хөрвөх чадвар өндөртэй, хүүний орлого авчирдаг хадгаламжийн данс.*

Дэвтрийн хадгаламжийн данс нь тодорхой болон тодорхой бус хугацаатай байдаг.

Хадгаламж эзэмшигчийн нэр дээр бүртгэгдэх бөгөөд хамтран эзэмшигчтэй байж болдог. Дансанд орлого, зарлагын гүйлгээ бүрийг хадгаламжийн дэвтэрт бүртгэх бөгөөд заавал банкин дээр очих шаардлагагүй, цахим банкны үйлчилгээгээр дансаа удирдах боломжтой.

***Хадгаламжийн сертификат:** Тодорхой хугацаагаар мөнгөө байршуулж буй хадгаламж эзэмшигчдэд банкны зүгээс олгосон үнэт цаас.*

Хадгаламжийн сертификат нь нэг төрлийн богино хугацаат үнэт цаас бөгөөд хөрвөх чадвар өндөр, хүүний орлого авчирдаг, бусдад гэрээслэх, өвлүүлэх, бэлэглэх, худалдах боломжтой.

Гэрээний хугацаанд орлого, зарлагын гүйлгээ хийх боломжгүй бөгөөд гэрээний нөхцөлөөс хамаарч хүүний орлогыг хугацааны эцэст болон гэрээний хугацаанд хэд хэдэн удаагийн давтамжтайгаар авах боломжтой.

Хадгаламжийн дээрх төрөл, ангиллуудаас өөрийн санхүүгийн хэрэгцээнд тохируулан оновчтой шийдвэр гаргах нь таны сонголтын асуудал юм.

10.3. Хадгаламжийн орлогын тооцоолол

Хадгаламжийн орлого нь БСБ-ын мөнгөн хадгаламждаа төлж буй хүүний хэмжээгээр тодорхойлогдох ба хадгаламжийн төрөл, нөхцөлөөс хамаарч орлого нь харилцан адилгүй байна.

Хадгаламжийн хүү: Банк, санхүүгийн байгууллагаас иргэд болон байгууллагын мөнгөн хөрөнгийг ашигласны төлөөсөнд амлаж буй төлбөр.

Хадгаламжийн хүү нь хувиар илэрхийлэгдэх бөгөөд мөнгөн хадгаламжаас тогтоосон хувиар тооцогдоно. Хүү нь иргэд, байгууллагын хувьд орлого, БСБ-ын хувьд зарлага болно.

Хадгаламж нь дараах шинжийг агуулна. Үүнд:

1. Мөнгөн хадгаламж хүүтэй байна. Хугацаатай хадгаламжийн хүүний хэмжээ нь хадгаламжийн гэрээнд заасан хугацааг дуустал анх тохиролцсон хэвээр байна.
2. Хадгаламжийн гэрээнд заасан хүүний хэмжээ өөрчлөгдөөгүй тохиолдолд хугацаатай хадгаламжид орлогын гүйлгээ хийвэл хүүг уг гэрээний дагуу хэвээр мөрдөнө. БСБ-ын тогтоосон хүүний хэмжээ өөрчлөгдсөнөөс хойшхи хугацаанд хийсэн аливаа орлогын хувьд хадгаламжийн гэрээг заавал шинээр байгуулна.
3. Хугацаагүй хадгаламжийн хүүний хэмжээг БСБ-аас өөрчлөх тохиолдолд энэ тухай нийтэд мэдэгдсэнээс хойш 1 сарын дараа тодорхой бус хугацаагаар байгуулсан хадгаламжийн гэрээнд заасан хүүний хэмжээ өөрчлөгдсөнд тооцно.
4. Хадгаламжийн хүүний хэмжээг бодох аргачлалыг Монголбанк батална.

Хадгаламжийн хүү, түүний төрлүүд

Хүүг тооцож буй аргачлалаас хамааруулан энгийн⁵³ ба нийлмэл хүү⁵⁴ (хүүнээс хүү бодох), нөлөөллөөс хамааруулж бодит хүү⁵⁵ ба нэрлэсэн хүү⁵⁶ гэж ангилдаг тухай номын сэдэв 4-т авч үзсэн билээ. БСБ-аас хадгаламж эзэмшигчийн хадгаламжид төлөх хүүг хүү бодох аргачлалаас хамааруулан хэрхэн тооцох талаар жишээгээр авч үзье.

⁵³ Хадгаламжийн үндсэн дүнд тооцсон хүүний хэмжээ

⁵⁴ Хадгаламжийн үндсэн дүн дээр өмнөх хугацаанд бодогдсон хүүний дүнг нэмсэн дүнгээс тооцсон хүүний хэмжээ

⁵⁵ Инфляцийн нөлөөллийг оруулж тооцсон хүүний хувь

⁵⁶ Хадгаламжид төлөхөөр амлаж буй хүүний хувь

Энгийн хүү бодох аргачлал:

$Hүү = Үндсэн дүн \times Нэрлэсэн хүүний хувь \times Хугацаа/365$

$$I = P \times R \times T/365$$

Энд: I – Хүү

P – Үндсэн дүн)

R – Нэрлэсэн хүүний хувь

T – Хугацаа, хуанлийн хоногоор

Жишээ: Та 50`000 төгрөгийн хуримтлалаа банкинд хадгаламж хэлбэрээр 2 жилийн хугацаатай байршуулахаар болсон гэж үзье. Банкны 2 жилийн хугацаатай хадгаламжийн хүү жилийн 12.5%, хүүг энгийн хүүний аргаар тооцдог гэвэл энгийн хүүний аргаар таны хадгаламжид ногдох хүүний тооцооллыг хэрхэн хийх талаар авч үзье.

Таны хадгаламжид эхний жилд бодогдох хүү:

$$I = 50'000 \times 12.5\% \times \frac{365}{365}$$

$I = 6250$ төгрөг

Та хадгаламждаа нэмж хуримтлал хийгээгүй тохиолдолд дараагийн жилд мөн 6250 төгрөгийн хүү авна. 2 дахь жилийн эцэст таны анх хийсэн 50`000 төгрөг дээр хүү болох 12`500 (1 дэх жилийн хүү 6250+2 дахь жилийн хүү 6250) төгрөг нэмэгдэж, нийт 62`500 төгрөгийн хуримтлалтай болно.

Нийлмэл хүү бодох аргачлал:

$Hүү = Үндсэн дүн \times (1+Нэрлэсэн хүүний хувь \times Хугацаа_1/365) \times (1+Нэрлэсэн хүүний хувь \times Хугацаа_2/365) \times \dots \times (1+Нэрлэсэн хүүний хувь \times Хугацаа_t/365) - Үндсэн дүн$

$$I = P \times \left(1 + R \times \frac{T_1}{365}\right) \times \left(1 + R \times \frac{T_2}{365}\right) \times \dots \times \left(1 + R \times \frac{T_t}{365}\right) - P$$

Энд: I – Хүү

P – Үндсэн дүн

R – Нэрлэсэн хүүний хувь

T – Хугацаа, хуанлийн хоногоор

Жишээ: Та 50`000₮-ийн хуримтлалаа банкинд хадгаламж хэлбэрээр 2 жилийн хугацаатай байршуулахаар болсон гэж үзье. Банкны 2 жилийн хугацаатай хадгаламжийн хүү жилийн 12.5%, хүүг нийлмэл хүүний аргаар тооцдог гэвэл нийлмэл хүүний аргаар таны хадгаламжид ногдох хүүг хэрхэн тооцохыг доор авч үзье.

Таны хадгаламжид эхний жилд бодогдох хүү:

$$I = 50'000 \times \left(1 + 0.125 \times \frac{365}{365}\right) \times \left(1 + 0.125 \times \frac{365}{365}\right) - 50'000$$

$$I = 50'000 \times 1.125 \times 1.125 - 50'000$$

$$I = 63'281.25 - 50'000$$

$$I = 13'281.25 \text{ төгрөг}$$

Та хадгаламждаа нэмж хуримтлал хийгээгүй тохиолдолд эхний жилд 6250 төгрөгийн хүү авна. Таны анх хийсэн 50'000 төгрөг дээр эхний жилд тооцогдсон хүү 6250 төгрөг нэмэгдэж нийт 56'250 төгрөгөөс 2 дахь жилийн хүү бодогдох бөгөөд 2 дахь жилийн хүү 7031.25 төгрөг болно. 2 жилийн хугацаанд таны анх хийсэн 50'000 төгрөг дээр хүү болох 13'281.25 (1 дэх жилийн хүү 6250+ 2 дахь жилийн хүү 7031.25) төгрөг нэмэгдэж, нийт 63'281.25 төгрөгийн хуримтлалтай болно. Хадгаламжийн хүү бодох давтамж⁵⁷ олон байх тусам нийлмэл хүүний аргаар бодож буй хадгаламжийн хүүний орлого өндөр байна.

Жишээ: Та 50'000₮-ийн хуримтлалаа банкинд хадгаламж хэлбэрээр 2 жилийн хугацаатай байршуулахаар болсон гэж үзье. Банкны 2 жилийн хугацаатай хадгаламжийн хүү жилийн 12.5%, хүү бодох давтамж нь 6 сар, хүүг нийлмэл хүүний аргаар тооцдог гэвэл нийлмэл хүүний аргаар таны хадгаламжид ногдох хүүг хэрхэн тооцохыг доор авч үзье.

$$I = 50'000 \times \left(1 + \frac{0.125}{2} \times \frac{365}{365}\right) \times \left(1 + \frac{0.125}{2} \times \frac{365}{365}\right) \times \left(1 + \frac{0.125}{2} \times \frac{365}{365}\right) \times$$

$$\left(1 + \frac{0.125}{2} \times \frac{365}{365}\right) - 50'000$$

$$I = 50'000 \times 1.0625 \times 1.06125 \times 1.06125 \times 1.06125 - 50'000$$

$$I = 63'721.45 - 50'000$$

$$I = 13'721.45 \text{ төгрөг}$$

Та хадгаламждаа нэмж хуримтлал хийгээгүй тохиолдолд эхний хагас жилд 3125 төгрөгийн хүү авна. Таны анх хийсэн 50'000 төгрөг дээр эхний хагас жилд тооцогдсон хүү болох 3125(50'000 x 1.0625-50'000) төгрөг нэмэгдэж нийт 53'125 төгрөгөөс 2 дахь хагас жилийн хүү бодогдох бөгөөд 2 дахь хагас жилийн хүү 3320.3(53'125 x 1.0625-53'125) төгрөг болно. 1 жилийн хугацаанд таны анх хийсэн 50'000 төгрөг дээр хүү болох 6445.3 (1 дэх хагас жилийн хүү 3125 + 2 дахь хагас жилийн хүү 3320.3) төгрөг нэмэгдэж, 1 жилийн эцэст таны дансанд нийт 56'445.3 төгрөг хуримтлагдана. Энэ дүнгээс 3 дахь хагас жилийн хүү бодогдох бөгөөд

⁵⁷ Хүүгээ хуримтлуулж байгаа хугацааны давтамж бөгөөд хагас жилээр бол жилийн хүүг 2-т, улирлаар бол жилийн хүүг 4-т, сараар бол жилийн хүүг 12-т, өдрөөр бол жилийн хүүг 365-т хувааж хуанлийн хуваарийн дагуу ашигласан хоногоор тооцно (Монголбанк, 2013).

3527.83(56`445.3 x 1.0625-56`445.3) төгрөг, 4 дэх хагас жилийн хүү 3748.32 (59`973.13 x 1.0625-59`973.13) төгрөг байна. 2 дахь жилийн эцэст таны дансанд нийт 63`721.45 (50`000+13`721.45) төгрөг хуримтлагдах бөгөөд нийт 13`721.45 төгрөгийн хүүний орлого олж байна.

Энд зөвхөн нэг удаагийн орлого хийсэн хадгаламжийн жишээг авч үзсэн бөгөөд хуримтлалаа байнга тогтмол нэмэгдүүлэх, тогтмол биш хэмжээгээр нэмэгдүүлэх болон хадгаламжийн гэрээгээ цуцлах тохиолдлуудад хадгаламжийн хүү хэрхэн бодогдох талаар дараагийн хэсэгт авч үзнэ.

Та хуримтлалаа хадгаламж хэлбэрээр хийх гэж байгаа тохиолдолд БСБ таны сонирхсон хадгаламжийн хүүг ямар аргаар боддог вэ? гэдгийг заавал лавлаж асуугаарай. Ихэнх тохиолдолд банкууд энгийн хүүний аргачлал ашиглаж байгаа хадгаламждаа нийлмэл хүү боддог хадгаламжаасаа арай илүү хүү тогтоосон байдаг. Өөрөөр хэлбэл, нэрлэсэн хүүтэй харьцуулбал энгийн хүүгээр бодох хадгаламжийн хүү өндөр байж болох ч, нийлмэл хүүгээр бодох хадгаламжийн хүүний орлого өндөр байж болох тул аль болох өөрт өгөөжтэйг сонгох чухал бөгөөд энэ нь мөн л таны санхүүгийн сахилга батын асуудал юм. Энэ хэсэгт бид зөвхөн хүүний тооцооллын тухай авч үзсэн бөгөөд дараагийн хэсэгт хүүний орлого, өгөөжийн тооцооллын талаар, мөн таны шийдвэр гаргалтад нөлөөлж болох хүчин зүйлсийн талаар авч үзэх болно.

Хадгаламжаас олох орлого, өгөөжөө тооцоолох нь

Хадгаламжийн **орлого** нь үндсэн дүнгээс хүүний хэмжээгээр өссөн дүн бөгөөд хадгаламжийн үйлчилгээтэй холбоотой танаас гарч байгаа мөнгийг (данс нээхэд дэвтрийн 1`000 төгрөг, хадгаламжийн орлого хийхэд банк хооронд шилжүүлбэл 300 төгрөг, данс хооронд шилжүүлбэл 100 төгрөг, бэлнээр мөнгө тушаахад замын зардал 500 төгрөг гэх мэт зардал гарна) **зардал** гэж ойлгож болно.

$$\text{Ашиг} = \text{Орлого} - \text{Зардал}$$

Дээрх томъёогоор та өөрийн хийсэн хадгаламжаас тухайн хугацаанд (сар, улирал, хагас жил, жил) хэдий хэмжээний ашиг олсон бэ? гэдгийг тооцож болох бөгөөд харин хадгаламжийн өгөөжийг дараах байдлаар тооцож болно.

$$\text{Өгөөж} = \frac{\text{Тухайн хугацаанд олсон ашиг}}{\text{Тухайн хугацаан дахь хадгаламжийн үлдэгдэл}}$$

Өгөөж нь хадгаламжид хөрөнгө оруулалт (хуримтлалаа хадгаламж хэлбэрээр байршуулсан) хийснээр таны 1 төгрөг тутамдаа олж байгаа ашгийн хэмжээ юм. Өгөөжөө тооцох нь таны хуримтлалаа хаана байршуулах, юунд хөрөнгө оруулалт хийх вэ? гэдэг сонголтод нөлөөлөх бөгөөд үүний цаана эрсдэл гэсэн ойлголт байнга хамт байхыг анхаараарай. Өгөөж өндөр байх нь өндөр эрсдэлийг дагуулах бөгөөд

эрсдэлийг удирдах асуудал чухал юм. Өөрөөр хэлбэл, өгөөжийг өндөр түвшинд хадгалж, эрсдэлийг бага байлгахын тулд хөрөнгө оруулалтын сонголтоо зөв хийх шаардлагатай гэсэн үг. Хөрөнгө оруулалтын сонголт буюу ямар төрлийн хадгаламжид, ямар нөхцөлөөр, аль банкинд хийх вэ? гэдэг шийдвэр гаргалт хийнэ.

Өмнөх хэсэгт үзсэн жишээн дээр тулгуурлан таны хадгаламж хэдий хэмжээний өгөөжтэй болохыг авч үзье. Жишээ: Та 50'000 төгрөгийн хуримтлалаа банкинд хадгаламж хэлбэрээр 2 жилийн хугацаатай байршуулахаар болсон. Банкны 2 жилийн хугацаатай хадгаламжийн хүү жилийн 12.5%. Та хадгаламжийн дэвтэр нээлгэхэд 500 төгрөг төлсөн, өөр зардал гаргаагүй гэж үзье. Хүснэгт 10-1-ийг харна уу.

Хүснэгт 10-1. Хадгаламжийн өгөөжийн тооцоололт ба харьцуулалт

д/д	Хадгаламжийн хэлбэр	Хүүний орлого (2 жилийн)	Зардал* (2 жилийн)	Ашиг**	Өгөөж***
1	Энгийн хүүтэй хадгаламж	12'500₮	500₮	12'000₮	0.24
2	Нийлмэл буюу хүүнээс хүү боддог хадгаламж (жилд 1 удаа)	13'281.25₮	500₮	12'781.25₮	0.256
3	Нийлмэл буюу хүүнээс хүү боддог хадгаламж (жилд 2 удаа)	13'721.45₮	500₮	13'521.45₮	0.27

* Зардалд ХХОАТ-ыг оруулаагүй бөгөөд сэдвийн төгсгөл хэсэгт дэлгэрэнгүй авч үзнэ.

** Ашиг=Орлого-зардал (12'000=12'500-500)

*** Өгөөж=Ашиг/үндсэн хадгаламж (0.24=12'000/50'000)

Таны хадгаламж энгийн хүүний аргачлалаар бодогдож буй тохиолдолд 2 жилийн хугацаанд 24%-ийн өгөөж, нийлмэл хүүний аргаар бодогдож байгаа, хүү бодох давтамж жилд нэг удаа тохиолдолд 25.6%-ийн өгөөж, хүү бодох давтамж жилд 2 удаа тохиолдолд 2 жилийн хугацаанд 27%-ийн өгөөжийг авчирч байна. Өөрөөр хэлбэл, нэг төгрөгийн хадгаламжаасаа 24-27%-ийн өгөөж хүртэж байна гэсэн үг.

Хадгаламжийн шийдвэр гаргалтад нөлөөлөх хүчин зүйлс

Хадгаламжийн шийдвэр гаргалтад олон хүчин зүйлс нөлөөлөх бөгөөд тэдгээрийн талаар товч авч үзье. Үүнд:

1. Өгөөж
2. Хугацаа
3. Инфляци
4. Валютын ханш

Өгөөж: Хадгаламжийн хөрөнгө оруулалтаас хэдий хэмжээний өгөөж олж болохыг дээр жишээгээр авч үзсэн. Хуримтлалаа хадгаламж хэлбэрээр хийх үү? Бусад хөрөнгө оруулалтад байршуулах уу? гэдэг шийдвэр гаргалтад тухайн хөрөнгөөс

олох өгөөж ихээхэн нөлөөтэй. Хүмүүс өгөөж, ашиг гэхээсээ илүү хаана өндөр хүү амласан байна түүнд хөрөнгөө байршуулах хандлага түгээмэл бий. Энэ нь нэг талаас санхүүгийн талын ойлголт дутмаг, нөгөө талаас юманд өнгөцхөн ханддаг хариуцлагагүй (санхүүгийн сахилга бат) байдалтай нь холбоотой. Тэгэхээр хөрөнгө оруулалт хийх гэж байгаа хүн тухайн хөрөнгө оруулалтаас хэдий хэмжээний орлого олох, хэдий хэмжээний зардал гаргах, ямар өгөөжтэй байж болох вэ? гэдгээ тооцох шаардлагатай. Жишээлбэл: 500`000 төгрөгийн хуримтлалаа 1 жилийн хугацаатай санхүүгийн хэрэгсэлд байршуулах шаардлагатай болсон гэж үзье. Танд хөрөнгө оруулалт хийх 5 боломж байгаа бөгөөд хөрөнгө оруулах боломжуудыг Хүснэгт 10-2-г харууллаа.

Хүснэгт 10-2. Хөрөнгө оруулалтын боломжууд ба өгөөжийн харьцуулалт

д/д	Хөрөнгө оруулалтын хувилбар	Хүүний хувь (жилийн)	Өгөөжийн түвшин (жилийн)	Давуу тал	Сул тал, эрсдэл
1	Банкны хадгаламж*	15%	13.3%	ХДС-ийн даатгалтай, найдвартай.	Хөрвөх чадвар сул, хүүний түвшин өсөх
2	ХЗХ-ны хадгаламж**	18%	14.6%	Өгөөж өндөр	Баталгааг хоршоо хариуцна, Хөрвөх чадвар сул, хүүний түвшин өсөх.
3	ЗГҮЦ***	13.2%	13.15%	Эрсдэлгүй, хөрвөх чадвар сайтай	Өгөөж бага.
4	Компанийн бонд****	14.5%	14.4%	2-догч зах зээлийн арилжаанд оруулах боломжтой.	Компани төлбөрийн чадваргүй болох эрсдэлтэй, бондын үнийн уналт.
5	Хадгаламжийн сертификат*****	15.3%	13.77%	Хөрвөх боломжтой, барьцаалах боломжтой, тогтмол хүүтэй.	Гэрээний хугацаанд орлого, зарлагын гүйлгээ хийхгүй, хугацаа цуцлах боломжгүй.

* Хүүг энгийн хүү бодох аргаар боддог, дэвтрийн үнэд 1000 төгрөг төлдөг, хадгаламжийн хүүний орлогоос 10%-ийн татвар төлдөг.

** Хүүг энгийн хүү бодох аргаар боддог, дэвтрийн үнэд 3000 төгрөг төлдөг, гишүүний хураамж жилд 5000 төлдөг, хадгаламжийн хүүний орлогоос 10%-ийн татвар төлдөг.

***Данс нээх шимтгэлгүй, арилжааны шимтгэл 0.05%, ХХОАТ-аас чөлөөлөгдөнө.

**** Данс нээх шимтгэлгүй, арилжааны шимтгэл 0.1%, ХХОАТ-аас чөлөөлөгдөнө.

***** Данс нээх шимтгэлгүй, хадгаламжийн хүүний орлогоос 10%-ийн татвар төлдөг.

5 хувилбарын хувьд өгөөжийн түвшинг харуулах зорилгоор хүснэгтийн доод хэсэгт нэмэлт оруулсан болно. Хүснэгтээс харахад хамгийн өндөр хүү амлаж байгаа нь ХЗХ бөгөөд хамгийн өндөр эрсдэлтэй. Учир нь хадгаламжид төрөөс баталгаа олгодоггүй, хоршооны удирдлага бүрэн хариуцдаг. Хугацаатай хадгаламжийн хувьд тогтмол хүүгээр тооцдог. Гэрээ цуцлагдвал торгуультай. Хамгийн бага өгөөжтэй, эрсдэлгүй нь ЗГҮЦ байна. Тиймээс таны шийдвэр гаргалтад өгөөжийн түвшин чухал ч цаана нь эрсдэл байгаа гэдгийг харж сонголт хийх хэрэгтэй.

Хугацаа: Хадгаламжийн шийдвэр гаргалтад хугацаа чухал бөгөөд таны хуримтлуулсан мөнгөн хөрөнгө танд хэзээ санхүүгийн хэрэгцээ гарах, хуримтлалаа юунд зарцуулах зэргээс хамаарч хугацааны сонголт хийх шаардлагатай болно. Мэдээж богино хугацаанд танд мөнгөний хэрэгцээ гарахаар байгаа бол урт хугацааны санхүүгийн хэрэгсэлд байршуулах нь тохиромжгүй бөгөөд тухайн хэрэгслийн хөрвөх чадвар мөн нөлөөлнө.

Жишээ нь: 5 жилийн хугацаатай компанийн бондод хөрөнгө оруулалт хийсэн байтал, 1 жилийн дараа мөнгөний хэрэгцээ гарсан гэж үзье. Компанийн бондыг хоёрдогч зах зээлийн арилжаанд оруулж болох хэдий ч, үнийн эрсдэлд орж болзошгүй. Та мөнгөний хэрэгцээгээ урьдчилан харж чадсан бол богино хугацааны хэрэгсэлд хөрөнгө оруулсан нь үр ашигтай байж болох юм. Тиймээс та хувь хүний, өрхийн хувьд санхүүгийн төсөв, төлөвлөлтөө богино, дунд, урт хугацаагаар хийх нь таны шийдвэр гаргалтад чухал нөлөөтэй юм.

Инфляци⁵⁸: Энэ нь нэг талаас барааны үнийн уналт, нөгөө талаас төгрөгийн худалдан авах чадварыг харуулах үзүүлэлт юм. Инфляци нь таны хөрөнгө оруулалтын бодит өгөөжид ихээхэн нөлөөтэй бөгөөд урт хугацааны шийдвэр гаргалтаас илүүтэйгээр богино хугацааны шийдвэрт нөлөөлөх талтай. Өгөөжид үзүүлэх инфляцийн нөлөөллийг Хүснэгт 10-3-ээр харууллаа.

Хүснэгт 10-3. Инфляцийн нөлөө

д/д	Хөрөнгө оруулалтын хувилбар	Хүүний хувь (жилийн)	Өгөөжийн түвшин (жилийн)	Инфляци (жилийн)	Бодит хүүний хувь (жилийн)	Бодит өгөөжийн түвшин (жилийн)
1	Банкны хадгаламж*	15%	13.3%	2.9%	12.1%	10.4%
2	ХЗХ-ны хадгаламж**	18%	14.6%		15.1%	11.7%
3	ЗГҮЦ***	13.2%	13.15%		10.3%	10.25%
4	Компанийн бонд****	14.5%	14.4%		11.6%	11.5%
5	Хадгаламжийн сертификат*****	15.3%	13.77%		12.4%	10.87%

Валютын ханш: Валютын ханш нь ямар төрлийн валютаар хадгаламж хийх вэ? гэдэг шийдвэрт нөлөөлөх бөгөөд төгрөгийн худалдан авах чадвар суларна, эсвэл чангарна (ам.доллартай харьцуулахад төгрөгийн ханш сулрах, чангарах) гэсэн хүлээлттэй байгаа нөхцөлд ханшийн хэлбэлзлээс сэргийлэх зорилгоор байгаа хуримтлалаа ам.доллар уруу хөрвүүлж, доллараар хадгаламж хийх, эсвэл долларын хадгаламжаа төгрөгийн хадгаламж болгох нь валютын ханшийн эрсдэлээс хамгаалах нөхцөл болдог. Валютын ханшийн өөрчлөлт нь богино хугацааны

⁵⁸ Хэрэглээний сагсанд багтсан буюу өргөн хэрэглээний бүтээгдэхүүн, үйлчилгээний ерөнхий буюу дундаж үнийн түвшний өсөлтийг инфляци гэнэ (Монголбанк Д. б., 2015).

хадгаламжийн шийдвэрт ихээхэн нөлөөтэй бөгөөд урт хугацаанд валютын ханшийн хэлбэлзлийг бодитойгоор харах боломж бага юм.

Хадгаламжийн хүүний орлогын хэмжээгээр таны ашиг, өгөөж тодорхойлогдохгүй гэдгийг анхаарч байх хэрэгтэй. Та орлого олсон бол тодорхой хэмжээний зардал гарна гэдгийг санах хэрэгтэй. Огт зардал гаргалгүйгээр орлого олно гэж байхгүй. Тиймээс хадгаламж ч гэсэн тодорхой хэмжээний зардалтай байдгийг мэдэх нь чухал. Өөрөөр хэлбэл, танд хадгаламжийн бүтээгдэхүүн үйлчилгээг хүргэхэд БСБ-аас тодорхой хэмжээний зардал (ажилтны цалин, бичиг хэргийн гэх мэт) гарна. Тэр зардлын багахан хэсгийг танаас шимтгэл, хураамж хэлбэрээр суутгаж авдаг. Мөн ажил хийгээд цалингийн орлогоосоо татвар төлдөгтэй адил, хадгаламжийн хүүний орлогоосоо татвар төлдөг гэдгийг мэдэх хэрэгтэй. Энэ бол олон улсын жишигт байдаг л зүйл. Хадгаламжийн хүүний орлогоос хэрхэн татвар авдаг талаар дараагийн хэсэгт авч үзье.

Хадгаламжийн хүүний орлогын албан татварын тухай

Дэлхийн зарим улс оронд банкинд мөнгөө хадгалуулсны төлөө хадгаламж эзэмшигч банкинд мөнгө төлдөг бол ихэнх улс оронд банк хадгаламж эзэмшигчид хадгаламжийн хүү хэлбэрээр мөнгө төлдөг. Мөн зарим улс орон хадгаламжийн хүүний орлогоос татвар авдаг байхад, зарим нь авдаггүй. Манай орны хувьд 2012 оны 10 дугаар сарын 25-ны өдөр “Хувь хүний орлогын албан татварын тухай” хуульд өөрчлөлт оруулж хадгаламжийн хүүний орлогоос албан татвар авах шийдвэр гаргажээ.



Мөнгөн хадгаламжийн нийт хэмжээ нь 100.0 сая төгрөгөөс дээш нэг жил ба түүнээс бага хугацаатай болон хугацаагүй хадгаламжийн хүүний орлогоос бусад Монгол Улсын иргэний мөнгөн хадгаламжийн хүүний орлогыг 2018 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд орлогын албан татвараас чөлөөлөхөөр заасан байна.

Өмнөх хэсэгт үзсэн жишээн дээр тулгуурлан таны хадгаламжийн өгөөжид хадгаламжийн хүүний орлогын татвар хэрхэн нөлөөлөхийг авч үзье. Жишээлбэл, та 50`000 төгрөгийн хуримтлалаа банкинд хадгаламж хэлбэрээр 2 жилийн хугацаатай байршуулахаар болсон. Банкны 2 жилийн хугацаатай хадгаламжийн хүү жилийн 12.5%. Та хадгаламжийн дэвтэр нээлгэхэд 500 төгрөг төлсөн, хадгаламжийн хүүний орлогоос 10%-иар ХХОАТ төлдөг гэж үзье. Хүснэгт 10-4 -ийг харна уу.

Хүснэгт 10-4. Хадгаламжийн хүүний орлогоос татвар суутгасан өгөөжийн тооцоололт ба харьцуулалт

д/д	Хадгаламжийн хэлбэр	Хүүний орлого (2 жилийн)	Зардал* (2 жилийн)	Ашиг**	Өгөөж***
1	Энгийн хүүт хадгаламж	12`500₮	500₮	12`000₮	0.24
2	Нийлмэл буюу хүүнээс хүү боддог хадгаламж (жилд 1 удаа)	13`281.25₮	500₮	12`781.25₮	0.256
3	Нийлмэл буюу хүүнээс хүү боддог хадгаламж (жилд 2 удаа)	13`721.45₮	500₮	13`521.45₮	0.27

* Зардалд ХХОАТ-ыг оруулан тооцов.

** Ашиг=Орлого-зардал (12`000=12`500-500)

*** Өгөөж=Ашиг/ундсэн хадгаламж (0.24=12`000/50`000)

Сэдвийн дүгнэлт

Санхүүгийн хуримтлал нь танд ирээдүйд үүсэх санхүүгийн хэрэгцээгээ хангах боломжийг олгох ач холбогдолтойгоос гадна мөнгөө оновчтой удирдах урлагт сургана. Хуримтлал их байх албагүй, гол мөн чанар нь бага багаар нэмэгдүүлдэг байхад оршино. Хүн нэгэнт хуримтлал үүсгэж чадсан бол бэлэн мөнгө хэлбэрээр хадгалах биш, хадгаламж, хөрөнгө оруулалт болгох хэрэгтэй. Учир нь хуримтлал өсч, мөнгөө оновчтой удирдах урлагт сургана.

Хадгаламж хэлбэрээр хуримтлалаа хийж байгаа тохиолдолд хадгаламжийн хүүгээр таны мөнгө өсч, үржинэ, үнэ цэнээ алдахгүй, алдсан ч багаар алдана. Тусгай харуул, хамгаалалттай газар байх тул найдвартай, ямар нэг эрсдэл үүсэх магадлал бага байна.

Эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж сөрөг үр дагавар гарахыг үгүйсгэхгүй ч, хадгаламж эзэмшигчид санхүүгийн зуучлалын мөн чанарыг зөв ойлгож, санхүүгийн сахилга баттайгаар хадгаламж хийх гэж байгаа БСБ-ын найдвартай байдлыг анхааралтай судалж, сонголтоо хийх нь зүйтэй.

Мөн хадгаламж, хөрөнгө оруулалтын нөхцөл, хүү, хугацаа, хүү тооцох аргачлал зэргийг харьцуулан судлахаас гадна хуримтлалд нөлөөлж болох бусад хүчин зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй. Тухайлбал, инфляцийн түвшин, валютын ханш гэх мэт. Сонголт зөвхөн таны гарт бий.

Бататгах асуултууд

1. Хуримтлал болон хадгаламжийн ялгааг ярилцаж, давуу, сул талуудыг тайлбарлана уу.
2. Хадгаламжийн төрлүүдийн талаар ярилцаж, Монгол Улсын банкуудын хадгаламжийн бүтээгдэхүүний талаар хэлэлцэнэ үү.
3. Дэвтрийн хадгаламж, хадгаламжийн сертификатын онцлог, мөн чанарын талаар ярилцана уу.
4. Хадгаламжийн нэрлэсэн болон бодит хүүний ялгаа юу вэ?
5. Хадгаламжийн энгийн болон нийлмэл хүүний талаар ярилцана уу.

СЭДЭВ 11. ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ТӨРЛҮҮД

Сэдвийг судлахын ач холбогдол, үр дүн

Энэхүү сэдвийг судалснаар хувьцаа, бонд болон хөрөнгө оруулалтын бусад хувилбаруудын онцлог, ялгаа, төрөл, ач холбогдлын талаар онолын мэдлэгтэй болно. Хувийн мөнгөн хөрөнгөө зөв удирдаж, өөрийн санхүүгийн зорилго, нөхцөл байдалд тохируулан хөрөнгө оруулалтын хувилбаруудаас оновчтой сонголт хийж, хуримтлалаа өсгөх, орлого ашиг олохтой холбоотой зөв шийдвэр гаргах чадвар эзэмшинэ.

Тулгуур ойлголт

- Хувийн хөрөнгө оруулалт
- Эрсдэлтэй хөрөнгө оруулалт
- Өрийн бичиг
- Бонд
- Корпорацийн бонд
- Бондын нэрлэсэн үнэ
- Бондын зах зээлийн үнэ
- Бондын эргэн төлөгдөх хугацаа
- Хувьцаа
- Энгийн хувьцаа
- Давуу эрхийн хувьцаа
- Ногдол ашиг
- Хувьцааны жижигрүүлэлт

11.1. Хөрөнгө оруулалт, түүний мөн чанар, ач холбогдол

Хөрөнгө оруулалт: Ирээдүйд орлого, ашиг олох зорилгоор өнөөдөр зарцуулж буй мөнгө.

Хөрөнгө оруулалтыг ерөнхий утгаар нь ашиг олж, хөрөнгө мөнгөө өсгөх зорилгоор ямар нэг үнэт цаас, үл хөдлөх хөрөнгө зэргийг худалдан авах үйл ажиллагаа гэж томъёолдог.

Хөрөнгө оруулалтын ерөнхий зорилго нь мөнгөөр мөнгө олох явдал байдаг. Хөрөнгө оруулалтын ач холбогдол нь хөрөнгө оруулагч өөрийн хөрөнгийг өсгөөд зогсохгүй улс орны эдийн засгийн өсөлтийг дэмжих хэрэгсэл болдогт оршино.


Хөрөнгө оруулалтын төлөвлөгөө боловсруулах шийдвэр гаргах нь урт хугацааны санхүүгийн зорилгоо хэрэгжүүлэхэд шаардлагатай анхны алхам болно. Зарим санхүүгийн төлөвлөгчид мөнгөн дээр суурилан хөрөнгө оруулалтын зорилгоо тодорхойлохыг санал болгодог. Жишээлбэл, 2020 оны 12 дугаар сарын 31 гэхэд би нийтдээ 120`000`000 төгрөгтэй болно гэх мэт. Харин зарим нь хүсч байгаа тодорхой зүйл дээр хөрөнгө оруулалтын зорилгыг чиглүүлэхийг илүүд үздэг. Тухайлбал, 2020 оны 12 дугаар сарын 31 гэхэд би өөрийн хоёр дахь зуслангийн байраа худалдан авахад хүрэлцэхүйц хэмжээний мөнгө хуримтлуулна гэх мэт. Ямар ч хөрөнгө оруулалтын зорилго тодорхой, хэмжиж болохуйц, санхүүгийн тодорхой хэрэгцээг хангахуйц байх ёстой. Хөрөнгө оруулалтын зорилго ямагт ирээдүйд чиглэдэг. Санхүүгийн зорилгыг богино, дунд, урт хугацааны гэж ангилдгийн адил хөрөнгө оруулалтын зорилго ч мөн ангилагдана. Жишээ нь, 12 сарын дотор 5`000`000 төгрөг хуримтлуулах богино хугацааны зорилго тавьж

болох юм. Түүгээрээ хувьцаа худалдан авах, бизнес эрхлэх зэрэг дунд болон урт хугацааны зорилгыг цаашид тавьж болно.

Дараах асуултууд хөрөнгө оруулалтын зорилгоо үндэслэлтэй тодорхойлоход тусална. Үүнд:

- Та мөнгөө юунд зориулж ашиглах вэ?
- Хөрөнгө оруулалтын зорилгоо биелүүлэхэд танд хэдий хэмжээний мөнгө хэрэгтэй вэ?
- Та хэрхэн мөнгө олох вэ?
- Танд мөнгө олоход хэдий хэр удаан хугацаа шаардагдах вэ?
- Ямар хэмжээний эрсдэлийг хүлээх чадвартай вэ?
- Хөрөнгө оруулалтын зорилгоо өөрчилж чадах эдийн засгийн болон хувийн ямар боломжит нөхцөлүүд байгаа вэ?
- Хөрөнгө оруулалтын зорилгыг хэрэгжүүлэх боломжтой эдийн засгийн нөхцөл байдлаа тооцсон уу?
- Хөрөнгө оруулалтын зорилгоо хэрэгжүүлэхийн тулд хэрэглээгээ багасгаж чадах уу?
- Хэрэв хөрөнгө оруулалтын зорилгодоо хүрч чадахгүй бол ямар үр дагавар гарах вэ?

Зураг 11-1. Хөрөнгө оруулалт хийх үе шатууд⁵⁹



Хөрөнгө оруулалтын найдвартай байдал болон эрсдэл гэсэн хоёр ойлголт нь нэг юмны хоёр тал юм. Иймээс эрсдэл, аюулгүй байдал хоёр хэрхэн холбогдож байгааг анхаарч үзэхгүйгээр хөрөнгө оруулалтын шийдвэр гаргаж болохгүй. Хөрөнгө оруулалт нь хамгийн найдвартайгаас хамгийн эрсдэл өндөртэй хөрөнгө оруулалтуудыг хамардаг.

Хөрөнгө оруулалтын олон сонголтуудын нэг талд хамгийн аюулгүй, найдвартай хөрөнгө оруулалтууд байх бөгөөд үүнд Засгийн газрын бонд, хадгаламжийн сертификат, хадгаламжийн данс, нэр хүнд бүхий компанийн бонд, хувьцаа зэрэг хамаарна. Эдгээр төрлийн хөрөнгө оруулалтууд нь үнэ цэнэгүй болох өчүүхэн бага

⁵⁹ Lewes J. Altfest, (2007). "Personal financial planning", USA. p226.

магадлалтай гэдгийг хөрөнгө оруулагчид мэдэж байдаг. Ийм төрлийн хөрөнгө оруулалтыг сонгох хэд хэдэн шалтгаан байдаг. Үүнд:

- Хөрөнгө оруулагч өөрийгээ санхүүжүүлдэг учраас эрсдэл багатай хөрөнгө оруулалтыг сонгодог.
- Тэтгэвэрт гарах дөхөж байгаа хөрөнгө оруулагчид өөрийн сүүлийн ганц боломжоо найдвартай хадгалж үлдэх үүднээс энэ төрлийн хөрөнгө оруулалтыг сонгодог.
- Банкнаас мөнгөө татаж байгаа хүмүүс бэлэн мөнгөтэй холбоотой эрсдэлээс сэргийлэхийн тулд энэ хөрөнгө оруулалтад мөнгөө байршуулдаг.
- Зарим хөрөнгө оруулагчид өндөр ашиг амлаж байгаа, эрсдэл өндөртэй хөрөнгө оруулалтаас зайлсхийж үүнийг сонгодог.

Эрсдэл багатай хөрөнгө оруулалтын зэрэгцээ эрсдэл өндөртэй хөрөнгө оруулалтууд байдаг.

***Спекулятив буюу эрсдэлтэй хөрөнгө оруулалт:** Харьцангуй богино хугацаанд их хэмжээний ашиг олох сонирхлыг төрүүлдэг, өндөр эрсдэл дагуулдаг хөрөнгө оруулалт.*

Ийм төрлийн хөрөнгө оруулалтууд их хэмжээний ашиг амладаг боловч амжилт олох нь бага бөгөөд хөрөнгө оруулагч нь хөрөнгийнхөө ихэнх хэсгийг, тэр ч байтугай бүгдийг алдах магадлал өндөртэй байдаг.

Эрсдэл өндөртэй хувьцаа, бонд, бараа таваар, опцион зэрэг нь хөрөнгө оруулалтын энэ төрөлд хамаардаг.

Хөрөнгө оруулагчдын баримталбал зохих үндсэн зарчим нь эрсдэл болон түүнд нөлөөлөх хүчин зүйлсийн хоорондын хамаарлыг үнэлж байх явдал юм. Учир нь хөрөнгө оруулагчийн төсөөлж байгаа хөрөнгө оруулалтаас олох боломжит ашгийн хэмжээ нь эрсдэлд шууд нөлөө үзүүлнэ. Хэдийгээр хүн бүр хөрөнгө оруулалт хийх тодорхой зорилготой байдаг ч сонголт хийхээсээ өмнө хөрөнгө оруулалтад нөлөөлж болох хүчин зүйлүүдийн талаар мэдлэгтэй болсон байх хэрэгтэй. Энэ нь хөрөнгө оруулалтын найдвартай байдлыг хангах, эрсдэлээс хамгаалах, орлого ашгаа өсгөх, хөрөнгө оруулалтын хөрвөх чадварыг сайжруулах зэрэг ач холбогдолтой байна. Хөрөнгө оруулалтын шийдвэрт нөлөөлөх хүчин зүйлсийг үндсэн гурван төрөлд хуваан авч үзнэ. Үүнд:

- Орлогын хүчин зүйл
- Өсөлтийн хүчин зүйл
- Хөрвөх чадварын хүчин зүйлс орно

Хөрөнгө оруулагчид зарим тохиолдолд хөрөнгө оруулалтаас тогтмол орлого олж байх зорилгоор хөрөнгө худалдан авдаг. Хамгийн эрсдэл багатай хөрөнгө оруулалт болох хадгаламжийн сертификат, Засгийн газрын бонд, хадгаламжийн дансууд зэрэг нь хамгийн тогтвортой орлогын эх үүсвэрт тооцогддог. Эдгээр төрлийн

хөрөнгө оруулалтуудаас хичнээн хэмжээний орлого олох, хэзээ хүү нь төлөгдөх зэргийг хөрөнгө оруулагчид тодорхой мэдэх боломжтой.

Өсөлтийн хүчин зүйлд хөрөнгө оруулалтын үнэ цэнийн өсөлт хамаарна. Тухайлбал, Зах зээл дээрх хувьцаа, бонд, үл хөдлөх хөрөнгийн үнийн өсөлт.

Хөрвөх чадвар: Ямар нэг зүйл үнэ цэнээ алдахгүйгээр мөнгөнд шилжих чадвар.

Чекийн болон хадгаламжийн дансууд хамгийн хөрвөх чадвар сайнд тооцогдоно.

Учир нь тэд маш хурдан бэлэн мөнгө болон хувирдаг. Гэтэл үл хөдлөх хөрөнгийг яаралтай худалдахын тулд хямд үнийг санал болгох хэрэгтэй болно.

Хөрөнгө оруулалтыг олон шинж чанар, шалгуураар ангилдаг бөгөөд хувь хүмүүс хөрөнгө оруулалтын олон төрлийг сонгох боломжтой байдаг. Тухайлбал, хувьцааны, бондын, үл хөдлөх хөрөнгийн, таваарын гэх мэт.

11.2. Хувьцааны хөрөнгө оруулалт

Хувьцаа нь тухайн байгууллагад хөрөнгө оруулсан болон хөрөнгийн тодорхой хувийг эзэмшиж байгааг гэрчлэх үнэт цаас бөгөөд оруулсан хөрөнгийн тодорхой хувиар хариуцлага хүлээж, ногдол ашиг хүртэх боломжтой. Монгол Улсын “Үнэт цаасны зах зээлийн тухай хууль”-д “Компанид хөрөнгө оруулж, түүнийг үндэслэн хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож санал өгөх, ногдол ашиг авах, компанийг татан буулгасны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдан борлуулснаас олсон орлогоос хувь хүртэх болон хуулиар тогтоосон бусад эрхийг гэрчилсэн үнэт цаасыг хувьцаа гэнэ”⁶⁰ гэж тодорхойлсон байдаг.

Хувьцаа: Компанид хувь нийлүүлснийг гэрчлэх үнэт цаас.

Хувьцаа нь тодорхой нэрлэсэн үнэтэй байх ба хугацаа дуусах, хэн нэгэнд, ямар нэгэн төлбөр төлөх үүрэггүй байдгаараа онцлог юм.

Хувьцаа нь бондоос огт өөр бөгөөд хувьцаа эзэмшигч нь зээлдүүлэгч биш харин хөрөнгө эзэмшигч болдог⁶¹. Хөрөнгө оруулагчид корпорацийг мөнгөөр хангадаг. Харин корпораци түүнийг ашиглан борлуулалт хийж ашиг олдог. Хөрөнгө оруулагчид энэ ашгаас хувь хүртдэг. Өнөөдөр маш олон хүмүүс хувьцаа худалдан авч, худалдаж байна. Учир нь тэд уламжлалт бусад хөрөнгө оруулалтуудаас илүү их өгөөж олохыг хүсч байдаг. Амжилттай ажиллаж байгаа компанийн хувьцаанаас илүү их өгөөж хүртэнэ. Гэхдээ хувьцаанд хөрөнгө оруулалт хийхээс өмнө энэ төрлийн хөрөнгө оруулалт нь илүү эрсдэлтэй бөгөөд илүү их хэмжээний алдагдал хүлээж болно гэдгийг ойлгосон байх хэрэгтэй.

⁶⁰ Монгол Улсын хууль, (2015). *Үнэт цаасны зах зээлийн тухай, шилжилсэн найруулга, 3.1.5 дахь заалт*

⁶¹ Jewis J. Altfest, (2007). “Personal financial planning” USA. p 237.

Хувьцааг энгийн болон давуу эрхийн хувьцаа гэж ангилдаг.

Энгийн хувьцаа: Зах зээл дээр нийтэд санал болгож байгаа, саналын эрхтэй хувьцаа.

Энгийн хувьцаа эзэмшигч нь компанийн гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагаанд хяналт тавих, санал өгөх эрхийг эдэлдэг.

Энгийн хувьцаа эзэмшигч дараах эрхүүдийг эдэлдэг. Үүнд:

1. Компанийн олсон ашгаас тодорхой хэмжээний ногдол ашиг авах. Энгийн хувьцаа эзэмшигч компани ашигтай ажилласан эсэх, ашгаа хуваарилах эсэхээс хамаарч ногдол ашиг хүртэх боломжтой. Ногдол ашгийг бэлэн мөнгөөр олгохоос гадна эд хөрөнгө, үнэт цаас хэлбэрээр олгож болдог.
2. Компанийг удирдахад санал өгөх замаар оролцох. Хувьцаа эзэмшигчид нь компанийн үйл ажиллагаатай холбоотой шийдвэр гаргахад хувь нийлүүлэгчдийн хуралд оролцож саналаа өгөх замаар компанийг удирдахад оролцох боломжтой байдаг. Нэг хувьцаа нэг саналын эрхтэй байна. Иймээс та нийт хувьцааны хэдэн хувийг эзэмшиж байгаагаас хамаарч таны санал нийт саналын хэдэн хувь болохыг тодорхойлдог. Жишээ нь, “Б” ХК нийт 200 ширхэг энгийн хувьцаа гаргасан. Нийт саналын эрх 100% байна. Нэг хувьцаанд хэдэн хувийн саналын эрх ногдож байгааг тооцоолбол:

$$\text{Нэг хувьцаанд ногдох саналын эрхийн хувь} = 200 \text{ ш} : 100\% = 0.5\%$$

Хэрэв та 102 ширхэг хувьцаа эзэмшиж байгаа гэж бодвол:

$$\text{Таны өгөх саналын эрхийн хувь} = 102 \text{ ш} \times 0.5\% = 51\%$$

Энэ тохиолдолд таны хувьцааны саналын эрх 51 хувь болж байгаа учраас ямар нэг асуудлаар шийдвэр гаргахад таны санал нийт саналын 51 хувь болж, таны хүссэнээр шийдвэр гарах болно. Иймээс компанид өөрийн хяналтыг хүчтэй болгохыг хүсвэл аль болох олон хувьцаа эзэмших шаардлагатай.

3. Компанийн үйл ажиллагааны талаарх мэдээллийг авах;
4. Компани татан буугдах үед оруулсан хөрөнгөө эргүүлж авах. Компани татан буугдах үед татан буулгах комисс нь зээлдүүлэгчдийн өр төлбөрийг барагдуулсны дараа үлдсэн эд хөрөнгийг худалдаж олсон орлогыг тодорхой дарааллын дагуу хувьцаа эзэмшигчдэд хуваарилна.

Давуу эрхийн хувьцаа: Зөвхөн энгийн хувьцаа эзэмшигчиддээ зориулж гаргасан саналын эрхгүй хувьцаа.

Давуу эрхийн хувьцаа эзэмшигч нь ашиг хуваарилах болон компани татан буугдах үед бусад хувьцаа эзэмшигчээс давуу эрх⁶² эдэлдэг.

Давуу эрхийн хувьцааны онцлог нь саналын эрхгүй, компани ашигтай ажилласан эсэхээс үл хамааран тогтмол хэмжээний ногдол ашиг хүртдэг явдал юм. Давуу

⁶² Энгийн хувьцаа эзэмшигчдээс түрүүнд ашиг хүртэх, хөрөнгийн хуваарилалт түрүүлж хийгдэхийг хэлнэ.

эрхийн хувьцааг улсын үйлдвэрийг хувьчлах, хувийн компаниуд хяналтын багцыг өөрчлөхгүйгээр санхүүжилтийн эх үүсвэр олж авах зорилгоор гаргадаг.

Давуу эрхийн хувьцаа нь энгийн хувьцааг бодвол доорх давуу талуудтай байдаг. Үүнд:

1. Энгийн хувьцаа эзэмшигчдээс түрүүлж ногдол ашиг авах
2. Тогтмол ногдол ашиг авах. Энгийн хувьцаанд ногдол ашгийг зөвхөн компани ашигтай ажилласан тохиолдолд захирлуудын зөвлөлөөс ногдол ашиг хуваарилахаар шийдвэр гаргасан үед олгодог бол давуу эрхийн хувьцаанд ямарч тохиолдолд тогтмол ногдол ашиг олгодог
3. Компани татан буугдах, дампуурах үед энгийн хувьцаа эзэмшигчдээс түрүүлж оруулсан хөрөнгөө авах
4. Энгийн хувьцаанд хөрвөх гэх мэт

Хувьцаа нь дараах онцлог шинжийг агуулж байдаг. Үүнд:

- Компанийн хувьцаа эзэмшигчид нь уг компанийн өмчлөгчид байдаг бол бонд эзэмшигч нь зээлдүүлэгч болдог.
- Хувьцаа эзэмшигчид нь ихэвчлэн компанийн захирлыг сонгох болон бусад гол асуудлуудыг шийдэхэд санал өгөх эрхтэй байдаг. Харин зээлдэгч нарт санал өгөх эрх байдаггүй.
- Хувьцаа эзэмшигчдийн ногдол ашиг болон хөрөнгө нэхэмжлэх эрх нь тухайн компанийн өр төлбөр төлөгдөж дууссаны дараа тавигдах болно.

Хүснэгт 11-1. Хувьцаа болон бондын харьцуулалт


Үзүүлэлт	Хувьцаа		Бонд	
	Энгийн хувьцаа	Давуу эрхтэй хувьцаа	Барьцаатай	Барьцаагүй
Хугацаа	Хугацаагүй		Дуусах хугацаатай	
Мөнгөн урсгал	Хувьсах ногдол ашиг	Тогтмол ногдол ашиг	Хүү (Купон)	
Саналын эрх	Эрхтэй	Эрхгүй	Эрхгүй	
Хөрөнгө хуваарилах дараалал	(IY)	(III)	(I)	(II)
Нөхцөл	Эргэн дуудагдах*	Хөрвөх**	Олон төрлийн нөхцөлүүдтэй.	

1. Компанийн хувьцаа эзэмшигч болсноор тухайн компанийн хөрөнгийн тодорхой хэсгийг өмчлөгч болно. Өөрөөр хэлбэл та компанийн нийт хувьцааны хэдэн хувийг эзэмшиж байгаатайгаа тэнцүү хэмжээгээр нийт хөрөнгийн тодорхой хэсгийг өмчлөгч боллоо гэсэн үг. Үүний дүнд та өмчлөх болон үр хүүхдэдээ өвлүүлэн үлдээх хөрөнгөтэй болно.
 2. Таны хувьцааг нь эзэмшиж байгаа компани ашигтай ажилласан үед ногдол ашиг хэлбэрээр орлого олох боломжийг бүрдүүлнэ.

Ногдол ашиг: Компанийн олсон ашигаас хувьцаа эзэмшигчдэдээ хуваарилах болсон хэсэг¹.
 3. Хувьцаагаа барьцаалан зээл авах боломжтой.
 4. Хэрэв та хүсвэл хувьцаагаа худалдаж, бэлэн мөнгөтэй болж болно.
 5. Ихэнх тохиолдолд хүмүүс хувьцаа худалдан аваад удаан хугацааны туршид эзэмшдэг. Хэрэв зах зээл дээр тухайн хувьцааны үнэ өсвөл хувьцаагаа өндөр үнэтэй байгаа дээр нь худалдах уу, эсвэл цааш эзэмшсээр байх уу гэдэг шийдвэр гаргах хэрэгтэй болно. Хэрэв хувьцаагаа худалдахаар шийдвэл худалдан авсан үнэ болон борлуулсан үнэ хоёрын зөрүүнээс ашиг олж болно. Өөрөөр хэлбэл, хувьцааны үнэ нь өссөн үед хувьцаагаа худалдах, буурсан үед нь эргүүлэн худалдан авах замаар үнийн зөрүүнээс ашиг олох боломжтой.
 6. Хөрөнгө оруулагчид мөн хувьцаа жижигрүүлэлтээс боломжит ашиг олдог.

Хувьцааны жижигрүүлэлт: Хувьцаа эзэмшигчдийн мэдэлд байгаа хувьцааг олон тооны хувьцаа болгон хуваах үйл явц.
- Хувьцааг жижигрүүлснээс компани хувьцааныхаа үнийг бууруулж, олон хөрөнгө оруулагчдыг өөртөө татах болно. Харин хувьцаа эзэмшигчид нь өмнөхөөсөө олон тооны хувьцааг эзэмшигч болж хувирдаг.
7. Хувьцаагаа бэлэглэж, өвлүүлж болно.

Зураг 11-2. Хувьцааны үр өгөөж



11.3. Бондын хөрөнгө оруулалт

Өрийн бичиг: Тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүг мөнгөн, эсвэл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаас.

Бонд нь үнэт цаас гаргагч хөрөнгө оруулагчид өртэй гэдгийг батлах, тодорхой хугацаатай, тодорхой хугацаанд тодорхой хэмжээний төлбөрийг эргүүлэн төлөхийг баталсан өрийн үнэт цаас юм. Бонд нь анх гарахдаа тодорхой тогтоосон үнийн дүн, нэрлэсэн үнэ, дуусах хугацаатай байх ба нэрлэсэн хүүтэй эсвэл нэрлэсэн хүүгүй байж болно. Бондын хугацаа, нэрлэсэн үнэ, дуусах хугацаа, купон, төрөл бүрийн хязгаарлах нөхцөлүүд, бонд эзэмшигчийн эрх болон бонд гаргагчийн үүрэг хариуцлагыг бондын гэрээнд тодорхой заасан байдаг. Бондыг Засгийн газар болон компаниуд гаргаж худалддаг.

Бонд: Тодорхой хэмжээний мөнгийг хүүтэйгээр эргүүлэн төлөх баталгаа.

Бондын хөрөнгө оруулалт нь сүүлийн 100 гаруй жилийн туршид хөрөнгө оруулалтын сонголтуудаас хамгийн гол нь болж байсан. Бонд нь зээлийн хөрөнгө буюу өрийн бичгийн нэг төрөл болдог.

Иймээс бондыг гаргагчаас нь хамаарч Засгийн газрын болон компанийн гэж ангилдаг.

Аль ч улсын Засгийн газар санхүүжилтийн эх үүсвэр олж авах зорилгоор бонд гаргаж болно. Засгийн газрын үнэт цаасууд нь эрсдэлгүй байдаг учраас ихэнх хөрөнгө оруулагчид тэдгээрийг сонгодог. Засгийн газар зээлсэн мөнгөө бүрэн эргүүлж төлөх найдвартай бөгөөд бондын гэрээний үүргээ үл биелүүлэх эрсдэл байдаггүй. Гэхдээ Засгийн газрын үнэт цаасууд нь компанийн үнэт цаастай харьцуулахад бага хүүтэй байдаг.

Засгийн газраас гадна компаниуд санхүүгийн зах зээл дээр бонд гаргаж, санхүүгийн эх үүсвэр татах эрхтэй байдаг. Энэ зорилгоор компаниас гаргасан бондыг компанийн бонд гэнэ. Бонд нэрлэсэн болон зах зээлийн үнэтэй байна.

Компанийн бонд: Тодорхой хэмжээний мөнгийг хүүтэйгээр зээлснийг гэрчлэх, компаниас гаргасан санхүүгийн хэрэгсэл.

Бондын хугацаа дуусахад бонд эзэмшигчид эргүүлэн төлөх мөнгөний дүн буюу зээлсэн мөнгөний хэмжээг бондын **нэрлэсэн үнэ** гэнэ.

Тухайн бондын зах зээл дээр арилжаалагдаж байгаа үнэ нь бондын зах зээлийн үнийг илэрхийлнэ. Бонд нь эргэн төлөгдөх хугацаатай байна.

Бондын эргэн төлөгдөх хугацаа: Компани зээлсэн мөнгөө эргүүлэн төлөхөөр гэрээнд заасан өдөр.

Энэ нь компани зээлсэн мөнгөө эргүүлэн төлөх ёстой өдрийг тодорхойлдог.

Бондын эргэн төлөгдөх хугацаа болоход компани бонд эзэмшигчид бондын нэрлэсэн үнэтэй тэнцэх хэмжээний мөнгийг эргүүлэн төлдөг. Бондын хугацаа ихэвчлэн 1-30 жил байна.

Бонд нь гаргалтын шинж чанар, эргэн төлөгдөх хугацаа, зах зээл, санхүүгийн агуулгаасаа шалтгаалж маш олон төрөл байдаг. Тухайлбал, төлөгдөх хугацаанаас өмнө бонд гаргагч нь худалдан авч болох нөхцөлтэйгээр эргэн дуудагдах бонд гаргадаг.

Эргэн дуудагдах бонд: Бонд гаргагч бондын төлөгдөх хугацаанаас өмнө эргүүлэн татах нөхцөлтэйгээр гаргасан бонд.

Ийм бонд гаргах зорилго нь зах зээл дээр хүүний түвшин унасан үед өндөр хүүтэй бондоо татан авч, бага хүүтэй бонд гаргах явдал байна.

Ийм бондыг ихэвчлэн нэрлэсэн үнээс нь илүү үнээр эргүүлэн худалдан авах бөгөөд эргүүлэн худалдан авах нөхцөлийг гэрээнд тусгасан байдаг.

Аль ч төрлийн бондод хөрөнгө оруулалт хийх нь хөрөнгө оруулагчдад дараах ач холбогдолтой. Үүнд:

1. Хүүний орлого олно.
2. Бондын үнийн өсөлтөөс ашиг болох боломжтой.
3. Бэлэн мөнгө хадгалснаас үүсэх эрсдэлүүдээс хамгаална.

4. Бэлэн мөнгө хэрэгцээтэй болсон үедээ санхүүгийн зах зээл дээр хялбархан худалдаж болох учраас төлбөрийн чадвараа хадгалж үлдэнэ.

Харин Засгийн газрын бонд худалдан авсан хөрөнгө оруулагч нь дараах давуу боломжийг олж авдаг. Үүнд:

1. Эрсдэлгүй хөрөнгө оруулалт хийх боломжтой.
2. “Хүн амын орлогын албан татварын тухай” хуулийн 16.1.16, “Аж ахуйн нэгжийн орлогын албан татварын тухай” хуулийн 18.1.1-д тус тус зааснаар иргэн, байгууллагын худалдан авсан ЗГҮЦ-ны төлбөр, хүү нь татвараас чөлөөлөгдөнө.
3. ЗГҮЦ-ны хүү зах зээлийн зарчмаар тооцогддог тул зах зээлийн дундаж хүүнээс багагүй өгөөж хүртэх боломжтой.
4. ЗГҮЦ нь хөрвөх чадвар өндөртэй тул худалдан авсан үнэт цаасаа хугацаанаас нь өмнө аливаа торгуульгүйгээр бусдад худалдах, бэлэглэх, барьцаалах бүрэн боломжтой.

11.4. Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалт

Үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулалт хийх нь инфляцийн эсрэг сайн хамгаалалт болдог тул хөрөнгө оруулагчид энэ төрлийн хөрөнгө оруулалтыг сонгодог. Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтыг шууд ба шууд бус гэж ангилдаг.

Шууд хөрөнгө оруулалт: *Хөрөнгө оруулагчийн хууль ёсоор эзэмших үл хөдлөх хөрөнгө худалдан авах замаар хийх хөрөнгө оруулалт.*

Шууд хөрөнгө оруулалт нь орон сууц, газар, зуслан зэрэг үл хөдлөх хөрөнгийг ашиг олох зорилгоор худалдан авах замаар хийж буй хөрөнгө оруулалт юм.

Энэ төрлийн хөрөнгө оруулалтыг дараах зорилгоор хийдэг. Үүнд:

- Амьдран суух
- Инфляцийн эрсдэлээс хамгаалах

Харин зуслангийн байр бол эрүүл агаарт гарч, тав тухтай амрахыг хүссэн хүмүүст тохиромжтой хөрөнгө оруулалт. Ер нь хоёр дахь орон байраа худалдан авах боломжтой болсон хүмүүс нэг бол зуслан, нөгөө бол түрээслүүлэх орон сууц гэсэн сонголттой тулгарч байдаг. Арилжааны ашиг олох зорилготой хөрөнгө оруулалтад түрээсэлж ашиг олох зорилготой газар, барилга, байгууламж хамаарна. Үүнд: Орон сууц, зочид буудал, албан тасалгаа, дэлгүүр болон бусад бүх төрлийн арилжааны зориулалттай байгууламж орно.

Газрын хөрөнгө оруулалтын тухайд үргэлж мөнгөний урсгал бий болгохгүй гэдгийг санах хэрэгтэй. Ихэнх хөрөнгө оруулагчид газрыг хувааж, ашиглах зорилгоор худалдан авдаг. Харин арилжааны зориулалттай худалдан авах нь ихээхэн эрсдэл

дагуулдаг. Тухайлбал, цэвэр, бохир ус болон бусад үйлчилгээ явуулах боломжийг бодолцох хэрэгтэй.

Шууд бус хөрөнгө оруулалт:

Хөрөнгө оруулагчийн нэрийн өмнөөс үл хөдлөх хөрөнгө хууль ёсоор эзэмшдэг байгууллагад хийх хөрөнгө оруулалт.

Шууд бус хөрөнгө оруулалт нь үл хөдлөх хөрөнгийн синдикат, үл хөдлөх хөрөнгө оруулалтын итгэлцлийн сан, моргейж, моргейжийн сан зэрэгт оруулах хөрөнгө оруулалт байдаг.

Синдикат: *Их хэмжээний хөрөнгө шаардлагатай тодорхой ажлыг гүйцэтгэх зорилгоор зохион байгуулсан компани эсвэл хувь хүмүүсийн түр зуурын нэгдэл.*

Синдикат нь ихэнхидээ их хэмжээний хөрөнгө, нөөц шаарддаг үйл ажиллагаа явуулах зорилгоор зохион байгуулсан компани, итгэлцлийн сан болон бүрэн бус хариуцлагатай нөхөрлөл байдаг.

Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын итгэлцлийн сан нь хамтын сан, хөрөнгө оруулалтын компанитай адилаар бирж болон биржээс гадуур үйл ажиллагаа явуулдаг. Эдгээр сангууд зээлийн сангийн хамт орон сууцны (моргейжийн) зээл эсвэл үл хөдлөх хөрөнгөд хөрөнгө оруулна. Ерөнхийдөө, илүү чадвартай хөрөнгө оруулагчид л моргейж болон бусад өрийн гэрээг худалдан авдаг. Эдгээр хөрөнгө оруулалт өндөр өгөөжтэйн хэрээр эрсдэл ихтэй.

Зураг 11-3. Үл хөдлөх хөрөнгөд хийх хөрөнгө оруулалтын давуу болон сул тал

Давуу тал

- Инфляциас хамгаална.
- Хязгаарлагдмал санхүүгийн харууллага хүлээнэ.
- Удирдлагын хувьд сэтгэл зовох асуудалгүй.
- Санхүүгийн хөшүүрэг болно.

Сул тал

- Хөрвөх чадваргүй.
- Хөрөнгийн үнэ цэнэ буурч болзошгүй.
- Эрсдэлийг тараан байршуулах боломж дутагдалтай.
- Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт хязгаарлагдмал.
- Урт хугацаанд элэгдэл тооцно.
- Зээлээ төлж чадахгүйгээс санхүүгийн хувьд хараат байдалд орж болно.

Сэлвийн дүгнэлт

Хөрөнгө мөнгөө өсгөх, ашиг олох зорилгоор үнэт цаас, үл хөдлөх хөрөнгө зэргийг худалдан авах үйл ажиллагааг хөрөнгө оруулалт гэж ойлгоно. Хувь хүн хөрөнгө оруулалтын шийдвэр гаргахын тулд юуны өмнө тодорхой, хэмжиж болохуйц, санхүүгийн тодорхой хэрэгцээг хангахуйц хөрөнгө оруулалтын зорилгоо тодорхойлох хэрэгтэй.

Хувь хүний хөрөнгө оруулалтын шийдвэрт хөрөнгө оруулалтаас олох орлогын хэмжээ, хөрөнгө оруулсан зүйлийн үнийн өсөлт болон хөрвөх чадварын үзүүлэлтүүд нөлөөлнө.

Хувь хүний хөрөнгө оруулалтын олон боломжит хувилбарууд байх бөгөөд эдгээрээс хамгийн түгээмэл нь хувьцааны, бондын, үл хөдлөх хөрөнгөд хийх хөрөнгө оруулалтууд байдаг.

Хувьцаа нь энгийн ба давуу эрхийн хувьцаа гэсэн төрөлтэй байх бөгөөд энгийн хувьцаа нь саналын эрхтэй байдгаараа онцлог. Харин давуу эрхийн хувьцаа нь тогтмол ногдол ашиг хүртдэг. Хувьцааны хөрөнгө оруулагч нь компанийн хөрөнгийн тодорхой хэсгийг өмчлөгч болох бөгөөд компанийн олсон ашгаас ногдол ашиг хүртэх, хувьцааны үнийн зөрүүгээс ашиг олох зэрэг давуу талыг олж авдаг.

Харин бондын хөрөнгө оруулалт хийснээр хүүний болон үнийн зөрүүнээс ашиг олох боломжтой.

Үл хөдлөх хөрөнгө худалдан авснаар инфляцийн эрсдэлээс хамгаалах, түрээсийн орлого олох зэрэг давуу талыг олж авдаг. Гэвч үл хөдлөх хөрөнгө нь хөрвөх чадвар муутай байдаг.

Бататгах асуултууд

1. Хөрөнгө оруулалт гэж юуг хэлэх вэ?
2. Хөрөнгө оруулалтын ач холбогдлыг дэлгэрүүлэн ярилцана уу.
3. Бондын болон хувьцааны хөрөнгө оруулалтын нийтлэг болон ялгаатай тал юунд орших вэ?
4. Давуу эрхийн хувьцааны давуу тал нь юу вэ?
5. Үл хөдлөх хөрөнгийн хөрөнгө оруулалтын давуу болон сул талыг тайлбарлана уу.
6. Бусад хөрөнгө оруулалтын талаар бие даан судалж, дэлгэрүүлэн ярилцана уу.

СЭДЭВ 12. ХУДАЛДАН АВАЛТЫН ШИЙДВЭР ГАРГАЛТ

Сэдвийг судлахын ач холбогдол, үр дүн

Энэ сэдвийг судалснаар худалдан авалтын шийдвэр гаргахдаа анхаарах, худалдан авалт хийх энгийн аргуудыг ашиглан санхүүгийн зөв шийдвэр гаргах чадварыг эзэмшиж, хэрэглэгчийн хувьд өөрийнхөө эрх ашгийг хамгаалахтай холбоотой мэдлэг олж авна. Мөн орон сууц болон тээврийн хэрэгсэл худалдан авахад зайлшгүй мэдвэл зохих зүйлсийн тухай мэдлэг эзэмшинэ.

Тулгуур ойлголт


- Харьцуулсан худалдан авалт
- Гэнэтийн худалдан авалт
- Нэгжийн үнэ
- Баталгаа
- Бүрэн баталгаа
- Хязгаарлалттай баталгаа
- Нийтийн тээвэр
- Шошгоны үнэ

12.1. Худалдан авалтын шийдвэр гаргалт

Аливаа хүмүүс нас, орлогын хэмжээ, гэр бүлийн байдал зэргээс үл хамааран бараа, үйлчилгээ худалдан авч, өдөр тутмын хэрэгцээгээ хангаж байдаг. Хувь хүний худалдан авалтын шийдвэр тухайн хүний хөрөнгийн зарцуулалт, хуримтлал, хөрөнгө оруулалт, хувь хүний санхүүгийн зорилгын хэрэгжилтэд зайлшгүй нөлөөлж байдаг. Иймээс ямарваа худалдан авалт хийхдээ ирээдүйн санхүүгийн баталгааг хангахын тулд орлогоо бүгдийг зарцуулахгүй байх хамгийн энгийн зарчмыг баримтлах нь зүйтэй. Орлогоос хэтэрсэн зарцуулалт бол зээлийн буруу ашиглалт буюу санхүүгийн хүндрэлийн гол шалтгаан болдог.

Худалдан авалтын шийдвэрт эдийн засгийн, нийгмийн, хувийн маш олон хүчин зүйлс нөлөөлдөг. Энэ бүгдийг тооцолгүй худалдан авалтын буруу шийдвэр гаргах нь санхүүгийн алдагдалд хүргэнэ. Худалдан авалтын буруу шийдвэр ямар үр дүнд хүргэж болохыг Зураг 12.1-д харууллаа. Иймээс төлөвлөгөөтэй, хувийн санхүүгийн нөхцөл байдалд тохирсон худалдан авалт хийж, өөрийн санхүүгийн зорилгод хүрэхийн тулд дараах зүйлсийг анхаарч үзэх шаардлагатай. Үүнд:

- Хэрэгцээт зүйлээ өнөөдөр зээлээр худалдан авах нь ирээдүйд илүү үнэ төлөх нөхцөл болно.
- Мэдэхгүй зүйлээ худалдан авах нь магадгүй шаардлагагүй, чанар муутай зүйлийг өндөр үнээр авахад хүргэж болно.
- Худалдан авсан бүтээгдэхүүнийг ашиглах явцад засвар, үйлчилгээ хийхэд хүндрэл гарч болно.
- Цахим худалдан авалт хийх нь цаг зав, хөрөнгө мөнгө хэмнэж болох боловч барааг буцаах, солих зэрэгт бэрхшээл учирдаг.
- Цаг хугацаа зарцуулж, харьцуулан худалдан авалт хийх нь мөнгө хэмнэх, чанартай бараа, үйлчилгээ худалдан авах гол арга болно.

Зураг 12-1. Худалдан авалтын шийдвэр санхүүгийн байдалд нөлөөлөх нь⁶⁴

Худалдан авалт нь харьцуулсан ба гэнэтийн гэсэн үндсэн хэлбэртэй.

Харьцуулсан худалдан авалт:

Дэлгүүр, барааг үйлдвэрлэсэн газар, үнийг харьцуулан судалсны үндсэн дээр хийж байгаа худалдан авалт.

Гэнэтийн худалдан авалт:

Санхүүгийн хүндрэл үүсгэж болох, төлөвлөгдөөгүй худалдан авалт.

Худалдан авалтын шийдвэр гаргахдаа дараах нийтлэг зүйлсийг анхаарах шаардлагатай. Үүнд:

- Хамгийн сайн чанартай бүтээгдэхүүнийг тодорхойлохын тулд ижил төрлийн барааны хувьд үйлдвэрлэсэн газрыг нь харьцуулах
- Үнэ, барааны чанар, санал болгож байгаа үйлчилгээ, буцааж болох нөхцөл зэргийг анхаарч, хаанаас худалдан авалт хийхээ шийдвэрлэх
- Шошгоны мэдээллийг уншиж, тооцоолох
- Байнга худалдан авдаг бараанд хөнгөлөлтийн тасалбар ашиглах
- Янз бүрийн савлагаатай ижил төрлийн бүтээгдэхүүний үнийг харьцуулахад нэгжийн үнийг тооцох
- Бараа, бүтээгдэхүүний хадгалалтын хугацааг харах
- Худалдан авалтын шийдвэрт нөлөөлж болохуйц төрөл бүрийн мэдээллийн эх үүсвэр ашиглах

⁶⁴ Jack r. Kapoor, Les r. Dlabay, Robert j. Hughes. (2012). Personal finance.Tenth edition. McGraw-Hill/Irwin, New York: USA

- Худалдан авч байгаа хүнсний бүтээгдэхүүний тэжээллэг чанар болон эрүүл мэндэд үзүүлэх нөлөөг анхаарч үзэх
- Янз бүрийн үйлдвэрийн барааны баталгааг харьцуулах
- Бүтээгдэхүүний шалгалтын тайлантай танилцаж, ямар бүтээгдэхүүн чанартай, аюулгүй талаар мэдлэг олж авах
- Тусгай нөхцөл болон хөнгөлөлт эдэлж болох худалдан авалтын төлөвлөгөө боловсруулах
- Бараа худалдан авахад шаардагдах цаг хугацаа болон давуу талуудыг тооцох гэх мэт

12.2. Худалдан авалт хийх аргууд

Худалдан авалтын зөв шийдвэр гаргахын тулд ямар барааг хаанаас, хэзээ, ямар үнэ, нөхцөлөөр худалдан авах тухай асуудал нэн тэргүүнд тавигддаг. Учир нь ижил бараа бүтээгдэхүүн ч гэсэн худалдаалж байгаа дэлгүүр, цаг хугацаа зэргээс хамаарч өөр үнээр борлогддог. Иймээс хамгийн чанартай барааг хамгийн хямд үнээр, хамгийн тааламжтай нөхцөлөөр худалдан авахын тулд дараах хэд хэдэн энгийн аргуудыг (Зураг 12-2) хэрэглэх нь илүү үр дүнтэй. Үүнд:

Цаг хугацааг тооцох арга

Зарим бараа бүтээгдэхүүн жил бүр тодорхой цаг хугацаанд хямдардаг. Тухайлбал, өвлийн хувцсыг өвлийн ид дунд эсвэл өвөл дуусаж байхад худалдан авбал үнийг буулгаж чадна. Ихэнх ухаалаг хүмүүс зуны аялал, зугаалга, амралтын зүйлсийг нэг, арван хоёрдугаар сард худалдан авдаг байна.

Түүнчлэн олон улсын эдийн засгийн байдал, улс төрийн хямрал зэрэг нь үнэ өсөхөд нөлөөлөх хүчин зүйлсэд ордог. Иймээс дээрх нөхцөл байдал үүсэх нь тодорхой болсон үед үнэ өсөхөөс өмнө нэн тэргүүний шаардлагатай, хадгалалтын нарийн горим шаарддаггүй зүйлийг бөөнөөр худалдан авахад ашигтай.

Зураг 12-2. Худалдан авалт хийх аргууд



Үйлдвэрийн харьцуулалт хийх арга

Бараа, үйлчилгээг олон газар үйлдвэрлэж, хэрэглэгчдэд хүргэдэг. Хаана, ямар үйлдвэрт үйлдвэрлэснээс бүтээгдэхүүний чанар, үнэ шууд хамаарна. Үндэсний

үйлдвэрийн бараа, бүтээгдэхүүнийг аль ч дэлгүүрээс авах боломжтой бол дэлгүүрийн брэнд буюу хувийн шошготой барааг ихэвчлэн сүлжээ дэлгүүрээр борлуулдаг. Брэнд бараа өндөр үнэтэй боловч худалдан авах сонирхлыг төрүүлэхүйц сайн чанартай байх нь элбэг.

Шошгийн мэдээлэлтэй танилцах арга

Шошгон дээр бичсэн мэдээлэл хэрэглэгчдэд хэрэгтэй, чухал мэдээлэл өгдөг. Шошгон дээр:

- Үйлдвэрлэгч, борлуулагчийн нэр, хаяг
- Бүтээгдэхүүний нэр
- Бүтээгдэхүүний цэвэр жин
- Хадгалах хугацаа, горим
- Орц зэргийг заавал бичсэн байна

Иймээс чанартай бараа бүтээгдэхүүн худалдан авахыг хүсвэл шошгон дээрх мэдээллийг заавал уншиж, танилцах хэрэгтэй.

Үнийн харьцуулалт хийх арга

Нэгжийн үнэ: Янз бүрийн хэмжээгээр савласан бараа, бүтээгдэхүүний үнийг харьцуулах стандарт хэмжүүр.

Худалдан авалт хийх бүртээ нэгжийн үнэ нь хамгийн бага байх бараа, бүтээгдэхүүнийг сонгох нь ашигтай.

Үүний тулд:

1. Тухайн бараа, бүтээгдэхүүний хэмжих нэгжийг тодорхойлно (ширхэг, кг, литр, метр гэх мэт).
2. Нийт үнийг бараа, бүтээгдэхүүний нийт хэмжээнд хуваана.
3. Янз бүрийн савлагаатай, өөр өөр дэлгүүрт зарагдаж байгаа эсвэл өөр үйлдвэрийн хэдий ч ижил төрлийн бараа, бүтээгдэхүүний нэгжийн үнийг хооронд нь харьцуулсны үндсэн дээр сонголтоо хийх нь зүйтэй.

ЖИШЭЭ

Найман ширхэг нарийн боовыг нэг уутанд савлан 1600 төгрөгөөр худалдаж байгаа бол 1 ширхэгийн үнэ нь 200 төгрөг болно. Мөн ижил төрлийн нарийн боовыг 4 ширхэгээр савлан 1000 төгрөгөөр худалдаж байгаа бол нэг бүрийн үнэ нь 250 төгрөг болно. Иймээс 8 ширхэгээр савласан нарийн боовыг авбал илүү ашигтай.

Бараа, бүтээгдэхүүний үнийг хооронд нь харьцуулахад дараах зүйлсийг анхаарах. Үүнд:

- Илүү тохилог, тав тухтай дэлгүүрийн бараа бүтээгдэхүүн илүү өндөр үнэтэй байдаг.
- Шууд хэрэглэх, ашиглахад бэлэн бүтээгдэхүүн илүү өндөр үнэтэй.

- Үнэ хямдарсан бараа бүхэн мөнгө хэмнэх арга биш.
- Нэгж үнийн хувьд тооцвол их хэмжээгээр савласан бүтээгдэхүүний үнэ хямд байдаг.
- Хэт ихээр савласан хүнсний бүтээгдэхүүнийг хадгалалтын хугацаанаас өмнө хэрэглэж дуусгаагүйн улмаас чанар алдагдах, муудах зэрэг асуудал гарч болзошгүй.

Баталгаат бүтээгдэхүүн худалдан авах арга

Баталгаа: Бараа бүтээгдэхүүнийг буцаах, солих, засварлахтай холбоотой нөхцөлийг тодорхойлон үйлдвэрлэгч эсвэл борлуулагчаас бичиж өгдөг батламж

Ихэнх бараа, бүтээгдэхүүнийг баталгаа дагадаг. Баталгаанд заасан хугацаа, бараа, бүтээгдэхүүнийг буцаах, солих, засварлах нөхцөл зэргийг судалсны үндсэн дээр худалдан авалт хийх нь зүйтэй.

Тухайлбал, манайд саяхан нээгдсэн нэгэн дэлгүүрээс бараа авсан бол 3 хоногийн дотор бараагаа буцаах, 7 хоногийн дотор бараагаа солих, 3 хоногийн дотор хэрэглэгчийн санал гомдлыг шийдвэрлэх баталгаа олгож байна.

Сайн чанарын бүтээгдэхүүний баталгаат хугацаа урт байхаас гадна бусад нөхцөл нь ч харьцангуй сайн байдаг. Ихэвчлэн цахилгаан бараа, тоног төхөөрөмж, техник хэрэгсэл, авто машин зэрэг үйлдвэрийн ажиллагаанаас шалтгаалсан гэмтэл ашиглалтын явцад илэрч болох бараанд баталгаа олгодог.

Баталгаа нь бүрэн болон хязгаарлалттай баталгаа гэсэн хоёр хэлбэртэй байдаг.

Бүрэн баталгаа: Заасан хугацааны туршид гэмтэлтэй барааг бүхэлд нь засварлах эсвэл сольж өгөх нөхцөлийг заасан баталгаа.

Хязгаарлалттай баталгаа: Барааг тээвэрлэх болон засварлах зардлын зарим хэсгийг худалдан авагч төлөх, эсвэл бараа бүтээгдэхүүний зөвхөн зарим нэг хэсэгт хамаарах нөхцөлтэй баталгаа.

Бичгэн баталгаанаас гадна бүх бараа бүтээгдэхүүнд борлуулах эрх, зориулалтын дагуу ашиглах боломжтой байх зэрэг хуулийн шаардлагад нийцсэн баталгаа байдаг.

Дэлгүүрийн сонголт хийх арга

Орчин үед өрсөлдөөн болон технологийн дэвшлийн дүнд цахим худалдаа бий болж, супермаркет зэрэг худалдаа эрхэлдэг олон байгууллага үүсч, үйл ажиллагаа явуулж байна. Ийнхүү олон дэлгүүр байх нь хэрэглэгчдэд таатай орчинд хямд үнээр бараа, үйлчилгээгээ худалдан авах боломжийг олгохын зэрэгцээ илүү сайн сонголт хийх шаардлагыг бий болгож байгаа юм (Хүснэгт 12-1-ийг харна уу). Иймээс хаанаас бараа бүтээгдэхүүнээ худалдан авахаа зөв тодорхойлох нь барааны чанар, нэр төрөл, тоо хэмжээнд шууд нөлөөлнө гэдгийг анхаарах нь зүйтэй.

Хүснэгт 12-1. Дэлгүүрийн төрөл

Төрөл	Давуу тал	Сул тал
Их дэлгүүр	Тохиромжтой байрлалтай, үйлчилгээний цаг урт, түргэн шуурхай үйлчилгээ бүхий тасгаар төрөлжсөн, олон төрлийн бүтээгдэхүүнтэй.	Ажилтнуудын мэргэжлийн боловсрол, мэдлэг жигд сайн биш, бараа, бүтээгдэхүүний үнэ нь бусад төрлийн дэлгүүртэй харьцуулахад харьцангуй өндөр.
Тусгай дэлгүүр	Тусгай төрлийн барааны өргөн дэлгэр сонголттой, өндөр боловсролтой ажилтнуудтай.	Өндөр үнэтэй, байрлал болон цагийн хуваарь тохиромжгүй.
Үнэ хямдарсан барааны дэлгүүр	Барааны үнэ хямд.	Барааны чанар муу, сонголт багатай, дагалдах үйлчилгээ хангалтгүй.
Бараа сурталчилах өрөө	Үйлдвэрийн нэрийн бараа, хямдарсан үнэтэй.	Хүргэлтийн болон угсарч суурилуулах үйлчилгээ үзүүлдэггүй.
Үйлдвэрийн нэрийн барааны дэлгүүр	Үйлдвэрийн нэрийн бараа, бага үнэтэй.	Хуучирсан болон доголдолтой барааг борлуулах талтай.
Төрөл бүрийн барааны дэлгүүр	Барааны өргөн сонголттой.	Худалдагч нь мэргэжлийн болон зөвлөх үйлчилгээ үзүүлдэггүй.
Бөөний худалдааны дэлгүүр	Их хэмжээний барааг бөөний үнээр худалддаг.	Жижиглэнгийн худалдаа хийдэггүй, ихэвчлэн байрлал муутай.
Дэлгүүрийн биш худалдаа (Хоршоо)	Ашгийн төлөө бус, гишүүд нь удирдаж, эзэмшдэг, хямд үнэтэй.	Барааны нэр төрөл цөөн, харилцагч багатай.
Шууд худалдаа / цахимаар, зурагтаар сурталчилан борлуулах (TV shop)/	Цаг хугацаа төдийгүй мөнгө хэмнэдэг.	Барааг буцаах хэцүү, худалдан авахаас өмнө барааны чанарыг мэдэх боломж бага, хүргэлт удаан.

Түүнчлэн сонголт хийхийн тулд дэлгүүрийн санал болгож байгаа нэмэлт үйлчилгээг анхаарч үзэх шаардлагатай. Тухайлбал, зарим дэлгүүр картын болон валют солих үйлчилгээ, машины үнэгүй зогсоол, үнэгүй хүргэлт, утас, цахим шуудангаар захиалга авах үйлчилгээ, бүтээгдэхүүний талаар зөвлөгөө өгөх зэрэг нэмэлт үйлчилгээг санал болгодог. Мөн дэлгүүрийн цагийн хуваарь, байрлал, нэр хүнд, үйлчилгээний соёл зэрэг нь дэлгүүрийн сонголтод нөлөөлөх хүчин зүйлсэд хамаарна.

12.3. Хэрэглэгчийн эрх ашгийн хамгаалалт

Худалдан авагч бүхэн хийсэн худалдан авалт бүртээ сэтгэл хангалуун байж чаддаггүй. Хэрэглэгчид ямар нэг байдлаар үйлдвэрлэгч, борлуулагчдын бүтээгдэхүүн, үйлчилгээний талаар санал, гомдол гаргаж байдаг. Эдгээр санал гомдол нь ихэвчлэн дараах бүтээгдэхүүн, үйлчилгээтэй холбоотой гардаг. Үүнд:

- Тээврийн хэрэгслийн худалдан авалт, засварын баталгаа
- Цахим худалдан авалт
- Телемаркетингийн худалдаа
- Гэр ахуйн цахилгаан хэрэгсэл, компьютер
- Эрүүл мэндийн клуб, хоолны дэглэм барих хөтөлбөр
- Хуурай хими цэвэрлэгээ, угаалгын үйлчилгээ
- Аялал, жуулчлалын үйлчилгээ гэх мэт

Ихэнх хэрэглэгчдийн гаргадаг санал гомдол нь бараа бүтээгдэхүүний чанар, үйлчилгээний хангалтгүй байдал, тохиромжгүй үнэ, гэмтэлтэй бараа зэргээс үүсдэг. Худалдагч болон худалдан авагчийн хоорондох энэ маргаантай асуудлыг үе шаттай арга хэмжээ авч, шийдвэрлэх боломжтой.

Зураг 12-3. Хэрэглэгчийн санал гомдлыг шийдвэрлэх үе шат



Тайлбар: *Хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг

Бараа үйлчилгээтэй холбоотой санал, гомдлын дийлэнх хувийг худалдан борлуулсан газар нь шийдвэрлэдэг байна. Тэд барааг сольж өгөх, буцаах зэргээр худалдан авагч, хэрэглэгчдийн гомдлыг барагдуулдаг. Хэрэв худалдан авалт хийсэн газарт асуудал шийдвэрлэгдэх боломжгүй бол том сүлжээ дэлгүүр, компанийн удирдлагад хандах нь зүйтэй.

ШИГТГЭЭ

АНУ-ын худалдаа, үйлчилгээний байгууллагууд “Хэрэглэгчийн гарын авлага” гарган, түүндээ хэрэглэгчдийн санал гомдлыг хүлээн авах цахим шуудангийн хаяг болон хариуцах ажилтны утасны дугаар зэргийг оруулдаг байна.

Манай улсын хувьд худалдан авагч, хэрэглэгчдийн гаргасан санал, гомдлыг худалдаа, үйлчилгээний байгууллагууд цаг тухайд нь шийдвэрлэж чадахгүй тохиолдолд хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах, үүсэн бий болох хохирлоос хамгаалах зорилготой төрийн болон төрийн бус байгууллага үйл ажиллагаа явуулж байна. Тухайлбал, “Шударга өрсөлдөөн, хэрэглэгчийн төлөө газар”, “Мэргэжлийн хяналтын газар” зэрэг төрийн байгууллагаас гадна “Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах нийгэмлэг” зэрэг төрийн бус байгууллага ажилладаг. Хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах эдгээр байгууллагад санал, гомдлоо амаар болон бичгээр гаргаж болно. Хэрэв хэрэглэгч гомдлоо амаар гаргаж байгаа бол тухайн байгууллагын ажилтан гомдлыг хүлээн авч, тэмдэглээд хэрэглэгчээр гарын үсэг зуруулж, баталгаажуулах үүрэгтэй. Хуульд зааснаар хэрэглэгчийн санал, гомдлыг хүлээн авсан аливаа байгууллага хүлээн авснаас хойш 30 хоногт багтааж шийдвэрлэх ёстой.

“Хэрэглэгчийн эдлэх үндсэн найман эрх”-ийг 1985 онд НҮБ-ын чуулганаар баталж, тунхагласан байдаг. Эдүгээ дэлхийн бүх орон хэрэглэгчдийн эрх ашгийг хамгаалах үүднээс энэхүү тунхагийг үйл ажиллагаандаа мөрдлөг болгож байна. Хүснэгт 12-2-ын харна уу.

Манай улсад 2003 оноос батлан, мөрдүүлж байна. Энэ хуулийн зорилго бол бараа, бүтээгдэхүүн худалдах, худалдан авах, ажил гүйцэтгэх болон үйлчилгээ үзүүлэх явцад хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалахтай холбогдсон харилцааг зохицуулах⁶⁵ юм. Мөн 2005 оны 10 дугаар сарын 14-нд “Монгол Улсын Засгийн газрын албан даалгавар”-ыг батлан гаргасан. Үүнд: Олон улсын хэрэглэгчдийн эрхийг хамгаалах өдөр болох жил бүрийн 3 дугаар сарын 15-ны өдрийг “Хэрэглэгчийн эрхийг дээдлэх, эрхийг эдлүүлэх өдөр” болгосонтой холбоотой төрийн захиргааны болон төрийн бус байгууллагуудын хамтран зохион байгуулах ажлыг уламжлал болгон хэвшүүлэх тухай⁶⁶ заасан байна.

⁶⁵ Монгол Улсын хууль, (2003). Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай, 1.1-р зүйл

⁶⁶ Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 09 дүгээр тогтоол.

Хүснэгт 12-2. Хэрэглэгчийн эдлэх үндсэн найман эрх

№	Эрх	Агуулга
1	Аюулгүй аж төрөх эрх	Хүний амь нас, эрүүл мэндэд хор аюул учруулах бүтээгдэхүүн, үйлдвэрлэл, үйлчилгээнээс хамгаалагдсан байх
2	Мэдээлэл олж авах эрх	Сонголт хийхэд шаардлагатай мэдээллийг олж авах, хуурамч хаяг, шошго, зар сурталчилгааны төөрөгдлөөс сэрэмжлүүлэгдсэн байх
3	Сонголт хийх эрх	Сэтгэлд хүрэхүйц баталгаат чанартай, өрсөлдөхүйц үнэтэй олон төрлийн бараа бүтээгдэхүүн, үйлчилгээнээс сонголт хийх
4	Үгээ хэлж сонордуулах эрх	Засгийн газрын бодлого боловсруулах, үр дүн гүйцэтгэлийг тайлагнах, бараа бүтээгдэхүүнийг дээшлүүлэх, ажил үйлчилгээг сайжруулахад хэрэглэгчдийн ашиг сонирхлын төлөөлөл орж байх
5	Үндсэн хэрэглээндээ сэтгэл ханамжтай байх эрх	Зайлшгүй хэрэгцээтэй эд юмс, үйлчилгээ болон шаардлага хангахуйц хоол хүнс, хувцас хунар, орон байр нь ариун цэвэр, эрүүл ахуйн үндсэн нөхцөл, шаардлага хангасан байх
6	Учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрх	Шаардлага хангаагүй үйлчилгээ, чанаргүй бараа бүтээгдэхүүн, буруу ташаа мэдээллийн улмаас учирсан хохирлыг барагдуулах нөхөн төлбөр авах
7	Хэрэглэгчийн ухамсартай шийдвэр гаргах эрх	Хэрэглэгч бараа, үйлчилгээний сонголт хийхэд шаардлагатай үндсэн эрх, үүрэг хариуцлагыг ухамсарлах, энэ талаар үйл ажиллагаа явуулахад өөртөө бүрэн итгэлтэй байх мэдлэг, мэдээлэл, дадлага, чадварыг олж авсан байх
8	Эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх	Одоо болон ирээдүй үеийнхэн эрүүл, аюулгүй, сайн сайхан орчинд ажиллаж, амьдрах

12.4. Орон сууц, тээврийн хэрэгсэл худалдан авахад анхаарах зүйлс

Орон сууц худалдан авахад анхаарах зүйлс

Амьдран суух орон байраа сонгох, түүнийг худалдах, худалдан авах тухай асуудал бол хувь хүн амьдралдаа маш цөөхөн удаа гаргадаг чухал хариуцлагатай шийдвэрийн нэг билээ. Иймээс сэтгэлд хүрсэн зөв сонголтоо хийж, аливаа эрсдэлээс зайлсхийхэд шаардлагатай мэдлэг эзэмшиж, түүндээ тулгуурлан орон байрны төлөвлөлт хийх нь зүйтэй.

Хувь хүмүүс цаг зав, хөрөнгө мөнгөө маш олон хэлбэрээр зарцуулдагтай адил амьдралын хэв маяг ч өөр өөр байдаг бөгөөд энэ нь хэрэглэгчийн худалдан авах

сонголтоор дамжин илэрч байдаг. Иймээс тухайн хүний хэрэгцээ, хүсэл сонирхол, хандлага зайлшгүй орон байрны сонголтод нөлөөлдөг.

Орон байрны сонголт хийхэд нөлөөлдөг амьдралын хэв маягийн хүчин зүйлсэд зэрэг зиндаа, хувийн үзэл бодол, хүрээлэн буй орчин зэрэг багтана. Амьдран суух орон сууц худалдан авах сонголт хийхдээ дараах зүйлийг анхаарч үзэх хэрэгтэй. Үүнд:

- **Байрлал** (ажил, сургууль, хүүхдийн цэцэрлэгт ойр эсэх, агаарын бохирдол, замын түгжрэл, худалдаа үйлчилгээний хангамж, автобусны буудал хүрэх зай гэх мэт)
- **Амьдрах орчин** (цонхоор үзэгдэх орчин, тээврийн хэрэгсэл орж гарах зай, ойр орчимд байрлах байгууллага, байгалийн гамшигт өртөх магадлал болон орчны тохижилт)
- **Барилгын чанар** (бүрэн цутгамал эсвэл блокон дүүргэлт)
- **Үнэ** (байрлал, барилгын чанар, дотоод засал үнэд нөлөөлнө)
- **Байрны үйлчилгээ** (харуул хамгаалалт, хашаа, орцны жижүүр, лифтний үйлчилгээ, хогийн цэг)
- **Бусад** (цонхны байрлал, дээд давхар бол дээврээс ус гоождог эсэх, тагттай эсэх гэх мэт)

Нийтийн болон хувийн эзэмшлийн орон сууц худалдан авах нь өмчтэй болох, сэтгэл ханамж авах, санхүүгийн хөнгөлөлт эдлэх, амьдралын тав тухтай орчин бүрдэх зэрэг ач холбогдолтой. Өөрийн гэсэн өмч хөрөнгөтэй болох нь хувь хүнд сэтгэлийн асар их ханамжийг өгдөг. Түүнчлэн байнга оршин суух хаягтай болох нь нийгмийн харилцаа, санхүүгийн байдалд эергээр нөлөөлдөг. Тухайлбал,

- Манай улсад анх удаа орон сууц худалдан авсан иргэдийн тухайн орон сууцыг худалдан авахад зарцуулсан 30 сая хүртэлх орлогыг татвараас чөлөөлж байгаа нь санхүүгийн хөнгөлөлтийн нэг хэлбэр юм.
- Мөн орон сууцны зориулалтаар ашиглаж байгаа үл хөдлөх хөрөнгийг албан татвараас чөлөөлдөг.
- Орон сууцаа барьцаалан зээл авч болно.
- Үл хөдлөх хөрөнгийн үнэ байнга өсч байдаг.
- Өөрийн сонирхолд нийцүүлэн засаж, өөрчлөх боломжтой.
- Түрээсийн байрнаас илүү эрх чөлөөтэй байна.
- Амьдралын тохь тух хангагдана.

Орон сууц худалдан авснаар зарим асуудал тулгардаг. Үүнд:

1. **Санхүүгийн тодорхойгүй байдал:** Хэрэв зээл авч орон сууц худалдан авсан бол зээлийн төлбөрийг төлөх явцад хувийн санхүүгийн боломж болон эдийн засгийн нөхцөл байдал өөрчлөгдсөнөөс шалтгаалж, санхүүгийн хүндрэлтэй асуудал тулгарч болзошгүй. Тухайлбал, ажлаас гэнэт халагдсан тохиолдолд сар бүрийн зээлийн төлбөрөө төлж чадахгүйд хүрнэ.

2. **Шилжин суурьшихад учрах бэрхшээл:** Хэрэв өөр газар шилжин, суурьших хэрэгцээ гарвал хувийн орон сууцаа зарах эсвэл түрээслүүлэх шаардлагатай болно. Энэ тохиолдолд орон сууцны үнийн уналт, эрэлт хэрэгцээнээс хамаарч санхүүгийн алдагдал хүлээж болзошгүй.
3. **Амьжиргааны өртөг өндөр:** Өндөр зэрэглэлийн, тансаг орон сууцанд амьдрахтай холбоотой байрны засвар, үйлчилгээ, харуул хамгаалалт, орчны тохижилт зэрэгт чамгүй их мөнгө зарцуулах шаардлага гарна.

Тээврийн хэрэгсэл худалдан авахад анхаарах зүйлс

Хоол хүнс, орон байртай адил тээврийн хэрэгслийн зардал хэрэглээний зардлын нэг гол хэсэг болдог. Өдөр тутам сургууль, ажилдаа ирж очих зэргээр хаа нэг тийшээ явах зайлшгүй шаардлага гарч байдаг. Энэ хэрэгцээгээ хангахын тулд тээврийн хэрэгслийн сонголт хийх хэрэгтэй. Тээврийн хэрэгслийн сонголтод хувийн, нийгмийн, эдийн засгийн гэх мэт олон хүчин зүйлс нөлөөлдөг. Үүнд:

1. **Хувийн болон нийгмийн хүчин зүйл:** Ажлын нөхцөл, ая тух, нийтийн тээврийн хэрэгслийн боломж зэрэг;
2. **Эдийн засгийн хүчин зүйл:** Орлого, өрхийн төсөв, хуримтлалын хэмжээ, мөрдөгдөж байгаа татварын хууль хүүний түвшин зэрэг;
3. **Хувийн хүчин зүйл:** Амьдралын хэв маяг, хувь хүний хэрэгцээ, сонирхол, шашин шүтлэг, нас, хүйс гэх мэт хүчин зүйлс голлон нөлөө үзүүлдэг.

Эдгээрээс гадна гэнэтийн хүчин зүйлс мөн нөлөөлдөг. Хэрэв бизнесийн болон хувийн имижээ бүрдүүлэх гэж байгаа бол автомашины тансаг байдал, гадаад үзэмж, хэлбэр хүртэл тээврийн хэрэгслийн сонголтод нөлөөлнө. Хэрэв тухайн хүн амьдралын хамгийн энгийн хэв маягийг эрхэмлэдэг бол тээврийн хэрэгслийн сонголт нь унадаг дугуй байж болох юм. Унадаг дугуй нь өртөг зардал бага, эрүүл мэндэд ашиг тустай зэрэг давуу талуудтай. Өнөөгийн байдлаар дэлхийн 500 сая гаруй хүн унадаг дугуйг сонгон хэрэглэж байна.

Бусад санхүүгийн шийдвэр гаргалтын нэг адил тээврийн хэрэгслийн сонголтөө зөв хийх нь хувийн болон санхүүгийн боломжоо нэмэгдүүлэх арга зам болно. Нийтийн тээврийн хэрэгслээр үйлчлүүлэх эсвэл хувьдаа автомашин худалдан авах эсэх сонголт хийхэд дараах зүйлс нөлөөлнө. Үүнд:

- Нийтийн тээврийн хэрэгслийн цагийн хуваарь;
- Хувьдаа автомашин худалдаж авахгүйгээр нийтийн тээврийн хэрэгслээр зорчиход хэмнэх мөнгөний хэмжээ;
- Автомашин худалдан авах санхүүгийн боломж (тээврийн хэрэгсэл худалдан авахад зарцуулах урьдчилгаа төлбөрийн хэмжээ);
- Янз бүрийн хэлбэр, загвар бүхий тээврийн хэрэгслийн үйл ажиллагааны зардал (шатахуун зарцуулалтын хэмжээ, даатгал, элэгдэл гэх мэт). Шинэ тээврийн хэрэгсэл нь өндөр даатгал, их хэмжээний элэгдлийн зардалтай байдаг бол хуучин машины хувьд засварын зардал өндөр байдаг.

Хувийн санхүүгийн боломж, авто машин эзэмшихтэй холбоотой гарах зардал, засвар үйлчилгээ, машины зогсоолын хүрэлцээгүй байдал, замын түгжрэл зэргээс хамаарч олон хүн нийтийн тээврийн хэрэгслийг сонгодог.

Нийтийн тээвэр: *Олон хүнийг нэгэн зэрэг, хурдан тээвэрлэхэд зориулсан автобус, галт тэрэг гэх мэт тээврийн хэрэгсэл.*

Нийтийн тээврийн хэрэгслийн эрэлт хэрэгцээ өсч байгаатай холбоотой Засгийн газраас үйлчилгээг сайжруулах, өргөтгөх арга хэмжээ байнга авч байдаг.

Машин худалдан авах шийдвэр гаргах үйл явц нь санхүүжилт, автомашины хэмжээ, загвар зэргийг сонгохоос эхэлнэ. Гэхдээ тээврийн хэрэгслийн сонголтонд хамгийн чухал нь санхүүгийн чадвар байдаг. Автомашин худалдан авах шийдвэр нэгэнт гарсны дараа санхүүгийн боломжоос хамаарч шинэ эсвэл хуучин автомашин худалдан авах сонголт хийнэ. Хуучин автомашин худалдан авах нь шинэ машинтай харьцуулахад өртөг, зардал багатай, бага мөнгө зарцуулна. Харин шинэ автомашин худалдан авахад санхүүгийн эх үүсвэр, эдийн засгийн боломж сайтай байх хэрэгтэй.

Хэрэв хуучин автомашин худалдан авах сонголт хийсэн бол дараах зүйлсийг мэдэж байх хэрэгтэй. Үүнд:

1. Хуучин машиныг хуучин, шинэ ямар ч төрлийн машин борлуулагчдаас худалдан авч болно. Шинэ машин борлуулагчид хуучин машин зарах тохиолдолд илүү сайн баталгаа, машины засвар үйлчилгээтэй холбоотой нэмэлт үйлчилгээ үзүүлдэг.
2. Хуучин автомашин борлуулагчид энэ тал дээр мэргэшсэн хүмүүс байх бөгөөд худалдаж байгаа машин нь ихэвчлэн хуучин загварынх байдаг. Мөн тэдний өгсөн баталгаа нь тодорхой хязгаарлалттай байх хандлагатай. Гэвч хуучин автомашины үнэ ямагт шинэ автомашины үнээс бага байдгаараа давуу талтай.
3. Машин борлуулагчдаас гадна өөрийн хэрэглэж байсан авто машинаа худалдах сонирхолтой хувь хүнээс ч худалдан авч болно. Хэрэв тухайн авто машин сайн засварлагдсан, гамтай эдэлсэн бол энэ нь ашигтай хэлэлцээр ч байж болох юм. Нөгөө талаар, маш эрсдэлтэй наймаа ч болох тохиолдол гардаг.
4. Хуучин автомашин худалдан авч болох бусад эх үүсвэрт Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, бизнесийн байгууллага, автомашин түрээсийн газруудад ашиглагдаж байсан хуучин автомашинууд орно. Засгийн газар болон түрээсийн байгууллагад ашиглагдаж байсан автомашинууд байнга засвар үйлчилгээ хийгдэж байсан боловч олон жолооч дамжуулан жолооддог, хэт их ачаалалтай байсан зэрэг дутагдалтай байна.
5. Тухайн загварын автомашиныг дагнан засварладаг засварын газар байгаа эсэх болон сэлбэгийн олдоц хэр байдгийг судлах хэрэгтэй. Манай улсад ихэвчлэн Япон, Солонгос, Хонконг зэрэг улсаас орж ирсэн автомашиныг худалддаг. Эдгээрийн сэлбэгийн олдоц сайн, шатахуун зарцуулалт харьцангуй бага зэрэг давуу талтай байдаг. Солонгосын автомашин Монголын замын нөхцөлд тохиромжгүй,

эвдэрч, дуу орохдоо амархан байдаг. Цөөн тохиолдолд Европын орнуудаас орж ирсэн авто машинуудыг худалддаг. Америкаас орж ирсэн автомашинууд шатахуун зарцуулалт ихтэй байна.

Шинэ машин худалдан авах шийдвэрт юуны өмнө үнийн асуудал чухал нөлөөтэй тул үнийн мэдээлэлтэй сайн танилцах хэрэгтэй.

Шошгоны үнэ: Цаасан дээр хэвлэж, авто машины цонхон дээр наасан, авто машины үнэ.

Энэ нь авто машин, түүнийг дагалдах хэрэгслүүдийн жижиглэн худалдаалах үнийг харуулдаг.

Автомашиныг худалдах буюу нэхэмжлэлийн үнэ нь шошгоны үнээс ямагт бага байх бөгөөд хоёр тал хэлэлцэн тохиролцсоны үндсэн дээр үнээ тогтоодог. Шошгоны үнэд суурилсан худалдах үнэ нь автомашины хэмжээ, загвараас хамаарч өөр өөр байна. Автомашин худалдан авахад анхаарч үзэх зүйлсийг үндсэн 3 бүлэгт хуваана. Үүнд:

1. Үйл ажиллагааг хангадаг механик тоног төхөөрөмжүүд (моторын эзлэхүүн, машины дамжуулах эд анги, хүчний дамжуулагч, тоормос болон хянах самбар гэх мэт)
2. Суудлын налуу, агааржуулагч, хөгжим, гэрэл бууруулагч хальс, машины удирдлага гэх мэт тав тухыг хангагч зүйлс
3. Машины үзэмж (тухайлбал, металл будаг, чимэглэл, суудлын бүрээс гэх мэт)

Автомашин худалдан авахад анхаарах бас нэг чухал зүйл бол өнгө. Учир нь автомашины өнгө аюулгүй байдалд нөлөөлдөг гэж үздэг. Жишээ нь: хөдөө нуга тал, цасан дээр улбар шар, саарал, цэнхэр өнгийн машинууд илүү тод харагддаг бол хүрэн, ногоон, хар саарал, хар хөх, хар машинууд ялгарч харагддаггүй байна.

Сэлвийн дүгнэлт

Худалдан авалтын хувьд оновчтой төлөвлөлт хийх нь хувийн хэрэгцээгээ хангах, санхүүгийн зорилгодоо хүрэх арга замын нэг болно. Иймээс худалдан авалтын төлөвлөлтөд баримтлах гол зарчим нь орлогоос давсан зардал гаргахгүй байх, гэнэтийн төлөвлөгөөгүй худалдан авалт хийхээс аль болох зайлсхийх явдал юм. Худалдан авалтын буруу шийдвэр санхүүгийн хүндрэлд орох нөхцөлийг бүрдүүлдэг.

Худалдан авалтын оновчтой зөв шийдвэр гаргах, санхүүгийн нөхцөл байдалд тохирсон худалдан авалт хийхийн тулд ямар үйлдвэрийн бараа, үйлчилгээг хэзээ, хаанаас, ямар хөнгөлөлттэй нөхцөлөөр, ямар үнээр, ямар баталгаатай худалдан авах вэ? гэдгийг сайн судалж, мэдсэн байх шаардлагатай. Ухаалаг худалдан авагч юуг, хэзээ, хаанаас худалдан авахаа мэддэг.

Худалдаа, үйлчилгээний салбарт хэрэглэгч бол хаан гэсэн зарчим үйлчилдэг ч зарим тохиолдолд гэмтэлтэй бараа өгөх, бүтээгдэхүүн, үйлчилгээний чанар муу байх зэрэг хэрэглэгчийн эрх ашгийг хохироосон үйлдэл гарсаар л байна. Ийм тохиолдолд худалдан авалт хийсэн газраа буцаж очих, тухайн байгууллагын удирдлагад хандах, хэрэглэгчийн эрх ашгийг хамгаалах байгууллагад хандах, асуудлыг шүүхээр шийдвэрлүүлэх гэсэн шат дараатай арга хэмжээ авч, эрх ашгаа хамгаалах боломжтой.

Амьдран суух орон байрны сонголт хийх нь хүмүүсийн амьдралдаа хийх хамгийн чухал, хариуцлагатай сонголтын нэг байдаг. Иймээс шийдвэр гаргахаасаа өмнө сайн судалгаа, тооцоолол хийх хэрэгтэй. Худалдан авах орон сууц нь санхүүгийн боломжид тулгуурлахаас гадна амьдралын хэв маяг, тав тухыг хангасан байх шаардлагатай. Орон сууц худалдан авахдаа үнэ, байршил, гадаад орчин, харуул хамгаалалт, чанар зэрэг олон хүчин зүйлсийг харгалзах нь зүйтэй.

Тээврийн хэрэгслийн сонголтод нийгмийн, хувийн, эдийн засгийн олон хүчин зүйлс нөлөөлдөг. Хэн хэрэглэх, ямар зориулалтаар ашиглах, санхүүгийн боломж зэргээс хамаарч ямар төрөл, загварын автомашин худалдан авахаа сонгоно. Авто машин худалдан авахдаа машины гадна, дотор тал, эд ангиудын чанар, үзэмжийг сайн шалгах хэрэгтэй. Ялангуяа, хуучин машин худалдан авч байгаа тохиолдолд түүний эдэлгээ, чанар, сэлбэгийн олдоц зэргийг нарийн судлах шаардлагатай болно. Энэ нь эвдэрхий, засвар үйлчилгээ хийх боломжгүй автомашин худалдан авахаас сэргийлнэ.

Бататгах асуултууд:

1. Худалдан авалт хийх ямар аргууд байдаг вэ?
2. Баталгааны ямар хэлбэрүүд байдаг вэ?
3. Бараа, бүтээгдэхүүний нэгжийн үнийг яаж тооцох вэ?
4. Шошгон дээрх мэдээлэл ямар ач холбогдолтой вэ?
5. Орон сууц худалдан авахдаа ямар зүйлсийг анхаарах шаардлагатай байдаг вэ?
6. Тээврийн хэрэгслийн сонголтод нөлөөлдөг хүчин зүйлсийн талаар дэлгэрүүлэн тайлбарлана уу.
7. Хэрэглэгчийн эрх ашиг зөрчигдсөн тохиолдолд хэнд хандах вэ?
8. Хэрэглэгчийн эдлэх ямар үндсэн эрхүүд байдаг вэ?

СЭДЭВ 13. ХУВЬ ХҮНИЙ ЭРСДЭЛИЙН УДИРДЛАГА

Сэдвийг судлахын ач холбогдол, үр дүн

Энэ сэдвийг судалснаар хувь хүнд тохиолддог эрсдэл, түүнийг хэрхэн удирдах талаар онолын мэдлэгтэй болж, хувь хүн эрсдэлээс урьдчилан сэргийлэх болон эрсдэлийн удирдлагын аргуудыг нөхцөл байдалдаа тохируулан ашиглах чадварыг эзэмшинэ.

Тулгуур ойлголт

- Эрсдэл
- Хувийн эрсдэл
- Хариуцлагын эрсдэл
- Санхүүгийн эрсдэл
- Эд хөрөнгийн эрсдэл
- Хувь хүний эрсдэлийн удирдлага

13.1. Эрсдэлийн тухай ойлголт

Германы тэрбумтан Бодо Шефер хэлэхдээ: “... Амьдрал гэдэг үргэлж уянгалаг, гэгээн нотоор бичигдсэн симфони биш шүү дээ! Энд бараан, гүн хар нүргээн ч тохиолдоно. Хэн өөрийн үнэ цэнийг ухамсарлана, тэр бэрхшээлээс айх шаардлагагүй...” гэж хэлсэн байдаг. Үнэхээр амьдрал бол тэмцэл. Амьдралд сайн, муу, сайхан, муухай зүйл байнга тохиолддог. Эрсдэлгүй амьдрал гэж огт байдаггүй. Баян ч бай, ядуу ч бай хүн болгонд өөр өөрийн гэсэн эрсдэл, тулгамдсан асуудлууд байдаг. Мөнгөтэй, хөрөнгө чинээтэй хүнийг хараад хүмүүс энэ хүнд мөнгө, ер нь бүх юм байна юунд зовох вэ? гэж боддог. Гэтэл тэр чинээлэг хүнд ч эрсдэл учирч болно. Мөнгөөр бүх асуудлыг шийдэж болохгүй.

Хүн сайхан мөрөөдөлтэй амьдрах хэрэгтэй. Мөрөөдөл бол таныг одоо, ирээдүйд аз жаргалтай болгох чухал зүйлийн нэгэн. Та өөрийн мөрөөдөл дээрээ үндэслэж амьдралын зорилгоо тодорхойлно. Хүн болгонд өөрийн гэсэн амьдралын зорилго байх хэрэгтэй. Амьдралын зорилго агуу байж хэмээн ирээдүйд өндөр амжилтанд хүрнэ. Өмнөө тавьсан зорилго өчүүхэн байвал та зорьсондоо хүрч чадахгүй гэдгийг санаж яваарай.

Та өнөөдөр цэргийн сургуулийн сонсогч гэвэл генерал болохыг мөрөөд, та өнөөдөр биеийн тамирын сургуулийн оюутан бол тив, дэлхий, олимпийн аварга болохыг мөрөөд. Та бүхэнтэй тохой зэрэгцээд ирээдүйн ерөнхийлөгч, ерөнхий сайд, дэлхийн хэмжээний мэргэжилтэн, генерал, тив, дэлхий, олимпийн аваргууд хамтдаа нэгэн ангид сурч байна гээд бод.

ШИГТГЭЭ

CNN-г үндэслэгч Тед Тернерийг залуу байхад эцэг нь түүнд хандаж “... Чи өөртөө энэ насандаа хурч чадахааргүй тийм том зорилго тавь ...” гэж зөвлөжээ. Тэрээр эцгийнхээ хэлсэн үгийг амьдралынхаа үндсэн зарчим болгосон ба дэлхийд хамгийн том телевизийн сувгыг байгуулахаар санаа шулуудсан байна. Түүний энэхүү зорилгоо биелүүлэх замд маш олон бэрхшээл саад учирч байсан гэдэг. Хожим нь Тед Тернер: “...Надад миний зорилготой харьцуулахад үргэлж жижиг бэрхшээлүүд тохиолдож байсан учраас би ямар ч бэрхшээл дунд төөрөлгүй, зорилгоо хэзээ ч хараанаасаа салгадаггүй байсан...” гэж хэлжээ.

Бидний сайхан мөрөөдөлдөө хүрэх зам шулуун дардан байхгүй. Янз бүрийн бэрхшээл, саад тохиолдоно. Хүмүүс бид өнөөдөр, маргааш, нөгөөдөр ирээдүйд хэрхэх нь тодорхойгүй нөхцөл дунд ажиллаж амьдарч, сурч хөдөлмөрлөж байна.

Эрсдэл: Хохирол учирч болох магадлал.

Амьдралд эрсдэл хэмээх дагуул сүүдэр мэт дагаж явдгаас амьдрал сонирхолтой болсон ч байж магадгүй.

Амьдралд бидний хүсэл зоригоос үл шалтгаалан байгалийн болон гэнэтийн аюул осол тохиолдож, амьдрал болон бизнесийн хэвийн үйл ажиллагаа алдагдан их, бага хэмжээний хохирол хүлээх явдал гарах ба үүнийг эрсдэл гэдэг. Үүний заримаас дурдвал:

1. Өвдөх, эрүүл мэндээ алдах, архаг хууч өвчтэй болох, мэс засалд орох, халдварт өвчин, хорт хавдраар өвчлөх, ДОХ-ын халдвар авах, сэтгэцийн эмгэгтэй болох, мэргэжлээс шалтгаалах өвчин тусах, хөдөлмөрийн чадвараа хагас болон бүрэн алдах, нас барах, бэлэвсрэх, эх, нялхас эндэх, үр хөндүүлэх, зуурдаар насан өөд болох, тэжээгчээ алдах, хөгжлийн бэрхшээлтэй болох, хүнийг гомдоох, үг хэлээр доромжлох, эрүүл мэндийн хувьд ажилдаа тэнцэхгүй болох, цус ойртолт болох, хэт таргалалтанд өртөх, хөдөлгөөний дутагдалд орох, төрөлхийн болон олдмол хөгжлийн бэрхшээлтэй болох, хүн амын дундаж наслалт багасах, хөгшрөх, өндөр настнуудын авч буй тэтгэвэр нь амжиргааны наад захын хэрэгцээг хангахгүй байх, интернэт, гар утасны хэрэглээ өсөхийн хирээр хүмүүсийн хоорондын амьд харилцаа багасах;
2. Байгалийн гамшигт өртөх, гэнэтийн болон ахуйн, зам тээврийн, үйлдвэрлэлийн осолд орох, тээвэрлэлтийн эрсдэлд өртөх, мэргэжлийн хариуцлага алдах;
3. Хүний амьдралаар тоглох, гэр бүл цуцлах, сэтгэл зүйн эрсдэлд орох, ганцаардах, үр хүүхэдгүй байх, гэр бүлийн хүчирхийлэлд өртөх, бэлгийн дарамт хүчирхийлэлд өртөх, хүсээгүй жирэмслэлт, өрх толгойлсон эмэгтэйчүүдийн тоо өсөх;
4. Арга хэмжээ авхуулах, албан тушаал буурах, орон тооны цомхотголд орох, ажилгүй болох, цалин буурах, тухайн гэр бүл дотор ажилгүй хүний тоо өсөх;

5. Валютын ханш өсөх, хүн амын худалдан авах чадвар буурах, инфляци өсөх, хадгаламжийн хүү буурах, зээлийн хүү өсөх, татвар нэмэгдэх, зээлээ төлж чадахгүй болох, төлбөрийн чадваргүй болох, мөнгөн торгууль төлөх, өрсөлдөөнд ялагдах, санхүүгийн эрх чөлөөгүй болох, ажиллаж буй байгууллага нь дампуурах, харилцагчаа алдах, ашиг орлого олох боломжоо алдах, компанид оруулсан хувьцаанаас алдагдал хүлээх, хөрөнгөө оруулсан компани нь төлбөрийн чадваргүй болж дампуурах, олгосон зээл нь найдваргүй болох, эд хөрөнгөө алдах;
6. Ялгаварлан гадуурхагдах, ядууралд өртөх, гэмт хэрэг үйлдэх, шүүхээр ял шийтгүүлэх, хэлмэгдэх, хилсээр ял эдлэх, архи, тамхи, хар тамхинд донтох, хуулийн цоорхой заалт;
7. Сургуулиас хасагдах, боловсрол мэргэжил эзэмшиж чадахгүй, бичиг үсэг үл мэдэх, сургуулиас завсардах;
8. Мөнгө угаалт, албан тушаалаа урвуулан ашиглах, авилга, хээл хахууль авах, хар тамхи зөөвөрлөх, хууль бус наймаа эрхлэх, хуурамч мөнгөн тэмдэгт хэвлэх, хориотой бараа бүтээгдэхүүн худалдах, компьютерын программд нэвтрэх, залилан хийх, хууль бусаар хөрөнгө хил давуулах, зөвшөөрөлгүй ан агнах, барих, хил давуулан наймаалах, түүх соёлын дурсгалт зүйлийг хил давуулан наймаалах, гаднаас зөвшөөрөлгүй төрөл бүрийн химийн хорт бодисыг улсын хилээр оруулж ирэх, хуурамч диплом, зээлийн карт хуурамчаар үйлдэх, гадаадын иргэдийг хууль бусаар хил нэвтрүүлэх, хүн хулгайлах, барьцаалах, зэвсгийн наймаа, биеэ үнэлэх, татвараас зайлсхийх, хэт өндөр хүүтэй зээл олгох, хууль бус мөрийтэй тоглоом тоглох, хулгай, дээрэм тонуул хийх, хүн наймаалах, хүний эд эрхтэн наймаалах, хуурамч бараа үйлдвэрлэх, алан хядах үйл ажиллагааг санхүүжүүлэх, хорлон сүйтгэх үйл ажиллагаа хийх, хууль бус үйл ажиллагаанаас олсон гэж үзэж болох орлогыг тээвэрлэх, шилжүүлэх, хөрвүүлэх, хувиргах болон хуулийн дагуу олсон бусад хөрөнгө мөнгөтэй нийлүүлэх замаар эдгээр орлогын мөн чанар, эх үүсвэр зарцуулалт, шилжилт хөдөлгөөн өмчлөлийн талаарх мэдээллийг нуун далдлах төөрөгдүүлэх зэрэг гэмт хэрэгт холбогдох, гэмт хэргийн золиос болох;
9. Агаарын болон хөрсний бохирдол зэрэг экологийн эрсдэлд өртөх, автозамын бөглөрөлд орох;
10. Улс төрийн эрсдэл, үймээн самуун, дайн, шашин хоорондын мөргөлдөөн гарах, гэмт халдлага үйлдэх, худлаа ярих, элдэв цуу яриа тараах, амиа золиослох;
11. Гадаадад ажиллахаар яваад эргэж эх орондоо ирэхгүй байх, сураггүй алга болох гэх мэт маш олон зүйлийг дурдаж болно.

ТАНЫ МЭДЛЭГТ

1. 2015 оны байдлаар авч үзэхэд манай улсын нийт өрхийн дотор өрх толгойлсон эхийн эзлэх хувийн жин 9.1% байна.
2. Манай хүн амын дундаж наслалт жил ирэх тусам өсч байгаа ч дэлхийн бусад орнуудтай харьцуулахад бага байдаг. Хүйсийн хувьд авч үзэхэд, эрэгтэйчүүдийн дундаж наслалт эмэгтэйчүүдээс 9 жилээр бага байна.
3. Нийт нас баралтын дотор 0-1, 45-49, 50-54, 55-59, 70 ба түүнээс дээш насны хүн амын нас баралт өндөр хувийг эзэлж байна.
4. Гэр бүл цуцлалт өмнөх оноос 3.3 хувиар өссөн байна.
5. Нийт ажилгүй иргэдийн дотор эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 57.9 хувийг эзэлж байна.
6. Нас барсан хүний тоо 16`374 байгаагийн дотор зүрх судасны тогтолцооны өвчнөөр нас барагсад 34.1 хувь, хавдар өвчнөөр нас барагчид 24.6 хувийг эзэлж байна. Нийт зонхилох өвчнөөр нас барсан хүн амын дотор эрэгтэйчүүдийн эзлэх хувийн жин 60 хувь байна.
7. Улсын дунджаар 1000 амьд төрөлтөнд ногдох нялхсын эндэгдэл 15, эхийн эндэгдэл 21 байна.
8. 10`000 хүн амд ногдох хорт хавдраар шинээр өвчлөгчдийн дунд элэг, ходоодны хорт хавдраар өвчлөгчид, нас барагчид ихэнх хувийг эзэлж байна.
9. Үр хөндөлт улсын хэмжээгээр 18`168 тохиолдол байгаа нь өмнөх онтой харьцуулахад 0.12% өссөн байна.
10. Ойн түймэр давхардсан тоогоор нийтдээ 184 гарчээ.

Эх сурвалж: Монгол Улсын “Статистикийн эмхэтгэл 2015”

13.2. Эрсдэлийн төрлүүд

Дээр дурдсан бүх эрсдэлийг даатгах боломжгүй. Эдгээрээс бид цаашид зөвхөн даатгах боломжтой эрсдэлийн талаар авч үзэх болно. Даатгах боломжтой эрсдэлд дараах эрсдэлүүд орно. Үүнд:

1. **Байгалийн эрсдэл:** Ган зуд, цаг зуурын бэрхшээл, ширүүн шуурга, хэт хүйтрэлт, хүйтэн бороо, аянга, гал түймэр, газар хөдлөлт, хөрсний нуралт, усны үер гэх мэт
2. **Ахуйн чанартай гарах эрсдэл:** Юманд цохиулах, түлэгдэх, халтирч унах, бэртэх, гэмтэх, ахуйн хийд хордох
3. **Үйлдвэрлэл, техниктэй холбоо бүхий эрсдэл:** Машин тоног төхөөрөмж, багаж хэрэгсэлтэй харьцаж ажиллах үед гарах эрсдэлүүд, сантехникийн, цахилгаан эрчим хүчний хэлбэлзлийн, технологийн алдааны эрсдэл, хорт хийд хордох, үйлдвэрлэлийн осолд орох

4. **Мал, амьтдын нөлөөллөөр үүсэх эрсдэл:** Морь малаас унах, чирэгдэх, хазуулах, тийрүүлэх, өшиглүүлэх, мөргүүлэх, тэжээвэр болон араатан амьтанд бариулах, уруулах
5. **Тээврийн хэрэгсэлтэй харьцах үеийн эрсдэл:** Бүх төрлийн тээврийн хэрэгслээр зорчин явах үед гарсан эрсдэлүүд
6. **Ажил мэргэжлийн онцлогоос шалтгаалан гарах эрсдэл:** Тамирчин, жүжигчин, цэргийн албан хаагчид, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэгчид, гал сөнөөгчид, онцгой байдлын аврагчид, шүхэрчид, уурхайчид зэрэг мэргэжлийн хүмүүс нь бэлтгэл сургуулилалт, уралдаан тэмцээн, үзүүлэх тоглолтын үед гэнэтийн осолд орох, мөн ил, далд уурхайн цөмрөлт, нуралт, дэлбэрэлтэд өртөх, хорт хийд угаартах, хордох зэргээр амь нас, хөдөлмөрийн чадвараа алдах
7. **Мэргэжлийн хариуцлагаас шалтгаалж гарах эрсдэл:** Инженер хүн барилгыг зураг төслийн дагуу бариулаагүйгээс орон сууцны барилга нурах, эмч буруу онош тавих, эмийн сангийн ажилтан буруу эм олгох, худалдааны байгууллага дээр хадгалалтын горим алдагдсанаас бүтээгдэхүүн муудах гэх мэт
8. **Хүн, мал амьтдын төрөл бүрийн өвчний эрсдэл:** Хүнд тусдаг ердийн болон халдварт өвчнүүд, малаас хүнд, малаас малд дамжин халдварладаг халдварт өвчнүүд болох шүлхий, мялзан, ил ям, годрон, адууны цусаар халдварлах өвчин, галзуу, боом, брадзот, бруцеллөз, сахуу, дуут хавдар, шувууны тахал, лейкоз гэх мэт халдварт өвчнүүд, хурдан удмын морь уралдааны замд бэртэл авах, бахардах
9. **Хүүхэд багачуудад тохиолдож болох эрсдэл:** 0-16 насны хүүхдүүд байгалийн гамшигт өртөх, ус шаварт унах, юманд цохиулах, хавчуулах, хальтрах, унаж бэртэх, түлэгдэх, гар хөлөө эсгэх, зүсэх, чавчих, зам тээврийн аюул осолд өртөх, цэцэрлэг, сургуулийн анги танхимд байх үед гарч болох осол, мал болон амьтдын нөлөөллөөр үүсэх эрсдэлүүд гэх мэт

Дээр дурдсан эрсдэлүүдийг дотор нь дараах байдлаар ангилдаг. Үүнд:

1. **Хувийн эрсдэл:** Хүн зуурдаар нас барах, өвдөх, хөдөлмөрийн чадвараа хагас буюу бүрэн алдах, өндөр насыг наслах, тэтгэврийн орлого нь амьжиргааны наад захын хэрэгцээг хангахгүй байх, ажилгүй болох, эрүүл мэндээ алдах зэргээс болж алдагдал хүлээхтэй холбоо бүхий тодорхойгүй байдлыг хувийн эрсдэл гэж хэлнэ.
2. **Эд хөрөнгийн эрсдэл:** Байгалийн үзэгдэл, хулгай болон бусад тохиолдлын улмаас эд хөрөнгөд хохирол учрахыг хөрөнгийн эрсдэл гэнэ.
3. **Санхүүгийн эрсдэл:** Ашиг орлого олох боломжоо алдах, компанид оруулсан хувьцаанаас алдагдал хүлээх, хөрөнгөө оруулсан компани нь төлбөрийн чадваргүй болж дампуурах, олгосон зээл нь найдваргүй болохтой холбоо бүхий эрсдэлийг санхүүгийн эрсдэл гэнэ.
4. **Хариуцлагын эрсдэл:** Өөрсдийн анхаарал болгоомжгүй үйл ажиллагаанаас болж бусдын амь нас, эрүүл мэнд, ашиг сонирхол, эд хөрөнгөд хохирол учруулахтай холбоо бүхий эрсдэлийг хариуцлагын эрсдэл гэнэ.

Эдгээр нь даатгах боломжтой эрсдэлд хамаарна. Даатгах боломжтой эрсдэлийг дараах шалгуураар тодорхойлдог. Үүнд:

- ✓ Эрсдэлд өртсөн объект нь чухал ач холбогдолтой байх
- ✓ Эрсдэл нь тодорхой байх
- ✓ Эрсдэлд өртөх тохиолдол нь олон (эрсдэлийн давтамж өндөр) байх
- ✓ Гарсан хохирол нь санамсаргүй, гэнэтийн шинжтэй байх
- ✓ Гарсан хохирол нь тайлбарлаж, хэмжиж болохуйц байх
- ✓ Гарсан хохирол нь сүйрлийн бус шинжтэй байх. Өөрөөр хэлбэл, эрсдэл нь гамшгийн шинжтэй байж болохгүй. Тухайлбал, эрсдэлд хэт олон хүн хамрагдсан, тоо томшгүй олон эд хөрөнгө сүйрсэн байж болохгүй
- ✓ Даатгалын компани ашиг олох боломжтой байх гэх мэт

13.3. Хувь хүний эрсдэлийн удирдлага

Эрсдэлийн удирдлага: Хувь хүн өөрийн хөрөнгө, мөнгөө эрсдэлээс хамгаалах, эрсдэлийг бууруулах талаар стратеги боловсруулж, түүнийгээ амьдралд хэрэгжүүлэх үйл ажиллагаа.

Эрсдэлийн удирдлага нь төлөвлөлтөөс эхэлдэг. Эрсдэлийг бүрэн алга болгоно гэж байдаггүй. Эрсдэлээс бүрэн сэргийлэх шалгарсан ганц арга гэж байдаггүй. Хувь хүн өөрт тохиолдох эрсдэлээ янз бүрийн аргаар удирддаг.

1. Өнөөдөр тулгарч байгаа болон өмнө тохиолдсон эрсдэлдээ дүн шинжилгээ хийх, гаргасан алдаагаа давтахгүйг хичээж ажиллах
2. Ирээдүйд ямар нэгэн эрсдэл гарахаас өмнө урьдчилан сэргийлэх арга хэмжээг авах. Үүний тулд тодорхой хэмжээний мөнгөн болон биет нөөцтэй байх
3. Эрсдэлээ бусдад шилжүүлэх. Даатгалд хамрагдах замаар эрсдэлээ багасгах
4. Эрсдэлээс зайлсхийх. Бараа нийлүүлэх гэрээнд бараа тээвэрлэлтийн эрсдэлийг худалдан авагч тал ба тээвэрлэгч байгууллагын аль нэг нь хариуцах заалт оруулах замаар бараа тээвэрлэлтийн явцад гарч болзошгүй эрсдэлээс зайлсхийх
5. Диверсификаци хийх буюу эрсдэлийг тараан байршуулах. Та мөнгөө үнэт цаасанд байршуулах гэж байгаа бол өөр өөр компанийн хувьцааг худалдаж авах. Энэ нь таны ирээдүйд хүлээх эрсдэлийг тодорхой хэмжээгээр бууруулах ба үүнийг диверсификаци буюу тараан байршуулалт гэж хэлдэг
6. Эрсдэлээ удирдахад шаардлагатай өөрийн оюуны чадамжаас ашиглах. Тухайлбал,
 - ✓ Логик математикийн чадамж
 - ✓ Орон зайн чадамж
 - ✓ Бие бялдрын чадамж
 - ✓ Хүмүүс хоорондын харилцааны чадамж⁶⁷ гэх мэт

⁶⁷ Балж.Г., (2015). Эрсдэл, эрсдэлийн удирдлага ба даатгал. х.50.

7. Даатгалд даатгуулах гэх мэт аргуудыг өргөн ашигладаг.

Хүн бүрийн эрсдэлээ удирдах чадвар харилцан адилгүй. Зарим нь өөрийн өмнө тулгарч буй бэрхшээлийг давж гардаг. Зарим нь бэрхшээлийн өмнө өвдөг сөхөрдөг. Иймд хувь хүн өөрт тохиолдсон эрсдэлээ удирдахдаа өөрийн оюуны чадамжаа ашиглаж сурах нь зүйтэй. Өөрөөр хэлбэл, оюуны чадамжаа хөгжүүлж түүгээрээ мэргэжлээ сонгох нь цаашдаа сайхан амьдрах боломж олгодог. Хоббигоо нээх, хөгжүүлэх хэрэгтэй.

Хувь хүний эрсдэлийн зөв удирдлага нь дараах ач холбогдолтой. Үүнд:

- Нийгэмд тухайн хүн, өрх гэрийн амьдрах чадварыг харуулах
- Ашиг орлого нь өсөн нэмэгдэх
- Ажил төрлийн бат бэх холбоо үүсэх
- Нэр хүнд нь олон түмний дунд өсөх
- Хувь хүн, гэр бүлд, бизнесийн үйл ажиллагаанд, нийгэмдээ ач тустай байх болно⁶⁸

Сэдвийн дүгнэлт

Хүмүүс бид өнөөдөр, маргааш, ирээдүйд хэрхэх нь тодорхойгүй нөхцөл дунд ажиллаж амьдарч, сурч хөдөлмөрлөж байна. Хүн бүхэн сайхан мөрөөдөлтэй амьдрах хэрэгтэй. Мөрөөдөл нь таныг одоо, ирээдүйд аз жаргалтай болгох чухал зүйлийн нэг. Та өөрийн мөрөөдөл дээрээ үндэслэж амьдралын зорилгоо тодорхойлно.

Хувь хүнд тохиолдох бүх эрсдэлийг даатгах боломжгүй, даатгах боломжтой, боломжгүй эрсдэл гэж ангилж болно. Өөрийн өмнө тулгарч буй эрсдэлээ зөв удирдаж чадсан хүн өөрийгөө засаад, гэрээ засаад, цаашид төрөө засахад их хувь нэмэр оруулах болно.

Хувь хүнд тохиолддог эрсдэлийг удирдах олон арга байдгийн нэг нь даатгалд даатгуулах явдал юм.

Багатгах асуултууд

1. Эрсдэл гэж юу? Өөрт тохиолдсон эрсдэлийн талаар ярина уу.
2. Даатгах боломжтой ямар эрсдэлүүд байдаг талаар ярилцана уу.
3. Эрсдэлийн төрлүүдийн талаар бодит жишээн дээр дэлгэрүүлэн ярилцана уу.
4. Хувь хүний эрсдэлийг удирдах ямар аргууд байдаг вэ?
5. Хувь хүний эрсдэлийн удирдлагын ач холбогдлыг ярилцана уу.

⁶⁸ Балжс.Г, (2015). Эрсдэл, эрсдэлийн удирдлага ба даатгал. х.57

СЭДЭВ 14. ДААТГАЛ, ТҮҮНИЙ ТӨРЛҮҮД

Сэдвийг судлахын ач холбогдол, үр дүн

Энэ сэдвийг судалснаар даатгал, даатгалын хамгаалалтын талаар онолын мэдлэгтэй болж, арилжааны даатгалд хамрагдах чадварыг эзэмшинэ.

Тулгуур ойлголт

- Даатгалын үйл ажиллагаа
- Эрдийн даатгал
- Урт хугацааны даатгал
- Албан журмын даатгал
- Сайн дурын даатгал
- Эрүүл мэндийн даатгал
- Амьдралын даатгал
- Гэнэтийн ослын даатгал
- Тамирчдын даатгал

14.1. Даатгалын хэлбэрүүд

Даатгал: Ирээдүйн үйлчилгээг одоо худалдан авч буй үйл явц. Эрсдэлийг шилжүүлэх механизм. Даатгагч, даатгуулагчийн хооронд үүсч буй мөнгөн харилцаа.

Даатгалын үйл ажиллагаа: Даатгалын гэрээний дагуу даатгагч нь даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажиллагаа.

Даатгал нь дараах үндсэн зарчмуудтай. Үүнд:

1. Даатгалын объектийг бүрэн хамрах
2. Учирсан хохирлыг нөхөж олгодог байх
3. Даатгаж болох ашиг сонирхлыг хангах
4. Хохирол нөхөлтийг олгохдоо шалтгааныг харгалзах
5. Их тооны хууль⁶⁹

Даатгалыг хугацаагаар нь ердийн ба урт хугацааны даатгал гэж ангилна.

Ердийн даатгал: Нэг жил хүртэл хугацаатай хийгддэг даатгал.

Урт хугацааны даатгал: Нэг жилээс дээш хугацаатай даатгал.

Жолоочийн хариуцлагын албан журмын даатгал нэг жилийн хугацаатай хийгддэг.

Амьдралын даатгалын төрлүүд урт хугацааны даатгалд орно.

Даатгал нь дараах төрөлтэй. Үүнд:

1. Албан журмын даатгал (заавал даатгал)
2. Сайн дурын даатгал

⁶⁹ Балж.Г, 2015. Эрсдэл, эрсдэлийн удирдлага ба даатгал. х.66.

Албан журмын даатгал: Хуульд заасны дагуу иргэд заавал даатгуулбал зохих даатгалын төрөл.

Зорчин явагчдын гэнэтийн ослын даатгал, жолоочийн хариуцлагын албан журмын даатгалууд орно.

Сайн дурын даатгал:

Даатгуулагч сайн дурын үндсэн дээр даатгуулдаг даатгалын төрөл.

Манайд ихэнх даатгал нь сайн дурын даатгал байдаг. Даатгалын төрөл тус бүр нь хэлбэртэй байх бөгөөд албан журмын даатгалын хэлбэрийг хуулиар тогтооно.

Сайн дурын даатгалын хэлбэрийг Санхүүгийн зохицуулах хорооноос тогтооно. Дээр дурдсан даатгалын төрөл нь дараах хэлбэрүүдтэй. Үүнд:

1. Хүний амь нас, эрүүл мэнд, ашиг сонирхлын даатгал
2. Гэнэтийн ослын даатгал
3. Эд хөрөнгийн даатгал
4. Санхүүгийн даатгал
5. Хариуцлагын даатгал

Даатгах эрсдэлийн хүрээнд гадаадын даатгалын компаниуд харилцагч нартаа дараах даатгалын бүтээгдэхүүнийг санал болгодог. Үүнд:

1. Гэнэтийн ослын даатгал, амьдралын даатгал, тэтгэврийн даатгал, боловсролын даатгал, иргэдийн гэнэтийн ослын даатгал, тамирчин жүжигчдийн гэнэтийн ослын даатгал, ажиллагсдын гэнэтийн ослын даатгал, оюутны гэнэтийн ослын даатгал, хүүхдийн гэнэтийн ослын даатгал, уралдааны морь унаач хүүхдийн гэнэтийн ослын даатгал, гадаадад зорчин явагчдын гэнэтийн ослын даатгал, гадаадын жуулчдын гэнэтийн ослын даатгал, эрүүл мэндийн даатгал, хуримын даатгал, гэрлэлтийн даатгал, ажилгүйдлийн даатгал, хөдөлмөрийн чадвараа түр алдсаны даатгал, бэлэвсрэлийн даатгал.
2. Орон сууцны даатгал, зуслангийн байшингийн даатгал, үл хөдлөх хөрөнгийн даатгал, иргэдийн эд хөрөнгийн даатгал, байгууллагын эд хөрөнгийн даатгал, тоног төхөөрөмжийн даатгал, малын эрсдэлийн даатгал, тээврийн хэрэгслийн даатгал, газар тариалангийн даатгал, далайн даатгал, газар хөдлөлтийн даатгал, үерийн даатгал, галт уулын дэлбэрэлтийн даатгал, хулгайн даатгал, гэрийн тэжээвэр амьтдын даатгал,
3. Хадгаламжийн даатгал, зээлдэгчийн амь насны даатгал, зээлийн барьцаа хөрөнгийн даатгал, үнэт цаасны даатгал, санхүүгийн алдагдлын даатгал, орлого бууралтын даатгал, ажилтнуудын үнэнч байдлын даатгал.
4. Бүтээгдэхүүний хариуцлагын даатгал, эмчийн хариуцлагын даатгал, эмийн санчийн хариуцлагын даатгал, жолоочийн хариуцлагын даатгал, зочид буудлын эзний хариуцлагын даатгал, эмийн бүтээгдэхүүний хариуцлагын даатгал, терроризмын даатгал, ажил олгогчийн хариуцлагын

даатгал, мэргэжлийн хариуцлагын даатгал, өрхийн тэргүүний хариуцлагын даатгал гэх мэт. Эдгээр бүтээгдэхүүнээс манай орны хувьд ихэнх нь байдаг.

Амьдралын даатгал. Иргэд тэтгэвэрт гарсны дараа санхүүгийн хувьд эрх чөлөөтэй байхын тулд амьдралын даатгалд даатгуулдаг.

Амьдралын даатгал: Тэтгэврийн насанд хүрээд даатгалаас нөхөн төлбөрөө авдаг, хэрвээ тэтгэвэрт гарахаасаа өмнө хөдөлмөрийн чадвараа бүрэн болон хагас алдсан тохиолдолд санхүүгийн дэмжлэг авдаг, даатгуулагч нь нас барвал өв залгамжлагчид нөхөн олговор олгодог даатгал.

Гадаад орны өндөр настай иргэд залуу байхдаа амьдралын даатгалд даатгуулаад тэтгэвэртээ гарахдаа нөхөн төлбөрөө авч, амьдралын эцсийн мөчөө хүртэл санхүүгийн хувьд эрх чөлөөтэй амьдардаг байна. Амьдралын даатгал нь урт хугацааны даатгалд орно.

Амьдралын даатгалд залуу байхдаа даатгуулж эхэлбэл төлөх хураамжийн хэмжээ бага байх ба тэтгэвэрт гарах нас ойртох тусам хураамж өндөр болдог. Өөрөөр хэлбэл, амьдралын даатгалын хураамж нь тухайн хүний нас, эрүүл мэндийн байдлаас хамаарах ба хураамжийг сар бүр төлдөг.

Хүмүүс дараах шалтгаанаар амьдралын даатгалд даатгуулдаг. Үүнд:

1. Өрхийн орлогоо нэмэгдүүлэх
2. Гэр бүл нь тэжээгчээ алдсан тохиолдолд гарч болзошгүй санхүүгийн хүндрэлээс сэргийлэх
3. Урт болон богино хугацаанд хөдөлмөрийн чадвараа бүрэн болон хагас алдсан тохиолдолд санхүүгийн дэмжлэг авах
4. Нэмэлт хуримтлалыг буй болгох
5. Бизнесийн эрсдэлээс хамгаалах, бизнесийн үйл ажиллагаагаа хэвийн явуулах
6. Үр хүүхдүүдээ өөрийн хуримтлалаас өвлүүлэх
7. Оршуулгын зардлаа санхүүжүүлэх
8. Хөрөнгө оруулалтын орлого олох гэх мэт

Амьдралын даатгал нь хүний амьдралын явцад амь нас, эрүүл мэндтэй нь холбоо бүхий янз бүрийн эрсдэл тохиолдоход тэрхүү эрсдэлийг даван туулахад нь нөхөн төлбөр олгох зорилго бүхий даатгал. Хүн амьдралынхаа туршид орон сууцтай, машинтай болох, боловсрол эзэмших, ирээдүйд өндөр настай болсон хойноо баталгаатай тэтгэвэр авах зэрэг олон зорилго тавин ажилладаг. Энэхүү зорилгын хүрээнд тодорхой хэмжээний мөнгийг хуримтлуулж хуримтлал үүсгэх шинж чанар бүхий даатгал юм.

Эрүүл мэндийн даатгал

Эрүүл мэндийн даатгал: Даатгалын хураамжаар бүрдүүлсэн сангаас даатгуулагчийн эрүүл мэндтэй холбоотой гарсан зардлыг санхүүжүүлэх зорилго бүхий даатгал.

Энэ нь эрүүл мэндийн эмчилгээ үйлчилгээний төлбөрийг даатгалын компаниас шууд төлөх боломжтой даатгалын бүтээгдэхүүн юм.

Гэнэтийн осолд орсон болон ердийн болон халдварт өвчнөөр өвдсөнийолон халдварт өвчнөөр г даатгалын компаниас шууд төлөх боломжтой ан зардлыг санхүүжүүлэх зорилго бүхий даатгал.эрсдэлийг даван өөрийн улс болон дэлхийн бүхий л улсад авах боломжтойгоос гадна гарсан зардлыг эрүүл мэндийн даатгалын сангаас төлүүлэх боломжтой. Үүний тулд эрүүл мэндийн даатгалд даатгуулсан байвал зохино.

Эрүүл мэндийн даатгалыг хийгдэх байдлаар нь ангилдаг. Үүнд:

1. Заавал даатгал (Улсын эрүүл мэндийн даатгал): Иргэн болон тухайн иргэний ажил олгогч сарын цалин түүнтэй адилтгах орлогоос тус тус 2 хувийн эрүүл мэндийн даатгалын шимтгэл төлдөг даатгалыг хэлнэ)
2. Сайн дурын даатгал: Энэ нь арилжааны даатгал юм.

Даатгалын компаниуд эрүүл мэндийн даатгалыг даатгуулагч нартаа санал болгодог. Үүнээс заримыг нь дурдвал: Эрүүл мэндийн даатгал, эх үрсийн багц даатгал, олон улсын эрүүл мэндийн даатгал, гадаадад зорчигчдын эрүүл мэндийн даатгал, гадаадын жуулчдын эрүүл мэндийн даатгал гэх мэт.

Эрүүл мэндийн иж бүрэн даатгал нь иргэд өөрийн эрүүл мэнддээ хариуцлагатай хандах, чанартай үйлчилгээг хүндрэл чирэгдэлгүй авах, эмнэлгүүд цаашлаад эрүүл мэндийн салбарт шинэчлэлт сайжруулалт хийгдэх хөрсийг бүрдүүлж өгсөн даатгал юм.

Даатгуулагч нь сайн дурын эрүүл мэндийн цогц даатгалд даатгуулснаар амбулаторийн болон хэвтэн эмчлүүлэх, жирэмслэлт, төрөлттэй холбоотой эмчилгээ, үйлчилгээ, эрхтэн шилжүүлэн суулгах зэрэг өндөр үнэтэй мэс ажилбарыг Монгол Улсын шилдэг хувийн болон улсын эмнэлэг, цаашлаад Азийн нэр хүндтэй эмнэлгүүдээс авах боломж бүрдэнэ.

Тэтгэврийн даатгал. Хувь хүмүүс өндөр насны тэтгэвэрт гарсны дараа санхүүгийн хувьд сэтгэл амар байх цөөнгүй үйлчилгээнүүд байна. Жишээ нь, Хас банк “Насны нүнжиг” хадгаламжийн бүтээгдэхүүн санал болгож байхад даатгалын компаниуд “Тэтгэврийн даатгал”-ыг санал болгодог. Та ирээдүйд өндөр насны тэтгэвэрт гарсан үедээ нийгмээс болон үр хүүхдээсээ санхүүгийн хамааралгүй элбэг хангалуун амьдармаар байвал “Тэтгэврийн даатгал”-д даатгуулах нь зүйтэй.

Тэтгэврийн даатгал хэнд хэрэгтэй вэ?

- Нийгмийн даатгалд хамрагдаагүй иргэд
- Нэмэгдэл тэтгэвэр авах сонирхолтой иргэд
- Үнэ цэнэтэй ажилтныг өөртөө татах, тогтвор суурьшилтай ажиллуулах арга хэрэгсэл хайж буй аж ахуйн нэгжүүдэд хэрэгтэй

Хэдий хэмжээний тэтгэврийн хуримтлал үүсгэх, хэдэн жилийн тэтгэвэр авахаа та өөрөө сонгоно. Даатгалын хураамжаа заавал сараар бус хүссэн үедээ өөрийн боломждоо тулгуурлан уян хатнаар төлж болно. Тэтгэвэрт гарахаасаа өмнө хөдөлмөрийн чадвараа бүрэн алдах, эсвэл нас барсан тохиолдолд нэр дээр нь хуримтлагдсан бүх мөнгийг гэр бүл эсвэл өв залгамжлагчид олгоно. Тэтгэвэр авч байгаад нас барсан тохиолдолд үлдэгдэл тэтгэврийн хуримтлалыг ар гэрт нь эсвэл өв залгамжлагчид нь буцааж өгдөг.

Тэтгэврийн хуримтлалаа өв залгамжлуулах буюу гэр бүлийн гишүүд, өөрийн дотны хүмүүстээ шилжүүлэх боломжтой. Тэтгэвэр авч байх хугацаандаа тэтгэврийн хуримтлалаа барьцаалан арилжааны банкнаас зээл авах боломжтой. Хэрвээ танай ажиллаж буй байгууллага байгууллагын дэргэдэх тэтгэврийн сантай бол та түүнд шимтгэл төлж хамрагдах хэрэгтэй. Та тэтгэврийн даатгалд хамрагдвал тэтгэвэрт гарсан хойноо нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр авахын зэрэгцээ даатгалын компаниас бас нөхөн төлбөр авна.

Гэнэтийн ослын даатгал.

Энэхүү даатгал нь даатгуулагч ажлын цагаар, ажлын байран дээрээ ажил үүргээ гүйцэтгэж байх үед эсвэл Монгол Улсын нутаг дэвсгэрийн хаана ч, ямар ч нөхцөлд гэнэтийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа түр алдах, хэсэгчлэн болон бүрэн алдах, нас барах тохиолдлуудад даатгуулагч эсвэл түүний ар гэрийнхэнд нөхөн төлбөр олгох зорилготой даатгал юм.

Гэнэтийн ослын даатгал:

Даатгуулагч гэнэтийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа бүрэн болон хэсэгчилэн алдах, нас барах тохиолдолд нөхөн төлбөр олгох зорилго бүхий даатгал.

Энэ даатгалд гэнэтийн, үйлдвэрлэлийн, зам тээврийн болон ахуйн осол, бусдын санаатай ба санамсаргүй үйлдлээс үүссэн эрүүл мэнд, амь насны хохирол гэх мэт эрсдэлээс хамгаалж даатгуулдаг.

Сургуулийн болон сургуулийн өмнөх бага насны хүүхэд, үйлдвэрлэлийн осол гарах болон ажил мэргэжлээс шалтгаалах өвчин тусах магадлал өндөртэй газар ажиллагсад, уралдааны морь унаж буй хүүхдүүд энэ даатгалд даатгуулах хэрэгтэй. Гэнэтийн ослын даатгал нь олон төрөлтэй байна. Үүнд:

1. Ажиллагсдын гэнэтийн ослын даатгал
2. Иргэдийн гэнэтийн ослын даатгал
3. Гадаадын жуулчдын гэнэтийн ослын даатгал
4. Гадаадад зорчигчдын гэнэтийн ослын даатгал

5. Уралдааны морь унаач хүүхдийн гэнэтийн ослын даатгал
6. Хүүхдийн гэнэтийн ослын даатгал
7. Оюутны гэнэтийн ослын даатгал
8. Тамирчин, жүжигчдийн гэнэтийн ослын даатгал гэх мэт

Энэ даатгалын хураамжийг жилд 1 удаа даатгалын үнэлгээнээс тодорхой хувиар бодож тооцдог. Жишээ нь, оюутны гэнэтийн ослын даатгалын хураамж даатгалын үнэлгээний 1 хувь байдаг.

Тамирчдын даатгал

Тамирчдын буюу спортын даатгал:

Спортын уралдаан тэмцээн, бэлтгэлийн явцад гэрээнд заасан эрсдэлийн улмаас тамирчдад учирсан хохирлыг нөхөн төлөх зорилготой даатгал.

Спортын даатгал гэдэг нь мэргэжлийн тамирчид, ямар нэгэн спортын тэмцээн уралдаанд оролцож буй, спортоор хичээллэж буй бүхий л талуудад санал болгож буй даатгал юм.

Тамирчдын даатгал, спортын даатгалд мэргэжлийн тамирчин, сонирхогч тамирчин, спортоор хичээллэж буй хүүхдүүдийн эцэг, эх, мэргэжлийн болон сонирхогчийн биеийн тамир спортын клубүүд, биеийн тамир спортын мэргэжилтнүүд, олон улсын болон үндэсний биеийн тамир спортын удирдах байгууллагууд, олон улсын, үндэсний, орон нутгийн чанартай биеийн тамир спортын арга хэмжээ зохион байгуулагч байгууллагууд, спортын мэргэжлийн холбоодууд хамрагдах боломжтой.

Тамирчдын даатгалын ач холбогдол юу вэ? Тамирчдын бэлтгэл сургуулилт уралдаан тэмцээн, үзүүлэх тоглолтын үед даатгалын гэрээнд заасан эрсдэлд орвол эмчилгээтэй холбоотой зардал, оршуулгын зардал, урт хугацааны асаргаа арчилгаа сувилгааны зардал, бусад зардлыг гэрээнд зааснаар нөхөн олгох даатгалын хамгаалалт юм. Мөн даатгуулагчийн гэнэтийн ослын дараа өмнө олж байсан орлогын алдагдлыг нөхөн олгоно. Тухайн даатгуулагч гэмтэлтэй байх хугацаандаа ажил хөдөлмөр эрхэлж чадаагүйн улмаас алдсан орлого, цаашдын хөдөлмөрийн чадвар алдалтаас бий болох орлогын алдагдлын өнөөгийн үнэ цэнийг тооцон олгох даатгал гэж хэлж болно.

Гэр, хашаа, байшингийн даатгал

Монгол гэр нь олон мянган жилийн тэртээгээс нүүдэлчдийн амьдралын олон сайхан чанарыг өөртөө шингээсэн уран төгс хэлбэр, байгаль эхтэйгээ хүмүүний зохицон шүтэж амьдрах хэлбэр, хүн төрөлхтөний уран барилгын өвөрмөц ухаан болсоор эдүгээ хүртэл хөгжиж ирсэн түүхтэй. Өнөөдөр монгол гэрт олон мянган хүн аж төрөн сууж байна. Иймээс гэрийн даатгалын талаархи асуудлыг хөндөж тавьж байна.

Хүн өөрийн амьдрах хугацаандаа өөрийн амьдралыг бүтээн буй болгож түүнийгээ өдрөөс өдөрт улам бүр цогцлоож байдаг. Энэхүү бүтээсэн амьдралын салшгүй нэгээхэн хэсэг бол түүний халуун дулаан орчин болсон орон гэр, хашаа байшин нь байдаг. Иймээс манай ихэнх даатгалын компаниуд иргэдэд зориулж гэр хашаа байшингийн даатгалыг санал болгодог. Гэр хашаа байшингаа 1 жилийн хугацаагаар байгалийн хүчит шуурга, цахилгаан, галд өртөх, шатах, үер усанд автах, гадны нөлөөллөөс болж сүйдэх зэрэг эрсдэлээс даатгана.

Агаарын хуурайшилт ихтэй үед ой, хээрийн түймэр гарч их хэмжээний хохирол учруулдаг. Хувийн эзэмшлийн байшин, гэр шатах явдал цөөнгүй гардаг. Иймээс гэр хашаа байшингаа даатгуулах нь чухал. Байгалийн болон гэнэтийн аюулыг бид таамаглаж чадахгүй ч аливаа учрах хохирлоос урьдчилан сэргийлж эд хөрөнгөө хамгаалж чадна. Гэр, хашаа байшингаа даатгуулснаар байгалийн болон гэнэтийн аюулын улмаас учирч болох эрсдэлээс үүсэх хохирлыг даатгалд шилжүүлснээр өөрт болон гэр бүлдээ учрах санхүүгийн дарамтыг хөнгөвчлөх боломжтой болно.

Орон сууцны даатгал

Бидний амьдралын салшгүй нэгээхэн хэсэг нь аж төрөн амьдардаг орон сууц маань байдаг. Иймээс манай ихэнх даатгалын компаниуд иргэдэд зориулж орон сууцны даатгалыг санал болгодог. Таны эзэмшиж, өмчилж буй орон сууцанд урьдчилан таашгүй гэнэтийн эрсдэл тохиолдсоноос үүдэн хэсэгчилэн болон бүрэн сүйрэл, хохирлыг нөхөн сэргээх зардлыг энэ даатгалаас олгоно.

Орон сууцны даатгалын эрсдэлийг үндсэн болон нэмэлт эрсдэл гэж хуваана. Үндсэн эрсдэлд байгалийн хүчин зүйл, гал, эрчим хүчний хэлбэлзэл, сантехникийн гэмтэл, ус чийгний нөлөөлөл зэргээс үүсэх эрсдэлүүд орно. Харин нэмэлт эрсдэлд далд гэмтэл, ахуйн гэмтэл, хулгай дээрэм, гуравдагч этгээдээс үүдэлтэй аливаа хохирлоос үүсэх эрсдэлүүд хамаардаг. Энэ хоёр эрсдэлийг хоёуланг, эсвэл аль нэгийг нь сонгон даатгуулж болно.

Лангуу түрээслэгч, жижиг худалдаа эрхлэгчдийн даатгал

Бүх төрлийн хүнс, гоо сайхан, барилгын материал, хувцас, гоёл чимэглэл, бэлэг дурсгал, бичиг хэрэг, гэр ахуйн цахилгаан бараа, авто машины сэлбэг хэрэгсэл гэх мэт барааг борлуулж буй иргэд галын, сантехникийн, байгалийн эрсдэлээс хамгаалж даатгуулна.

Та болон таны ойр дотны хүмүүс, танил хэн нэгэн тань лангуу түрээслэгч, жижиг худалдаа эрхлэгчид бол энэ даатгалыг заавал хийлгээрэй гэж зөвлөх байна. Хэрвээ энэ даатгалд даатгуулвал та жилдээ ганц л удаа хураамж төлж, бүтэн жилийн турш эрсдэлээс санаа зовох юмгүй бизнесээ явуулах болно.

Малын эрсдэлийн даатгал

Байгалийн эрсдэл, малын төрөл бүрийн халдварт өвчин, араатан амьтанд бариулах, ус, шаварт унах гэх мэт олон хүчин зүйлийн улмаас мал сүрэг зүй бусаар хорогддог. Энэхүү эрсдэлээс хамгаалахын тулд малын эрсдэлийн даатгалыг санал болгодог.

Малчин зөвхөн өөрийн малыг даатгуулах ба тавиул малыг эзэн нь өөрөө даатгуулна. МЭД-д зөвхөн малын зүй бус хорогдлыг эрсдэл гэж авч үзнэ. Даатгуулах хүсэлтэй малчдын Улаанбаатар хот, аймгийн төвд оршин суудаг ах, дүү хамаатан садан нь даатгуулагчийн өмнөөс даатгал хэрэгжүүлэгч даатгалын компаниудын аль нэгтэй холбогдон хураамжийг нь төлж, даатгалд хамруулах боломжтой. МЭД бол сайн дурын даатгал юм.

ТАНЫ МЭДЛЭГТ

Манай ард түмэн буянт малаа өсгөж сүү, ашиг шимийг нь хүртэж ирсэн малч удамтай ард түмэн. Жил ирэх тусам малын маань тоо толгой өсч байна. 2015 оны эцсийн байдлаар манай улсын нийт малын тоо толгой 55.9 саяд хүрсэн байна. Нийт малын сүргийн дотор хонь, ямааны эзлэх хувийн жин хамгийн өндөр байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад нийт малын тоо 3.9 саяар өссөн байна.

Малын хорогдол сумын хэмжээнд тухайн төрлийн мал дээр 6 хувь хүртэл байвал малчин өөрөө, 6-30 хувь хүртэл байвал даатгалын компани, малын хорогдлын хэмжээ 30–с дээш хувь байвал Засгийн газар тус тус хариуцна. Сумын малын хорогдлын хувийг малын төрөл тус бүр дээр тооцоолно. Харин нэг малчны мал их хорогдсон байлаа ч сумын малын хорогдол босго үзүүлэлтэд хүрээгүй нөхцөлд нөхөн төлбөр авахгүй.

Хариуцлагын даатгал. Мэргэжил болгоны цаана ажлын том хариуцлага дагаж явдаг. Ажлаа хийх явцдаа гэнэтийн санамсар болгоомжгүй үйл ажиллагаанаас болж хэн нэгний амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд хохирол учруулбал гаргасан хохирлыг нь даатгалын компани нөхөн олгодог даатгалыг хариуцлагын даатгал гэнэ. Хариуцлагын даатгалын дараах бүтээгдэхүүнүүд байдаг. Үүнд:

1. Инженерийн
2. Жолоочийн
3. Эмч, эмнэлгийн ажилтны
4. Эмийн санчийн
5. Өмгөөлөгчийн
6. Шүүгчийн
7. Нотариатчийн
8. Нягтлан бодогчийн
9. Зочид буудлын эзний
10. Ажил олгогчийн
11. Лангуу түрээслэгчийн
12. Мэргэжлийн гэх мэт олон хэлбэртэй

Манай орны хувьд жолоочийн хариуцлагын даатгал нь албан журмын даатгалд орох бөгөөд бусад хариуцлагын даатгал нь сайн дурын даатгалд ордог. Мэргэжлийн хариуцлагын даатгалд сайн дураар даатгуулах нь таны гаргах зөв шийдвэрүүдийн нэг байх болно. Энэ даатгал дараах ач холбогдолтой. Үүнд:

1. Гарсан хохирлын нөхөн олговрыг олгох
2. Даатгуулагчийн хүлээх эрсдэлийг багасгах
3. Ирээдүйд гарч болзошгүй санхүүгийн эрсдэлээс хамгаалах
4. Даатгуулагчийн айдас, түгшүүрийг багасгах, сэтгэлийн амар амгаланг буй болох
5. Хөрөнгө оруулалтын эх үүсвэр болох
6. Банкны зээлийн баталгаа болох
7. Ирээдүйд учирч болзошгүй гарз хохирлыг сануулах гэх мэт

14.2. Даатгалын гэрээ байгуулахад анхаарах зүйлүүд

- ✓ Даатгалын тухай сайтар судалж үзэх;
- ✓ Өөрийн хувьд даатгуулах хэрэгцээ байгаа эсэхээ эхэлж тодорхойлох

Амьдрал бол баян. Танд ямар нэгэн эрсдэл тохиолдвол түүнийг даван гарах хангалттай хэмжээний санхүүгийн нөөц өнөөдөр байна уу? Хэрвээ байгаа бол амь нас, эрүүл мэнд, эд хөрөнгөд учрах аливаа эрсдэлийг удирдахад их хувь нэмэр болно. Таны даатгуулах хэрэгцээг тодорхойлохын тулд танд энэ үед яах вэ гэдэг хэд хэдэн асуултыг тавьж үзье. Үүнд:

- Хэрвээ та болон танай гэр бүлийн аль нэг гишүүн байгалийн гамшиг, гэнэтийн осол, ахуйн осол, ердийн болон халдварт өвчний улмаас хөдөлмөрийн чадвараа түр, хагас, бүрэн алдсан тохиолдолд та яах вэ?
- Хэрвээ та болон таны ойр дотны хүн гэнэтийн осол, ахуйн осол, ердийн болон халдварт өвчний улмаас эсвэл зуурдаар нас барвал яах вэ?
- Таны өмчилж буй орон сууц, хувийн байшин, зуслангийн байшин, хашаа байшин, гэр, таны эдэлж хэрэглэж буй гэр ахуйн цахилгаан хэрэгсэл байгалийн болон гэнэтийн, ахуйн осолд өртвөл яах вэ?
- Таны амь, нас, эрүүл мэнд, таны эзэмшиж буй өмчид тохиолдох элдэв төрлийн эрсдэлээс та хамгаалагдсан уу?
- Таны хүүхэд цэцэрлэг, сургуульд явдаг уу? Таны хүүхэд аливаа эрсдэлээс бүрэн хамгаалагдаж чадсан уу?
- Та өөрийн гэсэн тээврийн хэрэгсэлтэй юу? Түүнийгээ даатгалд хамруулах хэрэгцээ шаардлага байна уу?
- Таны ажил мэргэжлээс шалтгаалж таны зүгээс хэн нэгний амь нас, эрүүл мэнд, ашиг сонирхол, эд хөрөнгө болон нэр хүндэд хохирол учруулах тохиолдол үүсэх боломжтой юу? Хэрвээ үүсвэл та хохирлыг хэрхэн барагдуулах вэ?

- Та өөрөө барилгачин, гал сөнөөгч, онцгой байдлын аврагч, цагдаа, уурхайчин, үйлдвэрийн ажилчин, мэргэжлийн тамирчин, жүжигчин, эмч, эмнэлэгийн ажилтан гэвэл ажлын байран дээрээ албан үүргээ гүйцэтгэж байгаад үйлдвэрлэлийн осолд орох, мэргэжлээс шалтгаалах өвчин тусах, элэгний “С” вирусын халдвар авах, хөдөлмөрийн чадвараа алдах, нас барах магадлал байна уу? Энэ бүхнээс та болон таны гэр бүл хамгаалагдсан уу?
- Таны ирээдүйд авах тэтгэвэр таны санхүүгийн хэрэгцээг бүрэн хангаж чадах уу?
- Та болон таны ойр дотны хүмүүс малчин, мал малладаг бол малд тань байгалийн гамшиг тохиолдож малын зүй бус хорогдол их, бага хэмжээгээр гарвал та яах вэ? Энэ бүхнийг сайтар тунгаан бодох хэрэгтэй. Амь насаа, эд хөрөнгөө, хариуцлагаа даатгуулах уу?, Ямар ямар эрсдэлээс хамгаалуулахыг хүсч байна вэ? Нэмэлт хэлбэрээр ямар эрсдэлээс даатгуулах вэ? гэдгээ зөвөөр тодорхойлох хэрэгтэй.

Иргэд, ААНБ-ууд нь үйлчлүүлэх даатгалын компаниа сонгохдоо www.frc.mn хаяг болон даатгалын компаниудын цахим хаягаар орж, компаниудын мэдээлэл, хэвлэл мэдээллийн хэрэгсэлүүдийн гаргасан мэдээлэлтэй тус тус танилцаж, ойр дотны хүмүүс болон найз нөхдөөсөө асууж сонголтоо хийх хэрэгтэй. Даатгалын компанийг сонгохдоо дараах үзүүлэлтүүдийг харгалзах хэрэгтэй. Үүнд:

- Бизнесийн түүх, туршлага, хүний нөөцийн чадавхи, харилцагчдын тоо
- Даатгалын зах зээлд эзлэх байр суурь
- Хөрөнгийн хэмжээ
- Даатгалын хураамжийн хэмжээ
- Нөхөн төлбөрийн хэмжээ
- Нөөц сангийн хэмжээ
- Хохирол нөхөлтийн харьцаа
- Нөхөн төлбөр олголтын шуурхай байдал, үйлчилгээний чанар
- Тухайн даатгалын компанийн төлбөрийн чадварын байдал гэх мэтийг авч судлах

Даатгалын гэрээнд гарын үсэг зурахдаа өндөр хариуцлагатай байх шаардлагатай. Тухайн гэрээ нь одоо мөрдөгдөж буй хууль, дүрэмтэй нийцэж байгаа эсэхийг нягтлан үзэх хэрэгтэй. Ялангуяа, санхүүгийн хариуцлага хүлээх гэрээнд гарын үсэг зурахдаа анхааралтай хандах нь зүйтэй. Таны эрх ашигт энэхүү гэрээ нь нийцэж байгаа эсэх, нэмэлт өөрчлөлт оруулж тусгуулах зүйл байгаа эсэх дээр анхаарч ажиллах нь чухал байдаг. Даатгалын гэрээнд гарын үсэг зурахын өмнө та даатгагчтай байгуулж буй гэрээгээ сайтар уншиж судлах хэрэгтэй. Үүнд: Өөрийн хүлээх үүрэг, эдлэх эрх, нөхөн төлбөрөөс бүрэн буюу хагас татгалзах нөхцөлүүд, гэрээг цуцлах нөхцөл гэх мэтийг анхааралтай унших хэрэгтэй.

Хэрвээ та дараах мэргэжлээр сурч байгаа болон дараах салбарт ажиллаж байгаа бол гэнэтийн ослын даатгалд сайн дураараа заавал даатгуулаарай. Үүнд: Цэргийн албан хаагч, цагдаагийн байгууллагын ажилтан, гал сөнөөгч, хил хамгаалагч, онцгой байдлын аврагч, шүүхийн шийдвэр гүйцэтгэгч, тамирчин, жүжигчин, эмч, эмнэлэгийн ажилтан, үйлдвэрлэлийн осол гарах магадлал өндөр үйлдвэр, байгууллага, ажил мэргэжлээс шалтгаалсан өвчлөл ихтэй салбарын ажилтан гэх мэт.

Хэрвээ та дараах мэргэжлээр болон дараах салбарт ажиллаж байгаа бол мэргэжлийн хариуцлагаа сайн дураараа заавал даатгуулах хэрэгтэй. Үүнд: Эрүүл мэндийн салбарт ажиллаж байгаа эмч, сувилагч, эмийн санч, наториатч, өмгөөлөгч, ажил олгогч, зочид буудлын эзэн, худалдаа наймаа эрхлэгч, хүнс болон эмийн бүтээгдэхүүн, гоо сайхны бүтээгдэхүүн үйлдвэрлэгч, хүнс болон эмийн бүтээгдэхүүн, гоо сайхны бүтээгдэхүүн борлуулагч, дээрх бүтээгдэхүүнүүдээр үйлчилгээ үзүүлэгч, тухайлбал, супер маркет, дэлгүүр, ресторан, цайны газар, үсчин, гоо сайханы салоны ажил эрхлэгч гэх мэт.

Мөн даатгалын компаниудаас үзүүлж буй хөнгөлөлт, урамшууллыг сайтар судлах, тухайн даатгалын компанийн нөхөн төлбөрийн үйлчилгээний талаар мэдээлэл авах боломж ямар байгаа зэргийг мэдэх шаардлагатай. Энэ бүхний эцэст дүгнэж хэлэхэд даатгалд хамрагдах нь таны гаргасан хамгийн зөв шийдвэрийн нэг байх болно.

Сэдвийн дүгнэлт

Даатгал нь ирээдүйн үйлчилгээг одоо худалдаж авах үйл явц юм. Даатгал нь ирээдүйд гарч болзошгүй санхүүгийн эрсдэлээс хамгаалах чухал хэрэгслийн нэг бөгөөд даатуулагчид гэрээнд заасан хохирол учирсан үед хохирлыг нөхөн төлөх, хохирлоос урьдчилан сэргийлэх үүрэгтэй байдаг.

Даатгалыг хугацааны хувьд ердийн даатгал, урт хугацааны даатгал гэж ангилдаг.

Даатгал нь албан журмын даатгал (заавал даатгал), сайн дурын даатгал гэсэн төрлөөс бүрддэг. Даатгалын төрөл тус бүр нь хэлбэртэй байх бөгөөд албан журмын даатгалын хэлбэрийг хуулиар тогтооно. Харин сайн дурын даатгалын хэлбэрийг Санхүүгийн зохицуулах хорооноос тогтоодог.

Даатгуулагч даатгалын гэрээ байгуулахын өмнө зайлшгүй анхаарах зүйлүүдийг сайтар судлах хэрэгтэй. Тухайлбал, даатгалын хураамжийн болон нөхөн төлбөрийн хэмжээ, нөхөн төлбөр олголтын шуурхай байдал, даатгалын компанийн үйлчилгээний чанар, зах зээлд эзлэх байр суурь гэх мэт.

Багатгах асуулууд

1. Даатгал гэж юу вэ? Ямар зорилгоор даатгалыг хийдэг вэ?
2. Даатгалын гэрээг байгуулахаас өмнө юуг анхаарах хэрэгтэй вэ?
3. Даатгал хийхийн ач холбогдол юу вэ?
4. Даатгалын хэлбэр, төрлүүдийг дэлгэрүүлэн ярилцана уу.

БҮЛЭГ V. ТЭТГЭВРИЙН БА ӨВ ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

СЭДЭВ 15. ТЭТГЭВРИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Сэдвийг судлахын ач холбогдол, үр дүн

Энэ сэдвийг судалснаар тэтгэвэр, тэтгэврийн төлөвлөлтийн онолын мэдлэгтэй болж, тэтгэврээ төлөвлөх, тооцоолох чадварыг эзэмшинэ.

Тулгуур ойлголт

- Тэтгэврийн төлөвлөлт
- Тэтгэврийн орлого
- Нийгмийн даатгал
- Өндөр насны тэтгэвэр
- Тэтгэврийн даатгалын нэрийн данс
- Цэргийн албан хаагчдын тэтгэвэр

15.1. Тэтгэврийн төлөвлөлт, түүний ач холбогдол

Та одоо залуу байна. Юун тэтгэврийн төлөвлөлт вэ? Одоо энэ талаар ярих цаг нь мөн үү гэж бодож байж магадгүй. Энэ нь хүн бүрт тохиолддог зүйл. Залуу насанд өөрийгөө мөнх залуугаараа байх юм шиг санадаг. Тэтгэвэрт гарах нас хаа хол мэт боловч цаг завгүй ажиллаж явахад чинь хоног хугацаа нисэх мэт өнгөрч нэг л мэдэхэд тэтгэврийн насанд хүрсэн байна. Тиймээс аль болох залуу насандаа тэтгэврийн төлөвлөлт хийж эхлэх нь зүйтэй. Тэтгэврийн төлөвлөлт нь таны амьдралд тохиолдож болох гэнэтийн өөрчөлтүүдээс үл хамааран өөрийн ирээдүйгээ сайтар төлөвлөж удирдах боломжийг танд олгоно.

Манай зарим иргэд тэтгэврийн төлөвлөлт эхлэхэд арай эрт, бүр дэндүү эрт байна гэж бодон дараах алдаатай бодлыг сэтгэлдээ тээж явдаг. Үүнд:

1. Өнөөдөр би ид хийж бүтээх насандаа явна. Би одоо 20 настай. Юун 35-40 жилийн дараах тэтгэвэр ярина вэ?
2. Өнөөдөр өөрийн тэтгэвэртээ зориулж хуримтлал үүсгэхэд хэтэрхий эрт байна.
3. Тэтгэвэрт гарах хүртлээ хангалттай мөнгө хуримтлуулах хугацаа надад байна.
4. Тэтгэврийн насны хүний зарлага өндөр биш учир санаа зовоод байх зүйлгүй.
5. Нийгмийн даатгалаас тэтгэврээ тухайн үед нь авна. Тэтгэвэрт гарсны дараа нийгмийн даатгал болон нийгмийн халамжаас зохих хөнгөлөлт эдэлнэ гэх мэт.

№	Үзүүлэлтүүд		Дүн төгрөгөөр	
1.	Хөрөнгө	Мөнгөн хөрөнгө	Бэлэн мөнгө (төгрөг)	500`000
			Төгрөгийн хадгаламж	2`000`000
			Валютын хадгаламж	-
			Хадгаламжийн сертификат	-
			Бэлэн валют	-
		Санхүүгийн хөрөнгө оруулалт	ЗГ-ын бонд	200`000
			Компанийн бонд	-
			Компанийн хувьцаа	1`000`000
		Амьдралын даатгал	Даатгалын үнэлгээ	5`000`000
		Тэтгэврийн даатгал	Даатгалын үнэлгээ	5`000`000
		Байгууллагын тэтгэврийн сан	Байгууллагын тэтгэвэр	-
		Үндсэн хөрөнгө	Орон сууц	70,000,000
			Зуслангийн байр	-
			Тавилга эд хогшил	5`000`000
			Цуглуулга (уран зураг, түүхийн дурсгалт, эд өлгийн зүйл)	500`000
			Үнэт эдлэл	1`000`000
			Автомашин	6`000`000
Ажлын байр	-			
Бусад	Зээлийн авлага (найздаа өгсөн зээл, үндсэн зээл, хүүгийн төлбөр)	500`000		
Нийт хөрөнгийн дүн			96`700`000	
2.	Өглөг	Зээлийн өглөг	Орон сууцны зээлийн үлдэгдэл	20`000`000
			Автомашинны зээлийн үлдэгдэл	-
			Цалингийн зээлийн үлдэгдэл	1`000`000
			Бусад зээл	500`000
		Бусад өглөг	Оюутны сургалтын төлбөрийн өглөг	-
			Татварын өглөг	-
			НДШ-ийн өглөг	-
			Бусад өглөг	200`000
Нийт өглөгийн дүн			21`700`000	
Цэвэр хөрөнгийн дүн			75`000`000	

Та тэтгэврийн жилүүдээ санхүүгийн хувьд эрх чөлөөтэй, тав тухтай, аз жаргалтай, тайван амгалан байлгахыг хүсч байгаа бол тодорхой хэмжээний мөнгөн

хуримтлалтай байх хэрэгтэй. Иймээс тэтгэвэрт гарсны дараа хэн нэгнээс санхүүгийн хувьд хараат амьдрахгүйн тулд яг одооноос тэтгэврийн төлөвлөлт хийж, мөнгөн хуримтлал үүсгэж эхлэх нь зүйтэй. Аль болох нас залуу байхдаа мөнгөн хуримтлал хийж эхэлбэл өөрт тань ашигтай байх болно.

Таны тэтгэврийн төлөвлөлтийн нэг хэсэг нь санхүүгийн эрх чөлөөтэй байх асуудал байхад нөгөө талд нь урт хугацааны зорилгууд байх хэрэгтэй. Тэтгэврийн төлөвлөлтөө хийж эхлэхийн өмнөхөн та өөрийн санхүүгийн байдалдаа шинжилгээ хийхийг оролдоод үз. Өөрийн цэвэр хөрөнгийн дүнг гарга. Өөрийн цэвэр хөрөнгийг гаргахдаа нийт хөрөнгийн дүнгээс өглөгөө хасна. Үүнийг хүснэгт 15-1-д жишээгээр харууллаа.

Тухайн хүний тэтгэвэрт гарах нас дөхөх тусам цэвэр хөрөнгийн дүн нь өсч байвал сайн байдаг. Иймд өөрийн санхүүгийн байдалдаа тогтмол хяналт тавьж, тооцож сурах нь чухал. Тэтгэврийн жилүүдэд зардлын бүтэц, хэмжээнд өөрчлөлт гардаг тул санхүүгийн хувьд эрх чөлөөтэй амьдрахад хичнээн хэмжээний мөнгө хэрэгтэй болохоо тооцох нь чухал. Тухайлбал, амралт, зугаалгад зарцуулах зардал, тээврийн зардал, хувцасны зардал тус тус буурч, харин эсрэгээр эрүүл мэнд, асаргаа, сувилалд зарцуулах зардал ихэвчлэн өсдөг.

Тэтгэврийн төлөвлөлтөө хийхийн тулд одооноос эхлэн хувийн санхүүгээ төлөвлөх хэрэгтэй. Үүний тулд дараах алхмуудыг хийх шаардлагатай. Үүнд:

1. **Тэтгэврийн төлөвлөлт хийж эхэлж буй үеийн санхүүгийн нөхцөл байдлаа үнэлнэ.** Хувийн болон гэр бүлийн санхүүгийн тайлангаа гаргах замаар хувийн болон өрхийн орлого, зарлагаа тооцож үзэх хэрэгтэй. Мөнгөө зарцуулах төлөвлөгөө гаргах, олсон орлого, гаргасан зардлаа залхууралгүйгээр нэг бүрчлэн бичиж хөтлөх хэрэгтэй. НӨАТ-ын E-barimt хөтөлж байгаа үед хувийн болон өрхийн зардлын хуваарилалт ямар байгааг харах замаар дүгнэлт хийх нь зөв. Ирээдүйд орлогоо нэмэгдүүлэхийн тулд мэргэжил боловсролоо хэрхэн дээшлүүлэх талаар бодит тооцоолол хийж үзэх нь чухал.
2. **Өөрийн өмнөө тавьж буй зорилгоо зөв тодорхойлох нь зүйтэй.** Жишээ нь, ирэх 5 жилд орон сууцны урьдчилгаа төлбөрт зарцуулах хангалттай хэмжээний хуримтлалтай болно, 5 жилийн дараа орон сууцны зээлд хамрагдан өөрийн гэсэн орон сууцтай, машинтай болно, Гуч хүртлээ мэргэжил боловсролоо дээшлүүлнэ, гэр бүлтэй болно, хуримаа хийнэ, хүүхэдтэй болно, байгууллагадаа чухал мэргэжилтэн нь болно, өөрийн ажлын байртай болно, сонирхолдоо түшиглэн өөрийн гэсэн бизнестэй болно, магистр, докторын зэрэг хамгаална, мэргэшсэн нягтлан бодогч болно, тавин таван нас хүрээд тэтгэвэрт гарахдаа 60 сая төгрөгийн хадгаламжтай болно гэх мэт олон зорилго тавьж болно.
3. **Өөрийн зорилгыг биелүүлэх төлөвлөгөө боловсруулна.** Ямар санхүүгийн байгууллагад ямар төрлийн хадгаламж байршуулах, ямар хөрөнгө оруулалт хийх, ямар компанийн хувьцаа худалдах авах, хэмнэлтийг ямар үед хийх, өдрийн орлого, зарлагаа тэмдэглэн хөтөлж занших, 7 хоног, сараар нь хэрхэн

тооцоолж үзэх, гарцаагүй хэрэгцээ, хүсэл хоёрыг ялгаж сурах гэх мэт. Бусдын эдэлж хэрэглэж, өмсөж зүүж байгааг та дуурайх албагүй. Бусдыг дуурайж та тамхи татах хэрэггүй. Тамхи бол хэрэгцээ биш.

4. **Гаргасан төлөвлөгөөгөө амьдралд хэрэгжүүлнэ.** Өмнөө тавьсан зорилгодоо хүрэхийн тулд өөрөө өөртөө үнэнч байх, ямар ч бэрхшээлийн өмнө гуйвалтгүй тууштай байх чадвар эзэмших нь чухал. Мөнгөө хэмнэж хуримтлал үүсгэх, хуримтлалыг хэвшил болгох хэрэгтэй. Та өөрөө болон таны ойр дотны хүмүүсээс хэн нэгэн нь гэнэт өвдөх, яаралтай мөнгөний хэрэгцээ гарах үед та мөнгөн хадгаламж, хуримтлал хийсэн нь ямар ач холбогдолтой зүйл байсныг ойлгох болно. Онцын шаардлагагүй бол банкнаас эсвэл хэн нэгнээс мөнгө зээлэхээс аль болох зайлсхийх нь зүйтэй. Гарцаагүй тохиолдолд сайтар тооцоо хийсний эцэст зээл авах шийдвэрээ гаргах нь зөв. Зээл авсан хүн зээлийн үндсэн төлбөрөөс гадна зээлийн хүү төлнө. Хэрвээ та зээлийн гэрээнд заасан хугацаанд төлбөрөө хийж чадахгүйд хүрвэл хугацаа хэтэрсэн хоног тутамд нь тодорхой хэмжээний алданги, торгууль төлөх болно. Зээл бол сэтгэлийн хөөрлөөр авдаг зүйл биш юм.
5. **Төлөвлөгөөнийхөө биелэлтэд хяналт тавьж, тодотгол хийнэ.** Таны боловсруулсан төлөвлөгөөнд танаас хамаарах болон үл хамаарах шалтгаанаас олон янзын бэрхшээл, саад тулгарч биелэгдэх боломжгүй болсны улмаас зайлшгүй тодотгол хийх шаардлага гарч болно. Аливаа нэг бэрхшээлээс болж зорилгоосоо ухарч болохгүйг санах хэрэгтэй. Таны амьдрал бол зөвхөн таны амьдрал. Өөр хэн нэгэнд найдаж хэрэггүй. Үргэлж хэн нэгэн танд туслахыг, бэлэг, мөнгө өгөхийг хүлээж суулгүйгээр өөртөө найдаж амьдарч сур. Мөн хүн бүрд өөрийн гэсэн амьдрал байдаг. Хэн нэгэн таны төлөө бүхнээ зориулах албагүй гэдгийг энд хэлье.

Тэтгэврийн төлөвлөлт нь мөнгийг зөв удирдах, мөнгийг хэрхэн яаж олох, түүнийгээ зөв зүйтэй захиран зарцуулах, хадгалах, өсгөж аривжуулах талаар илүү ухаалаг шийдвэр гаргаж ажиллахыг танаас шаардана. Тэтгэврийн төлөвлөлт хийснээр өөрийн санхүүгийн байдлаа үндэслэлтэй хянах боломжтой болно. Санхүүгийн аливаа эрсдэлээс сэргийлнэ. Санхүүгийн хувьд хэн нэгнээс хараат байдал багасна. Ирээдүйдээ итгэх итгэл нэмэгдэж, өөдрөг сайхан амьдрах болно.

15.2. Тэтгэврийнхээ орлогоор амьдрах нь

Энэ сэдвийг гүнзгийрүүлэн судлахын тулд эхлээд нийгмийн даатгалын талаар ойлгох нь чухал. Нийгмийн даатгалын төрлөөс бид тэтгэврийн даатгалын тухай онцлон ярилцах болно.

Иргэн болон ААНБ, төрөөс зохих журмын дагуу шимтгэл төлж, нийгмийн даатгалын сан бүрдүүлэх, даатгуулагч өндөр наслах, хөдөлмөрийн чадвараа алдах, өвчлөх, ажилгүй болоход өөрт нь, тэрчлэн даатгуулагч нас барахад түүний асрамжид байсан хүмүүст хууль тогтоомжид заасан тэтгэвэр, тэтгэмж, төлбөр өгөх агуулга бүхий нийгэм эдийн засгийн арга хэмжээг нийгмийн даатгал гэж хэлнэ.

Нийгмийн даатгал: Даатгуулагч өндөр наслах, өвдөх, ажилгүй болох зэргээр орлого олох боломжгүй болсон үед нь орлогоор хангах зорилго бүхий төрөөс хэрэгжүүлж буй арга хэмжээ.

Нийгмийн даатгал нь 5 төрөлтэй бөгөөд төрөл тус бүр бие даасан сантай байна. (Зураг 15-1-ийг харна уу). Нийгмийн даатгал нь бусад даатгалын адил заавал ба сайн дураар даатгуулах гэсэн хэлбэртэй байна.

Зураг 15-1. Нийгмийн даатгалын төрөл ба сан



Зураг 15-2. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага



Нийгмийн даатгалын сан нь орлого, зарлага гэсэн хоёр талтай. Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлагын бүтцийг Зураг 15-2-т харуулав.

Хүснэгт 15-2. Нийгмийн даатгалд заавал даатгуулахад төлөх НДШ-ийн хувь хэмжээ

№	Нийгмийн даатгалын төрөл	Ажил олгогчийн хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос (%)	Даатгуулагчийн хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогоос (%)
1.	Тэтгэврийн даатгалын сан	7.0	7.0
2.	Тэтгэмжийн даатгалын сан	0.8	0.8
3.	Эрүүл мэндийн даатгалын сан	2.0	2.0
4.	ҮОМШӨ-ний даатгалын сан	1.0, 2.0, 3.0	-
5.	Ажилгүйдлийн даатгалын сан	0.2	0.2
	Нийт дүн	11.0, 12.0, 13.0	10

Байгууллагатай хөдөлмөрийн гэрээгээр ажиллаж байгаа иргэд нийгмийн даатгалд заавал даатгуулна. Даатгуулагчийн төлөх НДШ-ийн хэмжээ нь тухайн даатгуулагчийн сарын цалин түүнтэй адилтгах орлогоос 10%, ажил олгогчийн хувьд 11-13% байна.

Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахад иргэн сарын орлогоо өөрөө тодорхойлох бөгөөд түүнээсээ 12 хувиар тооцож НДШ төлнө. Одоо мөрдөгдөж буй хуулиар нийгмийн даатгалд сайн дураар даатгуулагч иргэн жилд эрүүл мэндийн даатгалын шимтгэлд 46`080 төгрөг төлөх ба ажилгүйдлийн даатгалын шимтгэлийг төлдөггүй. Оюутнууд сайн дураараа НДШ төлж болох бөгөөд жилдээ 23`040 төгрөг төлнө.

Хүснэгт 15-3. Нийгмийн даатгалд сайн дураар даатгуулахад төлөх НДШ-ийн хувь хэмжээ

№	Нийгмийн даатгалын төрөл	Төлөх шимтгэлийн хувь хэмжээ (%)
1.	Тэтгэврийн даатгалын сан	10.0
2.	Тэтгэмжийн даатгалын сан	1.0
3.	ҮОМШӨ-ний даатгалын сан	1.0
	Нийт дүн	12.0

ТАНЫ МЭДЛЭГТ

2015 оны эцсийн байдлаар Монгол Улсын хэмжээгээр нийт тэтгэвэр авагчдын 69.3 хувь нь өндөр насны тэтгэвэр авагчид байсан. Эдгээр хүмүүст нийт олгосон тэтгэврийн 72.4 хувь нь ногдож байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өндөр насны тэтгэвэр авагчдын тоо 9.6 хувиар өсчээ.

Эх сурвалж: Монгол Улсын Статистикийн эмхэтгэл. 2015

15.3. Өндөр насны тэтгэврийн тухай ойлголт

Өндөр насны тэтгэвэр:

Өндөр насны тэтгэвэр тогтоолгох болзол хангаж, тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчид тэтгэврийн даатгалын сангаас сар бүр олгож буй мөнгөн хөрөнгө.

Өндөр насны тэтгэвэр нь тэтгэврийн даатгалд даатгуулсан тэтгэвэр тогтоох насны болон шимтгэл төлөх хугацааны болзол хангасан иргэнд хөдөлмөрийн хөлсний орлогоос нь тодорхой хувь хэмжээгээр тооцож, тэтгэврийн даатгалын сангаас насан туршид нь амьжиргааны эх үүсвэр болгон сар бүр олгогдоно.

Тэтгэвэр нь дараах онцлогтой. Үүнд:

1. Амьжиргааны үндсэн эх үүсвэр
2. Насан туршид нь олгогддог

Өндөр насны тэтгэвэр тогтоолгох эрх. Нийтдээ 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй. Мөн төрүүлсэн болон 3 хүртэл настайд нь үрчлэн авсан 4 түүнээс дээш хүүхдийг 6 настай болтол өсгөсөн эх 20-иос доошгүй жил тэтгэврийн даатгалын шимтгэл төлж, 50 нас хүрсэн бол өндөр насны тэтгэвэр тогтоолгон авах эрхтэй.

Газрын дор болон хөдөлмөрийн хортой, хүнд, халуун нөхцөлд ажилласан даатгуулагч дор дурдсан нөхцөлийг хангасан бол өндөр насны тэтгэврийг тогтоолгон авах эрхтэй. Үүнд:

- ✓ Нийтдээ 20-иос доошгүй жил үүнээс 10-аас доошгүй жил нь газрын дор ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас хүрсэн бол⁷⁰
- ✓ Нийтдээ 20-иос доошгүй жил үүнээс 10-аас доошгүй жил нь хөдөлмөрийн хортой, халуун нөхцөлд ажиллаж тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эрэгтэй 55 нас хүрсэн бол, мөн түүнчлэн нийтдээ 20-иос доошгүй жил үүнээс 7 жил 6 сараас доошгүй хугацаагаар мөн нөхцөлд ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн эмэгтэй 50 нас хүрсэн бол⁷¹

Тэтгэврийн насанд хүрээгүй боловч шимтгэл төлөх хугацааг хангаад цаашид тэтгэврийн даатгалын шимтгэл төлөхөө зогсоосон байхад түүний уг насанд хүрээд өндөр насны тэтгэврээ тогтоолгон авах эрх нь хадаглагдана.

Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-20 жил хүртэл төлсөн 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй шимтгэл төлсөн нийт хугацаандаа ногдох өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй⁷².

⁷⁰ Монгол Улсын хууль, (1994). Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, 4.3.1-р заалт

⁷¹ Монгол Улсын хууль, (1994). Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, 4.3.2-р заалт

⁷² Монгол Улсын хууль, (1994). Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай, 4.5-р заалт

Мэргэжлийн урлагийн байгууллагад ажиллаж буй уран бүтээлчдийн өндөр насны тэтгэвэр хэвийн, газрын дор болон хөдөлмөрийн хортой, хүнд, халуун нөхцөлд ажилласан даатгуулагчдыг бодвол онцлогтой тогтоогддог. Үүнд:

Урлагийн тэтгэвэр. Сонгодог болон мэргэжлийн урлагийн байгууллагад гоцлол дуучин, бүжигчин, агаарын болон хэрэглээний гимнастик, акробат, тэнцвэр, уран нугаралт, хүнд жингийн үзүүлбэрийн жүжигчин, зэрлэг араатан, ан амьтан сургагч, тоглуулагч, хөөмийчин, найрал хөгжимчний үлээвэр хөгжимчнөөр 20-иос доошгүй жил ажилласан эсвэл нийтдээ 25-аас доошгүй жил ажилласны дотор 15-аас доошгүй жилийг нь уг мэргэжлээр ажиллаж, тэтгэврийн даатгалын шимтгэл төлсөн даатгуулагч өөрөө хүсвэл нас харгалзахгүйгээр өндөр насны тэтгэвэр авах эрхтэй. Сонгодог, мэргэжлийн урлагийн байгууллагуудад дараах байгууллагууд орно. Үүнд:

1. Дуурь бүжгийн эрдмийн театр
2. Улсын драмын эрдмийн театр
3. Монголын үндэсний дуу бүжгийн чуулга
4. Үндэсний дуу бүжгийн “Түмэн эх” чуулга
5. Бүх цэргийн дуу бүжгийн чуулга
6. Хилийн цэргийн дуу бүжгийн чуулга
7. Улсын филарамони
8. Улсын цирк
9. Төмөр замчдын дуу бүжгийн чуулга
10. Аймгуудын хөгжимт драмын театр гэх мэт

Өндөр насны тэтгэвэр тогтоох зарчим. Өндөр насны тэтгэвэр тогтоолт нь өөрийн гэсэн зарчимтай. Үүнд:

1. Өндөр насны тэтгэврийг насан туршид нь олгох
2. Ажилласан жилийн болзол хангасан байх
3. Иргэдийн тэтгэвэр тогтоох насанд хүрсэн байхыг шаардах
4. Өнгөрсөн хөдөлмөрийн үйл ажиллагаанаас хамааралтайгаар тодорхой авч байсан хөдөлмөрийн хөлс, орлогын сарын дунджаас зохих хувь хэмжээгээр бодож тогтоодог

Өндөр насны тэтгэврийн хэмжээ, нэмэгдэл. Өндөр насны тэтгэвэр нь үндсэн болон нэмэгдэл тэтгэвэр байна. Өндөр насны тэтгэвэр тогтоох болзол, нөхцөлийг хангасан даатгуулагчийн өндөр насны бүрэн тэтгэврийг НДШ төлсөн сарын дундаж хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын 45 хувиар тогтооно. Тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20-иос илүү жил төлсөн жил тутамд нь өндөр насны тэтгэвэр тогтоолгосон хөдөлмөрийн хөлс түүнтэй адилтгах орлогын 1,5 хувиар нэмэгдэл олгоно. Тахир дутуугийн тэтгэвэр авч байгаад өндөр насны тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчийн тэтгэврийг хөдөлмөрийн чадвараа бүрэн алдсан жил тутамд 1 хувиар бодож нэмэгдүүлнэ.

Тэтгэврийн хэмжээг тухайн даатгуулагчийн тэтгэврээ бодуулахаар сонгосон сүүлийн 10 жилийн дараалсан 5 жилийн сарын дундаж цалингаас бодно. Даатгуулагчийн тэтгэврээ тогтоолгох сарын хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээ нь тухайн үеийн хөдөлмөрийн хөлсний доод хэмжээг 10 дахин нэмэгдүүлж тооцсонтой тэнцүү байна. Жишээ нь, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 192`000 төгрөг гэвэл даатгуулагчийн тэтгэврээ тогтоолгох сарын хөдөлмөрийн хөлсний дээд хэмжээ нь 1`920`000 төгрөг байна гэсэн үг. Хэрвээ хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ 240`000 төгрөг болвол тэтгэврээ бодох сарын дундаж цалингийн дээд хэмжээ нь 2`400`000 төгрөг болно гэсэн үг юм.

Өндөр насны тэтгэврээ авч буй иргэн тэтгэврээ тогтоолгосноос хойш шимтгэл төлж ажилласан бол нийт ажилласан хугацаагаар тэтгэврийг өөрчлөн нэмэгдэл олгоно.

Өндөр насны тэтгэврээ авч буй иргэн тэтгэврээ тогтоолгосноос хойш ажиллаж байгаа бол цалин түүнтэй адилтгах орлогоосоо дараах шимтгэлийг төлнө. Үүнд:

1. Тэтгэврийн даатгалын шимтгэл 7%
2. Тэтгэмжийн даатгалын шимтгэл 0.8%

Өөрөөр хэлбэл, өндөр насны тэтгэврээ авч буй иргэн тэтгэврээ тогтоолгосноос хойш ажиллаж байгаа бол цалин түүнтэй адилтгах орлогоосоо нийтдээ 7.8 хувийн шимтгэл төлнө гэсэн үг юм. Өндөр насны тэтгэврийн хэмжээ нь тухайн даатгуулагчийн тэтгэврээ бодуулахаар сонгосон сүүлийн 10 жилийн дараалсан 5 жилийн сарын дундаж цалингийн хэмжээ, нийт ажилласан жил ямар байгаагаас шууд хамаарна.

Өндөр насны тэтгэврээ бодох журам. Өндөр насны тэтгэврээ нь дотроо:

1. Өндөр насны бүрэн тэтгэврээ
2. Өндөр насны хувь тэнцүүлсэн тэтгэврээ гэж байна

Хэрвээ та тэтгэврийн даатгалын шимтгэлийг 20 жил ба түүнээс дээш жил төлсөн 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй бол өндөр насны бүрэн тэтгэврийг тогтоолгож авах эрхтэй. Харин тэтгэврийн даатгалын шимтгэлийг 10-20 жил хүртэл төлсөн 60 нас хүрсэн эрэгтэй, 55 нас хүрсэн эмэгтэй шимтгэл төлсөн нийт хугацаандаа ногдох өндөр насны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгож авах эрхтэй. 2016 оны байдлаар өндөр насны бүрэн тэтгэврийн доод хэмжээ нь 251`000 төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ нь 216`000 төгрөг байна.

Өндөр насны бүрэн тэтгэврийг дараах томъёогоор тооцно. Үүнд:

$$T = Sa \times [P + 1.5 \times (V - 20)]$$

Энд:

T - Өндөр насны бүрэн тэтгэврийн хэмжээ

Sa – Даатгуулагчийн тэтгэврээ бодуулахаар сонгосон сүүлийн 10 жилийн дараалсан 5 жилийн сарын дундаж цалин

P – 20 жил шимтгэл төлсөн даатгуулагчийн тэтгэвэр бодох хувь

1.5 – 20-иос илүү жил ажилласны нэмэгдэл

V - Шимтгэл төлсөн нийт жил

20 - Өндөр насны бүрэн тэтгэвэр тогтоох болзолт жил

Жишээ нь, даатгуулагч А нийтдээ 39 жил ажиллаж 60 нас хүрээд тэтгэвэртээ гарах хүсэлт гаргасан. Сарын дундаж цалин 1`920`000 төгрөг гэвэл өндөр насны тэтгэврийн хэмжээг бодож үзье. Үүнд:

$$T = Sa \times [P + 1.5\% \times (V - 20)]$$

$$T = 1`920`000 \times [45\% + 1.5\% \times (39 - 20)] = 1`411`200 \text{ төгрөг}$$

Даатгуулагч А-д өндөр насны бүрэн тэтгэвэрт сард 1`411`200 төгрөг тогтоож олгоно.

Жишээ нь, даатгуулагч С нийтдээ 20 жил ажиллаж 55 нас хүрээд тэтгэвэртээ гарах хүсэлт гаргасан. Сарын дундаж цалин 400`000 төгрөг гэвэл өндөр насны тэтгэврийн хэмжээг бодож үзье. Үүнд:

$$T = Sa \times [P + 1.5\% \times (V - 20)]$$

$$T = 400`000 \times [45\% + 1.5\% \times (20 - 20)] = 180`000 \text{ төгрөг}$$

Даатгуулагч С-д өндөр насны бүрэн тэтгэвэрт сард 180`000 төгрөг олгохоор байгаа боловч энэ нь тухайн үеийн бүрэн тэтгэврийн доод хэмжээ болох 251`000 төгрөгнөөс бага дүнтэй байгаа тул 251`000 төгрөгийн тэтгэврийг олгох болно.

Өндөр насны хувь тэнцүүлсэн тэтгэврийг дараах томъёогоор тооцно. Үүнд:

$$T = (Sa \times C_m \times P) / 240$$

Энд:

T – Өндөр насны хувь тэнцүүлсэн тэтгэврийн хэмжээ

Sa – Сарын дундаж цалин

Cm - Шимтгэл төлсөн сарын тоо

P - 20 жил шимтгэл төлсөн даатгуулагчийн тэтгэвэр бодох хувь

240 – Шимтгэл төлбөл зохих нийт сарын тоо

Жишээ нь, даатгуулагч А нийтдээ 19 жил ажиллаж 55 нас хүрээд тэтгэвэртээ гарах хүсэлт гаргасан. Сарын дундаж цалин 800`000 төгрөг гэвэл өндөр насны тэтгэврийн хэмжээг бодож үзье. Үүнд:

$$T = (Sa \times C_m \times P) / 240$$

$$T = (800`000 \times 228 \times 45\%) / 240 = 342`000 \text{ төгрөг}$$

Даатгуулагч А-д өндөр насны хувь тэнцүүлсэн тэтгэвэрт сард 342`000 төгрөг тогтоож олгоно.

Жишээ нь, даатгуулагч С нийтдээ 10 жил ажиллаж 55 нас хүрээд тэтгэвэртээ гарах хүсэлт гаргасан. Сарын дундаж цалин 500`000 төгрөг гэвэл өндөр насны тэтгэврийн хэмжээг бодож үзье. Үүнд:

$$T = (S_a \times C_m \times P) / 240$$

$$T = (500`000 \times 120 \times 45\%) / 240 = 112`500 \text{ төгрөг}$$

Даатгуулагч С-д өндөр насны хувь тэнцүүлсэн тэтгэвэрт сард 112`500 төгрөг олгохоор байна. Энэ нь тухайн үеийн хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ болох 216`000 төгрөгнөөс бага дүнтэй байгаа тул 216`000 төгрөгийн тэтгэврийг олгох болно.

Өндөр насны тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх материал

Өндөр насны тэтгэвэр авах гэж буй иргэд өндөр насны тэтгэвэрт гарахаасаа 1-2 сарын өмнө өөрсдийн харъяа дүүргийнхээ “Нийгмийн даатгалын хэлтэс” дээр очиж, өндөр насны тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх материалын талаар мэргэжлийн хүнээс нь зөвлөгөө авч, материалаа үнэн зөв бүрдүүлэх нь хугацаандаа тэтгэврээ авах боломжийг бүрдүүлнэ. Өндөр насны тэтгэвэр тогтоолгоход бүрдүүлэх материалд дараах зүйлүүд орно. Үүнд:

- Хүсэлт өргөдөл
- Даатгуулагчийн 1995 оноос өмнө ажиллаж байсан хугацааны хөдөлмөрийн дэвтэр
- Даатгуулагчийн нийгмийн даатгал (НД)-ын дэвтэр
- Даатгуулагчийн шимтгэл төлж ажилласан сүүлийн 10 жилийн дараалсан 5 жилийн хөдөлмөрийн хөлсний тодорхойлолт
- Шаардлагатай бол 1995 оноос өмнө ажиллаж байсан хугацааны үндсэн байгууллагын тушаалын хуулбар
- Цэргийн батлах, архивын лавлагаа
- Даатгуулагчийн ажилласан хугацааг сэргээн тогтоосон шүүхийн шийдвэр
- Хүүхдийн төрсний гэрчилгээний эх хуулбар
- Зураг 2 хувь (3x4)
- Иргэний үнэмлэх
- Оршин сууж буй хорооны тодорхойлолт гэх мэт

Өндөр насны тэтгэврийн талаар мэдвэл зохих зүйлүүд:

1. Та эмэгтэй бол 55 нас, эрэгтэй бол 60 нас хүрээд харъяа дүүргийн Нийгмийн халамжийн газраас нийтийн тээврээр үнэгүй зорчих хөнгөлөлтийн картаа авах эрхтэй болно.
2. Өндөр насны тэтгэвэр авч буй иргэн нас барвал оршуулгын тэтгэмж болох 1 сая төгрөгийг ар гэрт нь олгоно.
3. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед 3 жил цэргийн алба хаасан хүнийг улсад 3 жил ажилласанд тооцно.

4. Төвлөрсөн төлөвлөгөөт эдийн засгийн үед Техник мэргэжлийн сургуульд сурч байсан хугацааг ажилласан жилд тооцно.
5. Иргэн сард 1 удаа эрүүл мэндийн даатгалын сангийн зардлаар 55`000 төгрөгийн шинжилгээ хийлгэх эрхтэй.
6. Өндөр настан жилд нэг удаа ахмадын сувилалд, ахмадын амралтад тус тус 50%-ийн хөнгөлөлттэй үнээр сувилуулах, амрах эрхтэй.
7. Эрүүл мэндийн даатгалаас хөнгөлөлттэй үнээр эм авна.
8. Алдар цолтой ахмадууд тусламж авна.
9. Алдарт эхийн одонтой ээжүүд нийгмийн халамжийн үйлчилгээ, хөнгөлөлтийн зардлаас тусламж авна.
10. Ахмад настныг асарч буй иргэн мөнгөн тэтгэмж авна.
11. Та сургуулиа төгсөөд ажилд орж ажил олгогчтойгоо хөдөлмөрийн гэрээ байгуулах болон ажлаас халагдах үедээ тухайн байгууллагын удирдлагаас гаргасан ажилд авах болон ажлаас халах, чөлөөлөх тухай тушаалыг нийгмийн даатгалын дэвтэр дээрээ бичигдсэн эсэхийг нь хянах, тушаалынх нь нэг хувийг хувилж авахад илүүдэхгүй. Хожим нь тэтгэвэр тогтоолгох үед хэрэг болно.
12. Төрийн байгууллагын албан хаагчид, эрүүл мэнд, боловсролын салбарт ажиллагсад, цэргийн албан хаагчид тэтгэвэрт гарахдаа нэг удаагийн тэтгэмж авдаг.

Өөр бидний гарцаагүй мэдэж байх зүйлийн нэг нь Тэтгэврийн даатгалын нэрийн данс юм.

15.3. Тэтгэврийн даатгалын нэрийн дансны тухай

1999 оны 7-р сард “Тэтгэврийн даатгалын нэрийн дансны тухай” хууль гарсан. Тэтгэврийн даатгалын шимтгэлийн нэрийн данс гэдэг нь тэтгэврийн даатгалын шимтгэл төлж байгаа иргэн бүрийн нэр дээр нийгмийн даатгалын байгууллага данс нээж, уг дансанд даатгуулагчийн цалин хөлс, орлого, түүнээс ямар хэмжээний шимтгэл хэдийд төлсөн болон уг шимтгэлд ногдуулсан хүү, хуримтлалын ашиг зэргийг бүртгэх замаар даатгуулагчийг өөрийнх нь ирээдүйд авах тэтгэвэртэй холбогдсон бүхий л мэдээллээр хангах арга хэрэгслийг хэлнэ.

Тэтгэврийн даатгалын нэрийн дансны онцлог нь даатгуулагчийн ирээдүйд авах тэтгэвэр нь түүний ажиллах хугацаандаа авч байсан цалин дээр биш, харин түүний төлсөн шимтгэл дээр үндэслэдэгт оршино.

Тэтгэврийн даатгалын нэрийн данснаас өндөр насны тэтгэврийг тооцохдоо: Нэрийн дансны орлого, даатгуулагчийн тэтгэвэр авах дундаж хугацааг харгалзан дараах томъёогоор бодно. Үүнд:

$$T = X/K/12$$

Энд:

T - Сарын тэтгэврийн хэмжээ

X - Нэрийн дансны нийт орлого

K - Тэтгэвэр авах дундаж хугацааны илэрхийлэл

Одоогоор тэтгэврийн даатгалын нэрийн данснаас өндөр насны тэтгэвэр бодогдож эхлээгүй байна. Хойшид тэтгэврийн даатгалын нэрийн данснаас өндөр насны тэтгэвэр бодогдож эхлэхэд анхаарах зүйлийн нэг нь НДШ хэлбэрээр уг дансанд байршуулсан мөнгөний хэмжээ юм. Өөрөөр хэлбэл нэрийн дансанд байгаа мөнгөний хэмжээнээс таны авах тэтгэврийн хэмжээ хамаарна гэсэн үг.

15.4. Цэргийн албан хаагчдын тэтгэврийн тухай ойлголт

Хэрвээ та цэргийн албан хаагч болох гэж байгаа бол өндөр настай болсон хойноо цэрэгт алба хаасны тэтгэвэр авах болно. Цэргийн алба хаасны тэтгэвэр нь энгийн иргэдийн өндөр насны тэтгэврээс ялгаатай. Үүнд:

Цэргийн албан хаагч гэж хэн вэ? Цэргийн албан хаагчид зэвсэгт хүчин, хилийн цэрэг, тагнуулын байгууллага, цагдаа, шүүхийн шинжилгээний газар, авилгатай тэмцэх газар, онцгой байдал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын байлдагчаасаа генерал хүртэлх албан хаагчид, дайчилгааны цугларалтанд оролцож байгаа цэргийн үүрэгтэн, цэрэг, цагдаагийн сургуулийн сонсогчид тус тус орно.

Цэргийн алба хаасны тэтгэвэр. Цэргийн алба хаасны тэтгэврийг цэрэгт алба хаасан хугацаанаас нь хамаарч бүрэн болон хувь тэнцүүлсэн тэтгэврийг олгодог. Цэргийн албан хаагч нь нас харгалзахгүйгээр цэргийн алба хаасны тэтгэврийг авах эрхтэй. Үүнд:

- 25-аас доошгүй жил алба хаасан эрэгтэй
- 20-иос доошгүй жил алба хаасан эмэгтэй
- Байлдааны нисдэг тэрэгний нисэгчээр 23-аас доошгүй жил цэргийн алба хаасан, байлдааны тийрэлтэт сөнөөгч онгоцны жинхэнэ нисэгчээр 20-иос доошгүй жил цэргийн алба хаасан даатгуулагч

Хувь тэнцүүлсэн тэтгэвэр. 10-аас доошгүй жил цэргийн алба хаасан цэргийн албан хаагч нь дор дурдсан шалтгаанаар халагдсан бол цэргийн алба хаах насны хязгаарт хүрээд цэргийн алба хаасны тэтгэврийг хувь тэнцүүлэн тогтоолгон авах эрхтэй. Үүнд:

- Орон тоо зохион байгуулалтын өөрчлөлтөөр
- Биеийн эрүүл мэндээр
- Цэргийн алба хаах нас хэтэрсэн

Цэргийн алба хаасны тэтгэврийн хэмжээ, нэмэгдэл. Цэргийн алба хаасны тэтгэврийг тэтгэвэр тогтоолгогчийн сарын дундаж цалин хөлсний 80 хувиар тогтооно. 20-иос илүү алба хаасан жил тутамд тэтгэвэр тогтоолгосон сарын дундаж цалин хөлсний 1.5 хувиар тэтгэврийн нэмэгдэл олгоно.

Цэргийн алба хаасны тэтгэвэр тогтоолгосон боловч 12 сараас доошгүй хугацаанд хөдөлмөр эрхэлж, НДШ төлсөн тэтгэвэр авагч хүсэлтээ гаргасан тохиолдолд тэтгэврийн хэмжээг анхны тэтгэвэр тогтоолгосон дундаж цалингаас бодож

тэтгэврийг өөрчлөн тогтооно. Өөрөөр хэлбэл, тэтгэврийн нэмэгдэл авна гэсэн үг юм. Цэргийн албан хаагч нь нас харгалзахгүй тэтгэвэрт гарна. Энгийн газар ажиллаж байсан иргэн цэргийн албан хаагч болсон бол энгийн газар ажилласан 1 жилийг цэргийн албанд 6 сар алба хаасанд тооцох ба цэргийн албанд ажиллаж байсан албан хаагч энгийн газар шилжин ажилласан бол цэргийн албанд ажилласан 1 жилийг энгийн газарт 1 жил 6 сар ажилласанд тооцож, тэтгэврээ аль өндөр гарснаар тогтоолгож болно.

Бид тэтгэврийг хэрхэн тооцдог талаар авч үзлээ. Одоо тэтгэврийн төлөвлөлтийн дараагийн хэсэг болох тэтгэвэрт гарсны дараах үеийн төсөв, зардлаа тооцоолох талаар авч үзье. Тэтгэвэрт гарсны дараа таны авч байгаа тэтгэвэр санхүүгийн хэрэгцээг тань бүрэн хангаж чадахгүй байгаа бол хөнгөн өөрт таарсан ажил хийх замаар орлогоо нэмэгдүүлж болно. Зарим нэг хөрөнгө, үнэт зүйлээ зарж орлогын эх үүсвэр болгож болох юм. Жишээ нь, хадгаламжаасаа зарцуулах, даатгалаас нөхөн төлбөр авах гэх мэт. Өнөөдөр амьдрал дээр 100% тэтгэврээрээ сайхан амьдарч байгаа хүн тэр бүр олон байдаггүй. Тэтгэвэр авагчдын ихэнх нь баталгаат доод тэтгэвэр авдаг бөгөөд энэ нь амьдралын хэрэгцээг бүрэн хангаж чаддаггүй байна.

Тэтгэврийн орлого нь амьдралд нь хүрэлцээгүйгээс зарим хүмүүс тэтгэвэрт гарсны дараа цагийн ажил хийдэг. Энэ нь дараах ач холбогдолтой. Үүнд:

1. Би нийгэмдээ, хүмүүст хэрэгтэй хүний нэгэн гэдгээ мэдрэх
2. Хамт олонтой байх, хүмүүсийн дунд байх
3. Өөрийн үнэ цэнийн үнэлэмжийг мэдрэх
4. Сэтгэл санаа өөдрөг байх, ганцаардахгүй байх
5. Эрүүл мэнд сайжрах, байнгын хөдөлгөөнд байх
6. Байгууллага дээр ахмад, дунд, залуу үеийн төлөөлөл байх хэрэгтэй. Ахмад ажилтнуудаас суралцах зүйл залуучуудын хувьд маш их байдаг
7. Тэд залуу халаагаа бэлдэхэд сэтгэл гарган ажиллаж чаддаг
8. Хоёргүй сэтгэлээр ажилдаа хандаж, хариуцлагатай байж чаддаг
9. Тэтгэврийн орлогоо нэмэгдүүлэх улмаар санхүүгийн хувьд эрх чөлөөтэй амьдрахад нь дэмжлэг болох гэх мэт

Тэтгэврийн насандаа хуримтлуулсан хадгаламжаараа амьдарч болохгүй юу? гэсэн асуултыг зарим хүн тавьдаг. Энэ асуултад хариу өгөх зорилгоор манай улсын иргэдийн нийт хадгаламжийн хэмжээ ямар байгааг авч үзэхэд 2015 оны эцсийн байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 5`359`833, 7 сая төгрөг буюу 2.5 хувиар өссөн үзүүлэлттэй байна. Энэ нь Улаанбаатар хотын хувьд нийт хадгаламжийн 78.9 хувь нь ногдож байна. Иргэд нь хамгийн их хадгаламжтай бүс нутаг нь Хангайн бүс байна. Хангайн бүсэд Архангай, Баянхонгор, Булган, Орхон, Өвөрхангай, Хөвсгөл аймгууд ордог.

ТАНЫ МЭДЛЭГТ

2016 оны эхний хагасын байдлаар манай арилжааны банкуудад хадгаламжийн данс эзэмшигчдийн нийт тоо 5`319`158 байдаг бөгөөд үүний 5`270`774 болон 130 гаруй мянган хуулийн этгээд 20 хүртэлх сая төгрөгийн хадгаламжтай гэсэн тоог Сангийн яамнаас гаргажээ. Харин 40`167 нь 20-100 хүртэлх сая төгрөгийн хадгаламж эзэмшиж байдаг. 100 саяас дээш төгрөгийн хадгаламжтай 8217 иргэн, 1885 хуулийн этгээд байдаг аж. Өөрөөр хэлбэл, 100 саяас дээш хадгаламжтай иргэн нийт данс эзэмшигчийн 0.15 хувийг эзэлж байгаа юм.

Эх сурвалж: www.montsame.mn

Тэтгэврийн насандаа хуримтлуулсан хадгаламжаараа амьдрахтай холбоотой дараах асуудлууд гардаг. Үүнд:

- Хүн хүний хадгаламжид байршуулсан мөнгөний хэмжээ харилцан адилгүй, тэтгэврийн насанд хүртлээ ихэнх иргэд мөнгө хуримтлуулж чадаагүй байдаг.
- Иргэдийн дундаж наслалт харилцан адилгүй.
- Хөрөнгөө өвлүүлэх боломжтой эсэх, өвлүүлэх хөрөнгө байгаа эсэх нь харилцан адилгүй.
- Харин зарим иргэд нь тэтгэврээсээ гадна хадгаламжийн хүүг орлогын эх үүсвэр болгодог зэрэг олон хувилбар, асуудлууд харагддаг.

Амьдралынхаа эцсийн мөчийг хүртэл санхүүгийн хувьд эрх чөлөөтэй, сэтгэл амар, сайхан амьдрахын тулд эртнээс тэтгэврийн төлөвлөлтөө сайтар хийж төлөвлөх нь чухал. Хэмнэлт гаргаж хуримтлал хийж хэвших нь хамгийн зөв шийдвэр байх болно.

Сэдвийн дүгнэлт

Өндөр насны тэтгэвэр бол тэтгэвэр авагч хүний амьжиргааны үндсэн эх үүсвэр. Өндөр насны тэтгэвэр тогтоолгосноос хойш насан туршид нь олгодог.

Тэтгэврийн хэмжээ даатгуулагчийн тэтгэвэр бодуулахаар сонгосон сүүлийн 10 жилийн дараалсан 5 жилийн сарын дундаж цалингийн хэмжээ, ажилласан жилээс шууд хамаарна. 2016 оны байдлаар, өндөр насны бүрэн тэтгэврийн доод хэмжээ нь 251`000 төгрөг, хувь тэнцүүлсэн тэтгэврийн доод хэмжээ нь 216`000 төгрөг байна.

Тэтгэврийн даатгалын нэрийн дансны онцлог бол даатгуулагчийн ирээдүйд авах тэтгэвэр нь түүний ажиллах хугацаандаа авч байсан цалин дээр биш, харин түүний төлсөн шимтгэл дээр үндэслэдэгт оршино.

Цэргийн албан хаагчдын авах тэтгэврийн хэмжээ энгийн иргэдийн тэтгэврийг бодвол өндөр байдаг.

Амьдралынхаа эцсийн мөчийг хүртэл санхүүгийн хувьд эрх чөлөөтэй, сэтгэл амар, сайхан амьдрахын тулд эртнээс тэтгэврийн төлөвлөлт хийх нь чухал.

Бататгах асуулууд

1. Тэтгэврийн төлөвлөлтийн ач холбогдлыг дэлгэрүүлэн ярилцана уу.
2. Тэтгэврийн тооцооллыг яаж хийх вэ?
3. Өндөр насны тэтгэвэр авагчид мэдвэл зохих зүйлүүдэд юу юу орох вэ?

СЭДЭВ 16. ӨВ ХӨРӨНГИЙН ТӨЛӨВЛӨЛТ

Сэдвийг судлахын ач холбогдол, үр дүн

Энэ сэдвийг судалснаар өв хөрөнгийн төлөвлөлт хийх, гэрээслэл, итгэмжлэлийн талаар онолын мэдлэгтэй болж, өв хөрөнгөө төлөвлөх, гэрээслэл бичих чадвар эзэмшинэ.

Тулгуур ойлголт

- Хөрөнгө
- Гэр бүлийн хөрөнгө
- Гэр бүлийн гишүүний өөрийн хөрөнгө
- Өв хөрөнгө
- Өв хөрөнгийн төлөвлөлт
- Өв залгамжлагч
- Гэрээслэл
- Гэрээслэл үлдээлгүй нас барсан этгээд
- Уламжлалт гэр бүлийн гэрээслэл
- Энгийн гэрээслэл
- Албан гэрээслэл
- Бичмэл гэрээслэл
- Итгэмжлэл
- Өөрчилж болдог итгэмжлэл
- Өөрчилж болдоггүй итгэмжлэл
- Итгэмжлэгч
- Итгэмжлэгдэгч
- Асран хамгаалагч

16.1. Өв хөрөнгийн төлөвлөлт

ШИГТГЭЭ

Гэр бүлийн гишүүдийн хэн нэг нь нас барахад тухайн өрхийн санхүүгийн цаашидын байдал хүндэрч эхэлдэг. Иймээс өрхийнхөө гишүүдийн нийт орлого болон өр төлбөрийг би хэр мэддэг билээ? Манай гэр бүлийнхэн найдвартай даатгалын хамгаалалттай билүү? Хөрөнгөө хэнд итгэж үлдээх вэ? Хүүхдүүдийг маань хэн өсгөж хүмүүжүүлэх вэ? гэсэн асуултыг өөртөө тавьж, зохих хариултыг өгөх хэрэгтэй. Үүнд хувь хүний өв хөрөнгийн төлөвлөлт тусална.

Хөрөнгө: *Хувь хүний эзэмшиж буй тодорхой үнэ цэнэ бүхий зүйлс.*

Хувь хүний эзэмшиж буй зүйлсийг ерөнхийд нь хөрөнгө гэж нэрлэдэг.

Хувь хүний хөрөнгө, түүний төрөл, хууль, эрх зүйн зохицуулалтын талаар Иргэний хуулийн 84, 125-127-р зүйлд тодорхой заасан байдаг. Хувь хүний хөрөнгө эдийн ба эдийн бус хөрөнгөөс бүрдэнэ. Эдийн бус хөрөнгөд эзэмшигчдээ тодорхой орлого, ашиг авчирдаг биет бус хөрөнгө орно.. Үүнийг Зураг 16-1-ээс харна уу.

Зураг 16-1. Хувь хүний хөрөнгийн төрөл



Гэр бүлийн хөрөнгө гэрлэсэн хос болон гэр бүлийн бусад гишүүдийн хөрөнгөөс бүрддэг⁷³.

Гэр бүлийн хөрөнгө:

Гэр бүлийн гишүүдийн хамтран амьдарсан хугацаанд бий болсон, гэр бүлийн гишүүний өөрийнх нь хөрөнгөөс бусад хөрөнгө.

Хосууд гэрлэснээс хойш хамтран амьдарсан хугацаанд бий болсон, гэр бүлийн гишүүдийн өөрийн хөрөнгөөс бусад хөрөнгийг гэр бүлийн гишүүд хамтран өмчилнө.

Үүнд: Гэр бүлийн гишүүдийн хамтран олсон орлого, мөнгөн хуримтлал, түүгээр худалдан авсан эд хөрөнгө, хөрөнгө оруулалт багтдаг.

Гэр бүлийн гишүүний өөрийн хөрөнгө: *Гэр бүлийн гишүүний гэрлэхээсээ өмнө олж авсан эд хөрөнгө, хөрөнгийн эрх, оюуны өмч, хувийн эд зүйлс.*

Харин гэр бүлийн гишүүний өөрийн хөрөнгөд гэрлэхээсээ өмнө олж авсан, өөрөө эзэмшдэг эд хөрөнгө, мөнгөн хуримтлал, эд хөрөнгийн эрх, өв, бэлэг, хувийн хэрэглээний зүйлс, оюуны өмч, шагнал зэрэг орно.

Хувь хүн нас барахад түүний эзэмшиж байсан хөрөнгийг яах вэ? гэсэн асуулт тулгардаг. Үүнийг шийдвэрлэхэд өв хөрөнгийн төлөвлөлт тусална. Өв хөрөнгийн төлөвлөлт бол санхүүгийн тэр дундаа тэтгэврийн төлөвлөлтийн салшгүй нэг хэсэг юм.

Өв хөрөнгийн төлөвлөлт:

Тухайн хүнийг нас барсны дараа хэрэгжих, түүний хөрөнгийн талаарх хувь хүний сонирхлыг илэрхийлсэн хууль ёсны баримт.

Өв хөрөнгийн төлөвлөлт бол хэн нэгний амьдралын туршид болон түүнийг нас барсны дараах үеийн өмч хөрөнгийн удирдлага, ашиг сонирхлын асуудлыг тодорхой тусгасан төлөвлөгөө юм.

⁷³ Монгол Улсын хууль, (2002). Иргэний хууль, 125.1-р зүйл.

Өөрөөр хэлбэл, хувь хүн эд хөрөнгөө захиран зарцуулах чадвараа алдсан болон нас барсан тохиолдолд өмч хөрөнгийг өвлүүлэх, хөрөнгийн татвар төлөх зэрэг асуудлыг тусгасан хувийн төлөвлөгөөг өв хөрөнгийн төлөвлөлт гэж хэлж болно. Үүнд дараах зүйлс хамаардаг.


- Гэрээслэл бичих
- Шаардлагатай хөрөнгө ба хөрөнгө оруулалтын итгэмжлэгчийг томилох
- Өөрийн асрамжид байдаг хүмүүсийн асран хамгаалагчийг томилох
- Гэрээслэлийг хэрэгжүүлэх этгээд болон хугацааг тогтоох
- Амьдралын даатгалд даатгуулах эсвэл түүнийг шинэчлэх
- Оршуулах ёслолын талаар өөрийн хүслийг илэрхийлэх

Өв хөрөнгө: *Хувь хүний эзэмшиж байсан, нас барсны дараа өв залгамжлагчид очих хөрөнгө.*

Өв хөрөнгийг төлөвлөх явцад юун түрүүн өвлүүлэх хөрөнгийн тухай асуудал хөндөгддөг.

Хуулийн хүрээнд “Өвлүүлэгчийн эд хөрөнгө, эрх өвлөгдөнө”⁷⁴ гэж заажээ. Өвлүүлэх боломжтой хөрөнгөд хадгаламж, хөрөнгө оруулалт, даатгал, зохиогчийн эрх, патент зэрэг багтдаг. Монгол Улсын хуульд зааснаар оюуны үнэт зүйлийг өвлөх эрх 50 жилийн хугацаатай байдаг байна.

Зураг 16-2. Өв хөрөнгийн төрөл



Өв хөрөнгийн төлөвлөлтийн дараагийн үе шатанд хувь хүнийг нас барсны дараа хэнд өв хөрөнгийг шилжүүлэх тухай асуудлыг авч үздэг. Өв хөрөнгийн төлөвлөлтийн энэ хэсэг гэрээслэл болон итгэмжлэлийн гэрээгээр дамжин хэрэгжинэ.

Өв залгамжлагч: *Тухайн хүнийг нас барсны дараа түүний хөрөнгийг өмчлөх эрх бүхий этгээд.*

Өв хөрөнгө тухайн хүний хууль ёсны өв залгамжлагчид очдог. Гэхдээ зарим онцгой тохиолдолд өв залгамжлагч хөрөнгө өвлөх эрхээ алдаж болно.

Тухайлбал, өвлүүлэгч эсвэл түүний хууль ёсны өвлөгчийн амь насыг санаатай хохироосон болон тэдний аль нэгний нас барах шалтгаан болсон бусад гэмт хэргийг санаатай үйлдсэн нь хуулиар нотлогдсон бол өв залгамжлах эрхгүй болно.

⁷⁴Монгол Улсын хууль, (2002). Иргэний хууль 515.1-р зүйл.

Өв хөрөнгийн төлөвлөлт аливаа хүнээс эмх цэгцтэй, нягт нямбай байдлыг шаарддаг. Учир нь, бараг бүх насанд хүрэгсэд санхүүгийн маш чухал шийдвэрүүдийг гаргаж байдаг бөгөөд үүнтэй холбоотой баримт, материалыг зайлшгүй хадгалж байх шаардлагатай. Тэдний гаргадаг санхүүгийн шийдвэрүүд гэр бүлийн бусад гишүүдэд ч мөн адил чухал ач холбогдолтой байдаг. Аливаа хүний зохих хэмжээний мэдлэг болон бичиг баримтыг найдвартай хадгалах дадал санхүүгийн шийдвэр гаргалтыг илүү амар хялбар болгодог.

Өв залгамжлагчийн санхүүгийн найдвартай байдлыг хангах боломжтой хэдий ч өв хөрөнгийн төлөвлөлтийн асуудал хэцүү мэт санагдаж болно. Хэдийгээр мөнгөн хөрөнгийг зөв удирдахад хууль эрх зүйн болон мэргэжлийн мэдлэг хэрэгтэй ч шаардлагатай дадал, чадварыг эзэмшсэнээр хөрөнгө, мөнгөтэй холбоотой асуудлыг өөртөө ашигтай, ухаалгаар шийдвэрлэх боломжтой.

Гэр бүлтэй хүний өв хөрөнгийн төлөвлөлт хамгийн багадаа 2, түүнээс ч олон хүний ашиг сонирхлыг өөртөө багтаадаг. Гэрлэсэн хүний хувьд хуулийн шаардлага, хариуцлага нь гэрлээгүй хүнийхээс бүхэлдээ өөр байдаг. Үүнд:

- Илүү эмх цэгц, тодорхой байдлыг шаарддаг.
- Тухайн хүн нас барснаар гэр бүлийн гишүүдийнх нь амьдралын хэв маяг, санхүүгийн нөхцөл байдал өөрчлөгддөг.
- Өмч хөрөнгөө гэрээсэлсэн байх шаардлагатай.
- Тухайн хүний хүсэлт болон өв хөрөнгийн талаарх мэдээлэл ойлгомжтой, тодорхой, хуулийн дагуу байх ёстой.

Хэрэв тухайн хүн гэрлээгүй буюу түүний хөрөнгийг “өвлөх хууль ёсны өвлөгч байхгүй бол хөрөнгийг нь төрийн өмчлөлд эзэнгүй эд хөрөнгийн нэг адил шилжүүлнэ”⁷⁵ гэж хуульд заасан байна. Ганц бие хүний хувьд шаардлагатай мэдээ, материал иж бүрэн, авч ашиглаж болохуйц газар ил байх нь зүйтэй. Хэрэв тухайн хүн нас барвал түүний асрамжид байдаг болон ойр дотны хүмүүс нь түүний талаар мэдээлэлтэй, түүнийг нас барсны дараа амьдрах санхүүгийн баталгаатай байх шаардлагатай.

Хувь хүн өв хөрөнгийн төлөвлөлт хийснээр өөрийнхөө хөрөнгийг хожим хүссэнээрээ хуваарилах, гэр бүлийн гишүүдийн дунд өмч хөрөнгийн маргаан үүсэхээс сэргийлэх, үр хүүхэддээ хөрөнгө, буянаа хадгалуулан үлдээх ач холбогдолтой.

16.2. Итгэмжлэл

Итгэмжлэл: Ашиг олох зорилгоор өөрийн хөрөнгийг захирах эрхийг өөр хүнд олгодог гэрээ.

Өв хөрөнгийг төлөвлөх нэг арга нь өөрийн хөрөнгийг ашиг олох зорилгоор өөр этгээдэд итгэмжлэн өгч, захиран зарцуулах эрх олгох явдал байдаг.

⁷⁵ Монгол Улсын хууль, (2002). Иргэний хууль 515.6-р зүйл.

Итгэмжилсэн хөрөнгөөс олсон орлого, үр шимийг итгэмжлэгч хүртэх, өмчлөх ач холбогдолтой. Итгэмжлэлийн гэрээ байгуулах шалтгаан дараах зүйлд оршдог. Үүнд:

1. Хөрөнгийн татварыг бууруулна.
2. Итгэмжлэлээс тогтмол орлого орж байгаа үед хөрөнгийг захиран зарцуулахтай холбоотой ажлаас чөлөөлөгдөнө.
3. Гэр бүлийн гишүүд болон итгэмжлэгчийн халамжид байдаг бусад хүнийг тодорхой орлогоор хангана.
4. Тухайн хүнийг нас барсны дараа хөрөнгө нь түүний хүсч байсан зорилгоор ашиглагдана.

Итгэмжлэгдэгч: *Итгэмжлэлийн гэрээнд зааснаар итгэмжлэгчийн хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий этгээд.*

Итгэмжлэгдэгч нь хувь хүнээс гадна банк гэх мэт санхүүгийн байгууллага байж болно.

Банк итгэмжлэгдэгч болсон тохиолдолд үйлчилгээний бага зэргийн шимтгэл авах ба шимтгэлийн хэмжээ итгэмжлүүлсэн хөрөнгийн үнийн дүнгээс хамаардаг. Итгэмжлэгдэгч өмчлөгчийн бүрэн эрхийг хэрэгжүүлэхийн зэрэгцээ үйл ажиллагааныхаа үр дагавар, хариуцлагыг үүрэх бөгөөд итгэмжлэгчийн ашиг сонирхолд харш үйл ажиллагаа явуулсны улмаас түүнд учирсан хохирлыг нөхөн төлөх үүргийг мөн хуулийн дагуу хүлээдэг.

Хөрөнгө итгэмжлэх гэрээгээр итгэмжлэгч хөдлөх эд хөрөнгө буюу эрхийг итгэмжлэгдсэн өмчлөгчид шилжүүлэх, итгэмжлэгдсэн өмчлөгч нь итгэмжилсэн хөрөнгийг хүлээн авч итгэмжлэгчийн эрх, ашиг сонирхолд нийцүүлэн, захиран зарцуулах үүргийг тус тус хүлээдэг.⁷⁶ Итгэмжлэлийн гэрээг бичгээр хийх шаардлагатай.

Итгэмжлэлийн хэд хэдэн төрөл байдаг бөгөөд эдгээрээс тухайн нөхцөл байдалд тохирохыг авч хэрэглэх нь зохимжтой. Өмгөөлөгчдийн хувьд тухайн гэр бүл болон хувь хүний хэрэгцээнд аль нь илүү тохирох талаар зөвлөгөө өгч чадна. Иймээс мэргэжлийн хүнээс зөвлөгөө авч, итгэмжлэлийн гэрээ хийх нь эрсдэлээс хамгаалах ач холбогдолтой.

Бүх төрлийн итгэмжлэл нь:

- Өөрчилж болдог
- Өөрчилж болдоггүй гэсэн 2 хэлбэртэй байдаг

Өөрчилж болдог итгэмжлэл:

Амьдралын явцад нөхцөлийг сольж, өөрчлөх эсвэл дуусгаж болдог итгэмжлэл.

Өөрчилж болдоггүй итгэмжлэл:

Амьдралын явцад нөхцөлийг сольж өөрчлөх болон дуусгах боломжгүй итгэмжлэл.

⁷⁶ Монгол Улсын хууль, (2002). Иргэний хууль, 406.1 дэх заалт

16.3. Гэрээслэл, түүний төрлүүд

Өв хөрөнгийг төлөвлөх үндсэн асуудлын нэг бол гэрээслэл буюу түүнийг бичих явдал юм.

Гэрээслэл: Тухайн хүнийг нас барсны дараа хэрэгжих, түүний хөрөнгийн талаарх хувь хүний сонирхлыг илэрхийлсэн хууль ёсны мэдэгдэл.

Хэрэв хувь хүн гэрээслэл бичилгүй нас барсан бол тухайн хүний хууль ёсоор оршин сууж байсан орны хуулийн дагуу түүний юу хүсч, бодож байсныг үл харгалзан өв хөрөнгийн асуудлыг шийдвэрлэдэг.

Хувь хүн өөрийн хүсэл, шаардлагад бүрэн нийцсэн гэрээслэлийн төрлийг сонгоход олон хүчин зүйл нөлөөлдөг. Үүнд:

- Хөрөнгийн хэмжээ
- Инфляцийн түвшин
- Гэрээслэгчийн нас
- Гэрээслэгчийн зорилго гэх мэт орно

Гэрээслэл үлдээлгүй нас барсан этгээд: Хүчин төгөлдөр гэрээслэл бичилгүйгээр нас барсан хүн.

Олон улсын түвшинд гэрээслэл энгийн, уламжлалт, гэр бүлийн гэх мэт олон төрөлтэй байдаг. Гэрээслэлийн төрөл тус бүр өөрийн гэсэн онцлог, ялгаатай байдаг.

Энгийн гэрээслэл: Гэр бүлийнхээ хүнд бүх хөрөнгөө өвлүүлэхээр заасан гэрээслэл.

Энгийн гэрээслэлийг ихэвчлэн багавтар хөрөнгөтэй хүн бичдэг. Харин их хэмжээний хөрөнгөтэй хүнд энэ төрлийн гэрээслэл тохиромжгүй.

Аливаа хүн өөрийнхөө хөрөнгийг гэр бүлийн гишүүд болон угсаа залгамжлагчдаа хувааж өгөх шаардлага гардаг. Энэ зорилгоор гэр бүлийн уламжлалт гэрээслэл бичдэг.

Гэр бүлийн уламжлалт гэрээслэл: Хөрөнгийнхөө нэг хэсгийг гэр бүлийнхээ хүнд, бусад хэсгийг хүүхдүүд болон бусад удам залгах хүндээ өгөхөөр заасан гэрээслэл.

Гэрээслэлээр хуваах хөрөнгө тохиргоо хийгдсэн буюу цэвэр хөрөнгө байна. Цэвэр хөрөнгийн хэмжээг олохдоо нийт хөрөнгөөс өр төлбөр болон зардлуудаа хасч тооцдог.

ШИГТГЭЭ

АНУ-ын тэтгэвэрт гарсан иргэдийн холбооны судалгаагаар 45-аас дээш насны хүмүүсийн 40 гаруй хувь нь гэрээслэл бичээгүй байжээ.

Гэрээслэлийг гэрээслэгч өөрийн гараар болон урьдчилан бэлтгэсэн албан маягт дээр бичиж болно.

Албан ёсны гэрээслэл: *Хуулийн мэргэжлийн хүний туслалцаатай хэвлэмэл маягт дээр бичсэн гэрээслэл.*

Хэрэв хэвлэмэл маягт дээр бичсэн бол түүнийг албан ёсны гэрээслэл гэж үзнэ.

Бичмэл гэрээслэл: *Хувь хүн өөрийн гараар бичиж, гарын үсэг зурж баталгаажуулсан гэрээслэл.*

Бичмэл гэрээслэлийг гэрээслэл бичигч өөрийн үгээр бичиж, гарын үсэг зуран, огноог тавьсан байдаг.

Зарим улсад ийм хэлбэрийн гэрээслэлийг хүчин төгөлдөр гэж тооцдоггүй бөгөөд зарим тохиолдолд бичмэл гэрээслэлийг гэрчилж, хоёр хүн гарын үсэг зурсан байхыг шаарддаг. Ямар ч гэрээслэлийн төрлийг сонгосон бай гэрээслэлээ хууль ёсны болохыг нотолж, баталгаажуулсан байх ёстой.

Гэрээслэлийн баталгаажуулалт: *Гэрээслэлийг хууль ёсны эсэхийг нотлох үйл явц.*


Монгол Улсын Иргэний хуульд зааснаар гэрээслэлийг бичгээр үйлдэж, үйлдсэн газар, он, сар, өдрийг зааж, нотариатаар баталгаажуулах ёстой.

Энэ нь ирээдүйд гэрээслэлтэй холбоотой маргаан үүсэхээс сэргийлэх гол үндэслэл болно. Гэрээслэл бичсэн газар нотариат байхгүй бол баг, сумын Засаг даргаар гэрчлүүлэх боломжтой. Дараах тохиолдолд нотариатаар гэрчлүүлсэнтэй нэг адил гэж үздэг. Үүнд:

1. Цэргийн албан хаагчийн гэрээслэлийг түүний алба хааж байгаа цэргийн ангийн удирдлага гэрчилсэн
2. Хорих газар хоригдож байгаа буюу ажиллаж байгаа иргэний гэрээслэлийг хорих ангийн дарга гэрчилсэн
3. Хөлөг онгоцонд зорчиж яваа иргэн болон багийн гишүүдийн гэрээслэлийг онгоцны ахмад гэрчилсэн

Эдгээр шаардлагыг хангаагүй гэрээслэл хүчин төгөлдөр бус гэрээслэл болно.

Зураг 16-3. Гэрээслэл бичих зөвлөмж



Гэрээслэлд өв залгамжлагч, асран хамгаалагч, гэрээслэл биелүүлэгчийг заах ёстой.

Асран хамгаалагч: *Гэрээслэгчийн насанд хүрээгүй хүүхдийг халамжлан хүмүүжүүлэх, өв хөрөнгийг нь тэдний нэрийн өмнөөс захиран зарцуулах үүрэг хүлээсэн этгээд*

Асран хамгаалагч гэрээслэгчийн насанд хүрээгүй хүүхдүүдийг асран хүмүүжүүлэх, тэдний өвөлж авсан хөрөнгийг насанд хүртэлх хугацаанд захиран зарцуулах үүрэг хүлээж, эрх эдэлдэг.

Гэрээслэл биелүүлэгч: *Гэрээслэлээр томиллогдсон, гэрээслэл хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн этгээд.*

Харин гэрээслэл биелүүлэгч гэрээслэлийг хэрэгжүүлэх үүрэг хүлээдэг. Ихэвчлэн өв залгамжлагч нь гэрээслэл биелүүлэгч болдог.

Гэрээслэгч өөр этгээдийг гэрээслэл гүйцэтгэгчээр томилж болно. Гэрээслэл биелүүлэгч даалгасан үүргийг биелүүлэхийг зөвшөөрснөө баталж, гэрээслэлд гарын үсэг зурах буюу энэ тухай баримт бичиг үйлдэж, гэрээслэлд хавсаргаснаар уг даалгаврыг гүйцэтгэх үүргийг албан ёсоор хүлээдэг.

Гэрээслэл биелүүлэгч үүргээ гүйцэтгэхэд шаардагдах бүхий л арга хэмжээг авах, гэрээслэлийг биелүүлсний дараа өвлөгчид тайлагнах үүрэгтэй. Хэрэв гэрээслэл биелүүлэхтэй холбоотой зардал гарсан бол түүнийг өв хөрөнгөөс гаргуулан авах эрхтэй байдаг.

Гэрээслэгч хэдийд ч гэрээслэлээ өөрчлөх болон цуцлах эрхтэй. Амьдралд гарч болох өөрчлөлтүүдээс хамаарч (гэрлэх, гэрлэлтээ цуцлуулах гэх мэт) бичсэн гэрээслэлдээ шаардлагатай зохих өөрчлөлтүүдийг оруулах нь зүйтэй.

Шинэ гэрээслэл хийсэн тохиолдолд түрүүчийн гэрээслэлийг цуцалсан тухай зохих баримт үйлдэх ёстой. Шинээр хийсэн гэрээслэл болон гэрээслэлээ цуцалсан тухай баримт бичгийг мөн нотариатаар гэрчлүүлдэг. Гэрлэлт цуцлуулсны дараа гэрээслэл бичигчийн хуучин гэр бүлийн хүн болон түүний гэр бүлийн гишүүд (хадмууд) хөрөнгө өвлөх эрхгүй болдог.

Хувь хүн гэрээслэлээ бичсэний дараа гэрлэсэн бол тодорхой нөхцөлүүдэд гэрээслэл хүчин төгөлдөр хэвээр байх болно. Үүнд:

- Дараагийн гэрлэлт нь гэрээслэлд өөрчлөлт оруулах үндэслэл болохгүй гэдгийг гэрээслэлдээ тусгасан
- Гэрлэсний дараах нөхцөл байдлын талаар гэрээслэлдээ урьдчилан тусгасан байсан зэрэг нөхцөлүүд хамаарна

ТАНЫ МЭДЛЭГТ (Монгол Улсын Иргэний хуулиас)

Гэрээслэгч бүх эд хөрөнгөө хууль ёсны өмчлөгч бус этгээдэд гэрээслэх тохиолдолд өвлүүлэгчийн насанд хүрээгүй буюу хөдөлмөрийн чадваргүй, түүнчлэн түүнийг нас барснаас хойш төрсөн хүүхэд, түүний асрамжид байсан хөдөлмөрийн чадваргүй нөхөр /эхнэр/, төрүүлсэн болон үрчилсэн эцэг, эх, хууль ёсны бусад өвлөгчдөд хуульд заасан ёсоор өвлүүлбэл зохих хөрөнгийн хоёрны нэгээс багагүй хэсгийг заавал өвлүүлнэ. Ийнхүү заавал өвлүүлэх хэсгийн хэмжээг тодорхойлохдоо гэр бүлийн гишүүний өөрийн болон дундын өмчлөлийн эд хөрөнгийн өвлүүлэгчид оногдох хэсгийг оролцуулан тооцно.

Сэдвийн дүгнэлт

Өв хөрөнгийн төлөвлөлт нь хувь хүн эд хөрөнгөө захиран зарцуулах чадвараа алдсан болон нас барсан тохиолдолд өмч хөрөнгийг өвлүүлэх, хөрөнгийн татвар төлөх зэрэг асуудлыг тусгасан хувийн төлөвлөгөө юм. Энэ нь гэрээслэл бичих, асран хамгаалагч болон итгэмжлэгч томилох зэрэг асуудлыг хамардаг. Өв хөрөнгийн төлөвлөлт өөрийн хөрөнгийг хэнд үлдээхийг шийдвэрлэх, гэр бүлийн гишүүдийн дунд өмч хөрөнгийн маргаан үүсэхээс сэргийлэх, үр хүүхдэдээ хөрөнгө, буянаа хадгалуулах, тэдгээрийг насанд хүртэл асран хамгаалах найдвартай итгэл даах хүнийг томилон үлдээх боломжийг олгодгоороо ач холбогдолтой.

Тухайн хүнийг нас барсны дараа хэрэгжих, түүний хөрөнгийн талаарх хувь хүний сонирхлыг илэрхийлсэн хууль ёсны мэдэгдлийг гэрээслэл гэнэ. Гэрээслэлд өв залгамжлагчийн зэрэгцээ насанд хүрээгүй хүүхэд, хүний асрамжид байдаг ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй гэр бүлийн гишүүдийн асран хамгаалагчийг зааж өгөх шаардлагатай. Энэ нь тухайн хүнийг нас барсны дараа тэдгээр хүмүүсийн амьдралын баталгааг хангаж өгөх гол хэрэгсэл болно.

Бататгах асуултууд

1. Өв хөрөнгийн төлөвлөлтийн ач холбогдлыг дэлгэрүүлэн ярилцана уу.
2. Итгэмжлэл гэж юу вэ? Ямар зорилгоор итгэмжлэл хийдэг вэ?
3. Гэрээслэлд юу юуг тусгасан байвал зохих вэ?
4. Өв залгамжлагч хэн байж болох вэ?
5. Ямар тохиолдолд өв залгамжлах эрхээ алддаг вэ?

НЭР ТОМЬЁОНЫ ТАЙЛБАР

<i>Албан ёсны гэрээслэл</i>	Хуулийн мэргэжлийн хүний туслалцаатай хэвлэмэл бланк дээр бичсэн гэрээслэл.
<i>Албан журмын даатгал</i>	Хуульд заасны дагуу иргэд заавал даатгуулбал зохих даатгалын төрөл.
<i>Албан татвар</i>	Татвар төлөгчдийн орлого, эд хөрөнгөөс хуулийн дагуу албадан авч улс, орон нутгийн төсөвт оруулж байгаа мөнгө.
<i>Алдагдсан боломжийн өртөг</i>	Сонголт хийх явцад алдсан өөр нэг боломжоос олж болох байсан орлого, ашиг.
<i>Амьдралын даатгал</i>	Тэтгэврийн насанд хүрээд даатгалаас нөхөн төлбөрөө авдаг, хэрвээ тэтгэвэрт гарахаасаа өмнө хөдөлмөрийн чадвараа бүрэн болон хагас алдсан тохиолдолд санхүүгийн дэмжлэг авдаг, даатгуулагч нас барвал өв залгамжлагчид нөхөн олговрыг олгодог даатгал.
<i>Андеррайтинг</i>	Зах зээл дээр хөрөнгө оруулалтын банкууд үнэт цаасны үнийг тодорхойлон, олон нийтэд арилжаа хийх үйл ажиллагаа.
<i>Аннуити</i>	Хадгаламж, зээлийн төлбөрийн жигд, тогтмол хэмжээ.
<i>Анхдагч зах зээл</i>	Байгууллагууд үнэт цаасаа хөрөнгийн зах зээл дээр олон нийтэд санал болгох замаар арилжаалж, санхүүгийн эх үүсвэр олох үйл ажиллагаа явагдаж буй зах зээл.
<i>Асран хамгаалагч</i>	Гэрээслэгчийн насанд хүрээгүй хүүхдийг халамжлан хүмүүжүүлэх, өв хөрөнгийг нь тэдний нэрийн өмнөөс захиран зарцуулах үүрэг хүлээсэн этгээд.
<i>Банк</i>	Хувьцаа эзэмшигчдийн оруулсан мөнгөн хөрөнгөөс бүрдсэн хувь нийлүүлсэн хөрөнгөтэй, хувьцаа эзэмшигч нь эзэмшиж байгаа хувьцааны хэмжээгээр хариуцлага хүлээдэг, бусдын мөнгөн хөрөнгийг хуримтлуулан хадгалж, өөрийн нэрийн өмнөөс зээл олгох, төлбөр тооцоо хийх зэрэг санхүүгийн зуучлалын үйл ажиллагааг Монголбанкны тусгай зөвшөөрөлтэйгээр эрхэлдэг, ашгийн төлөө хуулийн этгээд.
<i>Баталгаа</i>	Бараа бүтээгдэхүүнийг буцаах, солих, засварлахтай холбоотой нөхцөлийг тодорхойлон үйлдвэрлэгч эсвэл борлуулагчаас бичиж өгдөг батламж.
<i>Бичмэл гэрээслэл</i>	Хувь хүн өөрийн гараар бичиж, гарын үсэг зурж баталгаажуулсан гэрээслэл.
<i>Бодит хүү</i>	Инфляцийн түвшинг тооцсон хүү.
<i>Бонд</i>	Тодорхой хэмжээний мөнгийг хүүтэйгээр эргүүлэн төлөх баталгаа.

Бондын эргэн төлөгдөх хугацаа	Компани зээлсэн мөнгөө эргүүлэн төлөхөөр гэрээнд заасан өдөр.
Бүрэн баталгаа	Заасан хугацааны туршид гэмтэлтэй барааг бүхэлд нь засварлах эсвэл сольж өгөх нөхцөлийг заасан баталгаа.
Валютын зах зээл	Валютыг худалдах, худалдан авах үйл ажиллагаа явагдаж буй зах зээл.
Валютын своп хэлцэл	Нэг валютаар нэрлэсэн төлбөрийг нөгөө валютаар илэрхийлсэн төлбөрөөр солилцох хэлцэл.
Гэнэтийн ослын даатгал	Даатгуулагч гэнэтийн ослын улмаас хөдөлмөрийн чадвараа бүрэн болон хэсэгчлэн алдах, нас барах тохиолдолд нөхөн төлбөр олгох зорилго бүхий даатгал.
Гэнэтийн худалдан авалт	Санхүүгийн хүндрэл үүсгэж болох, төлөвлөгдөөгүй худалдан авалт.
Гэр бүлийн гишүүний өөрийн хөрөнгө	Гэр бүлийн гишүүний гэрлэхээсээ өмнө олж авсан эд хөрөнгө, хөрөнгийн эрх, оюуны өмч, хувийн эд зүйлс.
Гэр бүлийн уламжлалт гэрээслэл	Хөрөнгийнхөө нэг хэсгийг гэр бүлийнхээ хүнд, бусад хэсгийг хүүхдүүд болон бусад удам залгах хүндээ өгөхөөр заасан гэрээслэл
Гэр бүлийн хөрөнгө	Гэр бүлийн гишүүдийн хамтран амьдарсан хугацаанд бий болсон, гэр бүлийн гишүүний өөрийнх нь хөрөнгөөс бусад хөрөнгө.
Гэрээслэл	Тухайн хүнийг нас барсны дараа хэрэгжих, түүний хөрөнгийн талаарх хувь хүний сонирхлыг илэрхийлсэн хууль ёсны мэдэгдэл.
Гэрээслэл биелүүлэгч	Гэрээслэлээр томилогдсон, гэрээслэл хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн этгээд
Гэрээслэл үлдээлгүй нас барсан этгээд	Хүчин төгөлдөр гэрээслэл бичилгүйгээр нас барсан хүн.
Гэрээслэлийн баталгаажуулалт	Гэрээслэлийг хууль ёсны эсэхийг нотлох үйл явц.
Даатгал	Ирээдүйн үйлчилгээг одоо худалдан авч буй үйл явц. Эрсдэлийг шилжүүлэх механизм. Даатгагч, даатгуулагчийн хооронд үүсч буй мөнгөн харилцаа.
Даатгалын нөхөн төлбөр	Даатгалын тохиолдол бүрдсэн нөхцөлд даатгалын сангаас хадгаламж эзэмшигчид олгох мөнгөн төлбөр.
Даатгалын үйл ажиллагаа	Даатгалын гэрээний дагуу даатгагч даатгалын тохиолдол үүсэхэд учирсан хохирол буюу хэлэлцэн тохирсон даатгалын нөхөн төлбөрийг төлөх үүргийг тодорхой этгээдийн өмнө хүлээж буй үйл ажиллагаа.
Давуу эрхийн хувьцаа	Зөвхөн энгийн хувьцаа эзэмшигчиддээ зориулж гаргасан саналын эрхгүй хувьцаа
Дампуурал	Өр зээлээ төлөх чадваргүй болсноос хөрөнгө, мөнгөө алдах үйл явц.

<i>Дефляци</i>	Инфляцийн эсрэг зүйл бөгөөд үнийн ерөнхий түвшин буурах үйл явц.
<i>Дэвтрийн хадгаламж</i>	Хөрвөх чадвар өндөртэй, хүүний орлого авчирдаг хадгаламжийн данс.
<i>Ердийн даатгал</i>	Нэг жил хүртэл хугацаатай хийгддэг даатгал.
<i>Зээл</i>	Бусдаас тодорхой хэмжээний хүү, хугацаа, эргэн төлөх нөхцөлтэйгээр авч ашиглаж буй мөнгө.
<i>Зээлдэгчээс хамаарсан эрсдэл</i>	Зээлдэгчийн буруутай үйл ажиллагаанаас зээл эргэн төлөгдөхгүй байх эрсдэл.
<i>Зээлийн нөхцөл</i>	Зээлийн гэрээнд тусгагдсан зүйлс.
<i>Зээлийн нөхцөл тохироогүйгээс үүсэх эрсдэл</i>	Зээл олгож байгаа нөхцөл зээлийг ашиглаж байгаа нөхцөлтэй тохирохгүйгээс үүсч буй эрсдэл.
<i>Зээлийн хүү</i>	Арилжааны банкны зээлийн үйлчилгээний үнэ.
<i>Зээлийн эрсдэл</i>	Зээл гэрээнд заасан хуваарийн дагуу хүүний хамт хугацаандаа төлөгдөхгүй байх магадлал.
<i>Инфляци</i>	Үнийн ерөнхий түвшний өсөлт.
<i>Ирээдүйн үнэ цэнэ</i>	Тодорхой хүү, тодорхой хугацаатайгаар өнөөдөр хадгалуулсан мөнгөний өсөх дүн.
<i>Итгэмжлэгдэгч</i>	Итгэмжлэлийн гэрээнд зааснаар итгэмжлэгчийн хөрөнгийг захиран зарцуулах эрх бүхий этгээд.
<i>Итгэмжлэл</i>	Ашиг олох зорилгоор өөрийн хөрөнгийг захирах эрхийг өөр хүнд олгодог гэрээ.
<i>Корпорацийн бонд</i>	Тодорхой хэмжээний мөнгийг хүүтэйгээр зээлснийг гэрчлэх, компаниас гаргасан санхүүгийн хэрэгсэл.
<i>Мөнгө</i>	Түгээмэл тэнцэгчийн үүрэг гүйцэтгэгч, хэрэгцээний өртөг бүхий онцгой таваар.
<i>Мөнгөний зах зээл</i>	Нэг жилээс богино хугацаатай үнэт цаасны арилжаа явагдаж байгаа зах зээл.
<i>Мөнгөний цаг хугацааны үнэ цэнэ</i>	Хүүний өгөөжийн үр дүнд мөнгөний тоо хэмжээ өсөх хэмжээ.
<i>Мэргэжил</i>	Мэргэжлийн хувьд өсөх, үргэлжлүүлэн сурч боловсрох шаардлагатай амьдралын баталгаат зүйл.
<i>Нийгмийн даатгал</i>	Даатгуулагч өндөр наслах, өвдөх, ажилгүй болох зэргээр орлого олох боломжгүй болсон үед нь орлогоор хангах зорилго бүхий төрөөс хэрэгжүүлж буй арга хэмжээ.
<i>Нийлмэл хүү</i>	Үндсэн дүн болон өмнөх хугацаанд бодогдсон хүүний нийлбэрээс тооцсон хүү.
<i>Нийтийн тээвэр</i>	Олон хүнийг нэгэн зэрэг, хурдан тээвэрлэхэд зориулсан автобус, галт тэрэг гэх мэт тээврийн хэрэгсэл.

Ногдол ашиг	Компанийн олсон ашгаас хувьцаа эзэмшигчид хуваарилах болсон хэсэг.
Нэгжийн үнэ	Янз бүрийн хэмжээгээр савласан бараа, бүтээгдэхүүний үнийг харьцуулах стандарт хэмжүүр.
Нэмэгдэл орлого	Шагнал, урамшуулал, бэлэг, хандив эд зүйлс худалдан борлуулсны болон туслах аж ахуйгаас орох орлого бөгөөд цаг үеийн шинж чанартай орлогууд.
Нэрлэсэн хүү	Банкуудын зарласан хүү.
Опцион хэлцэл	Тодорхой хэмжээний хөрөнгө арилжаалах эрхийг олгож буй хэлцэл.
Өв залгамжлагч	Тухайн хүнийг нас барсны дараа түүний хөрөнгийг өмчлөх эрх бүхий этгээд.
Өв хөрөнгө	Хувь хүний эзэмшиж байсан, нас барсны дараа хууль ёсны өв залгамжлагчид очих хөрөнгө.
Өндөр насны тэтгэвэр	Өндөр насны тэтгэвэр тогтоолгох болзол хангаж, тэтгэвэр тогтоолгосон даатгуулагчид тэтгэврийн даатгалын сангаас сар бүр олгож буй мөнгө.
Өнөөгийн үнэ цэнэ	Тодорхой хүү болон тодорхой хугацаанд суурилан тооцсон ирээдүйн мөнгөний өнөөгийн үнэ цэнэ.
Өөрчилж болдог итгэмжлэл	Амьдралын явцад нөхцөлийг нь сольж, өөрчилж эсвэл дуусгаж болдог итгэмжлэл.
Өөрчилж болдоггүй итгэмжлэл	Амьдралын явцад нөхцөлийг нь сольж өөрчлөх болон дуусгах боломжгүй итгэмжлэл.
Өрийн бичиг	Тодорхой хугацааны дараа үндсэн төлбөр болон хүүг мөнгөн эсвэл тодорхой эд хөрөнгө, эд хөрөнгийн эрхийн хэлбэрээр эргүүлэн төлөх үүргийг гэрчилсэн үнэт цаас.
Өрхийн тогтмол зардал	Орон сууцны төлбөр, зээлийн төлбөр, даатгалын хураамж гэх мэт тогтмол дүнтэй зардлууд
Өрхийн хувьсах зардал	Хүнс, хувцас, гутал, утасны төлбөр, нийтийн тээврийн тасалбар буюу төлбөр, эрүүл мэндийн үйлчилгээний хөлс гэх мэт тухайн үеийн хэрэглээнээс хамаарч гардаг зардлууд.
Сайн дурын даатгал	Даатгуулагч сайн дурын үндсэн дээр даатгуулдаг даатгалын төрөл.
Санхүү	Мөнгөн хөрөнгийг хуримтлуулах, хуваарилах, ашиглахтай холбогдон үүсч байгаа эдийн засгийн мөнгөн харилцаа.
Санхүүгийн зах зээл	Санхүүгийн хэрэгслүүдийг арилжих үйл ажиллагаа явагдаж байгаа зах зээл.
Санхүүгийн зуучлал	Мөнгөн хөрөнгийн илүүдэлтэй хэсгээс мөнгөн хөрөнгийн дутагдалтай хэсэг рүү шилжүүлэн хуваарилах үйл явц.

Санхүүгийн сахилга бат	Санхүүгийн төлөвлөгөө боловсруулж, түүнийхээ дагуу оновчтой шийдвэр гаргаж, гаргасан шийдвэртээ хариуцлага хүлээж, дүрэм журмыг дагаж, мөрдөх хүмүүжил.
Санхүүгийн тогтолцоо	Санхүүгийн байгууллагууд болон санхүүгийн зах зээлийн нэгдэл.
Санхүүгийн тогтолцооны үндсэн үүрэг	Хязгаарлагдмал санхүүгийн нөөцийг үр ашигтай удирдах явдал.
Санхүүгийн төлөвлөгөө	Хувь хүний өнөөгийн санхүүгийн нөхцөл байдал, санхүүгийн хэрэгцээг шинжилж, дүгнэсэн ирээдүйн санхүүгийн үйл ажиллагаанд зөвлөмж болох албан ёсны удирдамж.
Санхүүгийн хуримтлал	Ирээдүйд ашиглах үүднээс урьдчилан хадгалсан (нөөцөлсөн) мөнгө буюу татварын дараах орлогоосоо хэрэглээний зардлаа хассантай тэнцэх мөнгө.
Своп хэлцэл	Хэлцэлд оролцогч талууд өөрсдийн эзэмшиж буй төлбөрөө солилцох гэрээ.
Синдикат	Их хэмжээний хөрөнгө шаардлагатай тодорхой ажлыг гүйцэтгэх зорилгоор зохион байгуулсан компани эсвэл хувь хүмүүсийн түр зуурын нэгдэл.
Спекулятив буюу эрсдэлтэй хөрөнгө оруулалт	Харьцангуй богино хугацаанд их хэмжээний ашиг олох сонирхлыг төрүүлдэг, өндөр эрсдэл дагуулдаг хөрөнгө оруулалт.
Тамирчдын даатгал	Спортын уралдаан тэмцээн, бэлтгэлийн явцад гэрээнд заасан эрсдэлийн улмаас тамирчдад учирсан хохирлыг нөхөн төлөх зорилготой даатгал.
Татвар	Татвар төлөгчдийн орлого, ашиг, эд хөрөнгийн үнийн дүнгээс хамааруулан хуульд заасан хувь, хэмжээгээр төрөөс хураан авч байгаа мөнгө.
Татвар ногдох орлого	Хуулийн дагуу татвар ногдуулбал зохих орлогын дүн
Татвар ногдох орлогоос хасагдах зардал	Татвар ногдуулах орлогыг тодорхойлохын тулд татвар төлөгчийн нийт орлогоос хасч тооцдог зардал.
Татвар ногдуулах орлого	Татвар төлөгчийн татвар ногдох орлогоос хуулийн дагуу хасагдах зардлуудыг хассаны дараах орлогын дүн.
Татвараас зайлсхийх	Хууль ёсны арга хэрэгсэл ашиглан татвараа бууруулах оролдлого.
Татвараас зугатах	Татвар төлөхгүй байх, татвараа бууруулах зорилготой хууль бус үйлдэл.
Татварын хөнгөлөлт, чөлөөлөлт	Хуульд заасан үндэслэлээр татвар төлөгчдийн төлбөл зохих татварыг бууруулах үйл ажиллагаа.

Тогтмол орлого	Сар бүр ижил хэмжээгээр орж ирдэг орлого. Тухайлбал, хадгаламжийн хүүний орлого, хүүхдийн мөнгө, тэтгэвэр зэрэг нь тогтмол дүнтэй орлого юм.
Тогтмол татвар	Орлогыг нь тухай бүр тодорхойлох боломжгүй ажил үйлчилгээнд мөнгөн дүнгээр ногдуулдаг татвар.
Төлбөр	Төрийн өмчийн байгалийн баялгийг ашиглуулсны төлөө авч байгаа татвар.
Төсөв	Хувь хүний шийдвэрийн дагуу мөнгөн орлогыг бүрдүүлэх, түүнийг ашиглахтай холбоотой үүсч байгаа мөнгөн харилцаа.
Урт хугацааны даатгал	Нэг жилээс дээш хугацаатай даатгал.
Үл хөдлөх хөрөнгө	Газар болон газраас салгамагц зориулалтын дагуу ашиглаж үл болох эд юмс.
Үндсэн орлого	Цалин, хөдөлмөрийн хөлс, тэтгэвэр, оюутны тэтгэлэг, тэтгэмжийн хэлбэрээр сар бүр эсвэл тогтоосон хугацаанд орж буй мөнгөн орлогууд.
Форвард хэлцэл	Тодорхой хөрөнгийг, тодорхой хугацааны эцэст, урьдчилан тохиролцсон үнээр худалдан авах, худалдах хэлцэл.
Фьючерсийн хэлцэл	Тодорхой хөрөнгийг, тодорхой хугацааны эцэст, урьдчилан тохиролцсон үнээр худалдан авах, худалдах үүрэг бүхий хэлцэл.
Хадгаламж	Санхүүгийн дансанд байршуулсан мөнгөн хуримтлал.
Хадгаламж зээлийн хоршоо	Гишүүдийнхээ эдийн засаг, нийгэм, соёлын нийтлэг хэрэгцээг хангах зорилгоор гишүүддээ хадгаламж, зээлийн үйлчилгээг тусгай зөвшөөрлийн үндсэн дээр үзүүлэх ардчилсан удирдлага, хамтын хяналт бүхий ашгийн төлөө бус хуулийн этгээд.
Хадгаламжийн байгууллага	Байгууллага болон хувь хүнээс хадгаламж төвлөрүүлэх эрх бүхий байгууллага.
Хадгаламжийн бус байгууллага	Хадгаламж хэлбэрээр иргэд болон байгууллагаас мөнгөн хөрөнгө татан төвлөрүүлэх эрхгүй санхүүгийн байгууллага.
Хадгаламжийн даатгал	Хадгаламж татан төвлөрүүлдэг байгууллагын төлбөрийн чадвар муудан дампуурсан тохиолдолд хадгаламж эзэмшигчдийг алдагдлаас хамгаалах үйл ажиллагаа.
Хадгаламжийн сертификат	Тодорхой хугацаагаар мөнгөө байршуулж буй хадгаламж эзэмшигчид банкны зүгээс олгосон үнэт цаас.

<i>Хадгаламжийн хүү</i>	Банк, санхүүгийн байгууллагаас иргэд болон байгууллагын хадгаламжийн мөнгийг ашигласны төлөө төлж буй мөнгө.
<i>Харьцуулсан худалдан авалт</i>	Дэлгүүр, барааг үйлдвэрлэсэн газар, үнийг харьцуулан судалсны үндсэн дээр хийж байгаа худалдан авалт.
<i>Хоёрдогч зах зээл</i>	Анхдагч зах зээл дээр өмнө гаргасан үнэт цаасыг дахин арилжаалах үйл ажиллагаа явагдаж буй зах зээл.
<i>Хөдлөх хөрөнгө</i>	Үл хөдлөх эд хөрөнгөөс бусад эд хөрөнгө.
<i>Хөрвөх чадвар</i>	Ямар нэг зүйл үнэ цэнээ алдахгүйгээр мөнгөнд шилжих чадвар.
<i>Хөрөнгийн зах зээл</i>	Нэг жилээс дээш хугацаатай, хөрөнгө оруулалтын зориулалттай үнэт цаасыг арилжаалж буй зах зээл.
<i>Хөрөнгө</i>	Хувь хүний эзэмшиж буй тодорхой үнэ цэнэ бүхий зүйлс.
<i>Хөрөнгө оруулалт</i>	Ирээдүйд орлого, ашиг олох зорилгоор өнөөдөр зарцуулж буй мөнгө.
<i>Хувь хүний орлого</i>	Цалин, тэтгэвэр, оюутны тэтгэлэг, үндсэн хөрөнгө түрээслүүлсний орлого, хадгаламжийн хүү, гэрээгээр ажил гүйцэтгэсний хөлс гэх мэт хэлбэрээр хувь хүнд орж буй мөнгө.
<i>Хувь хүний санхүүгийн төлөвлөлт</i>	Хувь хүн орлого, зардлаа төлөвлөж, зөв удирдах үйл явц.
<i>Хувь хүний санхүүгийн удирдлага</i>	Хувь хүн санхүүгийн хувьд сэтгэл ханамжтай байхуйцаар мөнгөн хөрөнгийг оновчтой удирдах арга механизм.
<i>Хувь хүний санхүүгийн үндсэн үүрэг</i>	Хязгаарлагдмал санхүүгийн нөөцийг үр ашигтай хуваарилах явдал.
<i>Хувь хүний санхүүгийн үүрэг</i>	Санхүүгийн нөөц бүрдүүлэх, хуваарилах, хянах үйл ажиллагаа.
<i>Хувьсах орлого</i>	Сар бүр өөр хэмжээтэй байдаг орлого.
<i>Хувьцаа</i>	Компанид хувь нийлүүлснийг гэрчлэх үнэт цаас.
<i>Хувьцааны жижигрүүлэлт</i>	Хувьцаа эзэмшигчдийн мэдэлд байгаа хувьцааг олон тооны хувьцаа болгон хуваах үйл явц.
<i>Хугацаагүй хадгаламж</i>	Тодорхой бус хугацаагаар хадгалуулсан мөнгө.
<i>Хугацаатай хадгаламж</i>	Тодорхой хугацаа зааж банк, санхүүгийн байгууллагад хадгалуулсан мөнгө.
<i>Хураамж</i>	Төрийн байгууллагаас үйлчилгээ үзүүлснийхээ төлөө авч байгаа татвар.

<i>Хуримтлал</i>	Ирээдүйд ашиглах зорилгоор өнөөдөр үүсгэж буй нөөц.
<i>Хүү</i>	Бусдын мөнгийг ашигласны төлөө өгч буй төлбөр.
<i>Хэрэглээний зардал</i>	Эдийн засаг дахь бараа, үйлчилгээний нийт эрэлт.
<i>Хэрэглээний үнийн индекс</i>	Өргөн хэрэглээний бараа, үйлчилгээний үнийн жилийн өсөлтийг хэмждэг үзүүлэлт.
<i>Хязгаарлалттай баталгаа</i>	Барааг тээвэрлэх болон засварлах зардлын зарим хэсгийг худалдан авагч төлөх, эсвэл бараа бүтээгдэхүүний зөвхөн зарим нэг хэсэгт хамаарах нөхцөлтэй баталгаа.
<i>Шошгоны үнэ</i>	Цаасан дээр хэвлэж, автомашины цонхон дээр наасан, автомашины үнэ.
<i>Шууд бус орлого</i>	Үйл ажиллагаанд нь идэвхитэй оролцоогүй бизнесээс олж байгаа болон ажил олгогчоос олгодог ажил үүрэгтэй шууд холбогдолгүй орлого.
<i>Шууд бус татвар</i>	Бараа, үйлчилгээний үнэ тарифаар дамжуулан авч байгаа татвар.
<i>Шууд бус хөрөнгө оруулалт</i>	Хөрөнгө оруулагчийн нэрийн өмнөөс үл хөдлөх хөрөнгө хууль ёсоор эзэмшдэг байгууллагад хийх хөрөнгө оруулалт.
<i>Шууд татвар</i>	Татвар төлөгчдийн орлого ашиг, эзэмшиж байгаа хөрөнгийн үнийн дүнд ногдуулж байгаа татвар.
<i>Шууд хөрөнгө оруулалт</i>	Хөрөнгө оруулагчийн хууль ёсоор эзэмших үл хөдлөх хөрөнгө худалдан авах замаар хийх хөрөнгө оруулалт.
<i>Эдийн засаг</i>	Хязгааргүй хэрэгцээг хязгаарлагдмал нөөцөөр хэрхэн хангах талаар судалдаг шинжлэх ухаан.
<i>Энгийн гэрээслэл</i>	Гэр бүлийнхээ хүнд бүх хөрөнгөө өвлүүлэхээр заасан гэрээслэл.
<i>Энгийн хувьцаа</i>	Зах зээл дээр нийтэд санал болгож байгаа, саналын эрхтэй хувьцаа.
<i>Энгийн хүү</i>	Мөнгөний үндсэн дүнгээс тооцсон хүү.
<i>Эргэн дуудагдах бонд</i>	Бонд гаргагч бондын төлөгдөх хугацаанаас өмнө эргүүлэн татах нөхцөлтэйгээр гаргасан бонд.
<i>Эрсдэл</i>	Хохирол учирч болох магадлал.
<i>Эрсдэлийн удирдлага</i>	Хувь хүн өөрийн хөрөнгө, мөнгөө эрсдэлээс хамгаалах, эрсдэлийг бууруулах төлөвлөгөө боловсруулж, түүнийгээ амьдралд хэрэгжүүлэх үйл ажиллагаа.
<i>Эрүүл мэндийн даатгал</i>	Даатгалын хураамжаар бүрдүүлсэн сангаас даатгуулагчийн эрүүл мэндтэй холбоотой гарсан зардлыг санхүүжүүлэх зорилго бүхий даатгал.

- Frederic S. Mishkin, Stanley G. Eakins. (2014). *Financial markets and institutions*, eighth edition. New Jersey: USA
- Jack R. Kapoor, Les R.Dlabay, Robert J. Hughes. (2004). *Focus on Personal Finance*. McGraw-Hill/Irwin, New York: USA
- Jack R. Kapoor, Les R.Dlabay, Robert J. Hughes. (2008). *Personal Finance*. McGraw-Hill/Irwin, New York: USA
- Jack r. Kapoor, Les r. Dlabay, Robert j. Hughes. (2012). *Personal finance*. Tenth edition. McGraw-Hill/Irwin, New York: USA
- Lewes J.Altfest, (2007). *Personal financial planning*. USA
- Балж.Г, (2015). *Эрсдэл, эрсдэлийн удирдлага ба даатгал*. Улаанбаатар: Монгол Улс
- Батжаргал.Н нар, (2016). *Хувь хүний санхүү*. Улаанбаатар: Монгол Улс
- Лувсанцэрэн, Д. (2008). *Макро эдийн засгийн төрийн зохицуулалт, санхүү-мөнгөний бодлого*. Улаанбаатар: Монгол Улс
- Монголбанк, Дэлхийн банк (2015). *Эдийн засаг, санхүүгийн нэр томъёоны тайлбар толь*. Улаанбаатар: Монгол Улс
- Монгол Улсын хууль, (1992). *Үндсэн хууль*
- Монгол Улсын хууль, (2010). *Банкны тухай, шинэчилсэн найруулга*
- Монгол Улсын хууль, (2002). *Банк бус санхүүгийн үйл ажиллагааны тухай*
- Монгол Улсын хууль, (2013). *Банкин дахь мөнгөн хадгаламжийн даатгалын тухай*
- Монгол Улсын хууль, (1995). *Банк, эрх бүхий хуулийн этгээдийн мөнгөн хадгаламж, төлбөр тооцоо, зээлийн үйл ажиллагааны тухай*
- Монгол Улсын хууль, (2015). *Даатгалын тухай, шинэчилсэн найруулга*
- Монгол Улсын хууль, (2012). *Зээлийн батлан даалтын сангийн тухай*
- Монгол Улсын хууль, (2002). *Иргэний хууль*
- Монгол Улсын хууль, (1994). *Нийгмийн даатгалын сангаас олгох тэтгэвэр, тэтгэмжийн тухай*
- Монгол Улсын хууль, (2005). *Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай*
- Монгол Улсын хууль, (1999). *Тэтгэврийн даатгалын нэрийн дансны тухай*
- Монгол Улсын хууль, (2015). *Үнэт цаасны зах зээлийн тухай, шинэчилсэн найруулга*
- Монгол Улсын хууль, (2011). *Хадгаламж, зээлийн хориооны тухай*
- Монгол Улсын хууль, (2006). *Хувь хүний орлогын албан татварын тухай*
- Монгол Улсын хууль, (2003). *Хэрэглэгчийн эрхийг хамгаалах тухай*
- Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 10 дугаар сарын 14-ний өдрийн 09 дүгээр тогтоол
- МУҮСХ, (2016). *Монгол Улсын жил бүрийн статистикийн эмтхэтгэл -2015 он*. Улаанбаатар: Монгол
- Нээлттэй нийгэм форум, (2010). *Иргэдийн санхүүгийн хөтөч*
- Оюун. Л, Биндэрьяа. Л. (2016) *Хувь хүний санхүүгийн онол, арга зүй*. Улаанбаатар: Монгол

- Оюунцацрал,З. (2003). *Банкны удирдлага*. Улаанбаатар: Монгол
- Оюунцэцэг, Д. (2010). *Санхүүгийн үндэс*. Улаанбаатар: Монгол
- Оюунцэцэг,Д. (2011). *Хувьцаа эзэмших эрх- Таны алтан боломж*. Улаанбаатар: Монгол
- Оюунцэцэг, Д. (2012). *Хувь хүний санхүү*. Улаанбаатар: Монгол
- СЗХ, (2016). *Санхүүгийн зах зээлийн 2016 оны 1-р улирлын тойм*. Улаанбаатар: СЗХ.
- ҮСХ, (2015). *Монгол Улсын статистикийн эмхэтгэл*, Улаанбаатар: Монгол
- Эрдэм Мэдлэг Түгээх ТББ. (2012). *Төв Өрхийн төсөв дэвтэр*. Улаанбаатар: Монгол
- Шинжлэх ухааны академи, Хэл зохиолын хүрээлэн, (2015). *Монгол хэлний их тайлбар толь*

ХАВСРАЛТ

Хавсралт 1. СЗХ-ноос тусгай зөвшөөрөлтэй ҮЦК-иудын үйл ажиллагааны чиглэл

№	Гишүүн компани	Үйл ажиллагааны чиглэл			
		Брокер	Дилер	Андер-райтер	Хөрөнгө оруулалтын зөвлөх
1	“АСЕ энд Т Капитал ҮЦК” ХХК	√	√	√	√
2	“Алтан хоромсог ҮЦК” ХХК	√	√		
3	“Азиа Пасифик секьюритис ҮЦК” ХХК	√	√	√	
4	“Ард капитал групп ҮЦК” ХХК	√	√	√	
5	“Аргай бэст ҮЦК” ХХК	√	√		
6	“Батс ҮЦК” ХХК	√	√		
7	Би Би Эс Эс ХХК	√	√		
8	“БиДиСек ҮЦК” ХК	√	√	√	√
9	“Бага хээр” ХХК	√	√		
10	“Блэкстоун интернэйшнл ҮЦК” ХХК	√	√		
11	“Блүмсбюри секьюритис ҮЦК” ХХК	√	√	√	
12	“Блюскай секьюритиз ҮЦК” ХК	√	√		
13	“Булган брокер ҮЦК” ХХК	√	√		
14	“Бумбат-Алтай ҮЦК” ХХК	√	√	√	
15	“Дэү Секьюритис Монгол ҮЦК” ХХК	√	√	√	√
16	“Капитал маркет корпораци ҮЦК” ХХК	√	√	√	
17	“Ди Си Эф” ХХК	√	√		
18	“Дэлгэрхангай секюритиз ҮЦК” ХХК	√	√		
19	Догсон ХХК	√	√		
20	“Дархан брокер ҮЦК” ХХК	√	√		
21	“Еврази капитал холдинг ҮЦК” ХК	√	√	√	√
22	“Эф Си Икс ҮЦК” ХХК	√	√	√	
23	“Финанс линк групп” ХХК	√	√		
24	“Фронтнер ҮЦК” ХХК	√	√	√	
25	“Гацуурт трейд ҮЦК” ХХК	√	√		
26	“Гаүли ҮЦК” ХХК	√	√	√	
27	“Гранддевелопмент ҮЦК” ХХК	√	√		

28	“Гүүдсек ҮЦК” ХХК	√	√	√	√
29	“Голомт секюритиз ҮЦК” ХХК	√	√	√	√
30	“Гендекс ҮЦК” ХХК	√	√		
31	“Говийн ноён нуруу” ХХК	√	√		
32	“Хүннү Эмпайр ҮЦК” ХХК	√	√		
33	Ай трейд ХХК	√	√		
34	“Лайфтайм инвестмент ҮЦК” ХХК	√	√	√	
35	“Мэргэн санаа ҮЦК” ХХК	√	√		
36	“Эм Ай Би Жи” ХХК ҮЦК	√	√	√	
37	“Эм Ай Си Си” ХХК	√	√	√	
38	“Ард секьюритиз ҮЦК” ХХК	√	√	√	√
39	“Монгол секюритис ҮЦК” ХХК	√	√		
40	“Масдак үнэт цаасны компани” ХХК	√	√		
41	“Монсек ҮЦК” ХХК	√	√	√	
42	“Эм Даблю Ти Эс ҮЦК” ХХК	√	√		
43	“Новел инвестмент ҮЦК” ХХК	√	√		√
44	“Нэйшнл сэкюритис ҮЦК” ХХК	√	√	√	√
45	Превалент ХХК	√	√		
46	“Санар ҮЦК” ХХК	√	√		
47	“Сикап ҮЦК” ХХК	√	√	√	√
48	“Эс Жи Капитал ҮЦК” ХХК	√	√	√	√
49	“Стандарт инвестмент ҮЦК” ХХК	√	√	√	√
50	“Таван богд ҮЦК” ХХК	√	√		
51	“Тулгат чандмань баян ҮЦК” ХХК	√	√		
52	“Ти Ди Би Капитал ҮЦК” ХХК	√	√	√	
53	“Тэнгэр капитал ҮЦК” ХХК	√	√	√	√
54	“ТЭСО Инвестмент” ХХК	√	√		
55	“Өндөрхаан инвест ҮЦК” ХХК	√	√		
56	“Зюс капитал” ХХК	√	√		√
57	“Зэт жи би ҮЦК” ХХК	√	√		
58	“Зэргэд ҮЦК” ХХК	√	√		

Хавсралт 2. Хөрөнгийн биржид бүртгэлтэй хувьцаат компаниуд

№	Симбол	Компанийн нэр	Төрөл
1	APU	АПУ ХК	1-р ангилал
2	GOV	Говь ХК	1-р ангилал
3	NEH	Дархан нэхий ХК	1-р ангилал
4	MMX	Махимпекс ХК	1-р ангилал
5	MIK	Мик холдинг ХК	1-р ангилал
6	SUU	Сүү ХК	1-р ангилал
7	TCK	Талх чихэр ХК	1-р ангилал
1	ADL	Адуун чулуун ХК	2-р ангилал
2	EER	Ариг гал ХК	2-р ангилал
3	ATR	Атар-Өргөө ХК	2-р ангилал
4	BAN	Багануур ХК	2-р ангилал
5	BNG	Баянгол зочид буудал ХК	2-р ангилал
6	BTG	Баянтээг ХК	2-р ангилал
7	BDS	Би ди сек ХК	2-р ангилал
8	BEU	Бэрх Уул ХК	2-р ангилал
9	SUL	Газар сүлжмэл ХК	2-р ангилал
10	GHC	Ган хийц ХК	2-р ангилал
11	HRM	Гермес центр ХК	2-р ангилал
12	GTL	Гутал ХК	2-р ангилал
13	DZG	Дархан зочид буудал ХК	2-р ангилал
14	DHU	Дархан хүнс ХК	2-р ангилал
15	JTB	Женко тур бюро ХК	2-р ангилал
16	ZOO	Зоос гоёл ХК	2-р ангилал
17	MIE	Материалимпекс ХК	2-р ангилал
18	MRX	Мерекс ХК	2-р ангилал
19	BDL	Могойн гол ХК	2-р ангилал
20	MNB	Мон Наб ХК	2-р ангилал
21	MNH	Монгол нэхмэл ХК	2-р ангилал
22	UYN	Монгол савхи ХК	2-р ангилал
23	MSH	Монгол шилтгээн ХК	2-р ангилал
24	MNP	Монгол шуудан ХК	2-р ангилал
25	MCH	Монголын цахилгаан холбоо ХК	2-р ангилал
26	MIB	Монинжбар ХК	2-р ангилал
27	MNS	Монноос ХК	2-р ангилал
28	NKT	Нако түлш ХК	2-р ангилал

29	OLL	Оллоо ХК	2-р ангилал
30	RMC	Ремикон ХК	2-р ангилал
31	TTL	Таван толгой ХК	2-р ангилал
32	TAN	Тахь-ко ХК	2-р ангилал
33	TEX	Техник импорт ХК	2-р ангилал
34	TUS	Түшиг Уул ХК	2-р ангилал
35	BUK	УБ-БҮК ХК	2-р ангилал
36	UID	Улсын их дэлгүүр ХК	2-р ангилал
37	MDR	Фронттиер Лэнд Групп ХК	2-р ангилал
38	HBO	Хай би ойл ХК	2-р ангилал
39	HSR	Хасу-Мандал ХК	2-р ангилал
40	CHE	Хорго Хайрхан ХК	2-р ангилал
41	HHS	Хөвсгөл хүнс ХК	2-р ангилал
42	HGN	Хөх ган ХК	2-р ангилал
43	SHG	Шарын гол ХК	2-р ангилал
44	SHV	Шивээ овоо ХК	2-р ангилал
45	NRS	Шинэст ХК	2-р ангилал
46	ETR	Э-Транс ложистикс ХК	2-р ангилал

Хавсралт 3. СЗХ-ноос тусгай зөвшөөрөлтэй даатгалын компаниуд

№	Компанийн нэр	Тусгай зөвшөөрөл	Компанийн хаяг
1	“Бодь даатгал” ХХК	Ердийн даатгал	ЧД, 6 хороо, Сүхбаатарын талбай, Бодь цамхаг 305,306 тоот
2	“Гэр даатгал” ХХК	Ердийн даатгал	УБ хот, СБД, 8-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, Үнэн сонины байр, 4 давхарт
3	“Мандал женерал даатгал” ХХК	Ердийн даатгал	Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Сөүлийн гудамж, Мандал бюлдингийн 4 давхар ШХ-2772 УБ-15160
4	“Монре даатгал” ХХК	Ердийн даатгал	УБ хот, СБД, 6-р хороо, Бага тойруу, ОУХТ 302 тоот
5	“Мөнх даатгал” ХХК	Ердийн даатгал	Улаанбаатар хот, СБД, 1-р хороо, Элчингийн гудамж 14-р байр 2 тоот
6	“Ган зам даатгал” ХХК	Ердийн даатгал	БГД, 2-р хороо, Сөүлийн гудамж, Одод цогцолбор 201 тоот
7	“Миг даатгал” ХХК	Ердийн даатгал	Улаанбаатар хот, ЧД, 1-р хороо, Эрхтайваны өргөн чөлөө “Миг даатгал” ХХК-ийн байр
8	“Монгол даатгал” ХХК	Ердийн даатгал	1.СБД, 5-р хороо, Сөүлийн гудамж, өөрийн байранд. 2. СБД, 1-р хороо, Энхтайвны өргөн чөлөө-13
9	“Ард даатгал” ХХК	Ердийн даатгал	СБД, 8 хороо, Централ тавер 505 тоот
10	“Номин даатгал” ХХК	Ердийн даатгал	УБ хот, СБД, 3-р хороо, УИД, 6-р давхарт
11	“Практикал даатгал” ХХК	Ердийн даатгал	УБ хот, СБД, 8-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, Рокмон билдинг, 304 тоот
12	“Соёмбо даатгал” ХХК	Ердийн даатгал	УБ хот, ЧД, 1-р хороо, Бага тойруу-7/1, Зоос банкны төв байр, 7 давхар
13	“Тэнгэр даатгал” ХХК	Ердийн даатгал	УБ хот, СБД, 2-р хороо, Ерөнхий сайд амарын гудамж-8, Ник ХК-ийн байр, 3 давхарт
14	“Улаан баатар хотын даатгал” ХХК	Ердийн даатгал	УБ хот, ЧД, 5-р хороо, “Crown center” төв, 5 давхар
15	“Хаан даатгал” ХХК	Ердийн даатгал	БЗД, 15-р хороо Энхтайваны өргөн чөлөө 47-2
16	“Хөдөө аж ахуйн давхар даатгал” ХХК	Ердийн даатгал	УБ хот, СБД, 8-р хороо, Бага тойруу, Чингэс хааны талбай, 5 давхарт
17	“Нэйшнл лайф даатгал” ХХК	Урт хугацааны даатгал	УБ хот, СБД, 1-р хороо, Энхтайваны өргөн чөлөө, 15А/5, Амбассадор оффис 0-502-1 тоот

Хавсралт 4. Монголбанкны зөвшөөрөлтэй арилжааны банкууд

Д/д	Банкуудын нэрс	Холбоо барих утас	Цахим хуудас
1	Худалдаа хөгжлийн банк	1977, 331884	www.tdbm.mn
2	Голомт банк	1646, 311530, 310639	www.golomtbank.com
3	ХААН банк	1917, 332333	www.khanbank.com
4	Хас банк	1888, 317455, 318185	www.xacbank.mn
5	Капитрон банк	315503	www.capitronbank.mn
6	Капитал банк	50115022, 315500	www.capitalbank.mn
7	Ариг банк	70144402, 344550	www.arigbank.mn
8	Төрийн банк	1899, 324896	www.statebank.mn
9	Богд банк	70139999, 328311	www.bogdbank.com
10	Улаанбаатар хотын банк	319041	www.ubcbank.mn
11	Үндэсний хөрөнгө оруулалтын банк	75757070, 70111354	www.nibank.mn
12	Чингис хаан банк	318367	www.ckbank.mn
13	Кредит банк	319038	http://www.creditbank.mn
14	Тээвэр хөгжлийн банк	319591	www.transbank.mn

Хавсралт 5. Санхүүгийн зах зээлийн зохицуулагч байгууллагууд

Д/д	Байгууллагын нэрс	Цахим хуудас
1	Монголбанк	www.mongolbank.mn
2	Санхүүгийн зохицуулах хороо	www.frc.mn

Хавсралт 6. Санхүүгийн зах зээлийн бусад оролцогч байгууллагууд

Д/д	Байгууллагын нэрс	Цахим хуудас
1	Монголын хөрөнгийн бирж	www.mse.mn
2	Хадгаламжийн даатгалын корпораци	www.dicom.mn
3	Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв	www.schcd.mn
4	Монголын үнэт цаасны бирж	